

# ОРОС ҮЛГЭРҮҮД



# ОРОС ҮЛГЭРҮҮД

# БЭЛЭВСЭН ЭХНЭРИЙН ХҮҮ ИВАН

Хөхрөх тэнгисийн тэртээ, хөлгүй далайн цаана Буянт нэртэй арал дээр бүхлээр нь шарсан шарын мах бий. Шарын махны нэг сүвээнд хурц балиус хатгаж, нөгөө сүвээнд нухсан сармис тавьжээ. Шарын махнаас хурц балиусаар огтол, сармисанд түрхээд дураараа ид! Бүхэл шөнөжингөө найрла, сайхан биз дээ

Заа. энэ бол үлгэрийн эхлэл, үгийн хэлхээ. Шарсан боов идээд шар айргаар даруулаад жинхэнэ үлгэрээ эхэлье.

Эрт урьд цагт, энэ замбуутивийн нэгэн улсад залуу сайхан бэлэвсэн эхнэр жаал хүүтэйгээ ядуу зүдүү амьдран суудаг байжээ.

Хүүгийн нэрийг Иван гэдэг, хөрш хавийнхан нь харин бэлэвсэн эхнэрийн хүү гэнэ.

Бэлэвсэн эхнэрийн хүү Иван тоолох нас нь бага ч, төөлөх бие нь өндөр, төрөлх хүч нь их тул харсан бүхэн магтаж, үзсэн бүхэн гайхна.

Мөн тэр улсад нэг харамчийн харамч худалдаачин байжээ. Анхны эхнэрээ харангадуулж алсан, удаах эхнэр нь удсан ч үгүй нас баржээ.

Худалдаачин дахиад ганц бие хоцорч эхнэр авах санаатай эрж хайж гарч гэнэ. Харин түүнд эхнэр болох хүн олдохгүй, эмс хүүхнүүд зугтаадаг байж гэнэ.

Худалдаачин бэлэвсэн эхнэрийг гуйж:

Өнчин ганцаар зүдрээд яахав, эхнэр минь болооч гэжээ

Бэлэвсэн эхнэр бодож бодож «Эр нөхөр болох хүнд амьтны ам муу байлаа ч яая гэх вэ, амьдрал залгуулах юмгүй хойно эхнэр нь болж суугаад үзье! Өөрт минь ямар байсан ч яах вэ, өөдсөн чинээ хүүгээ өсгөж авья» гэж шийджээ.

Хурим найр хийжээ.

Худалдаачин гэрлэснийхээ маргааш нөгөөдрөөс дагуул хүүгээ ад үзэж, суусан ч зэмлэнэ, боссон ч зэмлэнэ. «Энэ хоолны савыг өсгөхөд хичнээн их юм үрэгдэх бол! Хоосорч гүйцэх нь!» гэж худалдаачин дотроо бодон идсэн уусныг нь нэгд нэггүй тоолно.

Хөөрхий эх чадах чинээгээрээ зүтгэж, үүрийн гэгээнээс өмнө босож, үдшийн шөнөөс хойш хэвтэж, хорин хүний хийх ажлыг хийвч ховдог нөхрийн санаанд үл нийцнэ

Өдрөөс өдөрт худалдаачны уур хилэн ихсэнэ.

«Энэ хүүгээс бүрмөсөн салж амрахсан» гэж хар санаандаа бодох болжээ. Өөр хотод зах зээлийн газар очих цаг болжээ. Худалдаачин:

- Иваныг дагуулаад явья. Ажил ч сураг, бас эд барааг харж хамгаалж байг. Ямар ч гэсэн тустай

гэж эхнэртээ хэлж гэнэ.

Харин дотроо «Хүний газар аваачаад төөрүүлчихье» гэж боджээ. Эх нь хүүгээ өрөвдөвч эр нөхөртэйгөө зөрж зүрхэлсэнгүй.

Уйлж, уйлж Иванушкаа алс замд явуулахаар зэхжээ. Тосгоноос гартал даган явж үдэхэд Иван хүү малгайгаараа далласаар салан одож гэнэ.

Холуур нэг тойрч, ойроор нэг эргэж, өргөн замд гарч, өндөр байцыг ороон яв явсаар ойд ороод амрахаар зогсоцгоожээ. Морьдоо суллан бэлчээжээ. Худалдаачин ачаа тэргээ шалган тоолж байснаа гэнэт уурлан харааж загнаж эхлэв.

- Нэг хайрцаг боов дутаад байна! Иван, чи л идсэнээс зайлахгүй!

- Би тэр тэрэг рүү ойртоо ч үгүй! гэж Иван хариулна. Худалдаачин улам их уурлан:

- Идчихээд идээгүй царай гаргана гэнээ. Чам шиг ийм амьтныг мангас авбал таарна! гэж хараав.

Энэ хараалыг хэлмэгц гачуур, хусан ой ганхан шуугиж эргэн тойрон харанхуйлж, ойн гүнээс өргөн мөртэй, өндөр биетэй, өвсөн бухал шиг толгойтой, аягын чинээ нүдтэй, аймаар өвгөн гарч ирээд:

- Чи надад энэ хүүгээ өгөөд хайрцагтай боовоо ав май! гээд нэгэн хайрцаг шидчихэв. Тэгээд Иваныг шүүрэн авахад ой мод шуугин шаагьжээ.

Худалдаачин айсандаа тэргэн доогуураа оржээ. Дуу чимээ намдсан хойно тэргэн доороос цухуйж харвал морьд нь айн дагжин дэл сүүл нь дэрвэх алдан боссон байна гэнэ. Хайрцагтай боов газар хэвтэж харагдана гэнэ.

Худалдаачин жаахан сэхээ орж, тэргэн доороосоо мөлхөн гараад эргэн тойрноо харваас хүү алга байжээ.

- Заа яахав. Хоолны савнаас салж амарлаа. Бараа таваар бүрэн бүтэн байна гэж баярлан бодоод морио тэргэндээ хөллөв.

Бэлэвсэн эхнэрийн хүү Иван яах ийхийн зуургүй аймаар өвгөнтэй хоёулхнаа байж байна гэнээ.

- Бүү ай. Бэлэвсэн эхнэрийн хүү Иван, чи энэ насаараа одоо миний зарц боллоо. Хэлсэн бүгдийг минь даган биелүүлбэл хооллож ундалж тэжээнэ, хичнээн л бол идэж уу, харин үгнээс минь зөрвөл хар үхэл амдан байна гэдгийг ойлго гэж өвгөн хэлэв.

- Надад айх юм алгаа. Хаана ч байсан хойд эцгийн гарт байснаас доргүй байх. Зөвхөн ээж минь л хөөрхий байна. Надгүйгээр элэг нь хатах байхдаа гэж Иван хариулав.

Өвгөн модны навчийг унатал, цэцэгсийг газарт налтал, өвс ногоог хорчийтол чанга исгэрэв.

Гэнэт түүний өмнө гурван алд сүүлтэй, уул мэт том морь гарч ирж гэнэ.

Мангас Иваныг шүүрч аван мордоод хуй салхи шиг давхицгаав.

- Зогсоорой, зогсоорой, би малгайгаа унагачихлаа! гэж Иваныг хашгирахад өвгөн:

- Чиний малгайг хаана гэж эрэх вэ! Чамайг хэлэх хооронд чинь бид таван зуун мод газар явчихлаа. Одоо бол бүүр мянган мод газар өнгөрөөд байна гэжээ.

Ой тайга, намаг, нуур усны дээгүүр дүүлэн хурдлахад гагцхүү исгэрэх дуу чихэнд сонсдоно. Орой нь мангасын ордонд ирлээ.

Ойн дунд өндөр ордон байх агаад хашааг тойрон бүдүүн бүдүүн мод хашаалан шигүү ургажээ.

Хашаа тэнгэр тулам өндөр бас хаалгагүй болохыг Иван ажиглажээ.

Морь нь үүлэнд тултал огло үсрээд хашаанд оров.

Мангас мориныхоо эмээл хазаарыг аваад улаан буудай цацаж өгөв. Тэгээд Иваныг дагуулан ордондоо оржээ.

- Өнөөдөр би өөрөө хоол хийнэ, чи амар. Маргаашаас эхлэн ажиллаарай гэж мангас хэлээд пийшингээ галлан амбан шарын бүхэл мах шарж, дөчин хувин дарстай торхоо өнхрүүлж авчрав гэнэ. Тэгээд:

- Заа суу, хоолоо ид! гэж гэнэ.

Иван энэхэн тэрхнээс идэж цадаад булгийн усаар даруулжээ. Өвгөн шарын махыг бүгдийг идэж, дарсаа дуустал уучихаад унтаад өгчээ.

Маргааш өглөө нь Иван эртийн эрт босоод нүүр гараа угааж, үсээ самначихаад хог шороог шүүрдэж цэвэрлээд пийшинг галлаж:

- Одоо өөр юу хийх вэ! гэв.

- Морь малаа усалж, өвс өг! Тэгээд арван тарган хонь шар. Одоо иднэ! гэжээ. Иван хэлсэн бүх ажлыг нь харсан хүн бахархмаар хурдан сайхан хийжээ.

Бүгдийг бэлтгээд ширээгээ засчихаад өвгөнийг:

- Та ундаа уу! гэв. Мангас хүүг магтан:

- Сайн байна! Авхаалжтай, юманд дүйтэй хүү байна, харин бяр чадал суугаагүй бага

балчир юм. Аяндаа бяр орно гээд нэгэн домбо авч өгөн:

- Гурав балга! гэжээ.

Иван гурав балгасанд хүч чадал нь гурав дахин нэмэгдэв гэнэ. Өвгөн:

- Одоо чиг орон гэрийн ажилд алзахгүй ээ гэв. Идэж ууж аваад мангас өвгөн ширээнээс босож:

- Одоо чамд хөрөнгө зоорио үзүүлнэ гээд хэлхээтэй олон түлхүүрээ авч Иваныг дагуулан орд харш сан хөмрөгөө үзүүллээ.

- Энэ зооринд алт, тэнд мөнгө бий гэв. Гурав дахь агуулахад оров. Тэнд элдэв зүйлийн эрдэнийн чулуу, сувд шүр өрөөстэй. Дөрөв дэхэд нь үнэг суусар, минж булга өнгө өнгөөрөө хураалгаастай гэнэ. Доошоо буун нэг зооринд орвол тэнд амтат дарс, бал бурам, ариун ундаа арван хоёр зоорь дүүрэн гэнэ. Энэ бүгдийг үзээд дээш гарч ирэн өвгөн нэгэн хаалгыг нээхэд Иван босгон дээгүүр хөл тавимагцаа дуу алдав. Ханаар нь нэлдээ хуяг дуулга, эмээл хазаар өлгөөстэй гэнэ. Алтан мөнгөн тоногтой, үнэт чулуун чимэгтэй, галын өнгөөр гялалзаж гэрэл туяа цацруулна.

Иван илд жад, эмээл хазаар хараад нүд салгаж чадахгүй зогсов.

«Би ийм сайхан хуяг дуулгатай, бас үнэнч сайн хөлөгтэй болоосой!» гэж бодлоо. Мангас Иваныг хамгийн захын нэгэн төмөр хаалганы дэргэд дагуулж очоод:

- Энэ бүх түлхүүрийг чи ав. Буян хишгийг хамгаалан харуулд. Аль ч агуулах, ямар ч зооринд орсон чиний дур, цөмийг чи хариуцна, харин чи эзэн хүн шиг байна шүү. Тэгээд төмөр хаалгыг зааж:

- Зөвхөн энд л миний зөвшөөрөлгүйгээр орж болохгүй. Үгнээс зөрвөл өөртөө гомдоорой, амьд үлдэхгүй шүү гэжээ.

Ингээд Иван мангасын хамаг ажлыг хийдэг болжээ.

Амьдран сууж, аж төрсөөр өдөр хоног өнгөрөн байтал нэг удаа өвгөн:

- Маргааш би гурван жилээр юманд явлаа чи ганцаараа үлдэнэ шүү. За тэгээд дураараа амьдар, захиж хэлсэн үгийг битгий мартаарай. Өөрөө буруудвал өршөөл бүү горьдоорой! гэжээ.

Маргааш өглөө нь үүрийн харанхуйгаар морио эмээллэж унаад хашаан дээгүүр харайлган бараа нь үзэгдээд алга болжээ.

Иван гав ганцаар үлдэв. Ярих хэлэлцэх ч хүн үгүй.

Хоёр жил өнгөрчээ. Иван уйдаж уйтгарлаж эхлэв. Нэг ч болтугай хүний үг сонсохсон гэхээс сууж байж чадахаа болив.

Тэгээд гэнэт мангас төмөр хаалгыг онгойлгож болохгүй гэснийг санажээ. «Тэнд хүн хоригдож байгаа юм биш байгаа? Онгойлгоод үзье, өвгөн юу ч мэдэхгүй» гэж сэтгэжээ.

Түлхүүрийг авч хаалгыг онгойлгов. Хаалганы цаана шат, шатыг хөвд өвс урган бүрхжээ. Иван шатаар уруудан газар зооринд оров. Тэнд аварга том нэгэн морины хөлийг шаланд гинжээр хүлжээ. Толгойгий нь гэдийлгэн цулбуураар нь дээврийн хөндлөвч модноос уяжээ. Яс арьс болтлоо турсан морь байна гэнэ.

Иван морийг өрөвдөн цулбуурыг нь тайлж улаан буудай, ус авчирж өглөө.

Дараа өдөр нь ирэхэд морь овоо тэнхэрсэн байж. Дахин улаан буудай, ус авчирж өгөв. Ингэж ханаж цадтал нь усалж ундаалжээ. Нөгөөдөр нь ортол:

- Сайн санаат залуу минь, амийг минь чи аварлаа. Энэ насандаа мартахгүй! гэх сонсдов. Иван гайхан хартал морь ярьж байна гэнэ.

- Дахиад есөн долоо хоног намайг ундалж тэжээ. Газар доороос өглөө болгон гарга. Гучин удаа шүүдэрт хөрвөөвөл урьдын хүч чадал минь эргэж ирнэ гэжээ.

Иван морийг ундалж, тэжээж, өглөө болгон гаргаж ногоон дээр бэлчээдэг болжээ. Морь нэг өнжөөд л нугын шүүдэрт хөрвөөдөг байж.

Ингээд есөн долоо хоног морийг усалж тэжээж, арчилж торджээ. Гуч дахь удаагаа шүүдэрт хөрвөөгөөд морь тун сайхан тарган цаггалан болоод иржээ. Тэгээд морь:

- Иванушка минь, урьдын хүч чадал минь мэдэгдэж байна. Над дээр морд, сайн бариарай гэв.

Аварга том моринд Иван арайхийж мордов.

Энэхэн хоромд эргэн тойронд харанхуйлж, үүл манан бүрхэх мэт болоод мангас харайн орж ирэв.

- Үгэнд минь орсонгүй, зоориноос морь гаргачихаж! гээд Иваныг ташуурдав.

Иван долоон алд газар үсрэн унаж ухаан алдав.

- Энэ чамд сануулга болог! Амьд үлдвэл аз чинь, эндээ үхвэл элээ хэрээний хоол болог! гэж мангас Иваныг харааснаа морь луу үсрэн очиж ташуурдахад хөөрхий морь өвдөг сөгдөн унав.

Мангас морийг гуядан балбаж:

- Арьсыг чинь хуулна даа, чонын хоол! гэж нүдэж нүдэж газар зооринд аваачин хөлийг нь гинжлэн, толгойгий нь гэдийлгэн уяв.

- Миний гараас яасан ч гарч чадахгүй, эрхэнд минь орох цаг ирнэ гээд гарчээ. Хэчнээн удсаныг бүү мэд, Иван ухаан орж толгойгоо өндийлгөхөд,

- За, амь орсон аз чинь болж. Анх удаа юм байна, өршөөе. Ажил төрлөө хий! гэж мангас хэлжээ.

Маргааш нь нэгэн хэрээ нисэн ирж гурван удаа «Гуаг, гуаг, гуаг!» гэж гуаглав.

- Гай дайрсан хэрэг! Атгаалжин хар могой ах минь, дэмий хэл ирүүлээгүй нь магад гээд мангас яаран сандран аян замд төхөөрөв.

Тэгээд явахдаа Иванд:

- Би удахгүй. Дахиад буруудвал амьд үлдэхгүй шүү! гэж хэлээд явжээ.

Иван ганцаар үлдээд «Мангас намайг алсангүй, морийг яагаа бол? Юу л болбол болог, очиж үзье» гэж бодов.

Газар зооринд орж үзвэл морь амьд байв.

- Хайрт морь минь, чамайг амьд байгаа гэж бодоогүй! гээд Иван баярлав. Иван цулбуурыг тайлахад морь дэл сүүлээ сэгсрэн толгойгоо хаялан:

- Чамайг дахиад наашаа ирж зүрхэлнэ гэж би бодсонгүй. Нас чинь бага, цус чинь шингэн

ч авхаалж зоригтой хүү юм чи. Мангасаас айлгүй над руу ирсэнд чинь гялайлаа. Харин одоо бид энд байж болохгүй гэв.

Ингээд Иван морь хоёул газар зоориноос гарав. Морь нугад очсон хойноо:

- Урд хөлий минь доорх газрыг ух гэв. Иван ухаж ухаж нүх рүү харав.

- Юу харагдаж байна?

- Нүхээр дүүрэн алт оргилж байна.

- Гарынхаа тохойг хүртэл алтанд дүр.

Иван гараа дүрвэл гар нь тохойгоо хүртэл алт болжээ. Морь дахин:

- Энэ нүхээ бул, тэгээд хойд хоёр хөлий минь доорх газрыг ух гэв.

Иван нүх ухлаа.

- Заа, юу харагдаж байна?

- Мөнгө оргилж байна.

- Хөлийнхөө өвдгийг хүртэл мөнгөнд дүр. Иваны хөл өвдгөө хүртэл мөнгөөр бүрхэгдэв.



- Нүхээ бул, энэ гайхамшигийг мангас мэдэхгүй байг. Иван нүхийг шороогоор бултал морь гэнэт шилгээн:

- Иванушка минь, түргэлээрэй. Мангас буцах гэж бэлтгэж байх шиг байна! Баатар эрийн

хэрэгсэл хадгалдаг агуулахад очоод зүүн талаасаа гурав дахь тоногийг аваад ир гэжээ. Иван яваад хоосон буцаж ирэв.

- Чи яав?

Иван дуугүйхэн хөлөө солбин, толгойгоо унжуулан зогсоно. Морь тааж мэдээд:

- Ай Иванушка минь, би мартчихжээ. Чиний бяр одоохондоо дутуу, миний тоног гурван

зуун пүү хүнд. Гэвч бүү гут, тэнхээ хүч авч болно. Тэр зоорины баруун буланд нэг сагсанд гурван болор домбо бий. Нэг нь ногоон, нөгөө нь улаан, гурав дахь нь цагаан ундаатай. Чи домбо бүрээс гурав гурван балгыг уугаарай. Илүү увал би чамайг даахгүй шүү гэлээ.

Иван гүйж одоод удсангүй тоногийг авчрав.

- Заа, яав? Бяр чинь нэмэгдэв үү?

- Би маш их бярттай боллоо! Морь дахин толгой өргөн шилгээснээ:

- Хурдлаарай, Иван. Мангас гэр лүүгээ гарлаа гэв.

Иван шалавхан морио эмээллэв.

- Одоо ордонд ор, зуны өрөөнд авдар бий. Тэр авдраас саван, сам, гар нүүрийн алчуур авчир. Замд хэрэг болно гэж морь хэлэв.

Иван саван, алчуур, сам авчраад.

- За явья? гэхэд морь:

- Байз, Иван. Чи цэцэрлэг рүү гүй. Хамгийн цаад буланд нь алтан алимтай сайхан мод байгаа. Тэр мод нэг өдрийн дотор ургаж, нэг өдөр цэцэглэж, гурав дахь өдрөө алим нь болдог юм. Энэ модны дэргэд мөнхийн устай худаг бий. Чи тэр мөнхийн уснаас нэг шанага утгаад ир, бидэнд хэрэгтэй. За хурдал, эгшин ч бүү саат. Мангас замынхаа талд ороод байна шүү гэв.

Иван цэцэрлэгт орж, мөнхийн уснаас домбоор дүүргэж аваад алимын модыг хартал алтан алим дүүрэн гэнэ.

«Энэ сайхан алимаас гэртээ аваачих юмсан! Хүмүүс тарьж суулгаж, алтан алим ургуулж харан баясаг. Нэг өдөр ургаж, хоёр дахь өдрөө цэцэглэж, гурав дахь өдрөө алим нь боловсордог гэнээ. За, юу л болбол болог, хэдэн алим түүж авья» гэж бодоод гурван шуудай алтан алим түүж аваад цэцэрлэгээс гүйн гарав.

Морь туурайгаараа газар цавчлан, чихээ солбилзуулан:

- Хурдал, хурдал! Мөнхийн уснаасаа өөрөө уу, надад жаахан уулга, үлдсэнийг аваад явна гэв.

Иван шуудайтай алимаа эмээлээсээ уяд мөнхийн уснаас мориндоо уулгаж, өөрөө уув. Тэр үед газар ганхан чичэрч эрэлхэг Иван хөл дээрээ арайхийн тогтов.

- Түргэл! Мангас ойртоод ирлээ гэж морь нь хэлэхэд Иван эмээл дээрээ үсрэн мордов. Морь урагш харайж хашаан дээгүүр дүүлэн гарлаа.

Мангас ордондоо нөгөө талаас үсрэн орж ирээд:

- Хөөе, зарц. Морь ав! гэж хашгирав. Баахан хүлээтэл Иван алга.

Мангас ийш тийш хартал газар зоорины төмөр хаалга дэлгээстэй байв.

Мангас:

- Өө, муусайн адсагнууд, зугтаачихаж! Заавал гүйцнэ дээ! гэж хашгираад мориноосоо,

- Гүйцэж чадах уу? гэхэд морь нь:

- Гүйцэх ч гүйцэх байх, гэхдээ эзэн та бид хоёрын толгойд халтай аюул тулгарах вий! гэв. Мангас уурлан харааж:

- Өө муу, чонын хоол өвсний тулам чи, аюул гайгаар намайг айлгана гэнээ!

Мангас морио хондлойгий нь тас гуядан:

- Оргодолуудыг гүйц! Гүйцэхгүй бол үхтэл чинь ороолгоно! гэж хашгирав. Морь нь тэнгэрт тултал дүүлэн хашаан дээгүүр харайн гарав.

Ингээд мангас тэдний хойноос хуй салхи мэт нэхэн хөөв.

Иван өндөр уулыг өвөрлөн намхан газрыг нарлан давхиж явтал морь нь:

- Мангас тун ойрхон ирж явна. Самаа гарга. Мангас дөхөн ирж гал сумаар харвахад нь самаа ардаа шид гэжээ.

Удалгүй хашгирах исгэрэх чимээ, морин төвөргөөн сонсдон ойртов.

- Надаас хэн ч зугтаж чадаагүй юм. Тэр тусмаа та нар гараас минь гарахгүй! Амьдаар чинь шатаана! гэж мангас хашгирч гал сумаар харваж эхлэв.

Иван самаа шидэхэд тэр даруй мангасын замыг халхлан өтгөн ой бий болов гэнэ. Явган хүн явашгүй, морьтой хүн нэвтрэшгүй, араатан амьтан ч мөлхөшгүй, жигүүртэн шувуу ч нисэшгүй өтгөн ой ургаж гэнээ.

Мангас баруун тийшээ нэг гүйж, зүүн тийшээ нэг гүйж нэвтрэн гарч чадахгүйдээ уур нь буцалж шүдээ хавиран:

- Заавал гүйцнэ дээ, шидэт сүхээ аваад ирье гээд авч ирж ойн модыг цавчин унагаж, хожуул ёзоорыг холдуулан цэвэрлэв.

Унагаж цэвэрлэсээр уужим чөлөөнд гараад ирэв. Иваныг дахин нэхэн хөөж:

- Одоохон гарт минь ороод ирнээ, гайгүй! гэж орилов. Энэ үед Иваны морь дахин шилгээн:

- Иван, савангаа гарга. Мангас яг гүйцэж ирээд гал сумаараа харвахад нь савангаа ардаа шид гэв.

Морь ийн өгүүлмэгц газар шуугин салхи босож мангас:

- Шидэт самыг минь авчихжээ, гэхдээ мултарч чадахгүй дээ! гэж хараан зүхэх сонсдов. Гал сум мөндөр мэт бууж эхлэв.

Иваны хувцас долоон газар түлэгдэн цооров.

Иван савангаа шидтэл ард нь тэнгэрт тулсан чулуун уул тогтов. Мангас уулын цаана хоцров.

- Ай, шидэт савангий минь авчихаж! Одоо яах билээ? Тойрвол их цаг алдана. Чулуун уулыг хагалж, шууд явбал дээр.

Мангас ингээд гэртээ эргэж очин зээтүү, хамуур авчрав. Тэгээд чулуун уулыг цохиж цавчиж гарчээ. Асар их дуу чимээ гарч, чулууны хэлтэрхий зуун бээрт үсэрч, амьтан шувууд үхэтхийн унаж байжээ.

Мангас өдөржин чулуун уулыг хагалан зам гаргасаар шөнө нь нэвтэлж чаджээ. Дахиад л Иваны хойноос шинэ мөрөөр нь шинжилж, хуучин мөрөөр нь мөшгөн нэхэн хөөв.

Энэ үед Иван морио идүүлж, өөрөө ч амарч амжаад цааш явж байжээ. Мангас гурав дахь удаагаа тэднийг гүйцэх шахаж гал сумаараа харвахад Иваны хувцас хунар шатаж, өөрөө ч морь нь ч энд тэндээ түлэгдэж шархаджээ.

Морь нь:

- Иванушка, цаг бүү алд, алчуураа гарган шид гэжээ.

Иван алчуураа гарган шидтэл тэдний ард гал гол урсав гэнэ. Голд ус урссангүй, гал асаж, улаан дөл нь ой модноос өндөрт өрвөлзөж, эргэн тойронд шатам халуун болжээ. Иван мориныхоо хамт шатаж үхэхийн даваан дээр арайхийн зугтан холдов.

Мангас морио зогсоож амжилгүй хар эрчээрээ гал руу орчихов.

- Өө, бас алчуурыг минь авчихаж! За яах вэ, та нарыг! Нэг гараад авбал одоо ч та нарт намайг

саагуулах юм байхгүй! гээд морио хүчтэй гуядахад морь нь гал дээгүүр харайх гээд чадсангүй. Дөлөнд нүд нь сохрон, галд бие нь түлэгдлээ. Ингээд мангас морьтойгоо цуг галд унаж шатаж үхжээ.

Иваны морь амьсгаа даран зогсож хэлсэн нь:

- За Иванушка минь, мангасын гараас мултарч чадлаа, ард олныг ч мангасын аюулаас ангижрууллаа. Мангас морьтойгоо шатаж үхлээ!

Иван мориноосоо эмээл хазаарыг авч түлэгдсэн шарханд нь мөнхийн ус түрхжээ. Өвчин нь намдаж, шарх нь анив. Өөрөө амарч унтахаар хэвтэв. Гурван өдөр баатрын нойронд дарагдан нам унтжээ. Дөрөв дэхь өдрийн өглөө сэрээд орчин тойрноо нарийвчлан харснаа:

- Энэ дотно сайхан газар байна. Энэ л миний нутаг мөн гэжээ. Энэ үед морь нь давхин ирж:

- За Иванушка, амарч унтах чинь гүйцлээ, ажил явдлаа бод! Аз заяагаа эр. Харин намайг ногоон нугад бэлчээж орхи. Хэрэг болвол цэлгэр хөндий, цэнхэртэх талд гарч чангаас чанга исгэр, эрэлхэг баатрын дуугаар «Эрдэмт чун хүрэн морь минь, эрээн уулыг эрэлзтэл, эрэг газрыг жирэлзтэл давхиад ирээч!» гэж дууд, тэр даруй би ирнэ гэжээ.

Иван морио суллан тавиад «Одоо би хаачих вэ? Хүмүүст яаж үзэгдэх вэ? Хувцас хунар минь шатаж нүцгэн үлдсэн билээ» гэж дотроо бодов.

Бодож гайхаж байтал холгүйхэн хэдэн шар бэлчиж яваа харагдав гэнэ Нэгийнх нь эврээс шүүрэн авч газар цохин сэгсэрвээс шарын мах вандуй мэт өнхрөн унаж гарт нь арьс нь үлдэв.

«Яаж ийгээд нүцгэн биеэ далдлах хэрэгтэй!»

Шарын арьсаар биеэ ороогоод, хурдан болдог алтан алимаа үүрээд хандсан зүг рүүгээ явж гарав.

Явж явж нэгэн хотын их хаалганы дэргэд иржээ

Хаалганы дэргэд ардууд цугларчихсан, хааны элчийн үгийг сонсоцгоож байв

- Нэг өдөр цэцэрлэг суулгаж, хоёр дахь өдөр нь ургуулж, гурав дахь өдөр нь тэр цэцэрлэгт болсон алим бондойлгож чадах тийм цэцэрлэгчийг хаан эрж байгаа гэнэ. Хаана ч юм тийм алим ургадаг гэдгийг хаан сонссон гэнэ. Хэн хааны хүслийг биелүүлж, сэтгэлийг амраах вэ? гэнэ

Хааны элчид хэн ч хариу хэлсэнгүй. Бүгд л дув дуугүй. Иван «Азаа үзье!» гэж бодоод элч рүү ойртон очиж:

- Хэзээ ажиллаж эхлэх вэ? гэв.

Цөм гайхан харж, хаанаас ийм хачин хүн гараад ирэв гэж хачирхаж гэнэ. Шарын арьсаар биеэ ороосон, сүүлийг нь газраар чирсэн нэг хачин жигтэйхэн амьтан зогсоно.

Хааны элч дооглож

- Маргааш үд дунд хааны хашаанд очоорой. Чамайг цэцэрлэгийн мануухай болгоё. Нэг ч шувуу ойрхон нисэхгүй, нэг ч амьтан ойртож очихгүй амар гэжээ.

- Яаран шоолох хэрэггүй? Дараа нь амаа барих цаг чинь ирэх вий! гэж Иван хэлээд оджээ. Маргааш нь Иван хааны хашаанд ирвэл тэнд олон цэцэрлэгч цугласан байв.

Хаан довжоон дээрээ гарч ирэн:

Та нарын хэн нь миний сэтгэлийг амрааж, улсынхаа нэрийг мандуулах вэ? Гурван өдрийн дотор алтан алим ургуулах хүн байна уу? Ургуулж чадсан хунд хүссэн бүгдийг нь өгнө гэв.

Нэгэн өвгөн цэцэрлэгч хаанд бөхийн мэндлээд:

- Дөчин жил алим жимс ургуулахдаа ийм сонин юм сонссонгүй. Гурван өдрийн дотор цэцэрлэг суулгаж, цэцэглүүлж, болсон алимаа хураана гэдэг ухаанд багтахгүй байна. Харин гурван жилий хугацаа өгвөл хийж үзнэ гэв.

Өөр нэг цэцэрлэгч хоёр жилийн хугацаа гуйв, Гурав дахь нь нэг жилд чадна гэв. Зарим нь хагас жил хүрэлцээтэй гэнэ. Энэ үед Иван

- Би гурван Өдрийн дотор мод тарьж ургуулж, алтан алим болгож чадна гэв. Дахиад л цөм түүнийг гайхан хачирхан харцгаав.

Хаан Иванаас нүд салгалгүй ширтэн «Энэ хачин хүн хаанаас гараад ирэв?» гэж бодоод:

- Ам алдвал барьж болдоггүй гэдгийг мэднэ биз дээ. Гурван өдрийн дараа шинэ цэцэрлэгээс болсон алим авчирвал юу дуртайгаа хүс. Хэрвээ хуурвал өөртөө гомд, толгойг чинь авна гээд хажуудаа байсан ноёнд,

- Шинэ цэцэрлэгт зориулж газар зааж өг. Хэрэгтэй бүгдийг энэ хүнд өг гэжээ.

- Надад юу ч хэрэггүй. Хаана мод суулгахыг л заагаад өгөөрэй гэж Иван хариулав.

Маргааш орой нь Иван цэлгэр хөндий, цэнхэртэх талд гарч чангаас чанга исгэрч, эрэлхэг баатрын дуугаар:

- Эрдэмт чунхүрэн морь минь, эрээн уулыг эрэлзтэл, эрэг газрыг жирэлзтэл давхиад ирээч! гэж дуудав.

Мориных нь чихнээс утаа савсаж, хамрынх нь нүхнээс дөл бадарч, дэл нь салхинд хийсэн дэрвэнэ. Газар чичрүүлэн давхисаар ирж уясан мэт зогсов.

- Иванушка, юу хэрэгтэй болоо вэ?

- Би гурван өдрийн дотор цэцэрлэг тарьж ургуулан алим хураана гэж ам алдлаа.

- Өө, энэ амархан. Намайг унаад, туурайгаараа гишгэсэн нүх болгонд нэг нэг алим хийгээд бай.

Ингээд морь нь алхах тоолондоо туурайгаараа бөөн шороо ухан гаргасаар Иван тэр нүхнүүдэд алимаа хийсээр явав.

Бүх алимаа суулгаад Иван морио суллан тавьжээ. Тэгээд алим бүрийн нүхэнд мөнхийн ус цацжээ. Дараа нь мөрийн хоорондуур явж тарьсан алимаа шороогоор булж газрыг тэгшитгэн цэвэрлэв. Тэр даруйхнаа модод ургаж эхэлжээ. Төдөлгүй цэцэрлэг нэлдээ ногооров. Өглөө болоход модод хүний бүсэлхий хүрэх өндөр болов. Нөгөөдөр орой нь болоход бүүр өндөр ургаж цэцэглэжээ. Алимын модны сайхан амтат үнэр хотоор дүүрэн тарж хүмүүсийг баярлуулав!

Иван хоёр өдөр хоёр шөнө нүд анилгүй гар хумхилгүй цэцэрлэгээ усалж хамгаалжээ. Ингээд тун ч их ядарсан тул модны ёроол налан сууж зүүрмэглэн байснаа өвсөн дээр өнхрөн унаж унтаад өгчээ.

Хаан гурван охинтой юмсанжээ. Бага гүнж:

- Эгч нар минь, шинэ цэцэрлэгт очиж үзье. Өнөөдөр тэнд алимын мод цэцэглэсэн, явцгаая гэжээ.

Хоёр эгч нь за гэжээ.

Гурван гүнж цэцэрлэгт ортол алимын мод цэцэглэн цагаан хөөс бургилах мэт сайхан харагдана.

- Алимын мод цэцэглэчихэж, хараач, хараач!

- Хэн ингэж тариад, ийм хурдан ургуулчихаа вэ?

- Тэр хүнийг харах юмсан!

Гурван гүнж цэцэрлэгчийг эрээд эрээд олсонгүй. Дараа нь модны ёроолд нэгэн хүн хэвтэж байхыг харцгаав. Хүн гэтэл хүн биш, амьтан гэтэл амьтан биш. Хамгийн эгч гүнж ойртон харснаа хурдан эргэж:

- Аймаар амьтан хэвтэж байна. Эндээс холдье! гэжээ. Дунд гүнж хараад:

- Эгч дүүс минь, ийм муухай амьтныг харахаас дотор муухайрна! Энэ амьтан цэцэрлэг тарьж Ургуулчихлаа гэж үү?

- Заа, хаанаас даа, хачин юм бодох юм! гэж хамгийн эгч гүнж зэвүүцэв. Бага гүнж Наталья:

- Хол битгий яваарай. намайг хүлээж бай. Би нэг хараадхья! гээд модыг тойрон ойртон очив. Тэгээд шарын арьсыг аяархан сөхөж харвал сайхан залуу унтаж байна гэнэ. Тун ч сайхан,

сэтгэлд багташгүй, сэтгээд олшгүй, үзгээр бичишгүй, үлгэрийн баатар шиг сайхан залуу унтаж байхыг үзэв гэнэ. Гар нь тохойгоо хүртэл алт, хөл нь өвдгөө хүртэл мөнгө ажээ. Бага гүнж Наталья харж үл ханаж, зүрх нь зогсолтгүй догдолно. Тэгээд өөрийн нэртэй бөгжөө Иваны чигчий хуруунд зүүчихжээ.

Эгч нар нь

Наталья! Наталья! Гэртээ харьцгаая' гэж дуудав. Бага гүнж Наталья гүйн ирэхэд хоёр эгч нь угтан

- Яагаад тэнд удав, аймаар муухай амьтныг юугий нь хараа вэ? Яг л мануухай шиг юм! Ер нь тэр юу вэ? гэцгээв. Харин бага гүнж Наталья:

- Яагаад хүнийг доромжилно вэ? Та нарт муу юм юу хийсэн билээ? Ямар сайхан цэцэрлэг ургуулсныг хараач. Хаан эцгийг минь тайтгаруулж, хаант улсыг минь алдаршууллаа биш үү! гэж хариулжээ.

Хаан өглөө сэрээд цонхоороо харвал цэцэрлэг нэлдээ цэцэглэсэн байв Хаан баярлаж «Цэцэрлэгч хэлсэндээ хүрчээ, сайн байна! Зочиддоо үзүүлэн гайхуулах юмтай боллоо. Өнөөдөр харь газрын гурван хааны хүү, хүргэн болох гурван хүн ирнэ. Шадар ноёдоо ч найрандаа урья. Охид минь заяаныхаа ханийг сонгож аваг» гэж бодлоо.

Зочид орой нь ирцгээв Маргааш өдөр нь ихийн их найр өрнөж, идээлж ундаалж, наргиж цэнгэх болно.

Иван унтаж унтаж сэрээд чигчий хуруунд нь шигтгээт алтан бөгж байхыг үзэв. «Юун бөгж вэ?» гэж гайхав.

Хуруунаасаа мултлан үзвэл бөгжин дээр бага гүнжийн нэр байна гэнэ.

«Нэг удаа ч болов харахсан, ямар сайхан гүнж бол?» гэж Иван бодов.

Алтан алим боловсорч нарны гэрэлд цэцэрлэг нэлдээ алтан шаргал өнгөөр тунарна. Иван хамгийн болсноос нь сагс дүүргэн ордонд авчрав. Босгоор алхаж ормогц алимын амтат үнэр сэнхийж, ноёд зочид цэцэрлэгт байгаа мэт болжээ.

Сагстай алимыг хаанд өргөв. Цөм алимыг нүд салгалгүй ширтэнэ. Хаан яах ухаанаа олохгүй алимыг барьж тавин дуугүй суув. Тэгснээ сэхээ орж:

- Сэтгэлийг минь тайтгаруулсан. чамд гялайлаа! Ийм алим энэ дэлхийн өөр хаанаас ч олдохгүй. Гурван өдрийн дотор алтан алим тарьж ургуулж чадсан чамайг ордны тэргүүн цэцэрлэгч болгосугай! гэв.

Хаан Иванд ийнхүү хэлэх зуур гурван гүнж зочиддоо дарс барьж нөхөр болох хүнээ шилж авах болов.

Хамгийн эгч болон дунд гүнж нар хаан хөвгүүдийг сонгон авцгаав. Бага гүнж зочиддоо дарс

барьж ширээг нэг тойров, хоёр тойров, хэнийг ч шилж авсангүй. Гурав дахь удаагаа тойрохдоо Иваны өмнө зогсож, эрэлхэг залууд мэхийн ёслоод:

- Сэтгэлд таарсан залуу минь, хувь заяаны минь эзэн бол! гээд цомтой дарсаа барьжээ. Иван цомыг авч гүнжийг эгцлэн харваас үзээд үзээд ханашгүй үзэсгэлэнтэй сайхан ажээ!

Баярлахдаа юу хэлэхээ мэдэхгүй зогсоно.

Найрын олон бага гүнжийн үгийг сонсоод ууж идэхээ орхин Иваныг нэг харж, бага гүнжийг нэг харж гайхан үг дуугүй сууцгаана.

Хаан суудлаасаа үсрэн босож:

- Эй, бүү үзэгд! гэхэд Иван:

- Эзэн хаантан минь, та бид тохиролцсон биш билүү. Гурван өдрийн дотор алтан алим ургуулж чадахгүй бол миний толгойг авах, хэрвээ чадвал хүссэн бүгдийг минь өгнө гэж та айлдсан ажгуу. Алтан алим ургуулж танд авчирлаа, зөвхөн ганц л юм гуйя. Бага гүнж Натальяг миний эхнэр болгон өгөөч!

Хаан гараа савчин, хөлөө дэвслэн:

- Аах, барлаг чи, өмсөх хувцасгүй, өгүүлэх нэргүй гөлөг! Ийм үг хэлж яаж зүрхэлнэ вэ! гэхэд гүнж эцэг эхдээ мэхийн:

- Эрэлхэг залууг би өөрөө сонгож авсан. Өөр хүний эхнэр болохгүй гэвээс хаан бүр уурлан дэвэрч:

- Хайртай охин минь байлаа чи, харин одоо ийм тэнэг үг хэлж байгаа бол охин минь биш, би чамайг мэдэхгүй чи намайг танихгүй явья! Энэ өрөвгөр барлагтайгаа дуртай зүг рүүгээ миний ордноос зайл. Нүдэнд минь дахин бүү үзэгд!

Хатан нулимсаа цувруулан:

- Алдар нэрийг минь гутааж, алд биеийг минь зовоолоо! Бузар энэ явдлаас болж булшинд ч тайван хэвтэхгүй нь!

Хатан ийнхүү уйлж гуншин байснаа:

- Хаантан минь, уур хилэнгээ орхи! Тэнэг ч гэсэн охин чинь билээ. Орон улсаасаа битгий хөө. Хаа нэгэн газар заагаад өг, тэндээ амьдраг. Ордонд орж ирэх эрхгүй байг, гэхдээ охин амьд эсэхийг мэдэж дуулж сууцгаая! гэжээ.

Хаан хатныхаа нулимсанд зөөлөрч:

- Манай дархан ойд хуучин модон байшинд сууцгаа! Нийслэл хотод үзэгдэх эрхгүй шүү! гэв.



Хаан ийнхүү бага гүнж Наталья Иван хоёрыг хөөж, хамгийн том охин дунд охин хоёроо ёс төртэй гэрлүүлжээ. Хурим найр хийж тараад ахмад хоёр хүргэндээ улсынхаа тэн хагасыг өгөх зарлиг буулгажээ.

Харь газрын хаан хөвгүүд хатангуудтайгаа хааны ордонд сууж, найр хурим, баяр цэнгэлд умбаж, баян тансаг амьдрах боллоо.

Иван ойн жижигхэн байшинг засаж шинэтгээд хэсэг газрын мод унагаж цэвэрлээд тариа тарьжээ. Ингээд залуу эхнэрийнхээ хамт өөрийн чадал тэнхээгээр амьдарч, нийслэл хотод үзэгдэхгүй байв.

Тийнхүү хэсэг хугацаа өнгөрөхөд хаант улсыг гэнэт их гай дайрлаа.

- Улсын эзэн-хаантан минь, үй түмэн цэрэгтэй харийн хаан улсын хилийг нэвтрэн орж ирлээ! Гурван хот дүүрэг, суурин гацаа олноороо үнсэн товрог боллоо. Хилийн цэрэг биднийг хэмх цохин устгалаа гэж элчийн мэдээлэхэд хаан суугаа чигээрээ хөшиж, хөөрөгдүүлсэн мэт өндөлзөвч хөл дээрээ гишгэн босож чадахгүй тэвджээ. Тэгээд сэхээ орж:

- Титэм аваад аль, хүргэнүүд, шадар ноёдыг дууд! гэж тушаав. Хүргэнүүд, шадар ноёд ирж мэхийн ёслол. Хаан титмээ засан:

- Хаан Гвидон үй түмэн цэргээрээ манайхыг дайрахаар орж ирлээ. Ард олныг цуглуулж атаатан дайсныг сөрөн устга.

Хоёр хүргэн-хаан хөвгүүд бардан байдлаар:

- Улсын эзэн-хаантан минь, сэтгэлийг бүү зовоо, бид таныг хамгаална! Гвидоны цэргийг хиар цохин, Гвидоныг өөрийг нь дөнгөлөн авчирна гэж амлав.

Хороо хороогоор цэргээ цуглуулан аян дайнд мордоцгоов.

Хаан зургаан шилдэг морь хөллөсөн сүйх тэргэнд суун цэргийнхээ араас хөдлөв.

- Залгамжлагчид минь дайн тулалдаанд ямар болохыг алсаас ч болов харья гэж шийджээ. Хааны сүйх өндөр довцог дээр зогсож тэндээс дурандваас довтлон дайрагчдын цэрэг ярайн харагдахад хааны зүрх палхийв. Гвидоны цэргийн зах нь үл харагдан, шонхор шувуу гурван өдөр нисээд ч тойршгүй их үзэгдэнэ. Хаашаа л харвал Гвидоны дайчид талыг бүрхэн харанхуйлна.

Атаатны нэгэн баатар нисэх мэт давхин «Надтай хүч үзэлцэн халз тулалдах баатар байна уу?» гэж дуудан хааны цэргүүдийг доог тохуу хийж байв.

Хааны цэргээс хэн ч хариу хэлсэнгүй. Хоёр хүргэн-хаан хөвгүүд шадар ноёдын араар нуугдан, ноёд тайжууд ухран ухарсаар хороо цэргээ сул орхин ой мод руу зугтан оджээ.

Энэ үед хааны цэрэг аян дайнд мордсон мэдээ Иванд иржээ. Иван цэлгэр хөндий, цэнхэртэх талд гарч чангаас чанга исгэрч, эрэлхэг баатрын дуугаар:

- Эрдэмт чун хүрэн морь минь, эрээн уулыг эрэлзтэл, эрэг газрыг жирэлзтэл давхиад ирээч! гэж дуудав.

Тэр дорхноо морь нь баатрын хуяг дуулгыг нь тохон давхиад иржээ.

Мориных нь амнаас гал бадарч, чихнээс нь утаа савсаж, хамрынх нь нүхнээс оч үсэрнэ. Гурван алд сүүл нь сугсалзаж, хур дэл нь туурайгаа шүргэн намирна. Иван морио эмээллэв. Эхлээд тохмоо тавьж тохом дээрээ зузаалга тавьж, түүний дээр эмээлээ тохож мяндсан олмоо чавхартал татаж алтан аралд нь дэгээдэв. Бардамнан гоёх гэсэндээ бус баг бөх гэж ийнхүү бөхөлжээ.

Мяндас үл тасарна, болд үл шантарна, шижир алт үл зэвэрнэ.

Иван өөрөө баатрын хуяг дуулгаа өмсөж эмээл дээрээ үсрэн мордоод чун хүрэн мориныхоо хангал ташааг шавхартал хурдлан давхихад гайхамшигт хүлэг нь ган дөрвөн туурайгаараа газрын хөрсийг онгилж, гишгэсэн газраас нь булаг ундарч байв гэнэ.

Гвидоны цэргийн зүг Иван шонхор шиг нисэн очиж харь газрын хүчирхэг баатрыг харав. Иван дун бүрээ дуугарах мэт чанга хашгирахад ургаа мод ганхаж газар шүргэн бөхөлзөв.

Харийн баатар ханхалзан:

- Халз тулалдах хүн газрын хаанаас олоов! Хоёр алганыхаа хооронд бяц дарна, хог новш, ус болоод л үлдэнэ шүү! гэв.

Иван хариу хэлсэнгүй. Зуун пүү шийдмээ барин бардамнагч баатрын өөдөөс давхив.

Уул мөргөлдөх мэт сүртэй учир Иван дайснаа эмээл дээрээс нь ховх цохин унагав. Тэр баатар нойтон газар унаад эргэж боссонгүй.

Баатрынхаа үхэтхийн унахыг харсан дайсны цэргүүд сүнс нь зайлан зугтан одоцгоов.

Хүргэн-хаан хөвгүүд, ноёд тайж бут модны араас гарч сэлмээ гялалзуулан цэргүүдээ уриалан зугтаагчдыг элдэн хөөв. Иван мориныхоо жолоог эргүүлэн шонхор шувуу нисэх мэт хурдлан давхив. Хэн ч түүнийг таньсангүй. Хааны хажуугаар давхин өнгөрөхөд хаан, баатар эрийн гар нь тохойгоо хүртэл алт, хөл нь өвдгөө хүртэл мөнгөн юм гэдгийг л харжээ.

Хаан:

- Эрэлхэг баатар эр минь, аль хотын, хэний хүү вэ? Алдар нэр хэн бэ? Хэн чамайг илгээсэн бэ? гэж хашгирахад Иван хариу хэлсэнгүй далдрав. Цэлгэр хөндийд очоод мориныхоо эмээл хазаарыг авч суллан тавив. Баатрынхаа хуяг дуулгыг ч тайлав. Бүгдийг хурааж янзлаад, шарынхаа арьсаар биеэ ороож гэртээ орон шууд л пийшин дээрээ гараад унтаад өгчээ.

Хоёр өдөр өнгөрөв үү, хүргэн-хаан хөвгүүд цэргүүдийнхээ хамт буцаж иржээ. Ордонд дайснаа дарсан дархан цолоо олсны их баяр хийж өргөн найр өрнөв.

- Хааны бага гүнж, хайрт Наталья минь, ээж аавдаа очиж цом архи, даруулах өөхтэй авчирч өгнө үү гэж Иван эхнэрээ ордон руу явуулжээ.

Бага гүнж Наталья ордонд уригдаагүй зочин залагдаагүй гийчин болон очив. Эцэг эхдээ мэхийн золгож ирсэн зочидтой хүндэтгэн мэндлэв.

- Иванд минь цом архи, даруулах өөхтэй хүргүүлнэ үү? гэвээс хаан эцэг нь:

- Гар хөдлөхгүй бол ам хөдлөхгүй. Чиний нөхөр Дайнд мордоогүй. Дулаахан пийшин дээрээ дуниарч хэвтсэн атлаа найрлах дуртай! гэж уурлахад хатан эх нь:

- Хаантан минь, ийм баярыг бодож уур хилэнгээ тайтгаруул! гэж гуйжээ.

- Тааллаар болгоё. Зочдоос үлдсэн юмыг Иванд явуулья гэжээ. Бага гүнж Наталья гомдон:

- Ахмад хүргэнүүд ууж идэж наргиг дээ. Тэд дайнд мордоод Гвидоны цэргийг бутны араас харж байсан гэж дуулсан. Гэтэл Иван бид хоёр тавагны ёроол долоох нь зүйн хэрэг үү! гээд буцаад явчихжээ.

Хаан зочдынхоо хамт найрлаж дуусаагүй байтал элч давхин ирж:

- Эзэн хаантан минь! Гвидон цэргийнхээ хамт дахин улсын хилийг нэвтрэн орж ирлээ. Тэдэнтэй цуг алагдсан баатрын ах ирж явна. Тэр баатар «Дүүгийн минь алсан эрийг авчрахгүй бол амьд хүн үлдээхгүй улс гүрнийг чинь түйвээнэ» гэж шаардаж байна.

Хаан энэ үгийг дуулмагц идсэн хоолоо ч залгиж чадахгүй хөл гар нь чичрэв. Согтсон хүргэн-хаан хөвгүүд бардамнан:

- Тэнгэр эцэг минь, тэвдэж сандарсан цагт чинь үнэнч түшиг болсон бидэнд найд! гэж хашгирцгаав.

Тэгээд цэрэг ардаа цуглуулан, морьдоо эмээллэн аян дайнд мордоцгоов. Хаан айн чичирч, ёолон хэвтэнэ.

Хааны цэргүүд атаатан дайсантай улаан халз тулалдав. Гвидоны баатар дийлдэшгүй их хүчээр дайрч, цуст тулалдаан өрнөв.

Хааны цэргүүд харийн дайсантай хүч сорин, нэг нь аравтай, хоёр нь мянгатай сөрөн тэмцэлдэв. Хааны хоёр хүргэн дайсны эрэлхэг баатар, тоо томшгүй олон цэргийг хармагцаа сүр сүлд нь бугаад өгөв. Хоёр хүргэн ноёд тайжийн араар орж, ноёд тайж өвс бутны цаагуур нуугдан зугтсаар ухрав.

Энэ үед Иван цэлгэр хөндий, цэнхэртэх талд гарч чангаас чанга исгэрч, эрэлхэг баатрын дуугаар:

- Эрдэмт чун хүрэн морь минь, эрээн уулыг эрэлзтэл, эрэг газрыг жирэлзтэл давхиад ирээч! гэж дуудав.

Энэ дуудлагаар нь үнэнч морь нь газар доргион давхин ирэв. Мориных нь амнаас гал бадарч, хамрынх нь нүхнээс оч үсчин, чихнээс нь утаа савсана гэнэ.

Иван морио барьж эмээллээд баатрын хуяг дуулгаа өмсөв. Тэгээд мордон тулалдааны талбар луу давхив. Гвидоны цэргийг дайран орж өвс хадах мэт ханаруулан цохиход нь явсан газар нь зам гарч эргэсэн газар нь эрэг гарч байжээ.

Эрэлхэг Иваныг амьдаар залгихад бэлхэн Гвидоны баатар эмээл дээрээ уул мэт дүнхийж Иваныг чиглэн ирэв.

Шагайж шагайж шидсэн жад нь хэн хэнээ гэмтээсэнгүй хуга хуга үсрэв. Хоёр морь нь цээж тулан зогсоход хоёр баатар хурц сэлмээ шүүрэн авцгаав. Харийн баатрыг Иван хага цавчин хоёр хуваахад баатрын бие эмээл дээрээсээ багласан өвс шиг өнхрөөд өгөв.

Үүнийг харсан Гвидоны цэргүүд зүрхээ хагартал айцгааж жад сэлмээ хаяад жалга бутаар тарцгаав. Манай хааны цэргүүд хүч орон сэргэж үлдсэн дайсныг үлдэн хөөв.

- Одоо надгүйгээр дайснаа дийлнэ! гээд Иван мориныхоо амыг эргүүлэв.

Өөдөөс нь хааны ахмад хоёр хүргэн шадар ноёдын хамт өнөр олон цэргээ гүйцэх гэж давхиж явав. Сэлмээ даллан «урай» хашгирч эрэлхэг Иваны хажуугаар харалгүй өнгөрөв.

Иван цэлгэр хөндийд очин морио суллан тавьж баатрынхаа хуяг дуулгаа тайлав. Тэгээд шарын арьсаар биеэ ороогоод гэртээ орон пийшин дээрээ гараад амарч хэвтэв гэнэ.

Бага гүнж Наталья энэхэн мөчид гүйн ирж.

- Иван, манай цэргүүд дайснаа даран байлдаж явахад хаашаа нуугдан дахин алга болов оо!

Иван юу ч хариулсангүй. Бага гүнж Наталья уйлан:

- Хүний нүүр харахаас ч ичих юм! гэв. Дараа өдөр нь ялан дийлсэн цэргүүд нийслэл хотдоо буцаж ирцгээв. Ард олон баяр хөөр болон угтав. Хоёр хүргэн нь хаанд яаж Гвидоны цэргийг цохин дийлснээ хөөрлөнө.

Хаан цэргийн жанжнуудаа гар таталгүй шагнав. Архи дарстай торх авчирч, дайнд тулаанд явсан цэргүүдийг дайлж, их буугаар буудаж, хонх дэлдэхийг тушаав.

Энэ нутагт ийнхүү ялалтын баяр хийж байхад алагдсан хоёр баатрын ах Росланей, хаан Гвидоныг гурав дахь удаагаа аян дайнд мордьё гэж зөвшөөрүүлээд өөрийн хороо цэргээ жагсаажээ.

Гвидон урьдахаасаа их цэрэг цуглуулж, хадам эцэг Салтаныгаа ч аян дайнд босгожээ. Цэрэг нь түм бум болов.

Гвидоны цэргүүд дуу дуулан, хэнгэрэг дэлдэн сүр бараатай хөдлөв. Их цэргийн урд сарацины морьтон, түүний ард Гвидоны улсын хамгийн хүчирхэг, хамгийн эрэлхэг баатар Росланей

явна.

Хилийн цэргийг нь бут цохин, захын хотуудыг нь эзлэн аваад хаанд бичиг бичжээ. «Манай эрэлхэг хоёр баатрыг ялсан морьтноо бидэнд өг, зуун жилийн алба урьдаас төл, эс биелүүлбээс гүрэн улсыг чинь түйвээн сүйтгэж чамаар үнээ хариулуулна» гэжээ.

Хаан бичгийг уншаад царай нь хувхайран чичирч хоёр хүргэн, шадар ноёдоо дуудуулав.

- Одоо яах билээ? Их хүргэн:

- Гвидоны баатруудыг хэн алсныг мэдсэн бол уу, олноороо байлдаж зовсноос нэгийг өгсөн дээр гэв.

Дунд хүргэн:

- Дахин байлдсанаас алтыг төлсөн дээр. Хэд л хэрэгтэй бол төчнөөнийг худалдаачин урчууд, тариачин эрчүүдээс цуглуулъя. Хааны хөрөнгөнд гар хүрэхгүй байж болно шүү дээ!

Ингээд зөвлөлдөж тохиров. Гвидон, Салтан хаадад бичиг явуулав. «Газар нутгийг минь бүү түйвээ. Албыг төлье. Хоёр баатрыг алсан хүнийг ч олж явуулъя. Гурван сарын хугацаа хайрлагтун» гэжээ.

Гвидон Салтан нар «Гурван долоо хоног» гэж тогтоожээ.

Хоёр хүргэн, шадар ноёд, тайж бүгд л яаран мэгдэн улс гүрнийхээ хот тосгодоор элч илгээв.

- Худалдаачин, урчууд, тариачин эрсээс алт мөнгө хурааж цуглуул! Гвидоныг гомдоогчийг эрцгээ!

Хаан гэнэт санаж:

- Тохойгоо хүртэл алтан гартай, өвдгөө хүртэл мөнгөн хөлтэй шүү, сайн хараарай. Миний нэрийн өмнөөс гавлан гинжилж авчир! гэв.

Бага гүнж Наталья энэ зарлигийг сонсоод «Баатрыг ялсан хүн миний нөхөр мөн! Тулалдааны үед гэртээ байхгүй байсан нь ийм учиртай аж» гэж таамаглан мэдээд сэтгэл нь сэргэж баярлав.

Тэгснээ эрж олоод гинжилж авчир гэснийг санан зовонгуйрлав. Гэртээ гүйн ирж, нөхрөө тэврэн авч:

- Иванушка, тэнэг эм намайг уучлаарай! Чамайг дэмий гомдоожээ. Хоёр баатрыг чи дийлсэн гэдгийг би мэдэж байна гээд нөхөртөө хааны зарлигийн тухай ярьж,

- Сайн нуугд, хааны элч нар үүгээр битгий ирээсэй гэжээ.

- Бүү уйл, бүү гашууд, эхнэр минь. Хааны элчээс би айхгүй. Одоо хамгийн эхлээд Гвидон

Салтан хоёрыг дарах хэрэгтэй. Эх нутгийг минь дайрч алба гувчуур авах гэдэг юу болохыг тэдний ухаанд нь шингэтэл, удамд нь үлдтэл харуулъя гээд Иван залуу эхнэртэйгээ салах ёс хийгээд цэлгэр хөндий, цэнхэртэх талд очив.

Чангаас чанга исгэрч, эрэлхэг баатрын дуугаар:

- Эрдэмт чун хүрэн морь минь, эрээн уулыг эрэлзтэл, эрэг газрыг жирэлзтэл давхиад ирээч! гэв.

Морь нь давхин ирж:

- Иванушка, өнөөдөр халуун тулалдаан болж чи бид хоёрын бүлээн цус асгарах чигтэй! гэхэд Иван:

- Алба гувчуур төлж, алхах газаргүй амьдарснаас үхлийн хор уусан дээр! гэж хариулав. Тэгээд морио эмээллэн, баатрынхаа хуяг дуулгыг өмсөөд хот тосгоноор явж:

- Алдар нэрээ хамгаалах ардуудаа! Эхнэр хүүхэд, эцэг эхийнхээ төлөө эцсийнхээ цусыг шавхартал үзэлцье! Эх сайхан нутгаа эзэрхэг Гвидон Салтан хоёроос хамгаалъя! гэж зарлан дуулав.

Иваны дуудлагад худалдаачин урчууд, тариачин эрчүүд хошуу хошуугаараа цуглав.

Иван гурван өдөр цэрэг цуглуулж, дөрөв дэх өдрөө цэргээ хороо хороогоор хувааж, тав дахь өдөр дайсны өөдөөс явжээ.

Хол ойрын хот хошуу бүрээс эрчүүд ирж, цэрэг нь нэг захаасаа нөгөө зах нь харагдахгүй их болов! Иваны цэргүүд харийн дайснуудтай нүүрлэн тулав. Сарацины морьтон эгнээнээсээ гарч ирэн:

- Ээ, гувчуур төлөхийн оронд эр цэргээ явуулжээ! Цэргийг бут цохин алба гувчуур авахдаа л авна! гэж хашгирахад Иван бардамнагчийг жадлав. Сарацины морьтон хадагдсан өвс шиг налан унахад Иван:

- Инээд аваарай, өлөн бар! гэв.

Энэ үед атаатны дундаас хамгийн хүчирхэг баатар Росланей дүүлэн гарч ирэв. Хангайн чинээ биетэй, хавцлын чинээ амтай морин дээрээ уулын чинээ баатар урагш хойш хөндөлдөн сууна гэнэ. Мориных нь туурай хүрсэн газар нуур тогтоно гэнэ.

- Надтай халз үзэх зоригтон байна уу? гэж дуудав. Иван өөдөөс нь очиход харийн баатар хөхрөн:

- Халз үзэх зоригтон гэж үү! Хатан зоригт баатартай хүч үзэлцэхийн оронд хатан ээжийнхээ хөхийг хөхөж хэвтэхгүй яагаав? гэхэд Иван:

- Атаатан чи, арай эрт баярлахаа боль, бардамнахаа тат! Чамайг эхлээд оршуулна!

гэж хашгирав.

Ингээд хоёр баатар арван хоёр мод газар ухарч ухарч дайралцах нь аянгат үүлс мөргөлдөх мэт, асгат уулс харшилдах мэт. Зуун пүү шийдмээрээ цохилцоход барьсан шийдэм нь тахийснаас төрсөн биес нь гэмтсэнгүй гэнэ.

Хоёр дахь удаагаа ухарч ухарч дайралцахдаа шагайж шагайж шидсэн жад нь хугарснаас шарх сорви олсонгүй гэнэ. Гурав дахь удаагаа ухарч ухарч дайралцахдаа хурц сэлмээ өргөцгөөв.

Иваны морь:

- Бөхий, байдгаараа бөхий! гэж хэлээд толгойгоо тонгойлгомгоц Росланей сэлмээ буулгав. Росланейн сэлэм шунгинан Ивановы зүүн гарыг шархдуулж, мориных нь чихийг сэт цохив.

Иван өндийн Росланейн сэлмийг цохин унагав.

Баатруудын хоёр морь цээж тулан мөргөлдөхөд Иван Росланей хоёр ч барилцаж авлаа. Хоёр баатар уулыг тал болтол, талыг там болтол, үдийн халуунаас үдшийн бүрий болтол ноцолдов. Росланей Ивановыг өвдгийг нь далдартал газарт дарав. Ивановы шарх янгинаж хүч нь суларч эхлэв. Иван Росланей баатрыг далайх хооронд сэхээ авч:

- Ард чинь, ард чинь! гэж хашгирч амжив.

Росланей тэсгэлгүй эргэн харахад Иван бүх хүчээ шавхан ганхаж унатал нь цохиод хором ч хүлээлгүй болд хутгаа сугалан авч дайснаа газарт цоо хатгав.

Энэ хооронд Ивановы морь Росланейн морийг унаган даржээ. Эрэлхэг баатар Иван эрдэмт чун хүрэн морь хоёул энэ тулалдаанд хүчийг ихэд баржээ.

Энэ үед Ивановы цэргүүд дайсны цэргийг дайран орж үлдэн хөөж байлаа. Эрэлхэг баатар Иван эрдэмт чун хүрэн морьтойгоо хоёул амрах зав эрэлхийлгүй тэр даруйхнаа тулалдааны талбар луу давхив. Үдшийн бүрийгээс үүрийн туяа гийтэл байлдав. Өглөө гэхэд Гвидоны болон сарацины цэргүүдийн хүүр талыг харалтал бүрхжээ. Салтан Гвидон хоёр үлдсэн хэдэн цэргээ аван айж зугтаасныг Иван цэргүүдийнхээ хамт шил даран хөөсөөр баривлан авчээ.

- Алба гувчуур авах гэж дайн тулаан дахин дэгдээх үү? гэж Иван асуухад Салтан Гвидон хоёр:

- Эрэлхэг хүчит баатар минь, ар гэрт минь амьд мэнд буцаа. Бид дахин аян дайн дэгдээж, хил давуулан хар хөлөө тавихгүйгээр үл барам үр хүүхэд, ач гучдаа танай улстай өнөд энхээр оршин тогтнож, үүрд алба гувчуур төлж байхыг захин үлдээнэ! гэж гуйв.

- Хэлсэн үгээ зөрчвөл гүрэн улс чинь үнс болж ор үндэсгүй устана гэж мэдээрэй!

Ингээд Иван тэднийг дуртай зүг рүү нь суллан тавиад өөрийнхөө цэргийг цуглуулан эргэх замдаа оров.

Энэ зуур худалдаачин урчууд, тариачин эрчүүд Гвидон, Салтаны цэргүүдийг бут цохин хөөж,

хүчирхэг баатар Росланейг ялсан тухай мэдээ хааны сонорт хүрчээ.

Хаан хоёр хүргэн, шадар ноёд, тайж нараа дуудан:

- Манай ардууд Гвидон, Салтаны цэргүүдийг хиар цохин устгажээ. Тохойгоо хүртэл алтан гартай, өвдгөө хүртэл мөнгөн хөлтэй тэр эрэлхэг эр цэргийг манлайлжээ. Энэ эрэлхэг эр худалдаачин урчууд, тариачин эрчүүдийг цуглуулан өөрийн дураар аян дайнд мордож атаатан дайсныг ялж хаан миний болон хамгийн дотно ноёд тайж та нарын нэр хүндийг гишгэн гутаалаа.

Эзэн төрийг үл тоон, эрх дураар авирлагчийг яах вэ? гэж асуув.

Дараах жилүүдэд давтагдуулахгүйн тулд эзэн хааны нэрийн өмнөөс эрх дураар авирлагчийг цаазлагтун! гэж ноёд тайж хашгиралдав.

Гэтэл нэгэн хөгшин ноён босож, хааныг хүндлэн мэхийгээд:

- Хаантан минь, хэлэх үгийг минь сонсоно уу, хэрэв таалахгүй бол өвгөн миний толгойг бүү аваарай!

- За, бодол саналаа хэл хэл! гэж хаан тушаав.

- Худалдаачин урчууд, тариачин эрчүүд хүчээ нэгтгэн хүслээ нийлүүлэн, мөр мөрөө зэрэгцүүлэн, зэр зэвсгээ эргэцүүлэн байгаа цагт үнэн санаагаа үзүүлээд хэрэггүй. Тэднийг уриалагхан угтаж, урамшуулан магтаж, архи дарс уулгаж, алт мөнгөөр шагнах хэрэгтэй. Идэж ууж хөөрч аваад ийш тийш таран одохын цагт нэг нэгээр нь барьж авах нь нэн амар болой. Тэгээд л хааны үгийг үл сонсогчийн гарыг гавлаж хөлийг дөнгөлж авъя. Тэр цагт эзэн хаан та түүнийг дураараа шийтгэгтүн! гэжээ.

Хөгшин ноёны энэ санаа хааны сэтгэлд тун ч тохиров.

Энэ үед Иван цэргүүдээсээ тасран цэлгэр хөндий, цэнхэртэх талд очин мориныхоо эмээл хазаарыг аван:

- Эрдэмт чун хүрэн морь минь, чамд гялайлаа! Үнэнч энэ ачийг чинь үүрд санах болно. Морь нь:

- Иван минь, хааны хайр хишиг, ноёдын зөөлөн үгнээс хамгийн их болгоомжил. Гэхдээ одоо чи миний хүслийг биелүүлбэл хэтийн аюулаас би чамайг аварна гэв.

- Шударга сайхан морь минь, юу хүссэнийг чинь биелүүлнэ! гэж Иван хэлэхэд морь нь:

- Хэлсэн үгнээсээ буцахгүй биз!

- Үгүй, үгүй буцахгүй, үнэн хүслээ хэл.

- Иван, хурц сэлмээрээ толгойг минь тас цавч гэж морь нь гуйв.



- Ээх, юугаа ярина вэ! Шударга сайхан мориныхоо толгойг өөрөө тас цавчина гэдэг зүйн хэрэг гэж үү! Өөр юу л бол хүс, зөвхөн ийм юм битгий ярь. Ийм хэрэгт гар минь сэлмээ үл даана.

Морь нь толгой ганзагалан:

- Ингээд би, энэ насаараа гай зовлонгоос салахгүй нь ээ гээд уйлан, гашуун нулимсаа бөмбөрүүллээ гэнээ.

Иван хайрт хань болсон морио харан сандран зогсоно.

- Бүү ай! Толгойг минь тас цавч, тэгээд юу болохыг үзээрэй гэж морь нь дахин дахин гуйв. Иван бодож бодож, сэлмээ аван мориныхоо толгойг тас цавчив.

Гэнэт өмнө нь мориных нь оронд нэгэн эрэлхэг сайхан залуу ургах мэт гарч ирээд:

- Иванушка, чи хүслийг минь биелүүлж, намайг илбийн хүлээснээс гаргаж өглөө! Үгийг минь сонсоогүй бол би морь хэвээр үүрд үлдэх байлаа.

Алдар нэр минь Василий, энэ нутгийн хүн, тариачны хүү. Хүч чадал ихтэй байлаа. Хааны нэгэн түшмэл эцэг эхийг минь гомдооход би түүнийг халз тулалдаанд дуудан дийлсэн юм. Хаан надад хилэгнэн уурлаж, унтаж байхад минь хөл гарыг минь гинжлэн, араатан махчны идэш болгохоор аглаг хар ойд хаясан билээ.

Энэ үед мангас миний хажуугаар явж өнгөрөхдөө намайг ордондоо аваачсан юм. Мангасын гар хөл болон ажиллахаасаа дургүйцэхэд мангас намайг морь болгон хувиргаж, өлсгөж тарчилгаж байлаа. Тэгтэл чи намайг аварсан билээ.

Чи бид хоёр мангас өвгөнөөс цуг зугтсан, гүрэн улсынхаа төлөө харийн дайсны өөдөөс харвах сум шиг орж халуун цусаа хамт урсгасан билээ.

Өөрөөс чинь өөр хэн ч намайг мангасын гараас салгаж чадахгүй байсан! Морь нь эрэлхэг залуу болж хувирсныг Иван итгэж ядан харан зогсоно. Тариачны хүү Василий Иванд бөхийн:

- Хуурай ах минь болооч! гэв.

Иван баярлан дүүгээ зүрхэндээ наалдуулан тэврэв. Тэгээд хоёул цэргийнхээ араас явлаа.

Дайснаа дарсан цэргүүд төв хот руу орж ирэхэд хаан их буугаар буудаж, хэнгэрэг дэлдэхийг тушааж өөрөө шадар ноёдынхоо хамт угтан гарч ирлээ.

- Дайснаа дарсан эрэлхэг эрчүүдээ, та нартаа гялайлаа! Үл мартагдах их гавьяа байгууллаа! Хүн бүрийг шагнаана! Одоо амарч цэнгэцгээ! Архи дарс, амтат идээ цөмд хүрэлцээтэй! гэж хаан өгүүлэв.

Иван тариачны хүү Василий хоёул урагш гарч:

- Ихийг амлаж, эелдэгхэн аашилснаар гэмийг дарж чадахгүй. Эрхэм хаан та шадар ноёдынхоо хамт Гвидон Салтан хоёрт эх орон, ард түмнээ боолын боол, босгоны шороо болгохоор өгөх гэж зөвшөөрснөө санаж буй биз дээ? Одоо эх орноосоо урвасныхаа горьг хүртэх болж дээ.

Хаан, шадар ноёд цөм үхсэн амьдын хооронд өвдөг чичрэн зогсоцгооход тариачны хүү Василий бэлэвсэн эхнэрийн хүү Иван хоёр тэдэнд:

- Эх нутгаас минь дуртай зүг рүүгээ тонилцгоо, энд та нарын бараа ч бүү үзэгдэг! гэв. Цэргүүд:

- Амийг хорлох хорт өвсийг шатаах мэт устгая гэж хашгиран дайрахад хаан, шадар ноёд хандсан зүг рүү зугтаан одоцгоов.

Ингээд бэлэвсэн эхнэрийн хүү Иван өөрийн хуурай дүүгийн хамт улс орноо удирдан жолоодох болжээ. Мангас өвгөний эд баялаг, ургамал жимсийг бүгдийг авчрав. Талаараа дүүрэн цэцэг жимстэй, уулаараа дүүрэн улаан алимтай болов. Худалдаачин урчууд, тариачин эрчүүдийн амьдрал тэр цагаас хойш өөдлөн дээшилж өдөр хоногийн тоогоор дэгжин дээрдэв. Улс гүрэн жилээс жилд баяжиж, урвагч хаан, тэнэг ноёдын тухай үлгэрт л хааяа нэг дурсах болжээ.

# НОЁН МУЖААН ХОЕР

Нэг мужаан хүнд ачаатай морин тэргээ хөтлөн ойгоос буцаж явав. Өөдөөс нь гурвалсан морьд хөллөн зугаалж яваа ноён гарч ирээд:

- Хөөщ, замаас зайл! гэж хашгирахад,

- Ноёнтон, та зайл! Би хүнд ачаатай, харин таны тэрэг хоосон тул танд амархан гэжээ. Ноён олон ч юм ярьсангүй, шууд дэлбэгч зарц хоёртоо:

- Ачаатай тэргийг замаас зайлуул. Энэ ядуу эрийг ноёны өөдөөс сөргөлзөхгүй болтол нь ташуурд! гэжээ.

Дэлбэгч зарц хоёр нь ноёныхоо тушаалыг биелүүлэхгүй байж зүрхэлсэнгүй. Яая гэхэв дээ? Дэлбэгч зарц хоёр суудлаасаа үсрэн босож тэрэгтэй ачаагийг нь жалга руу өнхрүүлж мужааныг зоджээ. Тэгээд цааш давхин одоход зам дагуу улаан тоос л манарсаар үлджээ.

Мужаан ачаатай тэргээ жалганаас арай ядан гаргаж «За яахав, ноёнтон! Үүнийг чинь зүгээр өнгөрүүлэхгүй ээ! Уран гартныг гомдоовол яадгийг үзэх болно!» гэж сэтгэжээ.

Гэртээ ирэнгүүт ачаагаа буулгаад хөрөө сүхээ аван баяны эзэмшил рүү явав. Ноёны байшингийн гадуур өнгөрөхдөө:

- Дулаахан пин бариулах уу, халуун усны байшин бариулах уу? гэж хашгирав. Нөгөө ноён байшин бариулах их дуртай хүн байжээ. Тэгээд мужааныг дуудан:

- Сайн пин барьж чадах уу? гэв.

- Чадалгүй яах вэ! Эндээс холгүй тун сайн модтой ой байна. Энэ ойн модоор барихад өвөл галлахгүй ч дулаахан пин болно. Та надтай явж мод сонгож авахгүй юу? гэж ноёныг дууджээ.

Тэгээд ойд ирцгээв.

Мужаан мод модыг сүхнийхээ ирээр тоншин цохиж үзнэ. Цохиод л чихээ наалдуулан чагнаж:

- Энэ тохирохгүй, энэ яг тохирно гээд байна гэнэ.

- Ямар нь тохирно гэдгийг чи яаж мэдэж байна вэ? Надад заагаад өгөөч гэж ноён хэлжээ. Мужаан ноёныг бүдүүн модны дэргэд аваачаад:

- Энэ модонд сайн наалдаад чагна. Би цохино, та сонсоорой, харин сайн наалд гэхэд ноён:

- Модыг тэврэх гэсэн гар хүрэхгүй байна.

- За тэгвэл би таныг модтой сайн наалдуулаад хүлээд өгье гэжээ.

Тэгээд ноёныг модонд хүлээд нэгэн хусны мөчир хугалж аваад балбаж гарчээ.

- Бас байшин бариулах санаатай гэнэ! Эр хүнийг гомдоовол ямар байдгийг үз! гээд нүдэж нүдэж хүлээстэй нь орхичихоод яваад өгчээ.

Зөвхөн дараа өдөр нь ноёныг олж гэрт нь авчиржээ. Ноён зодуулсандаа бие нь муудан хэвтжээ.

Мужаан домч маягтай болон ноёны гадуур:

- Эмчлүүлж, сувилуулах хүн байна уу? гэж хашгиран явжээ.

Ноён:

- Эрхэм минь, эмчилж өгөөч! Мориноос унаад босож ч, сууж ч чадахгүй байна гэж гуйжээ.

- Эмчлэлгүй яах вэ! Халуун усны байшингаа галлуул, эмчилж байх үед хүн харвал эдгэхгүй, иймд хүн орж болохгүй гэж тушаа.

Халуун усны байшинг галлаж бэлэн болгожээ. Мужаан ноёныг дагуулан орж үүдий нь түгжээд:

- За, хувцсаа тайлаад вандан дээр хэвг. Хорсгогч тос түрхэж хөлрүүлнэ. Их өвдөнө, тэвчих л хэрэгтэй дээ гэжээ.

- Оо, ёо, ёо, чи намайг вандантай минь хүлчих, би уначих байх гэж ноён гуйжээ. Мужаан ч ингэж хэлүүлэхийг хүсжээ.

Ноёныг вандан дээр чанга гэгч хүлээд сураар ороолгож гарчээ.

- Уран мужааныг гомдоож байх уу, эр хүнийг гомдоож байх уу, үгүй юу! гээд ороолгож ороолгочихоод гэртээ харьчихжээ.

Маргааш нь ноён хотын зах дээр явж байгаад мужааныг харжээ. Тэгээд:

- Хүүш, чи өчигдрийн эр мөн үү? гэхэд мужаан гайхсан дүр үзүүлэн:

- Үгүй чиш, би дөчин зургаатай. Яаж өчигдрийнх байх билээ дээ! гэж хариулжээ.

Ноён яаж ч чадалгүй эргэж явахдаа хэзээ ч уран хүнийг гомдоохгүй гэж өөртөө тангараглажээ.

# АМАРЛИНГУЙ ХИЙД

Нэгэн хийдэд гурван зуун лам, нэг хамба суудаг байжээ. Өргөл барьц ихтэй баян хийддээ лам нар тун ч элбэг дэлбэг амьдардаг байв. Амттаныг идэж, чихэртэнийг ууж үд болтол унтаж хийх ажилгүй хэлцэх зовлонгүй сууцгаажээ.

Энэ амарлингуй хийдийн тухай их Пётр хаан сонсоод «Яахаараа ингэдэг билээ? Ард олон цөмөөрөө, би ч гэсэн амрах завгүй ажиллаж, аж төрөл гээд зүтгэж байдаг. Өдөр ч, шөнө ч амар тайван суух арга алга. Гэтэл тэнд гурван зуун хүн өөхөнд боосон бөөр шиг, амттаныг идэж чихэртэнийг ууж үд болтол унтаж хийх ажилгүй хэлцэх зовлонгүй жаргаж байдаг чинь юу гэсэн үг вэ?» гэж тунгаан боджээ.

Тэгээд хаан тэр хийд рүү элч явуулжээ.

- Тэнгэрийн од хэд болохыг тоол, газар дэлхийн гүнийг хэмж, хаан миний бодож байгаа юмыг таа гэж хамбад хэл! Гурав хоноод хамба лам өөрөө ирж хариулаг! Зарлигийг эс биелүүлбээс та бүхнийг ажилд хөөж, хийдийг хаана гэдгийг дуулга! гэжээ.

Хамба лам хааны зарлигийг хүлээж аваад «Үйл гай дайрлаа!» гэж зовон шаналав.

Тэгээд бүх лам нартаа дуулгажээ. Лам нар толгой гудайн бодоод бодоод юу ч бодож олсонгүй. Энэ үед тэр хийдэд нэгэн халагдсан цэрэг орж ирэн:

- Өвгөд минь, юундаа царай даран шаналаа вэ! Дандаа л элбэг хангалуун элэг төвшин сууцгаадагсан. Өнөөдөр яагаад тэргүүнээ гудайлган түгшицгээнэ вэ? Лам нар:

- Ай цэрэг эр минь, айхгар гай биднийг дайрлаа! Хаан гурван таавар таалгахаар зарлиг буулгажээ. Гурван хоногийн дараа манай хамбыг ордонд ирж хариу хэл гэжээ.

- Ямар гэгчийн таавар вэ? гэхэд,

- Тэнгэрийн од хэчнээн бэ? Газар дэлхийн гүн хир вэ? Их хаан юу бодож байна вэ? гэдгийг хариулах ёстой гэнэ.

- Хэрвээ би та нарын оронд байсан бол хэлэх хариу ч бэлэн байна гэж цэрэг хэлжээ.

Лам нар хамба руугаа гүйн очиж:

- Энэ цэрэг хаанд хариулж чадна гээд байна гэхэд хамба цэргээс:

- Юу дуртайгаа ав, юу гэж хариулахыг зааж өг! гэж гуйжээ.

- Надад юу ч хэрэггүй. Хувцсаа тайлаад аль, би чиний оронд ордонд очъё гэжээ. Хамба, лам нар бүгд баярлаж:

- Бурхан өршөөлөө! Гай зовлон арилж, сэтгэл онгойлоо! гэжээ.

Тэгээд цэргийг зочлон:

- Юу дуртайгаа ууж ид! гээд өөрсдийгөө ч гомдоосонгүй ууж идэн цэнгэсээр маргааш нь босож чадахаа больжээ. Ингэтэл ч хаанд очих цаг болжээ. Халагдсан цэрэг хамба ламын хувцсыг өмсөөд ордонд очжээ. Хаан:

- За, миний тааврын хариуг олов уу?

- Оллоо, эзэн хаантан минь.

- Тэнгэрт хэдэн од байна?

- Долоон зуун дөчин хоёр мянга дөрвөн зуун наян ес.

- Үнэн үү?

- Эзэн хаантан минь, үнэн үнэн. Үнэмшихгүй байгаа бол өөрөө тоол. Хаан инээвхийлэн:

- За тийм байж. Газар дэлхийн гүн хэчнээн бэ?

- Газар дэлхий хэмжээлшгүй гүнзгий.

- Чи яаж мэдэв?

- Эцэг минь газар луу ороод гучин жил болж

байна. Одоо болтол эргэж ирээгүйг бодоход газар дэлхий хэмжээлшгүй гүн.

- За тэгвэл, одоо би юу бодож байна вэ?

- Эзэн хаантан минь, та одоо «Зөв хө, хамба лам сайн байна. Бүгдийг хариулж чадлаа!» гэж бодож байна. Хаан түүнийг магтаж:

- Чиний зөв! Хамба чи миний бүх тааврыг зөв хариулж чадлаа! гэхэд цэрэг:

- Эзэн хаантан, энэ удаа та алдлаа даа! гэжээ.

- Яаж?

- Өөрийнхөө хуучин цэргийг хамба лам гэж андуурлаа.

Хаан гайхаж, хэн таавар таасныг мэдэж авчээ. Цэрэг үнэнийг хэлжээ. Хаан инээж цэргийг шагнаж, хамба лам болон бүх лам нараар ажил хийлгэх зарлиг буулгажээ.

# ЦЭРЭГ БА ҮХЭЛ

-Хугацаат албаа чи хаалаа. Одоо дуртай зүг рүүгээ яв гээд хорин таван жилийн цэргийн албаа хаасан цэргийг чөлөөлжээ.

Цэрэг явахаар төхөөрч байхдаа «Хаанд хорин таван жил алба хаалаа. Гэтэл хорин таван манжин ч үгүй, ингээд гар хоосон хоцордог юм байжээ. Зөвхөн гурван зүсэм хатаасан талх замдаа ид гэж өглөө дөө. Одоо яах вэ? Хаана яаж амьдрах вэ? За, ямар ч байсан эхлээд нутагтаа очъё, эцэг эхтэйгээ уулзъя.

Хэрэв тэд минь эсэн мэнд үгүй бол булшин дээр нь ч болов очъё доо» гэж боджээ.

Тэгээд цэрэг эр замдаа гарав. Явж явж хоёр зүсэм талхаа идээд ганцхан үлджээ. Гэртээ хүрэхэд бас ч хол байжээ.

Тэгтэл нэг ядуу хүн гүйцэн ирж:

- Цэрэг эр минь, юм хайрла! гэж гуйжээ.

«Би яах вэ, цэрэг хүн байна, яаж ийгээд болох биз. Энэ муу хөгшин хэцүүджээ, хөөрхий» гэж бодоод нэг зүсэм талхаа өгчээ.

Тэгээд гаансаа дүүргэж нэг сайн тамхи татаж аваад цааш явжээ.

Явсаар байтал замын хажууд нэг нуур мэлтийн эрэг хавиар нь зэрлэг галуу хөвж харагдана гэнэ.

«Энэ удаа ч хоолтой боллоо!» гэж бодоод галуу руу гэтэн очиж гурвыг алжээ. Тэгээд хотод ирээд дэн буудлын газар очин эзэнд нь:

- За май, энэ гурван галууг ав. Нэгийг нь надад шарж, нөгөөг нь өөртөө ав, гурав дахийн нь оронд дарс өг гэжээ.

Цэрэг хоол болтол жаал амарч амжжээ.

Түүнд шарсан галуу, нэг шил дарс өгчээ. Цэрэг эр дарсыг ууж шарсан галуугаар даруулаад тайвуухан сууна. Цэрэг:

- Энэ гудамжны цаадах шинэ байшин чинь хэнийх вэ? гэвэл буудлын эзэн:

- Баян худалдаачин бариулсан юмаа. Гэхдээ шинэ байшиндаа орж сууж чадахгүй байгаа юм.

- Яагаад?

- Тэнд чөтгөр шүгэлчихээд, байгаа юм. Шөнөдөө чөтгөрүүд орилолдон шуугилдаж, хашгирч дэвхцэж эхэлдэг юм. Жаахан харанхуй болохоор хүмүүс тэр байшингийн ойр явахаас ч айцгаадаг юм.

Цэрэг буудлын эзнээс тэр байшин бариулсан баян худалдаачныг яаж олохыг заалгаж авчээ.

- Тэр худалдаачинтай ярилцъя, яаж мэдэхэв, ямар нэг аргаар тус болох ч юм билүү? гэжээ.

Цэрэг хоолныхоо дараа жаахан унтаж амраа орой болоход босон хотоор явж худалдаачныг олж уулзжээ. Худалдаачин:

- Цэрэг эр минь, юу гэж явна даа?

- Би замын хүн. Чиний шинэ байшинд чинь хонохыг зөвшөөрнө үү? Тэртэй тэргүй эзгүй байгаа юм чинь.

- Юу гэсэн үг вэ? Үхэх гээ юу? Өөр айлд хоно! Хотоор дүүрэн айл байна. Миний энэ байшинг барьсан цагаас нь эхлээд чөтгөр шүгэлчихээд орох аргагүй байгаа юм.

- Би чөтгөрийг хөөчих ч юм билүү? Чөтгөрүүд, хөгшин цэргийн үгийг сонсож ч магадгүй.

- Чамаас өмнө ийм зоригтон хоёр гурав ч гарсан, гэхдээ ямар ч ашиггүй. Одоо бүүр аргаа бараад байна. Өнгөрсөн зун бас нэг замын хүн чөтгөрүүдийг хөөхөөр байшинд хоноод өглөө нь бид ясыг нь хамж авсан. Чөтгөрүүд түүнийг алчихсан байсан юм.

- Орос цэрэг голд живдэггүй, галд шатдаггүй. Хорин таван жил цэргийн алба хаахдаа аян дайнд ч орж үзлээ, алаан тулааны талбараас амьд үлдсээр ирлээ. Харин муу чөтгөрөөс ч яаж ийгээд хар амиа аргалчих байлгүй, бууж өгөхгүй дээ гэхэд худалдаачин дахин:

- За мэдэхгүй. Өөрийн санаа өөртөө зөв. Айхгүй л байгаа юм бол яая гэхэв. Хэрвээ байшингий минь хар чөтгөрөөс салгаж өгвөл харамж шан хайрлахгүй гэжээ.

- Надад лаа, хуурсан самар, нэг томоохон чанасан манжин өгөөрэй.

- Дэлгүүр лүү очъё, юу хэрэгтэйгээ ав!

Цэрэг худалдаачны дэлгүүрээс арван лаа, гурван фунт хуурсан самар, галынх нь өрөөнөөс хамгийн том чанасан манжинг нь аваад шинэ байшин руу явжээ.

Том өрөөнд нь орж шинель богц хоёроо хадааснаас өлгөчихөөд лаагаа асаан тамхиа нэг татаад, самраа нэг цөмөөд л сууж байж.

Яг шөнө дундын үед их дуу чимээ гарч хаалга үүд хахирч яхирч, тал талаас орилоон чарлаан, бүжиглэх дэвхцэх сонсдож чихний хэнгэрэг хагармаар болжээ.

Цэрэг эр тамхиа татаад самраа цөмөөд юу ч болоогүй, юу ч сонсоогүй юм шиг л суугаад байж. Гэнэт үүд онгойн нэгэн чөтгөрийн толгойн цухуйн цэргийг харангуугаа.

- Энд хүн сууж байна. Амьдаар нь идэцгээе! гэж хашгирав.

Олон хөлийн чимээ гарч чөтгөрүүд цэргийн сууж байгаа өрөө рүү гүйлдэн иржээ. Үүдэнд



шавааралдан зогсож бие биеэ түлхэн:

- Хэдэн хэсэг зулгааж хаяя! Идье, идье! гэж орилолдов.

- Битгий онгируод бай! Энэ насандаа олон л юм үзлээ. Та нарын ах дүүсийг хэмх цохих хэрэг ч гарч байлаа. Хахаж үхмэрүүд!

Тэгэхэд хамгийн том чөтгөр урагш гарч ирэн:

- За тэгвэл, хүчээ үзье!

- Тэгье, тэгье. Хэн нь чулуунаас шүүс гартал шахах нь вэ, үзэх үү? гэжээ.

Том чөтгөр гадаанаас чулуу авчир гэхэд нэгэн жижигхэн чөтгөр авчрав. Тэгээд цэрэгт өгч:

- За үз! гэвэл цэрэг эр:

- Эхлээд та нарын нэг нь үзээд алд, би тэртэй тэргүй чадна гэжээ. Том чөтгөр чулууг шүүрэн авч шахахад атга элс болон хувирав.

- За харав уу!

Тэгэхэд цэрэг богцноосоо чанасан манжингаа гарган:

- За харцгааж байгаа биз дээ. Миний чулуу чинийхээс том! гээд манжингаа шахаж шүүс гаргажээ.

- За харцгаав уу?

Чөтгөрүүд гайхан хэсэг дуугүй байснаа:

- Юу мэрээд байгаа юм бэ? гэхэд цэрэг;

- Самар. Та нарын хэн нь ч миний самрыг хагалж чадахгүй. Цэрэг хүний самрыг идээд үз гээд том чөтгөрт сум өгчээ.

Тэр чөтгөр сумыг ам руугаа шидээд хазаж хазаж шамшийлгасан боловч хагалж чадсангүй, Харин цэрэг самраа нэг нэгээр нь хага хага хазаад л идээд байж...

Чөтгөрүүдийн омог дарагдан чимээгүй болцгоов. Айж гайхсандаа хөл дээрээ тогтож ядан ганхацгааж, цэрэг эрийг нүд бүлтийлгэн ширтэнэ.

- Та нарыг тун ч адтай сэргэлэн гэж дуулсан. Жижигхэн байснаа том болж, том байснаа жижиг болж хувирдаг, ямар ч нүх сүвээр орж чаддаг гэсэн байхаа.

- Энийг ч бид чадна шүү! гэж чөтгөрүүд хашгиралдав. Тэгэхэд нь цэрэг:

- За тэгвэл, бүгдээрээ миний богцонд ороод үзүүлээтэх. Багтах нь уу, үгүй юу!

Чөтгөрүүд богцонд уралдан орцгоов. Яаран, бие биеэ шахаж, нэг нэгийгээ түлхэн хөөнө. Нүд ирмэх зуур байшинд юу ч байгаагүй мэт чөтгөрүүдийн нэг нь ч үлдсэнгүй богцонд орцгоожээ

Цэрэг эр богцныхоо уяаг хэрж чангалаад горхинд нь хийв. Тэгээд:

- За, одоо амарч болно! гээд шинелиэрээ хучин унтжээ. Өглөө нь худалдаачин мухлагчиддаа:

- Цэрэг амьд байна уу, үгүй юу гэдгийг үзээд ир. Чөтгөрүүд идчихсэн бол ядахнаа ясыг нь хамаад ир дээ гээд явуулжээ.

Мухлагчид байшинд ороход цэрэг эр босчихсон, ерөө өрөөгөөр алхаж тамхи баагиулж явжээ.

- Цэрэг эр минь, сайн байна уу? Чамайг чинь эсэн энх байна гэж бодсонгүй шүү. Ясыг чинь цуглуулахаар хайрцаг бариад ирсэн шүү гэхэд цэрэг эр инээж:

- Намайг оршуулах арай л эрт байна! Харин энэ богцыг дархны газар аваачихад туслалцаач. Дархны газар эндээс хол уу? гэжээ.

- Ойрхоон гэж хариулжээ. Богцыг дархны газар авчрав. Цэрэг:

- Эрхэм дархчуул минь, энэ богцыг дөшин дээрээ тавиад налчийтал нүдээд өгөөч! гэхэд хоёр дархан алхаараа богцыг нүдэж балбаж гарчээ.

Чөтгөрүүд байж ядан, нэгэн дуугаар:

- Цэрэг эр, биднийг өршөөж суллаач! гэж гуйжээ. Хоёр дархан нүдсээр л цэрэг эр:

- Нүд нүд, дархчуул минь, бүүр чанга нүд! Хүмүүсийг гомдоох ямар байдгийг үзүүлээд өгье!

- Тэр байшин руу дахиад ерөөсөө шагайх ч үгүй. Энэ хот руу бүү ойрт гэж ураг төрөлдөө, удам судартаа ч захиана. Чамд маш их мөнгө өгнө, гагцхүү амьд үлдээгээч! гэж чөтгөрүүд хашгиралдан гуйв.

- Ай, ха, ха! Орос цэрэг эртэй тэмцэлдэх ямар байдгийг тогтоож ав! гэж цэрэг эр хэлээд дархчуулыг боль гэв. Богцныхоо оосрыг сулруулан чөтгөрүүдийг нэг нэгээр нь гаргаж байгаад хамгийн томыг нь үлдээжээ.

- Надад төлөх их мөнгөө аваад ирцгээ. Тэгэхлээр чинь үүнийг чөлөөлнө гэжээ. Дөнгөж л нэг гаанс татаад байтал жижигхэн чөтгөр нэгэн үүргэвч барьсаар гүйж ирээд:

- За май, энэ төлбөр! гэжээ.

Цэрэг үүргэвчийг аваад үзтэл тэнд юу ч байсангүйд чангаар:

- Надаар тоглох гэж шийдээ юү? Одоо танай том чөтгөрийг үйртэл цохино доо! гэж хашгирав.

Богцноос том чөтгөр:

- Цэрэг эр, намайг битгий цохь, миний хэлэхийг сонсооч! Энэ үүргэвч энгийн биш ид шидтэй юм. Дэлхий дээр ийм үүргэвч зөвхөн нэг байгаа нь энэ. Хүссэн бүхэн чинь энэ үүргэвч дотор бий болно. Өдөт шувуунаас авахуулаад өмсөх зүүх, идэх уух юу л бол юу, хүслээр чинь болно. Гагцхүү үүргэвчээ нэг сэгсрээд «Ороод ир» гэж хэлэхэд л боллоо.

- За байз, худал үнэнийг нь үзээдхье!

Тэгээд цэрэг эр «Үүргэвчинд гурван шил архи бий болог!» гэж бодтол үүргэвч нь хүндрээд ирэхийг мэдэрчээ. Үүргэвчээ онгойлгоод үзтэл үнэхээр тэнд гурван шил архи байсанд дархчуулд өгчээ.

Тэгээд гадаа гараад ийш тийш харвал дээвэр дээр бор шувуу сууж байх нь харагджээ. Үүргэвчээ сэгсрэн «Ороод ир!» гэж хэлмэгц бор шувуу дээврээс ховхрон үүргэвчинд оржээ.

Чөтгөрийн үгний үнэнийг үзсэн цэрэг эр дархны газар эргэн орж:

- Үнэн байнаа, үнэн хэлж. Хөгшин цэрэгт энэ үүргэвч хэрэг болно! гээд богцоо онгойлгон том чөтгөрийг суллажээ.

- Дуртай зүг рүүгээ тонил, дахин нүдэнд минь үзэгдвэл өөртөө л гомд! гэж чөтгөрт хэлжээ. Том жижиг хоёр чөтгөр арилж өгөв. Цэрэг эр богц үүргэвч хоёроо аваад дархчуултай салах ёс хийгээд худалдаачныд очин:

- Шинэ байшиндаа нүүж орцгоо. Тэнд та нарыг одоо хэн ч айлгаж зовоохгүй гэжээ.

Худалдаачин цэрэг эрийг гайхан харж:

- Орос цэрэг голд живдэггүй, галд шатдаггүй гэдэг үнэн юм даа! Далдын хар хүчтэй яаж тэмцэв, амь мэнд, эрүүл энх яаж үлдэв? Яриад өгөөч! гэжээ.

Цэрэг эр юу болсныг яг байснаар нь тодорхой ярьжээ. Мухлагчид ч батлав.

«Хоёр гурван өдөр нүүж орохоо хүлээзнэх хэрэгтэй. Тэнд үнэхээр юу ч үлдээгүй, чөтгөрүүд эргэж ирэхгүй байна уу, үгүй юу гэдгийг мэдье байз» гэж худалдаачин дотроо боджээ.

Тэгээд өдөр байшинд очсон хүмүүсийг орой нь цэрэг эртэй хамт тийш явуулжээ.

- За тэнд очоод хоноотох, ямар нэг юм болбол цэрэг эр хамгаална гэжээ. Тэд тэр шөнө тэнд хоноод өглөө нь эсэн мэнд, хөгжилтэйхэн буцаж ирцгээжээ.

Гурав дахь шөнө нь худалдаачин өөрөө хонохоор зоригложээ. Гурав дахь шөнө ч тайван чимээгүй өнгөрчээ. Хэн ч, юу ч айлгаж ичээсэнгүй. Үүний дараа худалдаачин бүх юмаа шинэ байшиндаа оруулж шинэ байрын баярт зэхэж эхэлжээ. Идээ будаа чанахыг нь чанаж, шарахыг нь шарж, жигнэхийг нь Жигнэж бэлджээ. Зочин гийчин ч олныг урьжээ.

Ширээгээр дүүрэн амттан, уух архи дарс өржээ. Аль амттайг, юу дуртайгаа зооглогтун!  
Хамгийн хүндэт суудалдаа цэрэг эрийг суулган дээд зэргээр хүндэтгэн дайлав.

- Цэрэг эр минь, зооглогтун! Чиний ачийг энэ насандаа мартахгүй! гэнэ.

Найр өглөө болтол үргэлжилжээ. Унтаад сэртэл цэрэг эр аян замдаа явах гэж байжээ.  
Худалдаачин:

- Битгий яар! Манайд ядахнаа долоо хонооч гэж гуйхад цэрэг:

- Үгүй дээ, даанч чадахгүй нь. Харин чиг энд удчихлаа. Гэртээ харилгүй болохгүй гэв.  
Худалдаачин цэрэг эрийн богцонд дүүрэн мөнгөн зоос хийж өгөөд:

- Орон байшин бариарай, аж амьдралаа төвхнүүлээрэй! гэвэл цэрэг эр:

- Би ганц бие хүн. Одоохондоо чадал тэнхээтэйгээ байна хэрэггүй ээ. Өөрөө өөрийгөө  
хооллочихно. Чиний мөнгө надад зохихгүй! гэжээ.

Ингээд цэрэг эр худалдаачинтай салах ёс хийгээд шидэт үүргэвч хоосон богц хоёроо үүрээд  
замдаа гарчээ.

Тэгээд явсаар төрөлх нутагтаа ирж гэнэ. Өндөр дов дээрээс өөрийн тосгоноо хараад сэтгэл  
санаа нь сэргээд иржээ. Эргэн тойрноо харан харан баясаж «Яасан ч сайхан нутаг вэ! Олон ч  
газар, олон ч тосгон, олон ч голыг үзсэн дээ гэхдээ төрөлх тосгоноос минь илүү сайхан нутаг  
энэ дэлхий дээр байхгүй юм даа!» гэж хайрлан бодов.

Байшингийнхаа гадаа ирэн үүдээ тогшвол эмгэн хаалгаа тайлав. Цэрэг эр эмгэнийг тэврэн  
авав. Эмгэн хүүгээ таньж уйлан, баярлан инээнэ.

- Эцэг чинь чамайг ярьсаар л байгаад хүлээж чадаагүй дээ! Өөд болоод таван жил ч өнгөрөв  
үү дээ гэж эмгэн болсон эх нь ярив.

Дараа нь ээж нь хоол цай хийх гэж сандарч эхлэхэд цэрэг эр:

- Ээж минь, юу ч битгий хий, тайвшир. Одоо хүү нь таныг харж хандах ээлж болжээ.

Тэгээд шидэт үүргэвчээ тайлан, идэх уух юм гэж бодоод сэгсрэв. Юм бүгдийг гарган ширээн  
дээр өрж эхээ хүндлэн:

- Цадталаа зоогло! гэжээ.

Дараа өдөр нь цэрэг эр дахиад үүргэвчээ сэгсрэн баахан мөнгө асгаж аваад амьдралаа өөд  
татахаар ажиллаж эхэлжээ. Шинэ байшин барьж үнээ, морь, гэр оронд хэрэгтэй  
бүхнийг худалдан авчээ. Тэгээд сайн хүүхэнтэй ханилан сууж сайн сайхан амьдрах болов.  
Эмгэн болсон эх нь ач нараа харан баясаж, хүүгээрээ бахархан суух болжээ.

Ийнхүү зургаа долоон жил өнгөрчээ. Гэнэт цэрэг эр өвдөж хоёр гурав хоног юу ч идэж

уусангүй. Цаг цагаар муудаад байжээ. Гурав дахь өдрөө цэрэг эрийн орных нь хажууд Үхэл зогсчихсон, хадуур ирлэж түүнийг байн байн харж байхыг үзэв гэнэ.

- За цэрэг эр минь, бэлтгээрэй! Чамайг авахаар ирлээ! Одоо чиний бодийг чинь хөтөлнө гэжээ.

- Үгүй байз, дахиад гучин жилийн нас өгөөч. үр хүүхдээ өсгөө. Хүү, охидоо гэрлүүлж ачийнхаа барааг харъя. Одоо үхэхийг хүсэхгүй байна гэж Цэрэг эр гуйхад Үхэл:

- Үгүй ээ, үгүй. Гурван цаг ч амьдрах хугацаа өгөхгүй.

- Тэгвэл ядахнаа гурван жил өгөөч! Амжаагүй ажил их байна! Бүгдийг хийж гүйцээх хэрэгтэй.

- Битгий гуй. Чамайг гурван хором ч амьд үлдээхгүй гэж Үхэл хариулжээ.

Цэрэг эр дахин юу ч ярьсангүй, үхэхийг ч хүссэнгүй. Тэгээд дэрэн дороосоо үүргэвчээ хурдхан авч сэгсрээд:

- Ороод ир! гэж хашгирчээ.

Дөнгөж хэлмэгц л бие нь хөнгөрөөд явчихыг мэдэрч гэнэ.

Сайтар харвал Үхэл ч алга болжээ. Үүргэвчээ шагайгаад хартал Үхэл тэнд сууж байна гэнэ. Цэрэг эр үүргэвчнийхээ амыг чангалан уятал бие нь сайжран, юм идэж уумаар ч санагджээ. Орноосоо босон нэг зүсэм давстай талх идэв. Дараа нь аяга квас уугаад бүүр сэргэжээ.

- Навшгар муу Үхэл чи, надтай сайнаар ярих дургүй байна гэнээ! Орос цэрэгтэй өрсөлдвөл юу болдгийг одоо үзнэ дээ! гэтэл Үхэл:

- Чи намайг яах гэж байна? гэж асуужээ.

- Үүргэвчнээсээ салах харамсалтай л байна. Гэхдээ яахав дээ, салахаас. Одоо чамайг өмхий намагт живүүлж хаяна даа. Энэ үүргэвчнээс чи хэзээ ч гарч чадахгүй!

- Цэрэг эр, намайг суллаач! Чамд гурван жилийн нас өгье!

- Үгүй ээ, одоо яасан ч суллахгүй!

- Суллаач дээ! Гучин жил амьдар, дураараа амьдар! гэж Үхэл гуйжээ.

- Байз хөө, хэрвээ чи энэ гучин жилд хүмүүсийн бодийг хөтлөхгүй бол суллана гэж цэрэг эр хэлэхэд,

- Үгүй ээ, үгүй. Хүний бодийг хөтлөхгүй бол би яаж амьдрах вэ?

- Энэ гучин жилд чи модны үндэс, хожуул, бул чулуу мэрэхгүй юү! Үхэл энэ үгэнд үл

хариулна.

Цэрэг:

- Хэрвээ дургүй байгаа бол өмхий намагт аваачлаа! Тэгээд үүргэвчээ мөрөн дээрээ тохоод алхжээ.

- За за, чиний дураар болог. Энэ гучин жилд нэг ч хүний бодийг хөтлөхгүй, хожуул, үндэс, бул чулуу мэрье, зөвхөн суллаад өгөөч! гэж Үхэл дахин гуйхад,

- Хуурч мэхэлсэн байвал уу, харж л байгаарай! гэж цэрэг эр хэлээд Үхлийг тосгоны зах руу гарган хаяжээ.

Үхэл хадуураа санд мэнд шүүрч аваад ой руу амь тавин гүйжээ! Үхэл ойд хожуул онгичиж, талд бул чулуу, үндэс ухаж мэрсээр амьдрах болжээ. Өөр яах ч билээ дээ!

Энэ үед ард олон гай зовлон, гашуудал гуниггүй, бүгд эрүүл энх, өвдөх үхэхийг үл мэдэн жаргаж байжээ.

Тэгтэл ч гучин жил өнгөрчээ.

Энэ хугацаанд цэрэг эрийн хүүхдүүд ч өсжээ. Хүү охид нь гэрлэж өнөр өтгөн болжээ. Нэгэнд нь туслах, нөгөөд нь зөвлөх, гурав дахийг нь сургах, ер нь бүгдийг ажилд дүйтэй, амьдралд хөлтэй болгох их ажил байжээ. Цэрэг эр бүгдийг амжуулж, баярлаж явав. Ажил үйлс нь ч бүтэмжтэй, аж төрөл нь дээшилсээр байв. Ер нь ажилд тун ч махруу хүн байжээ. Эр цэрэг үхлийн тухай бодоод суухгүй шүү дээ!

Үхэл хаяанд нь ирэн:

- Өнөөдөр яг гучин жил өнгөрлөө. Хугацаа ч боллоо. Цэрэг эр бэлэн үү? Чамайг авахаар ирлээ гэжээ.

Цэрэг эр маргасангүй.

- Цэрэг эр бол цэрэг эр л байх ёстой. Түргэн дохиогоор ажиллаж сурсан эр. Хугацаа болсон бол авсаа аваад ир гэжээ.

Үхэл төмөр бүслүүртэй царсан авс авчрав. Тагийг нь сөхөн:

- Цэрэг эр, хэвт! гэв. Цэрэг эр уурлан:

- Чи чинь юу вэ? Ес мэдэхгүй юм уу? Хөгшин цэрэг ажлыг өөрийн санаагаар ингээд л халтар хултар хийх дүрэм хаана байна? Намайг цэргийн алба хаах үед юуг, яаж хийхийг бидэнд эхлээд үзүүлдэг, дараа нь бид тэр үзүүлсэн ёсоор тушаалыг биелүүлдэг байлаа. Энд ч гэсэн, чи эхлээд өөрөө яаж хэвтэхийг үзүүлээд өг, дараа нь заавардаж тушаахгүй юу! гэв.

Үхэл авсанд хэвтээд:

- Цэрэг эр, за хар. Хөлөө хийгээд гараа цээжин дээрээ зөрүүлж тавиад ингээд хэвт. Үүнийг л хүлээж байсан цэрэг эр авсны тагийг бушуухан хааж бүслүүрийг нь хийжээ.

- Ингээд чи өөрөө хэвт, надад эндээ сайхан байна! гээд авсыг өндөр эрэг дээр аваачин гол уруу өнхрүүлжээ. Гол авсыг урсгалдаа тээсээр Үхлийг тэнгист аваачжээ.

Олон ч жил өнгөрч, Үхэл тэнгисээр хөвсөөр байж гэнэ.

Ард олон аз жаргалтай сайхан амьдарч цэрэг эрийг магтан алдаршуулсаар байв. Цэрэг эр ч ер хөгширсөнгүй. Ач зээгээ гэрлүүлж жич зээнцрээ сургаж зааварлаж суужээ. Өглөөнөөс орой болтол орон гэрийн элдэв ажлыг хийж ядрахыг мэдэхгүй гүйнэ.

Нэгэн удаа тэнгист хүчит шуурга дэгдэж ширүүн долгионд авс чулуу мөргөн хэмхэрчээ. Үхэл амь голтой төдийхөн л эрэг дээр гарчээ. Салхинд хийсэх шахан ганхана.

Тэнгисийн эрэгт хэвтэж тэнхээрч аваад цэрэг эрийн амьдарч буй тосгон руу гэлдэрсээр очжээ. Цэрэг эрийн хашаанд нь ороод гарч ирэхийг нь хүлээн нуугдан зогсжээ.

Цэрэг амбаараасаа үр авахаар хоосон шуудай барин гарч ирэв. Тэгээд амбаар луу яг ойртоод очмогц нь Үхэл булангийн цаанаас огло үсрэн гарч ирэн:

- Одоо ч миний гараас гарахгүй дээ! гэж хөхөрчээ.

Цэрэг эр ч гарцаагүй гай ирлээ гэдгийг мэдмэгцээ «Юу ч болсон яахав! Үхлээс зугтаж чаддаггүй юм гэхэд айлгаад орхиё» гэж бодоод хоосон шуудайгаа савчуулан:

- Үүргэвчинд орохоор ирээ юү? Өмхий намагт шигдэх гээ юү? гэж хашгирчээ.

Цэрэг эрийн гар дахь хоосон шуудай айж балмагдсан Үхлийн нүдэнд шидэт үүргэвч юм шиг харагджээ. Үхэл ч гялсхийн зугтан одоход цэрэг эр бараагий нь хараад хоцорчээ. Тэр цагаас хойш Үхэл хүний бодийг сэмхэн, нууцаар хөтөлдөг болсон юм гэнэ лээ. «Цэрэг эрийн нүдэнд оногдчихгүй юмсан! Харагдвал ч өмхий намагт шигдэнэ шүү» гэж айж явдаг болсон ажээ.

Харин цэрэг эр эрүүл энх одоо ч амьд, хааяа хааяа Үхлийг шоолж инээдэг гэнэ лээ шүү.

## ЯДУУ ЭР ХААН ХОЕР

Нэгэн хаан байжээ. Тэр хаан үлгэр сонсох тун дуртай юмсанжээ. Дандаа шинэ, сонин үлгэр сонсох гэдэг байжээ. Ордны үлгэрчид мэдэх бүх үлгэрээ ярьчихсан тул хааны сэтгэлийг хангаж чадахаа байв гэнэ. Хаан:

- Миний мэдэхгүй үлгэр ярьсан хүнийг охинтойгоо суулгана, хаант улсынхаа хагасыг өгнө! гэж зар тараах зарлиг буулгажээ.

Үлгэр ярихыг хүссэн олон хүн гарч иржээ. Тайж ноёд, генерал, худалдаачин гээд л, гэхдээ нэг нь ч амжилт олсонгүй. Нэг үлгэр ярьж эхэлмэгц хаан:

- Мэднэ, мэднэ. Энэ үлгэрийг сонссон! гэж зандарна. Тэгээд л үлгэрчийг хөөчихдөг байжээ.

Тэр улсад нэгэн ядуу эр зовж зүдрэн амьдардаг байж гэнэ. Орох оронгүй, оочих аягагүй ядуу эр гэнэ. Хаана ч хамаагүй хонож, юу ч олдсон идэж уугаад өдөр хоног өнгөрөөдөг юмсанжээ. Өл залгах цаг ч байж, өлсгөлөн суух өдөр ч байж. Нэг удаа ядуу эр аяга дарс ууж дулаацахаар архины мухлагт оржээ. Мухлагийн авгай түүнийг шоолон инээж:

- Яагаад хаанд очиж үлгэр ярихгүй байгаа юм бэ? Гүнж нүдээ бүлтэртэл харуулдаад чамайг тэсэн ядан хүлээж суугаа даа гэж дамшиглажээ.

Ядуу эр дооглон инээхийг нь сонсонгоо «Ер нь очоод азаа үзвэл яасан юм бэ? Хааны хүргэн болохгүй ч хоёр гурван өдөр хоолтой өнжье» гэж боджээ.

Ядуу эр ордонд ирэхэд хаан:

- За, ямар хэргээр ирэв?

- Их эзэнтэн минь, танд үлгэр ярихаар ирлээ. Гагцхүү эхлээд намайг хооллож ундлаач гэжээ.

Хаан түүнийг ширвэн хараад инээвхийлэн «Энэ бас гүнжийн нөхөр болох санаатай, ээ хөөрхий гэж! Далан нөхөөс болсон цамцтай, дан уяагаар тогтоосон дэрсэн шаахайтай байж» гэж боджээ.

Гэхдээ татгалзсангүй.

Ядуу эр хоол идэж цай уужээ. Хаан шадар ноёд, үнэнч зөвлөгч нараа тойруулан сууж:

- За, үлгэрээ ярь! гэж тушаав.

- Насан өөд болсон эцэг минь улсын хамгийн баян хүн байсан юм. Өндөр сайхан байшин бариулжээ. Тэр байшингийн дээвэр дээгүүр тагтаа гүйлдэж тэнгэрийн одыг тоншин байдаг байсан юм. Ийм л өндөр байшин байсан юм даа! Хашаа маань асар том цэлгэр. Тагтаа шувуу зуны өдөр нэг өнцгөөс нь нөгөө өнцөгт нь нисэн хүрч чаддаггүй байсан юм даа.

Хаан дув дуугүй, шадар ноёд ч дуугүй, үлгэрийг нь тасалсангүй. Ядуу эр:



- Үргэлжлэлийг нь маргааш цай ууж боов идсэнийхээ дараа үдээс хойш ярьж гэжээ. Тэгээд оройн хоол идэхээр гал зуух руу оржээ.

Хойд орой нь ядуу эр үлгэрээ үргэлжлүүлэв.

- Манай хашаанд нэг долоон настай бух зогсож байдаг байв. Нэг эвэр дээр нь нэг малчин, нөгөөх дээр нь өөр нэг малчин суугаад бүрээ үлээж, эвэр бүрээ тоглож, дуу дуулдаг байлаа.

Харин хоёр биеийнхээ царайг хардаггүй, дууг сонсдоггүй байсан юм. Ийм том бух манайд байсан юм даа!

Хаан дув дуугүй л сонсоно, шадар ноёд ч дув дуугүй. Ядуу эр босон:

- За, одоо унтаж амарцгаая, маргааш үлгэрээ дуусгана гэв. Тэгээд хоол идэхээр гал зуух руу оржээ. Энэ хойгуур хаан:

- Шадар ноёд минь, одоо яах вэ? Энэ үлгэрийг би сонсоогүй юм байна. Гэхдээ охиноо энэ муу ноорхой эртэй суулгалтай биш дээ. Хуурах арга бодоцгоогооч гэжээ.

Тайж, шадар ноёд бодож бодож ингэж шийджээ.

- Эзэн хаантан минь, та энэ үлгэрийг мэднэ гэж хэл. Бид ч батлаад өгнө. Бүүр итгүүлэхийн тулд бичээд дор нь бид гарынхаа үсгийг зурцгаая гэгцгээж, хаан ч зөвшөөрч тохиролцжээ.

Ядуу эр энэ хуйвалдааныг мэдсэн боловч мэдээгүй юм шиг л байв. Дараа өдөр нь ядуу эр үдээс хойш юу ч мэдээгүй хүний царай гарган орж ирээд үлгэрээ ярьж дуусгажээ.

- Манайд гурван өдрийн дотор дэлхийг тойрдог нэг гүү байсан юм... Тайж, шадар ноёд хаантай нүд ирмэлцэн жуумалзан сууцгаана.

- Алт мөнгө ч гэж амбаар амбаараар дүүрэн байлаа. Тэр үед хаан та нэг авдар алт аваад одоо болтол эргүүлж өгөөгүй билээ... Яг энэ хоромд хаан:

- Мэдэж байна, энэ үлгэрийг мэднэ гэж орилжээ. Тайж ноёд ч дагалдан:

- Мэднэ, мэднэ. Энэ үлгэрийг сонссон юм байна. Бичиг бичиж гарын үсгээ зурахад ч бэлэн! гэжээ.

Тэгээд яаран босоцгоож гарын үсгээ зурцгаажээ. Ядуу эр бичгийг аваад:

- За сонссон, мэдэж байгаа юм бол эзэнтэн минь, өрөө төл дөө! гэхэд хаан:

- Нөхөөс болсон эрд хууртлаа! гэдгээ сая ухаарчээ.

Үзгээр бичсэнийг сүхээр цавчилтай биш дээ, яах ч аргагүй болж, нэг авдар алт ядуу эрд өгчээ. Ядуу эр мөнгөтэй болоод амар сайхан амьдрах болжээ. Тэр ч байтугай одоо болтол эсэн мэнд эрүүл саруул гэнэ лээ. Хааяа хааяахан хааныг шоолж инээдэг гэнэ лээ.



# БАЯН ЯДУУ АХ ДҮҮ ХОЁР

Ах дүү хоёр байжээ. Ах нь баян, дүү нь ядуу юмсанжээ. Баян ах нь найр цэнгэл хийж, ядуу дүү нь заримдаа зүсэм талх ч үгүй суудаг байв. Ядуу дүү нь нас дараалсан олон бага хүүхэдтэй гэнэ.

Сүүлчийн үнээгээ идээд үр хүүхдээ тэжээх юу ч үгүй болсон ядуу эр:

- Эхнээр, хоёул ахынх руу очиж талх гуйя. Шуудай гурил өгч магадгүй гэжээ.

- Одоо яах вэ, явахаас. Ингээд тэд ахындаа очжээ.

Тэр өдөр ахынх нь найр хийж байжээ. Муж тосгон бүрээс зочид цугларчээ. Худалдаачин, лам, баячууд сууцгаан найрлан дуулцгаана.

Ядуу эр эхнэрийн хамт ахтайгаа золгон мэндлээд:

- Гурил өгөөч, ах минь, хүүхдээ хооллох юмгүй боллоо! Намар болохоор төлье гэв. Баян хатсан дугуй талх өгөөд:

- Ажил ихтэй цагаар нэг хоёр өдөр ирж ажиллаж өгөөрэй гээд ширээндээ ч суулгасангүй.

Тэд хэдийгээр гомдсон ч яах ч билээ дээ! Зарц нь квас авчирч өгч, тэгээд санд мэнд гэрлүүгээ буцжээ.

Зочдын дуу дуулах сонсогдоно. Ядуу эр:

- Эхнээр, хоёулаа дуулъя! Бид нарыг баян ах дарсаар дайлж гэж хүмүүс бодог.

- Юугаа ярих нь энэ вэ! Амттай хоол идэж архи дарс уусандаа зочид дуулж байна. Гэтэл чи бид хоёр юун дуу дуулах мантай.

Ядуу эр өөрийнхөөрөө зүтгэн дуулж эхэлтэл хоёр хоолой сонсогдов. Нэг нарийхан дуу хажууд нь дуулдаж гэнэ.

- Эхнээр, чи намайг дагаж дуулав уу?

- Үгүй чиш, би дуулмааргүй байна!

- Тэгээд өөр хэн дуулаад байна?

- Мэдэхгүй. За, чи дуул, би сонсьё.

Ядуу эр дахиад дуулав. Ганцаараа дуулж байгаа атал хоёр хоолой сонсогдоно гэнэ. Хэн нэгний нарийхан дуу дагаад дуулаад байх юм гэнэ. Ядуу:

- Хэн намайг дагаж дуулаад байна?

- Би, чиний Гачигдал.

Ядуу эр эргэж харвал хажууд нь тохойн чинээ жижигхээн биетэй ноорхой эмгэн байхыг үзэв.

- Энд юу гэж сүүтэгнээд байгаа юм бэ. Шуудайд минь ороод суу, би чамайг үүрээд явья гэж ядуу эр эмгэнд хашгирав.

Гачигдал шуудайд ороход ядуу эр шуудайнхаа амыг чанга боогоод цааш явжээ. Гэртээ ирсэн хойноо эхнэр нь хүүхдүүддээ талхаа хувааж өгөөд унтуулжээ.

Ядуу эр хэвтсэнгүй банз хөрөөдөж харуулдаж гарав. Эхнэр нь:

- Харанхуй шөнө юу хийх гээ вэ?

- Дуугүй, дуугүй бай! Гачигдлыг оршуулах хэрэгтэй. Ялзарсан луувангаас гашуун золиг чинь бүүр цөхрөнгий минь барлаа! гээд ядуу эр авс хийж Гачигдлыг тэнд хэвтүүлээд тагийг нь сайн гэгч хадав.

Тэгээд хүрз авч австай Гачигдлаа оршуулгын газар аваачжээ. Гүнзгий нүх ухан Гачигдлыг тэнд тавин булж эхэлтэл хүрз нь нэг юманд харших шиг болов. Бөхийж үзвээс хэсэг алт байв. Гачигдлыг хурдхан булж шороог нь гишгэлж тэгшлэв.

- Энд ингээд хэвтэж бай! Одооноос эхлэн гачигдалгүй амьдрах болно.

Ингээд ядуу эр гэртээ эргэж ирээд унтаад өгчээ. Дараа өдөр нь хот руу явж хэсэг алтаа зарж морь, үнээ, гурван тэрэг тариа худалдаж авчээ. Бас эхнэр хүүхдүүддээ шинэ хувцас хунар авсан авч их мөнгө үлджээ. Байшингаа засаж, өдрөөс өдөрт амьдрал нь дээшилсээр зовлонгоос ангижирчээ. Ажил бүхэн нь өөдрөг байх болов. Ургац тариа сайн хурааж, загас жарам ихийг барьж, хүүхдүүд нь өсөж ажил төрөлд нь туслах болжээ.

«Хүний ажил хийж явдаг ядуу байсан, одоо өөрийн хөрөнгөтэй болчихжээ. Энэ надаас юм хулгайлсан юм биш байгаа?» гэж баян ах нь атаархана.

Тэгээд баян ах нь тэссэнгүй, нэг өдөр дүүгийн дээ гүйж ирэн:

- Чи чинь энэ тосгоны хамгийн ядуу нь байлаа шүү дээ. Гэтэл одоо сүрхий хөрөнгөтэй болчихоод байна. Яаж ядуу зүдүү амьдралаас ангижирч чадав аа? гэж асуужээ.

Дүү нь ахдаа юу ч нуулгүй бүгдийг ярьжээ. Эхнэртэйгээ хоёул тэднийхээс буцаж явахдаа яаж дуулсан, Гачигдал яаж дагаж дуулж байсан, яаж Гачигдлыг оршуулснаа ярьжээ.

Гачигдлыг хаана оршуулсныг асууж аваад ах нь атаархсандаа тэсэж сууж үл чадан яаран явжээ.

- За үг олдлоо, би ч явья даа.

- Хоол ид, цай уу гэж дүү нь гуйхад,

- Хоол цай уух зав алга. Гэртээ харилгүй болохгүй гээд ах нь яваад өгчээ

Тэгээд гэртээ ирж төмөр хүрз, сүх аван оршуулгын газар луу гүйжээ. Гачигдал хаана байгааг эрж олоод булшийг нь ухан асуусан нь:

- Гачигдал, чи амьд уу?

- Амьтай шүү л байна. Энд надад ямар хэцүү, ямар муу байна гэж бодно! гэж дуулдах төдий хариулах сонсогдов.

- Одоохон, одоохон чамайг суллаж гарганаа гээд ухсан нүх рүүгээ орж сүхээрээ авсны тагийг хэмх цохин Гачигдлыг гаргав

Тэгээд:

- Гачигдал, чи дүүгийн д оч. Тэнд дураараа амьдар гэжээ. Харин Гачигдал ухасхийн баян ахын хүзүүн дээр мордоод авчээ.

- Дүү чинь намайг амьдаар оршуулсан. Харин чи намайг сулласан сайхан сэтгэлтэй! Би чамаас алхам ч холдохгүй гэжээ.

Ингээд тэр цагаас хойш Гачигдал ахынх нь гэрт суух болж, баян ахын амьдрал муудан муудсаар сүүлдээ бүүр хоосорчээ.

# ХААН ХҮҮ ИВАН МАРЬЯ МОРЕВНА ХОЕР

Нэг хүү, гурван охинтой хаан байжээ. Хааны хүүгий нь Иван, охидыг нь Марфа, Ольга, Анна гэдэг байжээ.

Хаан насыг насалж, өтөл болоод бие нь чилээрхэхэд хүү Иванаа дуудан ирүүлж өгүүлсэн нь:

- Энхрий хүү минь, миний хорвоод амьдрах хоногийн тоо гүйцэж байна. Хаан төрийг барьж яв. Гүнж дүү нарын чинь эрд гарах нас нь боллоо. Эхэлж авья гэсэн хүнд л эхнэр болгож өгөөрэй гэжээ.

Хаан эцэг нь гурав хоноод нас нөгчжээ.

Хаан хүү Иван харамсан гашуудавч одоо яах билээ! Хаан ширээнд сууж хамаг хэргийг залах боллоо.

Дүү гүнж нар нь эцгийнхээ хойноос уйлан гашуудаж нэгэн хэсэг цагийг өнгөрөөв. Тэгээд нэг удаа хаан хүү Иван:

- Дүү нар минь, дархан цэцэрлэгээр явцгаая, уйтгар гунигаа тайлья гэхэд,

- Тэгье, ах минь, явцгаая! гэж гэнэ.

Дархан цэцэрлэгт оров уу, үгүй юу хар үүл нөмөрч их салхи босож аянга дуугарч, хаанаас ч юм бэ, гэнэт хар Хэрээ нисэн иржээ. Хэрээ газар нэг хөрвөөгөөд сайхан залуу болж гэнэ. Тэгээд:

- Хаан хүү Иван, би Марфа гүнжийг эхнэрээ болгож авья гэжээ. Хаан хүү Иван эцгийнхээ захисныг санаж:

- Дүүгийн сэтгэл таалбал ав гэжээ.

Залуу эрийг Марфа гүнж сэтгэлдээ таалав. Хааны ордонд дутуу юм байх биш, сархад сав саваараа, шар айраг сөн сөнгөөрөө гэнэ.

Тийнхүү элбэг хурим хийж, их найр боллоо.

Найрын ширээнээс зочид өндөрлөмөгц эргэн тойрон харанхуйлж, хар үүл нөмөрч аянга дуугарч, Хэрээчийн Хэрээ Марфа гүнж хоёул нүдэнд үзэгдэхгүй, чихэнд дуулдахгүй газар луу алга боллоо.

Өдөр шөнө ээлжилсээр, хоног сар өнгөрсөөр жил болоход Марфа гүнжээс сураг чимээ алга байлаа.

Ольга Анна хоёр гүнж эгчийгээ санан уйтгарлаж:

- Ахаа, ахаа, дархан цэцэрлэгт очъё! гэж гуйжээ. Дархан цэцэрлэгт оров уу, үгүй юу дахиад л

хар үүл нөмөрч шуурга дэгдэн, аянга тачигнав. Гэнэт Шонхор шувуу дээрээс унах чулуу шиг яг дэргэд нь унав. Газар нэг хөрвөөгөөд лут сайхан-залуу болж гэнэ. Тэгээд:

- Хаан хүүгийн амрыг эрье? Сайн үйлсийг зорьж ирлээ би. Ольга гүнжийг би эхнэрээ болгож авья!

- Ёс төртэй ирсэнд чинь баярлалаа. Дүүгээ хүчээр захирахгүй. Өөрөө тунгаагаад зөвшөөрвөл өмнүүр нь орж хориглохгүй.

Ольга гүнж ахыгаа хүндлэн мэхийгээд:

- Заяа тавилангаас зайлж гаршгүй! гэв. Тэр өдөртөө хурим хийв.

Хурим найр өндөрлөөгүй байхад тэнгэр муухайрч, аянга тачигнаж Шонхорын Шонхор Ольга гүнжийг дагуулан харах бараагүй алга боллоо.

Өдөр шөнө солигдож, хоног сар өнгөрсөөр нэг жил болсон ч Марфа Ольга хоёр гүнжээс ямар ч сураг байсангүй.

Анна гүнж ганцаархнаа гадагш ч үл гаран ордондоо уйтгарлан сууна. Хаан хүү Иван хайрт дүүгээ өрөвдөн:

- Анна, дархан цэцэрлэгт очъё. Уйтгар гунигаа арилгая гэв.

Дархан цэцэрлэгт оров уу, үгүй юу хар үүл нөмөрч тэнгэр дуугарч, цахилгаан цахиж, их шуурга босоод хар үүлний дундаас Бүргэд шувуу нисэн ирж газар хөрвөөгөөд үлгэрт хэлэшгүй, үзгээр бичишгүй сайхан залуу болж хувирав.

- Хаан хүү Иван, зочин болж ирлээ би! Анна гүнжийг аван сууж, ахан дүүгийн холбоо тогтооё! гэв.

- Ес төртэй ирсэнд чинь баярлалаа. Дүүгээ хүчээр захирахгүй. Санаа сэтгэл нь шийдвэл сайныг ерөөгөөд хоцорно.

- За ах минь, өрх гэрийг үүсгэж өөрийн голомтыг асаах цаг минь болжээ гэж Анна гүнж хэлэв.

Ингээд хурим найр хийжээ.

Хуримын ширээ дундраагүй, хуралдсан зочид ууж халаагүй байхад хүчит аянга нижигнэж, их салхи босож хаалга үүдийг ярав. Их салхи Анна гүнж Бүргэдэйн Бүргэд хоёрыг хаман авч харах бараагүй алга боллоо.

Хаан хүү Иванд ганцаараа уйтгар гунигтай боллоо. Бүтэн жил өнгөрөхөд дүү нар нь газрын ангал руу орсон юм шиг сураглах сураггүй, сонсъё чимээгүй. «Ганцаараа ингэж суух гэж дээ! Өнгөт орчлонг үзье, өргөн хангайг туулья, охин дүү нарынхаа сургийг олж сонсох ч юу магад!» гэж хаан хүү Иван бодож гэнэ.

Шадар сайд нараа цуглуулж хаан төрөө даалгаад хүлэг мориндоо мордож одоход нь улаан тоос татан хоцорч гэнэ. Өндөр уулыг өвөрлөн намхан газрыг нарлан явсаар нэгэн улсад очтол хамаг их цэрэг нь хиар цохигдсон байж гэнэ.

- Амьтай голтой амьтан байна уу? Хэн энэ их цэргийг хиар цохьсон бэ? гэвэл нэгэн хүн:

- Ганц би амьд үлдсэн. Сайхан Марья Моревна гүнж хамаг цэргийг хиар цохьсон гэж хариулав.

Хаан хүү Иван «Хан хорвоод ийм сонин юм байх гэж. Ганц бүсгүй хүн ийм их цэргийг хиар цохьсон гэнэ! Тэр бүсгүйн барааг харахсан!» гэж боджээ. Тэгээд:

- Сайхан гүнж аль зүгт явсан бэ? гэвэл,

- Өмнө зүг рүү явсан гэв.

Хаан хүү Иван элдэвт эргэлзэн саатсангүй мориныхоо жолоог өмнө зүг рүү залав.

Бүтэн хоёр өдөр яваад гурав дахь өдрийн орой болоход дахин хиар цохигдсон үй олон цэрэг дайралдав.

- Амьтай голтой амьтан байна уу? Хамаг их цэргийг хэн ийнхүү хиар цохьсон бэ?

- Сайхан Марья Моревна гүнж манай цэргийг хиар цохьсон гэж хариулах дуулав. Хаан хүү Иван гайхахын ихээр гайхаж баатар бүсгүйг гүйцье гэж яаран морио шавхарч цааш хурдлав.

Яван явсаар нэгэн газар хүрч очвол зах нь харагдахгүй их цэргийг бас хиар цохьсон байна гэнэ.

- Амьд хүн байвал хэлээч! Энэ хэний цэрэг вэ? Дайчин их цэргийг хэн ингэж хядсан бэ? гэвэл бутны цаанаас нэг цэрэг өндийж:

- Ясан хэдрэг хааны гурван их цэрэг хиар цохигдлоо. Яагаад ч үхдэггүй Ясан хэдрэг хааныг суллах гэж бид сайхан Марья Моревна гүнжийнх рүү дайлаар мордсон билээ. Үзэсгэлэнт гүнж улс орондоо ч халдаалгүй угтан ирж амьд хүн үлдээлгүй алж хядаж дуусгалаа гэв.

Хаан хүү Иван хиар цохигдсон их цэргийг тойрон цааш явтал эзгүй хээр талд нэгэн цацар харагдав. Цацрын дэргэд нэг морь буудай идэж байна гэнэ.

Цацрын хаяанд очоод мориныхоо эмээл хазаарыг авч тавиад харвал морь нь шууд яваад буудай руу очиж, нөгөө морь ч хажигласангүй хоёул зэрэгцэн зогсож идэв гэнэ.

«Морийг минь морь нь хажигласангүй, баатрын цацарт надад зай олдох бизээ» гээд хаан хүү Иван цацарт оров. Баатар эр байгаа байх гэтэл тэнд үзэсгэлэн төгөлдөр нэгэн бүсгүй нойрсож байхад хаан хүү Иван гайхан зогтусав. Ийм сайхан үзэсгэлэнтэй хүнийг урьд ер үзээгүй билээ! Хаан хүү Иван ч аян замынхаа алжаалыг тайлан амарч унтмаар санагдав. Үзэсгэлэнт бүсгүйг сэрээсэнгүй, хажууд нь хэвтээд бөх нойронд дарагдав.



Сайхан бүсгүй сэрэн харснаа огло үсрэн босож:

- Уриагүй дуудаагүй байхад орж ирээд унтаж байдаг ёс мэдэхгүй юун хүн бэ? Бас морио буудайд минь тавьжээ! гэж санан илд сугалан далайснаа эргэлзэн бодож гараа буулгав.

«Энэ хүн унтаж байхад минь намайг албал алах л байсан. Унтаж хэвтээ хүнийг алахад эр зориг, алдар нэр юу билээ. Харин ч булай болно» гэж санаад урилгагүй зочныг сэрээв.

- Залуу эр, сэрээч, босооч! гэж хаан хүү Иваныг сэрээгээд:

- Аль нутгийн хэн гэгч вэ? Улаан буудайгаас минь яагаад мориндоо идүүлэв? Хүний цацарт зөвшөөрөлгүй орж унтахын учир юу вэ?

- Хааны хүү билээ би, алдар нэр минь хаан хүү Иван. Таныг харин хэний хэн гэдгийг мэдэхгүй байна. Сайхан Марья Моревна гүнж та биш биз?

- Тиймээ, би Марья Моревна.

- Аа тэгвэл сайхан Марья Моревна гүнж минь, аян замд ядраад амармаар байлаа. Таныг сэрээж төвөг удахыг бодсонгүй. Аяны хүн надад бүү уурлаарай.

Ингэж хаан хүү Иван хэлэхэд сайхан Марья Моревна гүнж тайтгарчээ.

- Хаан хүү Иван, хүсэлдээ хөтлөгдөн явна уу, хүний эрхээр явна уу? гэж Марья Моревна асуув.

- Сайн эр хэзээд хүслийн жигүүртэй билээ.

- Хэрвээ тийм яарах сандрах явдалгүй бол орон улсад минь зочлон саатна уу? гэж Марья Моревна өгүүлэв.

Хаан хүү Иван баяртай зөвшөөрч хоёул Марья Моревнагийн нутаг руу явав.

Хаан хүү Иван долоо хоног зочлон саатахдаа сайхан гүнж Марья Моревнагийн сэтгэлийг татжээ. Марья Моревна гүнж ч учирсан цагаас хаан хүү Иваны хайрыг булаажээ. Тэгээд хаан хүү Иван сайхан гүнж Марья Моревнатай их хурим хийжээ.

Ингээд аз жаргалтай сайхан амьдарч өдрийг дуулж, үдшийг инээн өнгөрөөж байв. Нэгэн удаа Марья Моревна гүнж эгчтэйгээ уулзахаар өөр оронд явах болов. Явахдаа хаан хүү Иванд:

- Хаан төрөө барьж, хамаг бүхнийг хянаж бай. Ордон харшийг минь эзэмшиж бай, харин дурсаар уяж давирхайгаар наасан хаалгыг бүү онгойлгоорой. Юу болсон ч бүү ороорой, хэрвээ тэр хаалгыг онгойлговол бидэнд муу болно гээд явжээ.

Сайхан Марья Моревна гүнж ингэж хэлээд олон түлхүүрээ өгч аян замдаа оджээ. Хаан хүү Иван ганцаар үлдэн, залуу эхнэрээ хүлээн гансран суух болов. Хэдэн өдөр өнгөрөхөд сэтгэлийг нь уйтгар гуниг эзлэн байж суухын аргагүй болжээ.

Уйтгар гунигаа яаж дарах, юу хийхээ мэдэхгүй байтал «Энд өчнөөн жил суусан атал орж үзээгүй өрөө танхим өдий төдий байна. Ямар эзэн гэж ийм байх билээ» гэж бодогдов.

Түлхүүрээ аваад өрөө танхимаар явж бүгдийг үзэв. Үнэт эрдэнэс, эд баялгийг үзээд ч сэтгэл нь сэргэсэнгүй. Хар уйтгар хамаг сэтгэлийг нь эзэлнэ. Марья Моревнагийн ирэх өдрийг тоолон байтал гэнэт нэгэн зоорь өрөөнд орохыг хориглосон нь санагдав.

Энэ тухай санамагцаа уйтгар нь арилж өөр зүйлийг умартан зөвхөн тэр зоорийг бодож эхлэв.

«Тэнд юу хадгалагдан байна вэ? Эхнэр нь мэдэж байгаа мөртөө нөхөртөө үзүүлэхгүй гэнэ! Ийм юм урьд өмнө үзэгдэж, сонсогдоогүй!» гэж тунгаажээ.

Тэгээд хаан хүү Иван тэсэж сууж ядаад гал тогоо руу гүйж очив. Газар хонгил руу орсон, хөвд хаг ургасан нэгэн шат байна гэнэ. Тэр нууц шатаар уруудтал дурсаар уяж давирхайгаар наасан хөвд ургасан нэг хаалга байна гэнэ.

«Намайг бүү ороорой гэсэн өрөө байна!»

Тэсгэлгүй яарсандаа болоод дурсан уяаг тайлсангүй, тохирох түлхүүрийг гаргасангүй хаалгыг дал мөрөөрөө зад түлхэн оров. Босгыг алхан ороход аалзны шүлснээс өөр юм харагдсангүй.

«Өөр зооринд ороод ирж!» гэж бодтол гэнэт ёолох дуу доороос сонсогдов.

- Уух юм өгөөч! Уух юм, ус өгөөч!

Ёолох дуу гарсан зүг тийш очиж харвал хананд нэг ширмэн хаалга байна гэнэ. Тэр хаалганд чихээ наалдуулан чагнавал,

- Уух юм өгөөч, ус өгөөч!

Хаан хүү Иван тээнэгэлзсэн ч үгүй тэр хаалгыг цөм цохив. Хаалганы цаана бас нэг шат байхад тэр шатаар уруудвал тэнд гал дүрэлзэж байв. Гал дээр нэгэн том тогоо арван хоёр гинжээр дүүжилсэн байх аж. Тогоон дотор гар хөл нь гинжлээстэй аймаар ногоон өвгөн сууж байна гэнэ.

- Сайн эр минь, уух юм өгөөч! Гурван жил юм уугаагүй, хатаж үхэх нь гэв.

Хаан хүү Иван өрөвдөн нэг хувин ус өгөв. Өвгөн уучихаад дахин гуйв. Дахиад нэг хувин ус өгвөл өвгөн дахин гуйв. Хаан хүү Иван гурав дахь хувин ус авчрав. Өвгөн гурав дахь хувин усыг уучихаад гар хөлийнхөө гинжийг сэгсэрэхэд төмөр гинж ялзарсан олс шиг тас үсрэв. Ногоон өвгөн тогооноос үсрэн гарч:

- Хаан хүү Иван, чи хайрт эхнэр Марья Моревнагийнхаа барааг дахин харахгүй! Хорт Ясан хэдрэг намайг ундалж хүч чадлыг минь эргүүлж өгсөнд хоёр удаа чамайг өршөөнө. Гурав дахь удаагаа миний нүдэнд бүү өртөөрэй!

Ингэж хэлээд Хорт Ясан хэдрэг их дуу гарган зоориноос нисэн одов.

Яг энэ үед ордныхоо үүдээр орж ирж байсан Марья Моревнаг Ясан хэдрэг шүүрч аваад зугтав. Марья Моревна:

- Хаан хүү Иван, үгэнд минь орсонгүй, гай зовлон тарилаа! Бид хоёр эргэж уулзахгүй боллоо! гэж хашгирч гэнэ.

Хаан хүү Иваны санаа сэтгэл нь шаналж «Алтан Дэлхийг тойрсон ч алжааж цуцалгүй явж амраг Марья Моревнагаа олж авна!» гээд аян замд гарчээ.

Өндөр уулыг өвөрлөн намхан газрыг нарлан явжээ. Үлгэрт хэлэхэд амархан ч үйлс бүтэх нь хэцүү. Явсаар байтал нэгэн ордон харагджээ. Ордны дэргэд царс, царсан дээр Хэрээ сууна гэнэ.

Хэрээ царснаас нисэн бууж газар хөрвөөгөөд сайхан залуу болж хувирав.

- Амар байна уу, хаан хүү Иван. Амрыг эрье, хадам ах минь! гэв.

Тэгтэл Марфа гүнж гүйн ирж ахыгаа угтан авч ордондоо урив. Амттан бүхнээр дайлж аж төрлөө ярьж, асууж шалгааж байна гэнэ.

Хаан хүү Иван гурван хоног зочлоод цааш явахаар салах ёс хийв.

- Тухтай зочилж чадахгүй нь. Сайхан гүнж Марья Моревнагаа олохоос нааш саатан суух завгүй!

- Ухаантайн хүчээр Марья Моревнатай суусан ч ухаангүй загаснаас алджээ. Хорт Ясан хэдрэгтэй хүч үзэх хэцүү билээ! гэж Хэрээчийн Хэрээ хэлэв.

Марфа гүнж уйлан:

- Хайрт ах минь, та үхлийн зам руу явах нь дээ! Хорт Ясан хэдрэг амийг чинь хөнөөнө! Яана даа!

- Дүү минь, нэг үхэхээс хоёр үхэхгүй, сайн эр санаснаасаа буцдаггүй гээд цааш явав. Дүү хүргэн хоёр нь үдэж гаргахад Хэрээчийн Хэрээ хэлсэн нь:

- Явсандаа яв. Гай зовлон дайрвал чадлаараа тусална гээд хэрээний нэг өд өгч,

- Гай тохиолдвол бид мэдэх болно гэв.

Хаан хүү Иван мориндоо мордон давхиж одоход улаан тоос татан хоцров.

Өндөр уулыг өвөрлөн намхан газрыг нарлан явсаар урьдынхаас сайхан ордон үзэв гэнэ. Ордны хаяанд гурван царс, царсан дээр Шонхор сууна. Хаан хүү Иван ордонд ойртон ирмэгц Шонхор шувуу газар хөрвөөгөөд сайхан залуу болж хувираад:

- Ольга гүнж, гараад ирээч, хүндэт зочноо угтан аваач гэж хашгирав.

Ольга дүү нь үүдэндээ гарч ирэн золгов. Хаан хүү Иван ахыгаа үзээд баярласан Ольга гүнж хаанаа суулгаж, юугаар дайлахаа олж ядан хөөрнө. Ундалж цайлаад унтуулжээ.

Маргааш өглөө нь хаан хүү Иван эртийн эрт босож нүүр гараа цэмцийтэл угаагаад:

- Талх давс барьж, дайлан зочилсонд гялайлаа! Ах нь одоо явья гэхэд,

- Ах минь, явна гэж юу гэсэн үг вэ? Ядахдаа долоо хоног зочил, юундаа яарах вэ!

- Саатан үлдэж чадахгүй нь сайхан Марья Моревна гүнжийг Ясан хэдрэгийн гараас аврах хэрэгтэй.

Ольга гүнж уйлж, Шонхорын Шонхор:

- Ясан хэдрэгтэй үзэлцэх гэдэг хэцүү, гэвч одоо яая гэх вэ. Хамаг хэрэг өөрийн чинь буруу, явтугай гээд шонхорын нэг өд өгч,

- Чамд аюул тохиолдвол бид мэдэх болно гэв. Тэгээд хаан хүү Иван хүргэн Шонхор дүү Ольга хоёрыгоо тэврэн үнсээд цааш явав.

Явсаар явсаар амьтан хүн байхгүй битүү харанхуй хар ойд оров. Морь нь эцэж өөрөө ч өлсжээ.

Гэтэл ойн цоорхойд урьд дайралдсан хоёр ордноос илүү гоё ордон байна гэнэ. Ордны дэргэд есөн өндөр царс, тэр есөн царс дээр Бүргэд сууна гэнэ. Бүргэд хаан хүү Иваныг хармагцаа нисэж газар хөрвөөгөөд сайхан залуу болж хувираад:

- Эрхэм ах, таныг эртнээс хүлээж байлаа! гээд ордондоо дагуулан оров.

- Анна гүнж минь, гал дээр байгаа бүхнээ

ширээн дээр тавь! гэхэд Анна гүнж ширээгээ засаж идээ зууц, бал дарс өржээ.

Хүндэт зочноо хүргэн дүү хоёр нь хүндлэн зочилж дайлж цайлаад учир явдлыг асуув. Хаан хүү Иван аж байдлаа ярьж, дүү нартайгаа уулзахаар гэрээсээ гарснаа, сайхан гүнж Марья Моревнатой уулзсанаа, Хорт Ясан хэдрэгт ус уулгаснаа гэтэл Ясан хэдрэг Марья Моревнаг аваад зугтсаныг ярьжээ.

- Ингээд эхнэрээ Хорт Ясан хэдрэгийн гараас аврах гэж яарч явна гэв. Бүргэдэйн Бүргэд:

- Хүндэт ах минь, энэ бүгдийг чинь бид мэдэж байна. Ухаантайн хүчээр Марья Моревнатой суусан ч ухаангүй загнаснаас эндэж алджээ. Хорт Ясан хэдрэгтэй тэмцэлдэж, хонгор Марья Моревнагаа аврах гэдэг хэцүү шүү!

- Хэцүүгээс хэлтийхгүй, араатнаас айхгүй! Нэг үхэхээс хоёр үхэхгүй. Марья Моревнагүй амьд явснаас яваагүй нь дээр! гэж хаан хүү Иван хариулав.

Хаан хүү Иван алжаалаа тайлж амраад аян замдаа мордов. Бүргэдэйн Бүргэд бүргэдийн нэг өд өгөөд:

- Биедээ хадгалж яваарай. Гай зовлон учирвал бид мэдэх болно, чадлаараа тусална гэв. Хаан хүү Иван хүргэн дүү хоёртоо талархаад мориндоо мордон Ясан хэдрэгийн нутаг руу явав.

Өндөр уулыг өвөрлөн намхан газрыг нарлан явсаар хаан хүү Иван нэгэн том ордон харав. Ордны цонхны цаана зовж шаналсан Марья Моревна сууж байна гэнэ.

Марья Моревна хаан хүү Иваныг хараад халуун нулимсаа мэлтэлзүүлэн:

- Хаан хүү Иван, хайрт нөхөр минь, юу гэж энд ирэв? Намайг аварч суллаж чадахгүй алтан амиа алдана. Ясан хэдрэг одоо буцаж ирээд чамайг алчихна. Ухаантайн хүчээр намайг авч суусан ч ухаангүй загнаснаас эндэж алдсан билээ чи!

- Марья Моревна, бүү уурлагтун! Түмэн бурууг минь уучил, дахиад би ингэхгүй. Одоо чамайгаа аврахаар ирлээ. Ганцаараа амьд явснаас чамтай цуг үхсэн дээр. Түргэл, эндээс явья! гэжээ.

Хаан хүү Иван Марья Моревна хоёр дөнгөж мордмогц Ясан хэдрэгийн зарц харцага болж хувираад Аггаалжин хар могойнх руу нисэж очоод:

- Энд чи идэж ууж наргиж цэнгээд, эх нутгаа мартав уу? Хаан хүү Иван ирээд Марья Моревнаг аваад явчихлаа! гэв.

Ясан хэдрэг морь руугаа үсрэн очиж:

- Морь минь, хурдал! Биднийг энд зочилж байх хооронд хаан хүү Иван Марья Моревнаг аваад явчихаж! Оргодол тэднийг гүйцэж чадах уу?

- Яарах хэрэггүй. Дахин гурав хоног найрлан цэнгэ, ханатлаа унт. Дараа нь бялуу жигнэж цадталаа ид, тэгээд явна гэж морь нь хэлэв.

Ясан хэдрэг дахин гурав хоног найрлаж, гурав хоног унтаад, дараа нь бялуу жигнүүлж, цадталаа идэж аваад морджээ. Хорт Ясан хэдрэг мордов уу, үгүй юу хаан хүү Иван Марья Моревна хоёрыг гүйцэв.

- Хаан хүү Иван, чи намайг ундалж хүчийг минь тэнхрүүлсэн учир би чамайг эхний удаа амьд үлдээсэн, одоо бас өршөөе. Гурав дахь удаагаа нүдэнд минь бүү өрт! Ахин нүдэнд минь өртвөл амьд үлдэх гүй шүү! гэж Ясан хэдрэг хашгирав.

Хаан хүү Иван илдээрээ цавчихад илд нь Ясан хэдрэгийг даахгүй хальтарч гулгана. Ясан хэдрэг:

- Хаан хүү Иван, чи ухаангүй болой. Хурц илд, хүч чадалдаа найдаа юу? Намайг илд даахгүй, ямар ч хүч дийлэхгүй гээд хөхрөв.

Ясан хэдрэг Марья Моревнаг шүүрч аваад эргэж давхихад хаан хүү Иван бараагий нь хараад хоцорчээ.

«Одоо яах вэ? Марья Моревнагаа яаж аврах вэ? Марья Моревнагаа орхисноос халз тулаанд үхсэн дээр!» гэж гуниж гутран бодов.

Тэгээд Хаан хүү Иван дахин Хорт Ясан хэдрэгийн нутаг руу явжээ. Ясан хэдрэгийн морь гурав харайх газарт хаан хүү Иваны морь гурван долоо хоног явна.

Хаан хүү Иван тэднийх рүү явж байх үед Ясан хэдрэг зуун уулын цаанатаа зургаан улсын тэртээ хол газар явахаар зэхэж барлаг ороолондоо:

- Би Атгаалжин хар могойнх руу загалмайлах найранд явлаа. Ордон эзэмшлээ хамгаал, онц аюул учирваас хэл өг! гэж захижээ.

Хаан хүү Иван Ясан хэдрэгийн ордонд хүрч ирэхэд Марья Моревна цонхны цаана уйлан нутгийнхаа зүг ширтэн сууна гэнэ. Марья Моревна хаан хүү Иваныг хараад улам их уйлж:

- Яах ч гэж эргэж ирэв дээ! Яасан ч бид зугтаж чадахгүй. Ясан хэдрэг мориороо биднийг гүйцээд чамайг алчихна.

- Үхэх цаг ирэхэд хэзээд нэг үхнэ. Чамаас хагацсанаас үхсэн дээр! гэж хаан хүү Иван хариулав.

Энэ үгийг сонсоод Марья Моревна тайтгарч олон зовлон тоочилгүй хаан хүү Иваныг ундалж хооллуулаад морио амрааж аваад хоёул явжээ.

Ясан хэдрэгийн зарц харцага болж хувираад Атгаалжин хар могойн загалмайлах найр болж буй агуй руу нисэн очив.

- Чи энд ууж идэж, найрлан цэнгэх хооронд чинь улс оронд чинь гай дайрлаа. Хаан хүү Иван Марья Моревнаг дахиад аваад авчихлаа! гэжээ.

- Хэзээ явав?

- Долоо хоног болж байна. Ясан хэдрэг морь руугаа очин:

- Биднийг энд найрлах зуур хаан хүү Иван ирээд Марья Моревнаг аваад явчихжээ. Долоо хоног өнгөрч байна гэнэ. Бид одоо гүйцэх үү? Морь:

- Дахиад гурван өдөр найрлан цэнгэ, дараа нь гурван өдөр амар. Дараа нь бялуу жигнэг! Бялуу цадталаа идэж аваад явахад тэднийг дорхноо гүйцнээ! гэжээ.

Тэгээд Ясан хэдрэг дахин гурван өдөр найрлаж, дараа нь гурван өдөр унтаж, дараа нь гурил эсгэж бялуу хийхийг тушаав. Тэгээд цадталаа бялуу идэж аваад мориндоо мордон гурав харайлган хаан хүү Иван Марья Моревна хоёрыг гүйцэв.

- Одоо чамайг өршөөхгүй!

Ингэж хэлээд Ясан хэдрэг хаан хүү Иваныг шидэт илдээрээ хэсэг хэсэг болгон цавчиж хаяад «Ингээд хэрээ шувууны хоол бол!» гэв. Тэгээд Марья Моревнаг аваад явав.

- Хаан хүү Иваныг би яав, чи хараа биз дээ? Хэрвээ надтай суухгүй бол чамайг бас ингээд л хаяна! гэжээ.

Ясан хэдрэг хаан хүү Иваныг цавчихад Хэрээчийн Хэрээ, Шонхорын Шонхор, Бүргэдэйн Бүргэд гурвын өдөн дээр цусан толбо гарчээ.

- Ахад минь гай тохиолдож!

Ингээд гурвуул хаан хүү Иваны хэдэн хэсэг цавчигдан хөсөр хэвтэж буй газар нисэн ирцгээв. Бүргэдэйн Бүргэд:

- Хэрээчийн Хэрээ, чи билгийн ус авчир, Шонхорын Шонхор, чи мөнхийн ус авчир, би эндээ үлдэж биеийг маная гэжээ.

Хэрээчийн Хэрээ, Шонхорын Шонхор нисэн одоход Бүргэдэйн Бүргэд биеийн хэсэг бүрийг булгийн усаар угаагаад байх ёсоор нь байрлуулан тавив. Тэгтэл ч Хэрээ Шонхор хоёр эргэн ирж, биеийг эхлээд билгийн усаар шүршвэл хэсэг бүр нийлэн ургаж эдгэв гэнэ. Дараа нь мөнхийн усаар шүршвэл хаан хүү Иван суниан биеэ чангалснаа нүдээ нээв.

- Би яасан их унтав! гэхэд нь,

- Хэрвээ бид байгаагүй бол эндээ мөнхөд нойрсох байсан бизээ гэж хүргэнүүд хэлээд,- Бос, бос, манайхнаар очиж амар! гэжээ.

- Эрхэм дүү нар минь, зочилж явах зав надад алга. Марья Моревнагаа аврах хэрэгтэй. Ясан хэдрэгийн гараас Марья Моревнагаа суллаж аваад танайхнаар зочилж очно гэж хаан хүү Иван өгүүлэв.

Хаан хүү Иван хүргэнүүдтэйгээ салах ёс хийгээд Ясан хэдрэгийнх рүү яаран явав. Марья Моревна түүнийг хармагцаа баярлан уйлах инээх хослуулна.

- Харж ханашгүй чи минь, хаан хүү Иван минь, чи минь мөн үү?

Мөн мөн, би байна.

Ингээд Хэрээчийн Хэрээ, Шонхорын Шонхор, Бүргэдэйн Бүргэд яаж түүнийг аварч амьдруулсан тухай хаан хүү Иван ярив.

- Ясан хэдрэгийг хар хүч, хатан илдээр дийлэхгүй юм шиг байна. Ясан хэдрэг зальтай аваас бид түүнээс илүү заль гаргах хэрэгтэй. Хурдан морь хаанаас олж авсан, амь нь хаанаа байдгийг чи асууж тагнаж мэд. Дараа нь би түүнтэй эр эмээ үзэлцье гэж хаан хүү Иван Марья Моревнад хэлэв.

Марья Моревна энэ үед ордондоо ганцаар байсан тул хаан хүү Иваныг цайлж дайлаад дараа нь зооринд оруулан:

- Энд нуугдаад хүлээж бай гэжээ.

Зоорио дөнгөж хааж амжтал их дуу чимээ гаран Хорт Ясан хэдрэг нисэн ирэв.

- Пах, пөх, яасан хачин юм бэ? Миний ордноос хүний үнэр үнэртээд байна!

- Хонгор минь, юу ярина вэ? Энд юун хүний үнэр байх билээ? Чи дэлхийг тойрон нисэхдээ хүний үнэртэй болоо биз. Хоол ундаа зоогло, тэгээд хэвтэж амар гэж Марья Моревна эелдэгхэн өгүүлэв.

Эелдэгхэн үгс Ясан хэдрэгийн сэтгэлд их л таатай нийцэв. Ясан хэдрэг ширээнд сууж шарсан шарын өрөөл мах идээд дөчин хувин багтдаг торхны тэн хагас дарсыг уугаад ханзан дээрээ өнхрөөд өгчээ.

Марья Моревна хажууд нь сууж:

- Чамайг үгүйд ихэд уйтгартай байлаа. Эргээд ирэхээр чинь уйтгар гуниг минь хийсэн арилж сэтгэл минь зуны нар шиг цэлмэлээ!

Ясан хэдрэг ийм энхрий үгсийг сонсоод их таатай инээмсэглэн хэвтэнэ.

- Марья Моревна минь, чихэнд чимэгтэй үгс чинь сэтгэлийг уяраалаа. Үнэн сэтгэл чинь ийм болбоос хурим найраа хийе! Хаан хүү Иван одоо ирэхгүй, аль хэдийнээ хэрээ шувууны хоол болсон.

- Хаан хүү Иван үхсэн гэж мэдэж байна, чамаас өөр надад тэнцэх нөхөр ч байхгүй гэдгийг мэдэж байна. Иваны нөгчсөнөөс хойш яг нэг жил өнгөрөөгөөд чамтай сууна.

Ясан хэдрэг их л баярлан «Жил гэдэг зуун биш юу байхав» гэж бодов. Марья Моревна:

- Чи ийм хурдан морь хаанаас авсан бэ?

- Зуун уулын цаанатаа зургаан улсын тэртээгээс би энэ морио авсан. Тэнд гал голын цаад талд миний нагац эгч Шулмас эмгэн амьдардаг. Шулмас эгчид минь гурван өдрийн дотор дэлхийг тойрдог, гучин жилд нэг удаа унагалдаг гүү бий. Шулмас эгчийн минь арван хоёр гүүг гурван өдөр хариулаад нэгийг нь ч алдахгүй бол тэр гүүний унагыг өгдөг юм. Харин хариулж чадахгүй алдвал толгойгий нь авдаг юм. Олон ч сайхан эр тийшээ очсон, хэн ч амьд үлдээгүй. Ганцхан би амьд ирсэн юм. Шулмасын гүүг хариулах гэдэг гай зовлонгоос хэцүү. Гал гол дээгүүр гарах гэдэг бүүр ч хэцүү!

- Яаж чи минь гал гол дээгүүр амьд гарсан бэ? Ясан хэдрэг нүүр гарын нэгэн алчуур үзүүлэн:

- Энэ алчуурыг гурван удаа баруун тийш сэгсрэхэд гал гол дээгүүр өндөр гүүр бий болно. Гүүрэнд гал хүрэхгүй. Гурван удаа зүүн тийш сэгсрэхэд гүүр алга болно!



Марья Моревна Ясан хэдрэгийг энхрийлэн:

- Хонгор минь, чиний амь чинь хаана байдаг вэ? Хэлээч наддаа, бүү нуугаач! гэвэл Ясан хэдрэг:

- Олныг мэдвэл одоохон хөгширнө! гэв.

- Амь чинь хаана байдгийг мэдвэл би чамайгаа аюул бүхнээс аварч чадахсан даа гэж

Марья Моревна дахин эелдэгхэн гуйв.

- Миний амь тэр пийшингийн дор хэвтэж байгаа шүүрт байгаа гэж ээжээсээ сонссон юм байна.

Тэгэхэд нь Марья Моревна пийшин дороос шүүрийг авч торгон алчуурт ороогоод хойморт тавив. Ясан хэдрэг хөхрөн:

- Эм хүний үс урт, ухаан богино! Миний амь хогийн шүүрт байна гэдэг байж болох уу даа? Ха, ха, ха. Миний амь өндөгөнд, өндөг нугасанд, нугас туулайд, туулай төмөр авдарт, цоожтой авдар тэнгис далайн дундах Буянт арлын дээрх том царсны дор булаатай байгаа. Тэнд л миний амь байгаа даа! Хэрвээ ямар нэг хүн тэр аралд хүрч чадлаа ч миний амь хүний гарт тийм амар баригдахгүй гэв.

Ингээд нэг шөнө өнгөрч, өглөө нь Ясан хэдрэг шарсан шарын өрөөл махаа идээд гурван хувин дарс уугаад аян замд зэхэж эхлэв.

- Атгаалжин хар могойнхоор зочлоод ирье. Эргээд ирэхэд хуримд бэлэн байгаарай! Ингэж хэлээд Ясан хэдрэг мордон явмагц Марья Моревна хаан хүү Иванд сонссон бүгдээ ярьж, шидэт алчуурыг өгөөд замын хүнс төхөөрөв.

Тэгээд хаан хүү Иван зуун уулын цаанатаа зургаан улсын тэртээ Шулмас эмгэнийд очиж хурдан морь олж авах, эсвэл үхэх эсэхээ үзэхээр явлаа.

Өндөр уулыг өвөрлөн намхан газрыг нарлан явсаар Марья Моревнагийн жигнэж төхөөрч өгсөн замын хүнсийг дуусаад өлсөж ядрахын туйлд хүрэв.

Тэгээд замын хажуудах чулуун дээр амрахаар сууж байжээ. Тэгтэл хажуугаар нь баавгай бамбарууштайгаа гүйж явав.

Хаан хүү Иван хурц сумаа гаргаж нумаа хөвчлөн баавгайг онилтол,

- Сайхан залуу минь, намайг бүү харва, бамбаруушуудыг минь бүү өнчрүүл! Чамд би тус болно гэж баавгай гуйв.

Хаан хүү Иван тэр ёсоор болгон харвасангүй. Өлссөнөө тэсвэрлэн амарч суугаад цааш явав. Өндөр уулыг өвөрлөн намхан газрыг нарлан явсаар тун их ядарч, өлсөж цангажээ. Тэгтэл зөгийн нэгэн том үүр харагдав.

«За байз хө, бал идье!» гэж бодтол хатан зөгий:

- Хаан хүү Иван, үүрэнд минь бүү хүр, үрсийг минь бүү түйвээ! Ачийг чинь ачаар хариулна гэжээ.

- Чамайг яая гэх вэ! Дахиад тэсвэрлэхээс дээ!

Ингэж хэлээд хаан хүү Иван цааш явжээ. Хаан хүү Иван өлсөж цангаж ядарч туйлдаад хөлөө зөөж ядан явав.

Ийнхүү явсаар тэнгисийн захад хүрэв. Гэтэл усны эрэг дээр нэгэн том цурхай загас хэвтэж харагдав.

«Өлссөн гэдсэндээ хийх юм олдлоо!» гэж бодоод цурхайг барьж авах гэтэл,

- Сайхан залуу минь, намайг тэнгист тавиач! Үнэнч шударгаар чамд тусална гэж цурхай гуйв.

Хаан хүү Иван «Баавгайг явуулсан, зөгийнд хүрээгүй, цурхай ч бас гэмгүй амьтан! Ахиад нэг цаг тэсвэрлэе, ойр хавьд амьтан хүн байгаа биз» гэж бодов.

Тэгээд цурхайг тэнгист тавиад, бүсээ чангалж бүслээд цааш явжээ.

Тэнгисээс холгүйхэн нэгэн байшин харагдана гэнэ. Тэр байшинг чиглэн явгал байшин голын цаана байна гэнэ. Голоор ус биш гал улаан дөл улалзан урсаж байв.

Хаан хүү Иван өврөөсөө Ясан хэдрэгийн шидэт алчуурыг гарган баруун тийш гурав дахин сэгсэртэл гал гол дээгүүр нуман гүүр бий болов гэнэ. Гал гүүрэнд хүрэхгүй байв. Хаан хүү Иван голын цаана гараад алчуураа зүүн тийш гурав сэгсэрвэл гүүр алга болчихжээ. Тэгээд Дов дээр гарвал тахиан хөлт байшин өмнө нь харагдав. Тахиан хөлт байшинг тойруулсан шивээ хашааны мод бүрийн орой дээр хүний гавлын яс өлгөөтэй гэнэ. Ганц мод л хоосон ажээ.

Хаан хүү Иван «Энэ модонд миний толгойг өлгөх юм биш байгаа?» гэж бодов.

- Тахиан хөлт байшинхан минь, ар ханаа ой руу онгойх хаалгаа над руу харуулаач! Зууныг энд хороохгүй зуур хоноод явна гэв.

Байшинхан ар ханаа ой руу онгойх хаалгаа сайхан залуу руу харуулав. Хаан хүү Иван довжоон дээр нь гарч хаалгыг нь дэлгэн харвал тааз хүрсэн хамартай, тахир дэгээ гартай, ясан хөлт Шулмас эмгэн суугаад утас ээрч ясан хөлөөрөө дэвслэн байна гэнэ. Хаан хүү Иваныг хармагцаа амаа байдгаараа ангайгаад:

- Ээх, хүний үнэр үнэрлээгүй олон жил болсон юмсан. Одоо чинь орос сайн эр өөрөө ороод ирдэг болоо шив! гэв.

- Хөгшин Шулмас минь, хүлээж бай! Аяны хүнийг эхлээд ундал, халуун усанд орж, хар хирнээсээ салах минь! Дараа нь ярих юмаа ярилцъя гэж хаан хүү Иван хэлэв.

Шулмас эмгэн сөхрөн сууж, зоорио уудлан дугуй талх гаргаж, пийшингийнхээ амыг харчигнуулан шөл аягалж хаан хүү Иваныг ундлав. Халуун усныхаа байшинг галлаж хаан хүү Иван ч хар хирнээсээ салав. Тэгээд хаан хүү Иван ханзан дээр нь гараад хэвтэв.

Шулмас эмгэн:

- Сайхан залуу эр ажлаас зугтаж явна уу, ажил эрж явна уу?

- Эмгэн, танд хурдан морь бий гэж дуулаад ирлээ. Надад хурдан морь хэрэгтэй байна.

- Надад хурдан морь бий нь бий. Харин зүгээр өгөхгүй, зүгтэй өгнө. Гурван жил ч биш, нэг жил ч биш, ердөө гурван өдөр гүүнүүдийг минь хариул. Гүүнээс минь алдахгүй хариулж чадвал хурдан морь шанд нь аваарай, чадахгүй бол өөртөө гомдоорой. Гадаа шивээнд өлгөөтэй байгаа толгойнуудыг харсан биз дээ? Ганц толгой дугуу байгаа шүү гэв.

Шулмас эмгэн өглөө босоод хаан хүү Иваныг хооллуулж ундлаад үс зүс нь ив ижил арван хоёр гүүгээ гаргав. Гүүнүүд сүүлээ агсан тал тийш бутран ой руу орж алга боллоо. Хаан хүү Иван тэдний зөвхөн барааг хараад хоцров.

Хаан хүү Иван ойд ороод хожуул дээр гутран сууж байтал хаанаас ч юм бэ, баавгай гүйж ирэв.

- Гутарч гонсойгоод яах вэ! Хугархааргүй сайн саваа бэлдэж аваад тайван унт. Би орой гэхэд бүх гүүг цуглуулаад ирье. Чи тэднийг саваагаараа сүвээ рүү нь гуядан туугаарай, тэд зугтаж чадахгүй гэр лүүгээ явна гэжээ.

Баавгай гүйгээд явчихав. Хаан хүү Иван тэс модны мөчрөөр нэг сайн саваа бэлдэж аваад хожуул дэрлэн унтаад өгчээ.

Нар жаргахын үед ойд морин төвөргөөн гарч зүг зүгээс дэл нь босож, бие нь чичирсэн арван хоёр гүү давхин ирэв. Хаан хүү тэднийг саваагаар сүвээ рүү нь шавхарч гарав. Тэс мод хатуу, тахийвч үл хугарна. Нуруугий нь ороолгоход нугдайлгана. Ингэж арван хоёр гүүг номхотгож, арван хоёр гүү усан хулгана болтлоо хөлрөөд гэр лүүгээ давхицгаав.

Шулмас эмгэн хаалгаа онгойлгон хашаандаа гүүгээ хашив.

- Ай хижиг, усалж идүүлэхээсээ илүү хөөж тууж зовоогоо шив! гэжээ

Тэгээд ширээ засаж хаан хүү Иваныг хооллуулав

- Одоо унт, үүрээр чамайг сэрээнэ!

Хаан хүү Иван унталгүй чагнан хэвтвээс Шулмас эмгэн төмөр саваа шүүрч аван агтны хашаандаа очоод:

- Яасан ясан хэдрэгүүд вэ? Би та нарт юу гэж хэллээ! Зугтан алга болж чадсангүй юу! Шулмас эмгэн төмөр саваагаа хугартал гүүнүүдээ нүдэв.

- Яаж бид алга болох вэ? Манай ойд хамаг газрын баавгай хүрээд ирчихэж! Бид гэр лүүгээ зугтаагүй бол та биднийг ингэж харж байхгүй сан! Бид баавгайн хоол болох байлга.

Маргааш нь Шулмас эмгэн үүр цүүрээр хаан хүү Иваныг сэрээн талхны зах өгөөд:

- За яв, амласнаа биелүүл гэв.

Хаан хүү Иван гүүнүүдийг хашаанаас гаргамагц тэд сүүлээ агсан зүг зүг рүү давхин одов.

Хаан хүү Иван явсаар ойд очиж хожуул дээр сандайлаад «Яаж гүүн сүргийг цуглуулах билээ» гэж гутран суутал хатан зөгий нисэн ирэв.

- Жин-жин, бүү гутар, унгаж амар орой ажил чинь бүтнэ. Орой гүүнүүд цуглаад ирэхээр нь ташуураар тас ороолго, нэг нь ч үлдэхгүй гэр лүүгээ гүйнэ гэж зөгий хэлэв.

Зөгий нисээд явчихав. Хаан хүү Иван ташуур сүлжиж аваад унтжээ.

Нар шингэхийн үед ойгоор их чимээ гарч арван хоёр гүү хөөс сахруулан, чихээ солбилзуулан тангаран тангарсаар тал талаас давхин ирэв. Хаан хүү Иван хашгиран исгэрч ташуураараа далайтал цөм гэр лүүгээ давхив.

Шулмас эмгэн үүдэндээ зогсоод хараан зүхнэ.

- Пөх, энэ муу хижиг, алуурчин, гүүнүүдийг минь хөөгөөд усалж ундалсангүй! Шулмас эмгэн гэртээ орж ирээд хаан хүү Иванд аяга шөл, талхны хатсан зах өгөв. Хаан хүү Иван шөлийг уучихаад ханзан дээр хэвтээд унталгүй чагнаж байж гэнэ.

Шулмас эмгэн зэс саваа шүүрч аваад агтныхаа хашаанд очиж гүүнүүдээ зэс саваагаар гуядаж хараав.

- Өчигдөр би та нарыг бага нүдэж дээ. Дахиад алга болж чадсангүй юу!

- Зөгийнүүд байгаагүй бол биднийг хаанаас ч олохгүй, цуглуулахгүй байхсан. Үзэгдэж харагдаагүй олон зөгий нисэн ирж биднийг хатган хөөж тэсвэрлэхийн аргагүй болголоо!

- Хуурай газар нуугдаж чадахгүй бол маргааш усан дотор нуугдацгаа! гэж Шулмас эмгэн хашгирав.

Өглөө нь гүүнүүд тэнгисийн эрэг рүү давхин ус руу үсрэн орцгоов. Усан дээр зөвхөн дугуй хээ, хөөс гараад хоцров. Дараа нь чив чимээгүй болов. Хаан хүү Иван усны эрэгт чулуу сандайлан

«Яаж ч тэнгисийн гүнээс гүүнүүдийг эрэх билээ дээ?» гэж санаашран суув. Гэтэл уснаас цурхай цухуйж:

- Хаан хүү Иван, бүү санаашир, би цөмийг хөөгөөд авчирна! Би өнөөдөр чиний ачийг чинь хариулна. Хэрэгтэй цагтаа намайг санаж байгаарай.

Ингэж хэлээд цурхай алга болов. Хаан хүү Иван өдрийг арайхийн өнгөрөөжээ. Орой нар жаргахын үед тэнгис давлагаалж, арван хоёр гүү нэг нэгээр дараалан уснаас годхийн гарч ирэв. Дэл нь босож хамар нь сарталзан чичирцгээнэ.

Хаан хүү Иван гүүнүүдийг туугаад ирэхийг Шулмас эмгэн хараад уурлан гүүнүүдээ тоолж тоолж, ясан хөлөөрөө дэвслэн, гараа савчин хараав.

- Ясан хэдрэгүүд, нуугдаж чадсангүй! За гайгүй ээ, тэртэй тэргүй миний гараас амьд гарахгүй гээд Шулмас эмгэн:

- За сайхан залуу минь, сайн байна! Албыг алдалгүй гүйцэтгэлээ! Одоо тэр хамгийн цаад талын хашаанд оч. Тэнд чиний авах хурдан морь бий ав.

Хаан хүү Иван тийш очвол тэнд нэг өлөн туранхай морь байв.

- Ийм адсага дээр баатар эр мордох биш ус зөөх биз! гэтэл морь:

- Хаан хүү Иван, намайг бүү гологтун. Үгийг минь сонс. Гүүнүүд чамаас зугтаж нуугдаж гэж Шулмас эмгэн гурван шөнө миний хүчийг гүүнүүдэд өгсөн юм. Хэрвээ чи энэ шөнө унтвал чиний бүх хүчийг сороод авчихна, чи ч амьд үлдэхгүй. Өнөө шөнийн дотор хоёулаа гал голыг гатлах хэрэгтэй. Голын цаана хоногт хүргэдэггүй хонин өвс ургаж буй. Тэр өвсний шүүдэр дээр хөрвөөхөд хүч минь эргээд ирнэ. Оройн хоол идчихээд бүү унт, над руу хүрээд ир гэжээ.

Шулмас эмгэн хаан хүү Иваныг эелдэгхэн угтаж янз бүрийн хоол ширээнээ өрөн:

- Сайхан залуу, зооглогтун! Амласнаа биелүүлж азтай зочин боллоо. Цадталаа ид, ханатлаа унт, үүрийн харанхуйгаар сэрээхгүй гэж өгүүлэв.

Аман дотроо «Гайгүй ээ чи, дахиж сэрэхгүй бөх нойрсоноо» гэж занан зүхнэ.

Оройн хоолны дараа Шулмас эмгэн унтаж, хаан хүү Иван агтны хашаа руу сэмхэн очиж морийг гаргаж аваад гал гол руу явав. ал голын захад ирээд шидэт алчуураа баруун тийш гурав сэгсэрвэл голын дээгүүр өндөр гүүр бий болов. Голын цаана гараад шидэт алчуураа зүүн тийш гурав биш хоёр сэгсэрвэл гүүр тун нарийхан болон үлдэв.

Морь нь хоногт хүргэдэггүй хонин өвстэй нугад очиж үүрийн гэгээнээр шүүдэр дээр хөрвөөгөөд босож биеэ сэгсрэн:

- За хаан хүү Иван минь, энэ бие минь тэнхэрлээ, эр чадал минь эргэлээ! Чамд хэрэгтэй газар явья! гэжээ

- Тэнгисийн дундах Буянт арал дээр очихсон гэж хаан хүү Иван хэлэв.

- За намайг уна, явцгаая!

Энэ үед Шулмас эмгэн сэрж, пийшин дээрээсээ үсрэн буувал хаан хүү Иван алга болжээ. Агтныхаа хашаа руу гүйн очвол тэнд хоосон байв

- Морийг минь хулгайлж аваад оргочихож! Хаан хүү Иван, за чи харж байгаарай! Чиний гавлын ясыг өлгөчихөөд инээх цаг ирнээ гайгүй!

Ингээд Шулмас эмгэн чулуун ууртаа сууж хаан хүү Иваны мөрөөр хөөж гарав. Нүдүүрээр уураа түлхэн түлхэн, мөрөө шүүрээр шүүрдэн арилгасаар явна. Тэгээд гал голын захад ирээд гүүр байхыг харав. Гүүрэн дээгүүр гарч явахад дөнгөж дангаж тогтож байсан гүүр Шулмас эмгэнийг голын дунд очиход нурж унав. Ингээд Шулмас эмгэн гал голд унаж шатаж үхэв.

Хаан хүү Иван тэнгис далайн эрэг дээр ирээд шидэт алчуураа гурав сэгсэртэл Буянт арлыг хүртэл гүүр тавигдав гэнэ.

Гүүрэн дээгүүр давхисаар Буянт арал дээр очин хамгийн өндөр царсны дор ухаж эхэлжээ. Ухаж ухаж төмөр авдарт хүрэв. Авдрын цоожийг хэмх цохин тагийг онгойлгомогц туулай үсрэн гарч ой руу зугтав. Хаан хүү Иван ой руу давхитал өөдөөс нь баавгай туулайг барьчихсан гарч ирэв.

Хаан хүү Иван туулайн гэдсийг хүүлтэл нугас гарч тэнгэрт нисэв. Хаан хүү Иван нум сумаараа нугасыг харвахад нугас тэнгист үхэтхийн унав. Одоо яах вэ? Хаан хүү Иван цурхай загасыг санав. Тэр хоромд цурхай гарч ирэн нугасыг шүүрч аван эрэг дээр гаргаж өгөв.

- Сайхан залуу минь, нугасаа ав! Би чиний ачийг мартаггүй гэв.

Хаан хүү Иван нугасыг өвчиж өндгийг авч алчуурт боогоод богцондоо хийжээ. Тэгээд мориндоо мордон:

- Хорт Ясан хэдрэгийнх руу хурдлаад! гэв.

Ясан хэдрэгийн ордонд ирвэл Марья Моревна довжоон дээрээ уйлан уулгалан гарч ирэв.

- Хаан хүү Иван минь, одоо Ясан хэдрэг буцаж ирээд чамайг минь алчихна даа!

- Одоо ч Ясан хэдрэгтэй үзэлцэнэ шүү! Хэн нь хэнийгээ дийлэхийг хэрэг үйлс үзүүлэг! За миний араар сундалд!

Ингэж хэлээд хаан хүү Иван Марья Моревнаг сундалдаж аваад давхив. Яг энэ үед Ясан хэдрэг гэртээ буцан ирж довжоо өөдөө өгсөн:

- Марья Моревна, хуримын ширээнээ зэрэгцэн суухад бэлэн үү? гэж хашгирлаа. Зарцууд нь гүйн гарч:

- Хаан хүү Иван ирээд Марья Моревнаг аваад явчихлаа гэхэд Ясан хэдрэг уурлан:

- Яагаад явуулсан бэ!

Ясан хэдрэг зарцууд руугаа үсчин заримынх нь гарыг, заримынх нь хөлийг цавчиж заримыг нь алав. Тэгээд агтныхаа хашаа руу гуйн очиж мориндоо:

- Зовлонг минь сонс. Хаан хүү Иваныг хүргэнүүд нь амь оруулчихаж, тэгээд хаан хүү Иван дахин Марья Моревнаг аваад явчихжээ!

Морь нь:

- Энэ удаа удаж болохгүй. Хаан хүү Иваны морь нь миний дүү. Бушуу морд!

Ясан хэдрэг мөрдөн хөөсөөр хаан хүү Иван Марья Моревна хоёрыг гүйцэхийн даваан дээр морь нь бүдчээд эхэлжээ.

Ясан хэдрэг уурлан харааж:

- Чонын хоол өвсний тулам, чи яагаад бүдрээд байгаа юм бэ?

- Чамайг гай дайрах нь.

- Намайг биш хаан хүү Иваныг гай дайрна!

Ингэж хэлээд Ясан хэдрэг мориныхоо гуяыг тас гуядав. Морь нь үүлтэй тэнгэрээс доохнуур, үзүүртэй модноос дээгүүр дүүлэв.

Энэ үед Иваны морь:

- Ах минь намайг гүйцэх байх. Ясан хэдрэг ганцаараа, та нар хоёул хүнд байна. Хаан хүү

Иван богцноосоо өндгөө гарга. Ясан хэдрэг гүйцэх нь байна шүү гэв. Тэгтэл ардхан нь Ясан хэдрэг:

- Хаан хүү Иван, зогс! Надаас яасан ч мултарч чадахгүй! гэж хашгирав. Хаан хүү Иван өндгийг газар хага шидэв.

Тэр дорхноо аянга цахиж, газраар нэг өмхий хярвас үнэртэн Ясан хэдрэг мориноосоо өнхрөн унав.

Хаан хүү Иван мөчир түүж Ясан хэдрэгийг шатааж үнс нурам болгоод Ясан хэдрэгийн морийг унаж Марья Моревнатайгаа хоёул айх аюул, гай гачигдалгүй цааш явжээ.

Тэгээд Хэрээчийн Хэрээ, Шонхорын Шонхор, Бүргэдэйн Бүргэдийнд очин найрлаж цэнгээд дараа нь залуу сайхан Марья Моревнатайгаа цуг улс гүрэндээ буцжээ.

Хотол даяар найр хийж, гурван өдөр цэнгэж, гурван өдөр дуулжээ. Харин дараа нь хаант төрөө барьж, хамаг үйлсийг бүтээжээ.

# СЭРГЭЛЭН АЛБАТ

Гурван хүүтэй ядуу өвгөн байжээ. Ядуу өвгөн том хүүгээ:

- Ажил хийж, юм олж ир гээд явуулжээ.

Том хүү нь зэргэлдээх тосгон руу явж байтал нэгэн лам дайралджээ.

- Надад ажил хийж өг. Гэхдээ хугацаанаасаа нэг өдрийн өмнө явбал хөлс төлөхгүй шүү. Нэг ч мөнгө өгөхгүй гэж лам хэлэв.

Залуу эр юу ч хэлсэнгүй, ламынд нэг жил ажиллахаар тохиролцжээ.

Лам албатаа үүрээс өмнө сэрээж үдшийн харанхуй болтол ажиллуулж, өдөрт нэг удаа муу хоол өгдөг байжээ.

Хүнд хүчир ажил, өлсөж цангаснаас болж залуу эр турж эцэн хөлөө ч даахгүй болжээ.

- Хугацааг дуусгах гэвэл амьд үлдэхгүй юм байна.

Ингэж бодоод ажлын хөлс ч яамай гээд гар хоосон гэртээ буцжээ.

Албатаа хугацаанаасаа өмнө буцаасай гэж хүсэж байсан ламын сэтгэл ханажээ. Хүнд хүчир ажлаа хийлгэчээд мөнгөний гарзгүй үлджээ.

Дараа жил дунд хүү нь ажил олж хийхээр явжээ. Нөгөө ламынд ах шигээ хагас жил зүдэрч, зүтгэж байгаад гар хоосон буцжээ.

Гурав дахь жил нь бага хүү нь ажил олж хийхээр явжээ.

Бага хүү нь ах нарынхаа ажиллаж байсан нөгөө ламынх руу шууд очжээ.

- Яасан сайн юм бэ! Би албат эрж байсан юм. Ажилла, мөнгө хөлс хайрлахгүй. Гэхдээ хугацаанаасаа өмнө явбал нэг ч мөнгө өгөхгүй шүү, өөртөө гомдоорой.

- За тохиролцлоо гэж залуу хариулжээ. Ингээд тохиролцжээ.

Маргааш өглөө нь лам албатаа үүрийн харанхуйгаар сэрээж байна гэнэ.

- Босоорой, морь тэргээ хөллө, хадлангаа зөөе гэжээ.

Залуу албат морь тэргээ хөллөх зуур лам сайн гэгч ундаалж амжжээ. Харин ламын авгай залуу эрд өчигдрийн хоолноос үлдсэн хоёр төмс өгч:

- Замдаа идээрэй. Одоо манай лам яарч байна, уурлана... гэж гэнэ.

Тэгээд тэр хоёр явжээ. Дөнгөж тосгоны захад гармагцаа залуу албат тэргэнээсээ үсрэн бууж:



- Зогсоорой, зогсоорой, лам гуай минь! Би дээсээ мартчихаж гүйж очоод аваад ирье. Лам морио барьсаар үлджээ.

Залуу албат буцан гүйж ирээд:

- Авгай минь, лам гуай дугуй цагаан талх, загастай гурван бялуу аваад ир гэж байна гэв. Ламын авгай талх, бялуу боож өгчээ.

Залуу албат пингээс нэг дээс шүүрч аваад буцжээ.

- За явья, дээсээ авчирлаа.

- Хол явчихаагүй нь их юм гэж лам үглэв. Хадландаа хүрч өвсөө ачиж багласаар удав. Оройдоо буцах замдаа оржээ.

Лам:

- Зам сайхан, би нэг жаахан дугхийгээдхье. Чи тэр салаа зам дээр очоод зүүн тийш эргээрэй гээд дулаахан хүрмээрээ толгойгоо хучаад хэвтээд өгчээ.

Залуу албат бялуу, дугуй талхаа идэж цадаад өвсөн дээр таатайхан хэвтэж явжээ. Салаа зам дээр морио зүүн тийш биш баруун тийш эргүүлжээ. Тэгээд өвсөн дээр хэвтээд «Урт дээлтэд үзүүлээд өгье байз, намайг мартахгүй болтол нь үзүүлээд өгье» гэж бодон инээж явав.

Замаар эргэснээс хойш арван таван мод газар явжээ. Гэтэл лам сэрж өөр зүг рүү явж байгааг мэдээд харааж загнан:

- Өө, эргүү амьтан! Зүүн тийш эргээрэй гэж байхад юугаа харж, юугаа бодож явдаг амьтан бэ? гэж хашгичив.

Залуу албат:

- Юу гэнээ, хаашаа харлаа? Та өөрөө баруун тийш эргээрэй! гэсэн шүү дээ гэжээ.

«Би буруу хэлчихэж дээ» гэж лам бодоод:

- Одоо яая гэхэв, тойруу замаар явахаас. Арваад мод газар яваад тосгон дайралдана. Тэнд хонохоос доо. Их ч орой болж, өлсөж байна гэдэг жигтэйхэн.

- Лам гуай минь, та өвс идээд үз. Би өвснөөс идээд бүр цадчихаад явж байна гэж залуу албат хэлэв.

Лам өвсний зөөлнөөс чимхэж аваад зажилж зажилж тургиж хаяв.

- Энэ ч надад тохирохгүй хоол байна. Тэгээд тэд хоёр цаг яваад тосгонд хүрэв.

Баян худалдаачны хамгийн том байшинд дөхөж очоод лам:

- За хонуулаач гэж гуйгаад ир. Өлсөөд гар хөл минь хүртэл чичирч байна гэв. Залуу албат хаалгыг нь тогшин:

- Сайн санаат хүмүүс минь, замын хүнийг хонуулаач!

Эзэн гарч ирэн:

- Ор, ор, орон гэрээ тээж явдаггүй гэдэг дээ гэв.

- Би ганцаараа биш ээ. Надтай цуг нэг лам яваа, бие нь муу юм. Жаахан ухаан солиотой юм. Ерөнхийдөө ч номхон, харин нэг юмыг дахин давтан хэлбэл араатан мэт уурлан хүмүүс рүү дайрдаг юм гэж залуу эр гэрийн эзэнд шивгэнэн хэлжээ.

- За за, мэдлээ. Гэрийнхэндээ ч хэлье гэж эзэн хариулав.

Залуу албат морио тэргэнээс нь мултлан өвс өгч, ламыг өвсөн дээрээс түшин буулгав. Байшинд орцгоов. Гэрийн эзэд ламыг болгоомжлон харж дуугүйхэн байцгаана.

Хоол идэцгээх болж. Эзэгтэй:

- Зочид минь, бидэнтэй сууж хоол идэцгээ гэж хэлэнгүүт залуу албат шууд ширээнд очиж суув. Харин лам шууд суухаасаа нэрэлхэн дахин урихыг нь хүлээв.

Эзэгтэй дахин хэлэхээсээ айж дуугүй байв.

Цөм хоол идэцгээв. Лам «Шууд л суудаг байж» гэж өөрийгөө хараан уурлан сууна. Ингээд лам юу ч амсалгүй суусаар тэр айлынхан ч хооллож дуусав.

Эзэгтэй аяга саваа хураачихаад лам залуу албат хоёрт ор засаж өгөв.

Залуу албат дэрэн дээр толгой тавингуутаа бөх гэгч унтав. Гэрийн эзэд ч унтав. Харин өлссөн ламын нойр хүрсэнгүй.

Лам албатаа түлхэн сэрээж:

- Өлсөж үхэх нь, юм идмээр байна.

- Яагаад хоол идээгүй юм бэ?

- Дахиад урих байх гэж бодсон юм.

- Пийшингийн хажууд тавиур дээр ваартай будаа байна лээ, би харсан. Та очоод идчих гэж залуу албат заав.

Лам босож явснаа төдөлгүй албатаа дахин сэрээж:

- Ваартай будаа оллоо, харин халбага алга. Залуу албат уурлан:

- Халбага би хаанаас олох вэ! Ханцуйгаа шамлаж байгаад гараараа ид гэв.

Лам хомхойрон хоёр гараа ваар луу дүртэл вааранд будаа биш халуун давирхай байжээ. Дахиад л албатаа сэрээн, гартаа углаатай ваараа сэгсчин:

- Гар, гар түлэгдлээ. Гар давирхайд наалдчихаад байна, яах вэ, үхлээ...

- Ээ зайлуул гэж. За тэр, хана түшүүлсэн билүү чулууг харж байна уу? Тэр билүүнд ваараа хага цохь, юу байхав гэж албат дахин заав.

Лам ваараа билүүн дээр хамаг хүчээрээ буулгатал ваар ч бут үсрэв. Тэгтэл ч нэг хүн муухай дуугаар:

- Амь авраарай, аллаа! гэж орилов. Лам ч байшингаас гүйн гарч зугтав.

Тэр айлынхан сэрцгээж үймээн шуугиан болж, лаа асаавал гэрийн эзний толгой нэл давирхай болжээ. Гэрийн эзэн дуу тавин ёолно. Гэрийн эзний хөвгүүд ч албат руу давшлан:

- Эцгийг минь чи л эрэмдэг зэрэмдэг болголоо?

- Би гэж үү? Би хараа ч үгүй, сонсоо ч үгүй, унтаж байсан. Харин та нар өвчтэй ламыг яачихав? Лам хаачсан бэ? гэж залуу албат хашгирав.

Гэрийнхэн ийш тийш гүйлдэн эрж хайвч лам алга болжээ.

- За харж байгаа биз дээ, гэрийн эзэн ч ухаан орлоо, харин лам алга. Та нар боломжтой хүмүүс байна, зуун рублийн барьцаа өг! Би үүгээр чинь аргалъя. Тэгэхгүй бол ламыг алга болгосон хэрэгт та нар татагдана шүү гэж залуу албатыг хэлэхэд гэрийн эзэд тээнэгэлзэж тээнэгэлзэж нэг зуун рублийн бараа өгөв.

Залуу албат барааг аваад морин тэргээ хөллөөд тэндээс хөдлөв.

Тэгээд тосгоноос нэг мод хиртэй газар яваад байтал овоолттой сүрэл дороос лам мөлхөн гарч ирэв.

- Гэрийн эзэд чамайг тавихгүй байх гэж айж байлаа шүү.

- Гэрийн эзнийг би биш та алсан шүү дээ. Та л шоронд суух болж дээ. Намайг юу боллоо гэж барих билээ?

- Тэгээд бүр үхчихсэн үү?

- Тэгэлгүй яах вэ, та юу гэж бодоов? Одоо занги зална гэж байна лээ. Лам халаглаж, айн чичирч:

- Өө, ямар их гай вэ! Яаж ийгээд аргалж болохгүй юм байх даа? гэхэд залуу албат:

- Аргалж болох нь болох л байх. Өвгөнийг тэртэй тэргүй амьлуулахгүйгээс хойш гэж би ч гуйгаад үзсэн л дээ.

- За тэгээд юу гэж байна?

- Яах юу байх вэ, үнэрхэж байна.

- Би юугаа ч хайрлахгүй, хэргийг аргалдаг юм бол бүх юмаа өгнө!

- Тэд хоёр морь, гурван зуун рубль нэхэж байна лээ. Тэгээд надад бас шан болгож зууг өгнө биз дээ.

«Ээх, бурхан минь, ашгүй амархан саллаа» гэж лам дотроо бодоод залуу албатдаа дөрвөн зуун рубль, хоёр морио өгөв.

- За хурдан аваачаад өг, үгээ буцчихаас нь өмнө аваачаад өг!

Залуу албат үтрэм дээр очиж морьдоо уяад тэнд жаал сууж байгаад лам дээр буцаж ирэв.

- За зовох юмгүй, гэртээ харь! Бүгдийг аргаллаа гэв. Лам баярлан гэр лүүгээ ухаан жолоогүй харайлгав.

Залуу албат гэртээ хоёр морь хөтөлчихсөн, их мөнгөтэй буцаж иржээ.

Ингэж сэргэлэн албат ах нарынхаа болон өөрийн ажлын хөлсийг ламаас салгаж авсан гэдэг.

## УУТНААС УХААН

Эрт урьд цагт эмгэн өвгөн хоёр амьдран суудаг байжээ. Эмгэн өвгөн хоёр тун ч ядуу, хатсан талх, хар цайгаар л өдөр хоногийг залгуулдаг байжээ. Өвлийг өлсөж даарч өнгөрөөн, зунжингаа мөөг жимсхэн түүж иддэг байжээ.

Нэг удаа өгөн шээзгий улаан буудай олж аваад: - Бүх хүн тариа тарих юм. Хоёулаа бас тарья, намар өөрийн гэсэн тариатай болно гэжээ.

Тэгээд эмгэн өвгөн хоёр улаан буудайгаа тарьжээ. Улаан буудай ч гайхалтай сайхан ургаж гэнэ. Өвгөн эмгэн хоёр хөл газар хүрэхгүй баярлаж, өдөр бүр тариа руугаа очиж харж баясдаг болжээ.

Буудай түрүү түрүүгээ налан ханаран найгана. Айл хөршийнхөн нь атаархан:

- Ийм их ургац насандаа үзээгүй! гэцгээнэ. Тариа хураах цаг ч болж өвгөн хадуураа ирлэв.

- Эмгээн, маргааш улаан буудайгаа хадъя! гэв.

Тэгтэл гэнэт хүчтэй салхи дэгдэж, хар үүл гарч, өвгөний тариалан дээр том том мөндөр асгаран буув. Мөндөр буудайг нь цохиж нэг ч түрүү үлдсэнгүй.

Өвгөний урам хугаран гутарч, эмгэн хараал тавин:

- Арчаагүй амьтан, аль ч юманд дүйгүй чамтай насаараа зовлоо! Ямар ч азгүй амьтан чи! Арай чарай гэж байж атга будаатай болсон чинь аюул гай дайрч, бусдынх зүгээр байхад манайх ширхэг ч үр үлдсэнгүй.

Өвгөн эмгэнээ тайтгаруулан:

- Уйлж унжаад яах вэ! Уурлалаа, уйллаа гээд унасан гарзыг нөхөх биш. Салхи үүлийг авчирч мөндөр буулгасан, салхи л гарзыг нөхөж өгөг гэв.

Эмгэн улам уурлан:

- Энэ өвгөн бүр солиорчихож! Амны зоргоор бурж, хүн сонсмооргүй юм ярьж байхыг нь хараач! Чи хээр гараад салхийг эрээч! гэжээ.

Өвгөн улам цаашлан:

- Салхинаас л боллоо, салхи гэмтэй хойно салхи л мэдэг гэж үглэж байснаа хувцаслаж таяг тулаад аян замд гарчээ.

Өндөр уулыг өвөрлөн намхан газрыг нарлан явсаар нэгэн өндөр ууланд иржээ. Уулын ёроолд нэг том байшин байна гэнэ.

Байшин дөрвөн талдаа хаалгатай юм гэнэ. Нэг хаалга нь нар гарах зүг, нөгөө нь урд, гурав

дахь нь баруун, дөрөв дэх нь хойд зүг чиглэжээ.

Гэтэл хувин хангинан нэгэн хөгшин эмгэн худгаас ус авахаар гарч ирлээ гэнэ. Эрүү өвдөг нь нийлэх шахсан хөгшин юмсанж. Ус утгаж авав.

Өвгөн тэр эмгэнтэй мэндлэв.

- Амар байна уу, эмээ! Би танд усыг чинь дөхүүлээд өгье.

- Амар сайн, сайхан сэтгэлтэй хүн минь! Сэтгэлийн сайхан үгэнд чинь баярлалаа. Манайд ор, аян замын алжаалаа тайл. Хувинтай усаа би өөрөө оруулъя, одоохондоо өөрөө чадна гэв.

Шатаар өгсөн байшинд орцгоов. Эмгэн өвгөнийг зочлон хооллуулж ундалж дулаахан хучин хэвгүүлээд:

- Сайхан сэтгэлтэй хүн, та аль газрыг зорьж явна вэ? Өөрийн дураар явна уу, гачигдал зовлонгийн эрхэнд явна уу? гэж асуув.

- Эмээ минь, миний зовлон ихээ! Эмгэн бид хоёр улаан буудай тарьж ургацаа хураахаар баярлаж суутал салхи гарч мөндрийн үүл хөөж ирээд ургацыг минь цохичихлоо. Бидэнд ширхэг үр ч үлдсэнгүй. Хотлыг хэсээд ч амь зуух аргагүй боллоо. Ингээд би нарт хорвоогоор үнэнийг эрэхээр явна гэв.

- Тэгвэл ч түүний учрыг олж болноо. Би дөрвөн салхины эх билээ. Хөвгүүд минь одоохондоо миний үгнээс гарахгүй. Миний бага хүү Умард салхи чамайг гомдоосон бололтой. Умард салхи тэгж дүрсгүйтэх дуртай. Одоохон хүүхдүүд минь буцаад ирнэ. Гэмтнээр гарзыг чинь нөхүүлнэ гэж эмгэн өгүүлэв.

Удалгүй зүүн зүгээс чимээ гарч зүүн хаалга дэлгэгдэн Дорно салхи нисэн орж ирэв. Дараа нь өмнө зүгээс дулаан амьсгаа ханхлан урд хаалга нээгдэн Өмнө салхи намалзан орж ирэв. Яг энэ үед нар жаргах зүгийн хаалга онгойн Өрнө салхи орж ирэв. Дараа нь эргэн тойрон шуугин сийгэн хойд зүгээс Умард салхи исгэрэн хөхөрсөөр орж ирэв.

Умард салхи:

- Өнөөдөр тэнгис далайгаар үлээж хөлөг онгоцнуудыг хөөргөдөж өгсөн дөө! Тоглож тонгочсоор өлсчихлөө! гэв.

Эмгэн ширээ засан хөвгүүдээ ундалж хооллуулж дуусаад:

- За хөвгүүд минь, та нарын хэн чинь саяхан зовлон тарьсан бэ? Тэгээд өвгөнийг дуудав.

- Юу болсныг айлтгүй ярь!

Өвгөн пийшин дээрээс бууж юу болсныг цөмийг ярьжээ. Умард салхи дуугүй болон толгой бөхийв.

- Умард салхи, чи буруутай юу? Чи гарзыг нөхөж өг гэж эх эмгэн өгүүлэв.

- Зовох юмгүй, ээжээ. Би бүгдийг нөхөж өгнө!.. Харин зочин та зоригтой, шаргуу хүн байна. Би ийм хүнд дуртай! Намайг эрж, үнэнийг нүүрэн дээр ил хэлэхээс айгаагүй болохоор та миний хуурай ах минь болно уу? Гарсан гарзанд бүү гутар гээд өврөөсөө нэг боодолтой юм гаргаж өвгөнд өгөв.

- Энэ бол шидэт бүтээлэг. Үргэлж цаггалан явах болно. Бүтээлгээ дэлгээд «Уя, идье!» гэдэг хоёр үг хэл. Тэгэхлээр шидэт бүтээлэг дээр янз янзын амттан бэлэн болж юу дуртайгаа зооглож болно. Харин одоо харих замдаа дэн буудлын газар битгий ороорой гэлээ.

Өвгөн дөрвөн салхины эхэд зочилж хүндэлсэнд, хуурай дүүдээ бэлэг өгсөнд талархаад бүгдэд нь сайныг ерөөгөөд буцах замдаа оржээ.

Өвгөн яван явсаар ядарч, хүч тамир нь барагдахад «Энэ шөнө замдаа нэг газар хонохоос, өнөөдөртөө ч харьж чадахгүй нь. Умард салхи яагаад дэн буудлын газар битгий ороорой гэсэн юм бол? Хээр хонолтой биш! Идэх юм өвөрт байгаа цагт толгой хоргодох газар хэрэгтэй» гэж бодов. Тэгээд дэн буудлын газар орж тухлан суугаад амарч байтал эзэн:

- Оройн хоол идэх үү? Алжаал ядралаа тайлж аяга архи уух уу? Захиалаарай! гэхэд,

- Би юу ч худалдан авахгүй, надад бүх юм байгаа. Ингэж хэлээд өвгөн өврөөсөө шидэт бүтээлгээ гарган:

- Уя, идье! гэж хэлэв.

Гэтэл, бурхан минь, янз янзын амттан бүтээлэг дээр бэлэн болов. Амтат бал, архи дарс, чихэр жимс юу л бол юу! Юу хүссэнээ ид!

Дэн буудлын эзэн мэл гайхан, нүдээ бүлтэртэл харж, үг ч дуугарч чадахгүй зогсоно. Ийм гайхамшгийг хэзээ ч үзээгүй билээ.

Өвгөн «Эмгэн бид хоёр ч идэх уух юмтай боллоо! Сайн хүмүүсийг зочлох ч юмтай боллоо!» гэж бодон баярлан хөөрч, дэн буудлын эзнийг дуудан:

- Наашаа суу, гэрийнхнийгээ дууд, хамт хооллоцгооё. Уух идэх юм бүгдэд хүрэлцээтэй! гэв. Буудлын эзэн эхнэр хүүхдээ дуудан цөм өвгөний ширээнээ суун ууж идэн баярлацгаана. Өвгөн

амтат дарс ууж халаад толгой нь мансуурав. Өвгөн дуу дуулж эхлэв.

Буудлын эзэнд гэнэт «Энэ бүтээлэг надад тун хэрэгтэй юм байна!» гэж бодов.

Өвгөн унд хоолныхоо дараа ханзан дээр унтаад өгөв. Буудлын эзэн шидэт бүтээлгийг яг адилхан жирийн бүтээлгээр сольжээ.

Маргааш нь өвгөн үүрээр сэрээд гэр лүүгээ яаран харьжээ. Эмгэн нь харааж загнан угтав.

- Савдаг чи хаагуур тэнэж яваад ирэв? Гэрт чинь атга будаа, хэрчим түлээ алга. Гэтэл энэ зовлон нь багадаад байгаа юм байх даа!

- Эмгээн, дуугаа тат! Ширээний цаана суу, хүссэн бүгдээ ид уу! гэж өвгөн зандран эмгэнийг суулгаад бүтээлгээ дэлгэн:

- Ууя, идье! гэж хэлэв. Гэтэл юу ч байдаггүй? Юу болов?

Өвгөн бүтээлгээ дахин сэгсрэн дэлгэж, гараараа цохиод:

- Ууя, идье! гэв. Дахиад юу ч алга.

Тэгтэл ч эмгэн үсрэн босож хайруулаа шүүрч аван:

- Ээ, чалчигч чинь, бас надаар тохуу хийх нь үү! гэж хашгираад өвгөнийг цохиж,- Ингээд чи хуур! Ингээд чи хуур! гэжээ.

Өвгөн санд мэнд зугтан гараад хар хурдаараа гүйв.

Тосгоныхоо захад очоод зогсосхийн «Энэ ч буруу юм боллоо. Умард салхи намайг хуурсан бололтой. За гайгүй ээ, би ч тийм амархан толгой биш шүү!

Одоо ч замаа мэдэж байгаа хойно олоод очно доо» гэж бодов. Тэгээд дөрвөн салхины эхийнх рүү явжээ.

Явж явж орой бүрий болсон хойно өндөр уулын хажуу дахь дөрвөн талдаа хаалгатай том байшинд хүрч очив. Энэ үед ах дүү дөрвөн салхи дөрвөн зүгээс гэртээ буцаж явжээ. Зочноо шүүрч аван байшиндаа орцгоов.

Өвгөн дөрвөн салхины эх, ах дүү нартай мэндлээд Умард салхинд хандан:

- Хуурай дүү минь, ах дүүгийн хооронд ийм хэрэг байж болох уу? Чиний шидэт бүтээлэг чинь зөвхөн нэг удаа намайг ундалж хооллууллаа, тэгээд л байдаггүй. Надаар ингэж тохуу хийх нь зүйн хэрэг гэж үү?

- Байз, байз, замдаа дэн буудлын газар орсон уу? гэж Умард салхи асуув.

- Орсон.

- За тэгвэл үгэнд минь ороогүй өөрийгөө зэмлэ, өөрөө буруутай. Тэгээд өврөөсөө нэгэн түрийвч гарган:

- Энэ түрийвчийг ав. Гачигдал зовлонгүй амьдрах болно. Мөнгө хэрэгтэй болбол түрийвчээ сэгсэр! Хичнээн мөнгө хэрэгтэй, төчнөөнийг сэгсэрч авч байгаарай! За тэгээд үгэнд минь ор, замдаа юунд ч, хэнийд ч бүү ороорой гэв.

Зочин ундалж хооллож аваад гэр лүүгээ гарчээ. Үлгэр маань үргэлжилсээр өвгөн маань гэр



лүүгээ яарсаар.

Явж явж түрүүчийн удаа хоносон дэн буудлын газар хүрчээ.

«Ёох ёх, бүүр ядарчихлаа, хөл минь ч хөших нь. Тэртэй тэргүй өнөөдөр гэртээ харих өнгөрлөө. Танил газар байна, ороод хоночихъё» гэж өвгөн шийдэв.

Тэгээд дэн буудлын газар орж мэнд амар мэдэлцэв. Буудлын эзэн өвгөнийг таниад их эелдэгхэн угтаж:

- Сайн санаатан минь, сууж амар! Унд хоолноос минь сэжиглэхгүй бол захиалаарай! Аян замынхаа алжаалыг тайл! гэжээ.

Өвгөн өлсөж даарсан гэдэг жигтэйхэн.

«Умард салхи намайг юугаар шагнасныг үзье байз» гэж бодоод хоол унд, архи дарс авчирахыг хүсэв. Буудлын эзэн хэлсэн бүгдийг нь зөөнө. Өвгөн нэг хоёр жүнз уугаад алжаал нь тайлагдан ам нь халж буудлын эзнийг дуудан:

- Надтай хамт сууж хоолло, гэрийнхнийгээ бүгдийг дууд, зуухан дээрхээ бүгдийг нь ширээн дээр тавь! Мөнгө хайрлахгүй төлнө гэв.

Буудлын эзний хөл хөнгөрч янз янзын амттан, архи дарсаа зөөж, эхнэр хүүхдээ дуудан цөм идэж ууж гарав. Ингэж суухдаа өвгөнд ямар шидэт юм байгаа бол гэхээс буудлын эзэн тэсэж ядна.

Тэгээд сүүлдээ тэсэлгүй:

- Сайн санаатан минь, дайлсанд чинь баярлалаа. Маргааш өглөө эрт явах биз дээ. Одоо мөнгөө өгчих гэв.

Өвгөн өврөөсөө илбэт түрийвчээ гарган хоёр удаа сэгсэрвэл бөөн алтан мөнгөн зоос унаж ирэв. Тавгаар дүүрэн алтан мөнгөн зоос унагаж өгөөд:

- Буудлын эзэн та, ав ав, бүгд чинийх. Надад энд элбэг хүрэлцэнэ! гэв.

Буудлын эзэн өвгөнийг харан, гайхахдаа хөдөлж чадахгүй сууна. Тэгснээ гэнэт ухаан орох мэт тавгийг шүүрч аван зооснуудыг барилж үзвэл үнэхээр алтан мөнгөн ажээ.

- Яасан гайхамшиг вэ!

Өвгөн хэвтэж алжааж ядарсандаа бөх унтаж, хар гай хажууд нь байгааг үл мэдэн тайвнаар хурхирсаар байв.

Буудлын эзэн яг адилхан түрийвч эрж олоод илбэт түрийвчийг сольчихов. Өвгөн өглөө эрт босож гэр лүүгээ яаран явжээ.

Өвгөн дөнгөж босгоо алхмагцаа өврөөсөө түрийвчээ гарган үзүүлж:

- Эмгээн, харааж загнаад хэрэггүй. Энэ удаа хуурахгүй! Алив шээзгийгээ өгөөдөх, зоосоор дүүргээд өгье. Тэгээд зах дээр очиж юу хэрэгтэйгээ ав гэв.

Эмгэн шээзгийг авчирч өгөв.

Өвгөн түрийвчээ нэг хоёр сэгсэрвэл хуучирсан төмөр товчноос өөр юм юу ч унасангүй. Дахин дахин сэгсрэвч юу ч байдаггүй.

Эмгэн гартаа ойр байсан шээзгийг шүүрч аван өвгөнөө цохин, уйлан үглэв.

- Хоосон чалчигч, усан толгой, гайны эзэн! Чамтай бүхий л насаараа зовж сайн сайхныг үзсэнгүй өнгөрөөлөө. Насны эцэст бүүр зөнөглөчихөж, өдрөөс өдөрт тэнэгтээд байх юм!

Ингэж үглээд зодоод байтал шээзгийг үйрч унав. Тэгэхээр нь галынхаа шилээвэр рүү ухасхийв. Өвгөн ч энэ хооронд ухасхийн тосгоныхоо барааг далдартал гүйв. Тэгээд зогсоохийн «Одоо хаачдаг юм билээ? Эмгэн харааж загнаад хатгаж нүдээд суулгахгүй юм. Ингэж муухай хуурчихаад нүүрийг нь харахаас ч халуун байна. Арга учир олохоос нааш эргэж харихгүй. Энэ муу буудлын эзэн шидэт бүтээлэг, илбэт түрийвчийг минь сольчихоогүй байгаа? Эсвэл Умард салхи надаар тохуу хийгээд байна уу? Буудлын эзэн шидэт бүтээлэг, илбэт түрийвчийг минь сольсон ч сольсон гэхгүй. Тэгэхлээр юу ч гэсэн эхлээд хуурай дүү дээрээ очъё» гэж бодов.

Ингээд өвгөн гурав дахь удаагаа өндөр уулыг зорин очив.

Умард салхи гэртээ байв. Гэрээсээ баргар царайлан гарч ирээд хуурай ахдаа:

- Би чиний бүх зовлонг мэдэж байна. Дахиад миний үгэнд ороогүй өөрийгөө л зэмлэ! За май, энэ уутыг ав! Ухаанаараа амьдар. Гай гачигдал тулгарсан үед уугаа сэгсрэн «Хоёулаа уутнаас гар!» гэж хэл, тэгээд юу болохыг нь хараарай. За баяртай!

Умард салхи өөр юу ч хэлсэнгүй, исгэрэн шуугиж үүлэнд тултал боссоноо зуун уулын цаанатаа зургаан улсын тэртээ нисэн одов.

Өвгөн уутыг үүрээд буцаж явав. Явж явж «Гэдэс өлсөж байна! За байз, энэ уутны ид шидийг нэг үзээдхье» гэж бодоод уугаа мөрнөөсөө мултлан сэгсрээд:

- Хоёулаа уутнаас гар! гэж гэнэ.

Тэр хоромд уутнаас шийдэм барьсан хоёр залуу гарч ирэн өвгөнийг нүдэж гэнэ. Хоёр залууд нүдүүлсээр өвгөн аргаа бараад сүүлдээ нэг юм таамаглан:

- Хоёулаа уутанд ор! гэв.

Өвгөнийг «Хоёулаа уутанд ор!» гэж хэлмэгц хоёр залуу огт байгаагүй мэт алга болжээ.

Өвгөн «Умард салхи энэ уутыг зүгээр ч өгөөгүй дээ... Аа аан, хэрвээ ухаантай хэрэглэвэл уут

ч үнэхээр ажил бүтээх юм гээч!» гэж бодож олов.

Тэгээд уугаа үүрсээр цааш явжээ.

Явсаар байтал танил дэн буудлын газар харагдаж гэнэ.

«Аа, энд ч уутанд минь ажил олдоноо!»

Өвгөний ирж явахыг харсан буудлын эзэн үүдэн дээрээ гүйн гарч ирэв.

- Ороорой, орогтун, хүндэт зочин минь!

Буудлын эзэн өвгөнийг тойрон бөмбөгнөж зочныхоо өрөөнд оруулан:

- Тэрлэгээ энд өлгөчих, таягаа энэ буланд тавьчих! гээд, вандан пийшин рүү ойртуулан,- Ийшээ сууж дулаац, би ширээ засуулъя. Өнөөдөр би чамайг дайлна. Яасан баяртай өдөр вэ? Эхнээр нааш ир! гэж хашгирав.

Эхнэр нь гарч ирэн эелдэгхэн мэндлэв. Буудлын эзэн хөл болон гүйж:

- Бушуухан ширээ зас! Амттай бүхнийг өр, архи дарс авчир гэнэ.

Ширээ засаж өвгөнийг хамгийн хүндэт суудалдаа суулгав.

- Хүндэт зочин минь, зооглогтун. Хаагуур яваад, юу үзэв? Яриач! Бид гэдэг гэрийн мухар сахисан улс хорвоо дэлхий дээр юу болж байгааг мэдэх ч үгүй, сонсох ч үгүй юм.

Өвгөн идээ будаанаас зооглон элдэв зүйлийг ярина. Буудлын эзэн уутнаас нүд салгаж чадахгүй хялалзан зочиндоо дарс аягална.

- Энэнээс амсаад үз, бүү нэрэлх, уухгүй бол гомдоно шүү! Эхнэр бид хоёр таныг ирсэнд ямар их баяртай байна гээч! гэнэ.

«Буудлын эзэн уутанд шунаад байнаа» гэж өвгөн дотроо сэжиг аваад гаднаа ууж идсэн шигээ дүр үзүүлж инээмсэглэн суув.

Буудлын эзэн тэссэнгүй асуусан нь:

- Хүндэт зочин минь, энэ уутанд чинь юу байгаа юм бэ? Бас л ямар нэг гайхамшиг биз? Өвгөн хариулсан нь:

- Энэ уут биш ёстой гайхалтай гайхамшиг. Нэг сэгсрээд «Хоёулаа уутнаас гар!» гэж хэлэхтэй зэрэг хоёр илбэч гарч ирэн юу хүссэнийг биелүүлнэ. Ийм л гайхамшиг даа!

Буудлын эзэн өвгөнийг их эелдэгхэн харж намалзан нахилзана. Харин дотроо «Энэ уутны эзэн болохгүй бол ч би хүн биш!» гэж андгайлна.

Зочилж дуусаад өвгөнийг дээд буландаа зөөлөн дэвсгэр дээр хэвтүүлэв.

- Тавтай нойрсоорой!

Тэгээд буудлын эзний нойр нь хүрсэнгүй. Яг адилхан уут олж гэрийнхнийгээ бүгдийг унтмагц өвгөний уутыг авч оронд нь энгийн уутаа дүүжлэв.

Тэгээд эхнэрээ сэрээж:

- Би юу авчрав, чи хар! Одоо миний хүсэл бүхэн минь биелэгдэнэ. Хоёр илбэч эхлээд хааны ордноос гоё ордон босгог, эдлэн газар ихийг өгөг, бид ч ёстой хаад ноёд шиг амьдарна даа!

Тэгээд уутыг сэгсрэн:

- Хоёулаа уутнаас гар! гэж хашгирав.

Уутнаас шийдэм барьсан хоёр залуу гарч ирээд буудлын эзнийг эхнэртэй нь нүдэж балбаж гарав. Эзэн эхнэр хоёул хашгирахаасаа айна. Харин хоёр залуу нүдээд л нүдээд л байж.

Сүүлдээ буудлын эзэн тэссэнгүй.

- Залуу эрчүүд минь, өршөөж, хайрла! Уул шиг их мөнгө өгье, зодохоо болиоч гэж гуйв. Уутнаас гарсан хоёр залуу буудлын эзнийг эхнэртэй нь нүдээд л нүдээд л байж.

Эхнэр уйлж, буудлын эзэн байдаг тэнхээгээрээ:

- Амь авраарай! Амь авраарай! гэж хашгирав.

Өвгөн дуу чимээг сонсоод жуумалзан хэвтэж байв. Буудлын эзэн бүүр байдгаараа хашгирна.

- Амь авраарай! Аллаа! Авраарай!..

«За одоо очихгүй бол болохгүй. Муу хулгайчийг хоёр залуу хэмх нүдчихнэ» гэж өвгөн бодоод очвол эзэн эхнэр хоёулаа тэрийж унаад ёолж гуугалж байна гэнэ.

- Сайн санаатан минь, зодоонч нараа холтгооч, үр хүүхдийг минь бүү өнчрүүлээч! гэж зэрэг зэрэг гуйхад нь өвгөн:

- Миний шидэт бүтээлэг илбэт түрийвч хоёрыг буцааж өг! гэжээ.

- Хүндэт зочин минь хаанаасаа бид шидэт бүтээлэг, илбэт түрийвч олох билээ? Бид энэ насандаа тийм юм хэрэглэж үзээгүй!

- Тэгвэл яагаад миний уут энд байдаг билээ? Хэрвээ миний гайхамшгийг буцааж өгөхгүй бол та нарыг үхтэл чинь нүднэ!

Тэгтэл эхнэр нь тэсвэр алдаж:

- Нөхөр минь, чи буруугаа хүлээ! Бүтээлэг түрийвч хоёроос амь нас үнэтэй. Тэр юмыг нь буцааж өг!

Буудлын эзэн ч тэсэшгүй болсон бололтой:

- Залуу эрчүүдээ холтго. Шидэт бүтээлэг, илбэт түрийвчийг чинь эргээж өгье, бас дээр нь чаргатай морь өгнө. Зөвхөн амь насыг минь авар! гэж орилов.

Өвгөн ч үүнийг хүлээж байсан тул:

- Хоёулаа уутанд ор! гэв.

Шийдэм барьсан хоёр залуу алга болж буудлын эзэн эхнэртэйгээ ёолон гиншин хэвтэнэ.

- Ёо, ёо, үхлээ, үхлээ. Эрүүл газар алга. Эрэмдэг зэрэмдэг боллоо! Одоо яаж амьдарна. Хэн биднийг тэжээж тэтгэх вэ! Сайн санаатан минь, биднийг өрөвдөөч! Шидэт бүтээлэг эсвэл илбэт түрийвчийнхээ нэгийг ч болсон өгөөч дээ!

Өвгөн уурлан:

- Аа, бас хашраагүй байна уу! Бүтээлэг түрийвч хоёр бушуухан аваад ир! Авчрахгүй бол уутнаас хоёр залууг дуудна шүү!

Буудлын эзэн үсрэн босож авдраасаа бүтээлэг түрийвч хоёрыг нь гарган өгөв.

- Май, ав ав. Хүний юм бидэнд хэрэггүй!

Өвгөн бүтээлгээ дэлгэн «Ууя, идье!» гэвээс тэр дорхноо амттан бий боллоо. «Минийх байна» гээд бүтээлгээ эвхэж өвөртлөв.

Түрийвчээ нэг сэгсэрвэл алт мөнгөн зоос асгарав.

- Түрийвч минийх мөн байна! гээд бас өвөртлөв. Тэгээд уутаа үүрээд:

- Эзэн, чарга тэргээ бэлтгэ, харих цаг боллоо гэж хэлэв.

Буудлын эзэн моринд чарга хөллөхийг албатдаа тушаагаад өөрөө ёолон ёолон байж үүдэндээ гарч өвгөнийг гаргаж өгөв.

Өвгөн чарганд суугаад:

- За баяртай! Хаширсан биз, дахиад хүний юманд бүү хүр! гээд явжээ.

Өвгөн замдаа «За байз, эмгэнийг жаахан айлгаж хашраая, үглэж яншдагаа болиг» гэж бодоод инээд нь хүрч явав.

Гэрийнхээ гадаа ирээд:

- Чүү, үү! гээд зогсов.

Эмгэн ч үүдэн дээрээ гарч ирээд өвгөнийгөө хармагц загнаж гарав.

- Зуны сар, намрын сарыг зугаалж өнгөрөөсөн, өвөл болохоор өрвийгөөд хүрээд ирлээ! Хэн чамд идэш бэлдсэн гэж санаав?

- Орцгооё, орцгооё, эмгэн минь даарчихна!

Өвгөн эмгэн хоёр гэртээ орцгоов. Эмгэн дуугүй болохгүй бүүр ч чангаран загнав.

Өвгөн уугаа сэгсрэн «Хоёулаа уутнаас гар!» гээд хашгиртал уутнаас хоёр залуу үсрэн гарч ирээд:

- Хэнийг сургах вэ? Хэнийг хашраах вэ? гэв. Эмгэн айж:

- Өвгөн минь, надад бүү хүр! Энэнээс хойш ерөөсөө загнахгүй, хараахгүй! гэхэд өвгөн:

- За тийм бол яахав, аль хэзээний ингэх байсан юм гээд «Хоёулаа уутанд ор!» гэж шивгэнэв. Шийдэм барьсан хоёр залуу ч алга болов. Өвгөн бүтээлгээ дэлгэн:

- Ууя, идье! гэж сэгсрэв.

Гэтэл ширээн дээр янз янзын амттаны дээж, идээ будаа цуглав... Эмгэн гайхахын ихээр гайхаж, нүдэндээ итгэхгүй сууна.

- Суу, юу дуртайгаа ид, уу! Энэ бүгд манайх гэж өвгөн хэлэв.

Ингэж эмгэнээ хооллуулж ундлаад дараа нь илбэт түрийвчээ гарган:

- За харж бай! гээд хоёр удаа сэгсэрвэл алтан мөнгөн зоос асгарав.

- Энэ мөнгө ч бүгд манайх!

Эмгэн тун их баярлав. Өвгөн энэ гайхамшгийг яаж олж авсан, буудлын эзэн яаж түүнээс хоёр удаа хулгайлсан, хулгайч эзнээс шидэт бүтээлэг, илбэт түрийвчээ яаж эргүүлж авсан тухайгаа эмгэндээ цөмийг ярьжээ.

- За өвгөн минь, урьдын юм улиг болог. Одоо бидэнд юу л бол юу байна. Өөрсдөө идэх юмтай, өргөн олонтойгоо хуваалцах юмтай боллоо гэж эмгэн тайтгаруулав.

Тэр цагаас хойш эмгэн өвгөн хоёр дутагдах гачигдах юмгүй сайхан амьдрах болжээ. Айл хотныхондоо тусалж олондоо нэртэй түмэндээ хүндтэй жаргаж байжээ. Энэ үед далайн чанадаас нэгэн ноён эдлэн газартаа эргэж иржээ. Тэр ноён өвгөн эмгэн хоёр халгин цалгин амьдарч суудгийг сонсоод дууджээ. Өвгөн ноёныд ирэв.

- Энэ хорвоо дээр чамаас ядуу хүн байгаагүй. Гэтэл одоо чи хамгийн баян болжээ. Хаанаас

яаж ингэж баян болсноо нуулгүй хэлээч! гэж ноён асуужээ.

Өвгөн юу ч нуулгүй ярьжээ. Ноён:

- Нүдээрээ үзэхээс нааш энэ худал үгэнд би итгэхгүй гэв. Өвгөн:

- За тэгвэл манайд очоорой. Би чамд шидэт бүтээлэг, илбэт түрийвчээ үзүүлнэ гэжээ. Ноён гурвалсан морь хөллүүлэн өвгөнийг дэлбэгчтэй цуг суулгаад өөрөө сүйхэндээ суун явцгаажээ.

- За явья, өвгөн, чи зам заа!

Өвгөнийд ирцгээжээ. Өвгөн ноёныг оруулан хоймороо суулгав. Эмгэн шидэт бүтээлгээ авчрав.

- За харж бай, ноёнтон! гээд өвгөн бүтээлгээ сэгсрэн дэлгэж «Ууя, идье!» гэж шивгэнэв. Ширээнээ янз янзын амттаны дээж, идээ будаа, архи дарс цуглав.

- Идээ будаанаас минь цээрлэхгүй зооглогтун! гэж эмгэн өвгөн хоёр зочноо хүндлэв. Ноён энэ тэрнээс амсаж, амттай шимтэйгий нь шагшина.

Ууж идэж цадаад:

- За, чи шидэт бүтээлгийн тухай үнэн хэлжээ. Одоо тэр илбэт түрийвчээ үзүүл! гэв.

Өвгөн түрийвчээ авчран нэг хоёр сэгсэрвэл алтан мөнгөн зоос асгарав. Ноёны нүд нь бүлтэгнэн, мөнгөнөөс хараа салгаж чадахгүй зогсоно. Тэгснээ дараа нь:

- Илбэт түрийвчийн тухай ч үнэн хэлжээ. Харин одоо миний үнэнийг сонс! Шидэт бүтээлэг, илбэт түрийвч хоёроо шинэ даавуунд боогоод миний сүйхэнд аваачиж надад өг! гэв.

Өвгөн эмгэн хоёр:

- Өршөө, ноёнтон минь! Яалаа гэж ингэх билээ! Энэ гайхамшгийг Умард салхи бид хоёрт өгснөөс чамд өгөөгүй шүү дээ гэж эсэргүүцэв.

- Дуугаа тат! Элдвийг тоочих эрх та нарт байхгүй! Та хоёр миний албат, та хоёрын юм ч минийх, ойлгов уу! гэж ноён хашгиран дэвслэв.

- Ойлголгүй яахав, ноёнтон! Ойлголоо гэж өвгөн өгүүлэхэд ноён:

- За ойлгосон бол түргэл, би хүлээж чадахгүй! гэв.

- Эмгээн, миний уутыг аваад ир. Ноёнтон яарч байгааг харахгүй юу... Ноёнтон минь, манайд шинэ даавуу алга гэж өвгөн хэлэх зуур эмгэн уутыг авчрав. Ноён яаруулав.

- За, уугандаа бушуухан боо!

- Одоохон одоохон, ноёнтон минь! гээд өвгөн уутаа сэгсрэн «Хоёулаа уутнаас гар!» гэж хашгирав.

Шийдэм барьсан хоёр залуу үсрэн гарч ирэв.

- Ноёнтонг мартахгүй болтол нь хашраагаад өг! Хоёр залуу ноёныг шийдмээрээ цохиж, нүдэж гарав. Ноён эхлээд дальдчин зугтахыг оролдож харайж байснаа сүүлдээ тэсэлгүй:

- Дэлбэгч ээ туслаарай! гэж хашгирав. Дэлбэгч нь гүйн ирж хоёр гурав цохиулаад аргагүй болохыг мэдэж ухарсаар ухарсаар зугтав.

Хоёр залуу шийдмээ пүд пүд хийлгэн ноёныг нүдсээр байв.

- Хөөе, өвгөн, намайг сулла! Үхэхээс минь өмнө эднийгээ болиул! Чи хариуцах болно шүү!

- Миний төлөө санаа зоволтгүй, ноёнтон. Их ч барьсан өмхий, бага ч барьсан өмхий. Харин чи байхгүй бол хүмүүст амар болно. Энэ чинь их юм байхгүй юу!

Ноён өвдөг сөгдөн бөмбөрч:

- Уучил, өвгөн минь, уучил! Үүнээс хойш хэзээ ч хүний юманд шунахайрахгүй, хүний юмыг булаахгүй!

- Үгүй ээ, үгүй, чи тэгж хүний юманд хүрэхгүй гэдэг худлаа. Амташсан хэрээ арван гурав дахина гэдгийг мэдэх үү. Хэрвээ эдлэн газраа эрчүүд бидэнд өгч, биднийг эрх чөлөөт иргэд мөн гэж бичээд энэ нутгаас бүүр явбал чинь амьд үлдээнэ. Үгүй бол эндээсээ шууд оршуулгын газар очиж дээ гэж өвгөн хэлэв.

Хоёр залуу ноёныг балбасаар байв. Сүүлдээ ноён тэссэнгүй:

- Ёо, ёо, юу ч гэсэн би үгээр чинь болгоё. Бийр янтай, цаас аваад ир, түргэл! Юу хэлснийг чинь бичье, гагцхүү амьд үлдээ! Ёо, ёо.

Өвгөн бийр янтай, цаас авчраад хоёр залууг түр хүлээж бай гээд болиулав. Ноён өөрийн барлаг эрчүүдийг эрх чөлөөтэй, эдлэн газар тэдний мэдэлд гэж бичив.

Өвгөн уншиж үзээд «Зөв байна!» гээд:

- Хоёулаа уутанд ор! гэж хашгирав.

Шийдэм барьсан хоёр залуу ч алга болов. Ноён байшингаас ёолсоор гараад:

- Би маргааш эндээс бүүр явна. Харин чи намайг энд зодсон гэдгээ хэнд ч битгий яриарай гэжээ. Маргааш нь ноён тэр нутгаас бүүр явжээ.

Тэр цагаас хойш барлаг эрчүүд ноёны газрыг нь авч өвгөнийг магтан сайхан амьдрах болжээ. Одоо болтол тэр нутгийнхан гачигдал зовлонгүй амар түвшин аж төрж оноос онд жилээс



жилд улам баян тансаг амьдарсаар байгаа гэнээ.

Ингээд сонин үлгэр төгслөө, сонссон хүнд гялайлаа.

# УХААНТАЙ ЭР

Нэгэн тосгонд хоёр эр суудаг байжээ. Нэг нь баян, нөгөө нь ядуу юмсанжээ.

Баяны гэрт хамаг юм халгиж цалгиж байдаг, харин ядуу эр олон хүүхэдтэй, ердөө нэг галуутай юм гэнээ.

Ядуу бүр тартагтаа тулж хүүхдүүдээ тэжээх юмгүй болжээ. Одоо яадаг билээ? Үр хүүхдээ яаж тэжээх вэ? гэж бодож бодож ядуу эр:

- Эхнээр, галуугаа шар! гэжээ.

Эхнэр нь галуугаа шараад ширээн дээр тавив. Гэтэл талхны үртэс ч байсангүй. Ядуу эр:

- Талхгүй яаж ч идэх билээ, энэ галууг хичнээн ч идэх билээ? Ер нь ноёндоо аваачиж өгөөд оронд нь гурил гуйя гэхэд эхнэр нь:

- Тэг тэг, аваачиж өг. Хагас шуудай гурил ч өгөх юм билүү! гэжээ. Ядуу эр ноёныдоо ирээд:

- Бүү сэжиглээрэй, шарсан галуу авчирлаа. Харин надад жаахан гурил өгөхгүй юу?

Хүүхдүүд хоосон сууж байна.

- За яахав, чи галуу бэлэглэж чадсан юм чинь, галуугаа бидэнд хувааж өг. Хэнийг ч гомдоолгүй хувааж чадвал гурил өгнө, чадахгүй бол банздуулна гэжээ.

Ноёных эхнэр, хоёр хүү, хоёр охинтойгоо зургуулаа юмсанжээ.

Ядуу эр хутга авчруулаад галуугаа хуваажээ. Эхлээд толгойгий нь огтлон ноёндоо өгөөд:

- Та энэ гэрийн тэргүүн, иймд танд толгой өгье. Тэгээд бөгсийг нь огтлон ноёны хатанд өгөөд:

- Та гэртээ сууж, орон гэрээ харж хамгаалдаг, иймд танд үүнийг өгье.

Дараа нь хоёр хөлийг нь огтлон хоёр хүүд нь өгөөд:

- Та хоёрт нэг нэг хөл өгье. Эцгийн замаар яваарай. Хоёр далавчийг нь огтлон хоёр охинд нь өгөөд:

- Та хоёр аав ээжтэйгээ үргэлж цуг амьдрахгүй, өсөж том болоод нисэн одож өөр өөрийн үүрийг засна гэв.

Тэгээд үлдсэн цээжийг нь өөрөө авч:

- Би хөөрхий ядуу, хөндий цээж, энэ цээжийг идье гэжээ. Ноён инээн:

- Сайн байна, сайн эр өөрийгөө ч гомдоосонгүй гээд аяга дарс өгөөд хоёр шуудай гурил гаргаж өгөхийг тушаажээ.

Энэ тухай баян эр сонсоод атаархжээ.

Баян эр таван тарган галуу шараад ноёндОО аваачиж өгчээ.

- Бүү цээрлээрэй, таван тарган галууг минь бэлэг болгон авна уу?

- Баярлалаа, баярлалаа! Галуу бэлэглэж чадсан юм чинь, галуугаа бидэнд хувааж өг. Хэнийг ч гомдоолгүй хуваах юм бол шагнана, чадахгүй бол банздуулна шүү гэж ноён хэлжээ

Баян эр хуваах гэж үзэж үзэж, ийш тийш нь эргүүлж тойруулж тойруулж таван галууг зургаан хүнд яагаад ч хувааж чадсангүй.

Ноён ядуу эрийг дуудуулж:

- За, чи таван галууг биднийг гомдоолгүй хувааж чадах уу? гэжээ.

- Чадахгүй яахав! гээд ядуу эр нэг галууг ноён хатан хоёрт өгөөд

- Та хоёр хоёулаа, одоо гурвуул боллоо. Өөр нэг галууг хоёр хүүд нь өгөөд:

- Та хоёр одоо гурвуулаа боллоо. Гурав дахь галууг хоёр охинд нь өгөөд:

- Та хоёр бас гурвуулаа боллоо. Үлдсэн хоёр галууг өөртөө аваад:

- Би ч бас гурвуулаа боллоо. Хэнд ч гомдолгүй гэжээ. Ноён инээн:

- Сайн байна, сайн байна! Сайн эр өөрийгөө ч бас орхисонгүй! гээд аяга дарс өгөөд ядуу эрд тэрэг гурил гаргаж өгөх, баян эрийг банздах тушаал буулгажээ.

# ЖАРГАЛТАЙ АЙЛ

Эрт урьд цагт нэг улсад тун баян сурвалжит ноён амьдардаг байжээ. Ноён баянаараа бардан, удам угсаагаараа гайхуулдаг байжээ. Бардахгүй, гайхуулахгүй ч яах билээ дээ. Газар гэж зах хязгааргүй их. үүний нутагт том том хот, тосгон, суурин, гацаа олон гэнэ. Ногоон нугад нь тоолж баршгүй адуун сүрэг бэлчинэ. Ой тайга нь ан амьтнаар дүүрэн, ус гол нь загас жараахайгаар элбэг гэнэ.

Ноёны эцэг өвгөд үеэс үед дээд албанд сууж улсын хэргийг шийтгэж явсан болохоор яаж ч удам угсаагаараа бахархахгүй байх билээ дээ!

Ноён ганц охинтой юмсанжээ. Охин нь үгээр хэлшгүй үзэсгэлэнтэй, үлгэрийн дагина шиг сайхан гэнэ. Үүний дээр цэцэн ухаантай гэнэ. Авхай том болох тусмаа л улам үзэсгэлэн төгс болж ухаан үзэсгэлэн хоёр нь хотол даяар алдаршжээ.

Ингээд өндөр цагаан ордондоо өвч их баялагтаа умбан өргөн олны хүндэтгэл эдэлсэн баян ноён амьдарч байжээ. Авхайг долоон шивэгчин, долоон аягач үргэлж тойрон далласан газар нь ил гарч, далайсан газар нь далд орж, нүдний цэцгий шиг хайрлан энхрийлэн байдаг байжээ. Ноён эцэг нь ч охиндоо амь шигээ хайртай байв гэнэ.

Үзэсгэлэнт авхай өсөж том болсоор хадамд гарах насанд хүрчээ. Баян ноёны хүргэн болохыг горьдсон өдий төдий эрчүүл охиныг нь гуйв. Өөрийн улс гүрэн, харь холын олон тайж ноёд баян ноёнттой ураг холбохыг хүсэж увж цувдаг болж гэнэ

Ирсэн бүхнийг ноён ихэд хүндэтгэн хүлээн авч:

- Орцгоо орцгоо, дээшилцгээ. Охиноосоо асууя. Хүчилж би чадахгүй, хувь заяагаа өөрөө шийдэг, өөрөө хариулаг гэхэд,

- Хайрт аав минь, хадамд гарч, хаяа тэлэх арай эрт байна. Таныхаа нөмөрт хоргодон танхил охин насаа жаахан ч болон уртасгая гэж охин нь хариулдаг байжээ.

Ингээд хүргэн болохыг хүсэгчид, зууч нар хаяанаас нь буцдаг байжээ. Ингэж нэг жил өнгөрч хоёр дахь жил дуусаж байж гэнэ. Тэгтэл гэнэт алс хол нутгийн алдар цуутай нэгэн хаант улсаас хадамлахаар иржээ.

- Эрхэм ноёнтон минь, сайн үг салхин чимээтэй гэдэг. Охины тань үзэсгэлэн гоо, цэцэн ухаан орчлон дэлхийд цуурайтлаа. Ингээд манай олон ардыг тэтгэгч, их хаан өчүүхэн зууч биднийг тан руу явууллаа. Их хаан тантай худ ураг болохыг хүсэж, үзэсгэлэнт охиныг тань гуйж байна гэжээ.

Энэ үгийг сонсоод ноён баярлажээ. «Хүчирхэг гүрнийг эзэмшигч их хаан хүн хүргэн минь болох нь. Охин минь алдарт улсын хатан болох нь, энэнээс сайн хүргэн гэж хаана байх вэ! Ёстой амандаа орсон алтыг хэлээрээ түлхчихгүй юмсан!» гэж ноён тунгаажээ.

Тэгээд ноён охиноосоо ч асуусангүй шууд л зочдыг дайлан зочилж их хааны элч зууч нарт

элэгсэг хариу хэлж хөөр баяр болов.

- Их хаантай ураг холбохдоо би сэтгэл дүүрэн байна. Охин минь бас баярлана. Охин минь хааны хатан болохыг дуртайяа зөвшөөрнө. Олон эрийг буцааж одоо болтол хүлээж байсан нь ийм ерөөлтэй байжээ гэж ноён ярьжээ.

Дайлж цайлаад зочид явсан хойно ноён охиныхоо өргөөнд орж:

- Хайрт охин минь, хуримдаа бэлтгэ! Алдарт нэгэн улсын их хаан чамайг гуйж зууч илгээжээ. I Аз буянтай сайхан хэрэг болж байна. Урьд өмнө ирж миний охины таашаалыг хүсээд гологдож буцсан ноёд тайжуудын хүүхдүүдтэй зүйрлэшгүй сайхан хүргэнтэй болно. Удахгүй миний охин их улсын хатан, олон ардыг захирагч болно. Манай олон гүнж атаархаж үхнэ! гэж өгүүлэв.

Авхай харцаа бууруулан, чичирсэн хоолойгоор эцэгтээ хариулав.

- Хүндэт эцэг минь, хүссэнээр чинь болог дээ.

- Тэгээд яагаад уруу царайлж, газар ширтэв? Нөхөр болох хүн сэтгэлд чинь нийцэхгүй байна уу?

- Би түүний барааг ч хараагүй шүү дээ гэж охин нь бүр ч аяархан хариулав.

- Хараагүй ч гэсэн сонссон биз дээ? Хуримаа хийгээд суухаар аяндаа хайртай болно доо. Ханилж суугаад дасна, харж суугаад дурлана. Намайг бодож, чамайг жаргалтай явуулахсан гэж байна шүү дээ!

- Тиймээ, аав минь. Таны үгнээс би зөрөхгүй. Таны хэлснээр болно гэж охин нь шивгэнэн хэлээд харцаа улам доошлуулан,

- Өнөөдөр бие муу байна улам дордож ч магадгүй, аав минь гэв.

Тэр өдрөөс эхлэн авхай өвджээ. Өдөр хоногоор улам өвдөн доройтов гэнэ.

Ноён эмч залаад тус болсонгүй. Олон олон эмч домч авхайн биеийг үзэж эм тан уулгаж, аргалж чаргалавч эдгэрсэнгүй улам муудаад, орноосоо ч босож чадахаа больжээ.

Ноёны сэтгэл түгшин зовов. Олон газрын олон эмчийг залан үзүүлэвч тус болсонгүй. Тэгэхээр нь авхайн эмгэгийг таньж, биеийг эдгээж чадах домч байна уу? гэж улс даяар зар тараан эрэл сурал болжээ.

Ноёны элч нар зүг бүрд мордон эрж сурагласаар нэгэн тосгоноос уналдаа тулсан нэг муу хөгшин эмгэнийг авчиржээ.

Эмгэн домч аягачин шивэгчин нараас авхайн бие хэзээнээс эхэлж яаж муудсаныг асууж лавлаад дараа нь авхайн өргөөнд орж асууж ярилцжээ. Хэнийг ч битгий оруул гэсэн тул тэр хоёр юун тухай ярьсныг хэн ч мэдсэнгүй.

Домч эмгэн авхайн өргөөнөөс гарч ирээд ноёнд мэхийн хэлсэн нь:

- Ноён минь жаргалтай хүнийг олж тэр хүнээс цамцыг нь гуйх юмуу ер нь л авах хэрэгтэй. Үзэсгэлэнт авхай тэр цамцыг өмсөнгүүт өвчин эмгэг нь илааршин эдгэнэ. Өөр ямар ч эм тан тус нэмэргүй гэв.

Ноён энэ үгийг сонсонгуутаа:

- Хамгийн жаргалтай хүнийг эрж олоод цамцыг нь авчир! Цамцгүй буцаж бүү ирэгтүн! гэж зарлиг буулгав.

Ноёны элч нар эрэлд мордов. Түмэн газраар явавч жинхэнэ жаргалтай хүнийг хаанаас ч олсонгүй. Зарим нь баян чинээлэг, эвтэй найртай сайхан гэр бүл боловч өвчин зовлон ээрэх учир ямар юмных нь жаргал вэ? Зарим нь эхнэр хүүхэддээ хайртай, эрүүл чийрэг, их сайхан амьдарч байгаа боловч айлынхантайгаа ая зүйгээ олохгүй, араатан мэт сууцгаана. Зарим эхнэр нөхөр хоёр эв түнжингүй амьдрах юм гэнэ. Заримын нь хүүхдүүд олиггүй, эцэг эхийнхээ чихий нь хангинуулсан улс байх юм гэнэ. Хичнээн явсан ч «Би жаргалтай хүн, надаас жаргалтай хүн хорвоод байхгүй» гэж омог бардам, сэтгэл дүүрэн хэлэх хүн дайралдсангүй.

Ноёны элч нар явж явж нэг удаа бүр харанхуй болох үед нэгэн тосгонд дөхөж иржээ.

- Өнөө шөнө энд хоноцгооё. Харанхуй шөнө мэдэхгүй газар хайчих вэ! гэж ахлагч нь хэлжээ. Тэгээд харцгаатал бүх байшин харанхуй зөвхөн хамгийн захын нэг муу яйжгий байшингийн цонх гэрэлтэж байна гэнэ. Тэгээд яйжгий байшин руу ойртож очицгоотол «Би энэ дэлхийд хамгийн жаргалтай хүн!» гэж хашгирах сонсогдов.

Ноёны элч нар яаран цонх руу очиж харвал буржгар үстэй залуу эр ширээнийхээ араас үсрэн босож «Энэ дэлхийг тойрсон ч над шиг жаргалтай хүнийг олохгүй» гээд бүжиглэж байна гэнэ.

Тэгтэл ч пийшин дээрээс сайхан хүүхэн үсрэн бууж «Жаргал минь чи билээ! Үүнээс илүү жаргал байхгүй. Надтай байхад чамд сайхан бол чамтайгаа байхад надад бүр ч сайхан» гэж дуулан дэвслэн бүжиглэв гэнэ.

Ноёны элч нар шууд үүдийг нь тогшин:

- Сайн санаат ах дүүс минь, биднийг хонуулаач! гэжээ. Гэрийн эзэн буржгар залуу үүдээ нээв.

- Орцгоо, орцгоо! Ор дэрээ авч явдаггүй гэдэг!

Ингэж хэлээд үүдэнд гарч ирэн морьд хашихад туслав. Элч нарыг гэрт ороход хүүхэн угаагууртаа ус хийн цэвэр алчуур авч өгөв.

- Сайн санаат ах дүүс минь, хувцсаа тайлцгаа! Тоос шорооноосоо салцгаа, тухалцгаа! Тэгээд залуу хүүхэн ширээгээ бүтээн идээ будаа өрөв. Залуу ч яаруулан:

- Хурдал! Зуухан дээр байгаа бүхнийг ширээн дээр тавь! гэв. Залуу эхнэр:

- За сууцгаа, байгаагаараа баян гэдэг! Зооглогтун! гэж урив. Ноёны элч нар ширээнээ суухад ахмад нь:

- Энэ дэлхий дээр хамгийн жаргалтай хүн гэж ярихыг бид гаднаас сонссон. Ингэж чи ярьсан уу?

- Өөр хэн энд ярих вэ? Би үнэхээр жаргалтай хүн! гэж гэрийн эзэн хариулав.

- Хэрэв тийм бол биднийг гай зовлонгоос ангижруулаач!

- Ямар, яасан гай зовлон та бүгдэд учраав? гэж гэрийн эзэн асуув.

- Ай, ямар гэж санана. Манай улсын хамгийн баян, сурвалжит ноёны ганц үзэсгэлэнт охин ухаант авхай айхтар их өвдөөд байна. Залаагүй эмч байхгүй, уугаагүй эм байхгүй, эдгэж илааршдаггүй ээ. Гэтэл ашгүй нэг эмгэн домч олдов. Эмгэн авхайг үзээд «Ганцхан зам, ганцхан арга байна. Жаргалтай хүний цамцыг өмсвөл авхай эдгэнэ. Өөр юу ч хэрэггүй» гэлээ. Ингээд ноён биднийг хамгийн жаргалтай хүний цамц олж ир гэж илгээсэн билээ. Чи жаргалтай хүн тул өмссөн цамцаа тайлж өгнө үү. Хэрвээ үзэсгэлэнт авхай эдгэж илааршвал ноён чамд юугаа ч хайрлахгүй их шан өгнө.

- Танай ноёноос надад юу ч хэрэггүй. Харин миний цамц хүнийг эдгээх юм бол би дуртайяа өгнө... гээд түгдэрснээ эхнэртээ:

- Алив, миний жанч аваад өгөөч! гэв.

Эхнэр нь түүнд нөхөөс болсон нэг жанч авч өгөхөд залуу эр цамцаа тайлан түүнийг нөмрөв.

- За май, энэ миний цамц. Сольж өмсөх цамц байхгүй юм байна. За яахав, би жанчтай байж л байя.

«Өөрийгөө хамгийн жаргалтай хүн гээд байгаа, тэгтэл сольж өмсөх цамцгүй эр шив дээ!» гэж ноёны элч бодсон ч юу ч хэлсэнгүй, цамцыг авч цүнхэндээ хийжээ.

Маргааш өглөө нь эрт босоцгоов. Хүүхэн хуймаг хайрч зочдоо дайлав. Ноёны элч нар дайлж зочилсонд, цамцаа бэлэглэсэнд баярласан талархсанаа илэрхийлээд тэднийхээс явжээ.

Элч нар давхисаар ордондоо ирцгээв.

Тэд хамгийн жаргалтай хүнийг яаж олсноо ноёндоо ярив. Домч эмгэн ч хүлээж байж. Эмгэн цамцыг аван охины өргөөнд орлоо.

Гурван өдрийн дараа охин нь дээрдэж, долоо хоногийн дараа бүүр эдгэж байна гэж ноён дуулаад баяр хөөр болон:

- Тэр жаргалтай эрийг аваад ир! гэж тушаажээ.

Түрүүчийн элч нараас нэгийг нь давхиулав. Удсан ч үгүй элч жаргалтай эрийг авчрав. Ноён түүнийг их л найртай угтан авч:

- Гай зовлонг минь чи нимгэллээ. Эмгэн домч юу гэж хэлсэн, яг тэрүүгээр боллоо. Охин минь илааршин эдгэв. Чи ямар ч гэсэн намайг зовлонгоос аварлаа. Гагцхүү чи яахаараа өөрийгөө хамгийн жаргалтай хүн гэж боддогийн учрыг үл олно?

- Яагаад гэвэл би үнэхээр хамгийн жаргалтай хүн!

- Чамайг хараад би гайхаж байна. Чи өөрийгөө жаргалтай гэнэ, гэтэл чиний өмссөн хувцас чинь уранхай ноорхой байдаг. Миний зарц нарын ярьснаар бол чи яйжгий муу байшинтай, гашуун лууван идэж, шар квас уудаг ядуу амьдралтай гэсэн шүү дээ. Сольж өмсөх цамц ч үгүй гэсэн. Энэ чинь ямар жаргал байх билээ?!

Залуу эр сурвалжит баян ноёныг харж дуугүйхэн байснаа:

- Таны элч нар үнэн хэлжээ. Орон гэр минь муу, өмссөн хувцас минь хуучин. Гэхдээ ордонд сууж, торгонд ороогдох жаргал гэж үү?

Зарим хүн агуулах зоорь нь багтаж ядан байхад ч бага гэж санадаг. Өөрийн болон эхнэрийн биеийг ажилд нухлуулж, шунахай зангаасаа болж амар заяа үздэггүй. Жаргал үзэхээ байдаг.

Зарим нь эд баялагт нь болоод хайргүй хүүхэнтэй суудаг. Эсвэл ядуу хүн залуу сайхан охиноо баян бэлэвсэн эрд өгнө. Охин нь жаргалгүй. эр нөхөртэйгөө энхрий сэтгэл, эв эс байхгүй хүний хүмүүс шиг амьдарна

Харин би хамгийн жаргалтай хүн! Эхнэр бид хоёр бие биедээ хайртай, эв найр, хайр сэтгэл биднийг нийлүүлсэн, бид хоорондоо хэрэлдэх нь битгий хэл бие биедээ муу үг ч хэлдэггүй. Биднээс сайхан амьдарч байгаа хүн байхгүй болохоор бид хэнд ч атаархдаггүй, атаархах ч үгүй. Бид хүнд чадах чинээгээрээ тусалдаг. Бидэнд тусламж хэрэгтэй бол айл хотынхон дуртайяа гар сунгадаг. Цамц бол яахав дээ? Эхнэр утас ээрч, даавуу нэхээд урьдынхаас илүү гоё цамц хийгээд өгнө. Байшин ч гэсэн засаж болно. Намрын ажил дуусмагц айл хотлынхноо дуудаж олноороо нийлээд засчихна. Нэг хоёрхон өдөрт л дүнхийтэл босгочно. Ер нь л зовох юмгүй амьдар! Гагцхүү хүн эрүүл саруул, эхнэр нөхөр хоёр хоорондоо хайртай, эв найртай байвал болох нь тэр. Тэгвэл ч аливаа сайхан амттанаас лууван ч дээр байх шүү!

Залуу эрийн үгийг сонсоод ноён гайхаж:

- Зовлонтой үед минь чи тус болсон. Эцсийн ганц цамцаа ч хайрлахгүй өгсөн билээ. Ачийг чинь ачаар хариулахыг хүснэ. Юу хүсэж буйгаа хэл, би биелүүлье! гэхэд,

- Надад юу ч хэрэггүй. Миний цамц хүнд хэрэг болсон нь надад их шан. Харин ноосон алчуур олдвол эхнэрээ баярлуулъя! гэж залуу хариулав.

Ноён урьд урьдахаасаа улам ч их гайхаж инээвхийлээд:

- Гал зууханд оч. Тэнд хоол унд зоогло. Жаал амар. Дараа нь чамайг дуудна гэв. Залуу эрийг



гарч явахад ноён домч эмгэнийг дуудуулав.

- Охиныг минь эмчилж, хөл дээр нь босголоо. Яагаад, юунаас болж охин минь өвдсөнийг хэлж өгөөч?

Эмгэн ноёнд мэхийж хүндэтгээд:

- Ноёнтон минь, танаас би жаал жуул юм нууж байсан, одоо бүх юм өнгөрсөн хойно илэн далангүй хэлье, бүү уурлаарай. Таны тушаалаар би энд ирэнгүүтээ аягачин шивэгчин нараас асууж лавлаж учрыг нь олохыг хичээсэн. Тэгээд ч авхайтай сэтгэл нээн ярилцаж, үнэн үгийг нь хэлүүллээ. Үзэсгэлэнт авхай бараагийг нь хараагүй, дуугийг нь сонсоогүй харийн хаан эхнэрээ болгохоор зууч ирүүлж энэ тухай таны хэлсэн өдрөөс л өвдөж эхэлжээ. Тэр өдрөөс хойш уйтгар гуниг сэтгэлийг нь идэж эрэмдэглэжээ... Харин охины уйтгарыг сайхан залуу арилгана.

Ноён дэвслэн уурлав.

- Зөнөг эмгэн! Ямар юмны чинь сайхан залуу яриад байгаа юм?!

- Уурлаад ч яах билээ дээ, ноёнтон. Үнэн мөнийг үзүүрийг олтлоо асууж шалгаасаар би бүгдийг мэдсэн шүү. Үзэсгэлэнт охин залуу сайхан торгон цэрэгт хайртай болоод жил илүү болж байгаа юм байна. Гэтэл та харийн хааны тухай хэлжээ. Ингээд охин өвджээ. Тэр торгон цэрэг ч авхайд ухаангүй хайртай гэнээ.

Ноёны царай хувиран, ширүүнээр:

- Хэн, тэр чинь хэн бэ?! Яаж зориглоов? Түүнийг чинь одоохон энэ хорвоогоос тонилгоно доо!

- Хэн гэдгийг авхайгаас асуу, би мэдэхгүй. Үзэсгэлэнт охинд чинь хайртай болсны учир гэвэл, ноёнтон минь, зүрх сэтгэлийг захирч болдоггүйн үлгэр энэ билээ! Авхай өөрөө түүнд хайртай шүү дээ. Ингэхлээр сайхан залууг тонилгоно гэдэг охиноо тонилгохын нэр...

- Байз, охин минь түүнийг марттал нь илбэдэж, сэтгэл зүрхийг яаж хөргөхийг домч чи надаар заалгалтгүй мэдэж байгаа биз дээ! гээд ноён толгойгоо барин «Энэ охин намайг ч, өөрийгөө ч амьдаар нь алах нь. Удахгүй харийн хаан хүргэн болохоор ирнэ! Гэтэл би их хаанд юу хэлэх вэ? Яаж нүүрийг нь харна?» гэж үглэв.

- Авхайг би эмчилсэн. Амт үнэр сайт янз бүрийн өвс ногооны ханд уулгаж хүчийг нь сэргээж, хүслийг нь бадраасан. Сэтгэлийн үгээрээ санаа бодлыг нь тайтгаруулсан. Харин ариун нандин сэтгэлийг хөргөх гэдэг энэ насандаа хийж үзээгүй нүгэл байна.

Эмгэн домч ийнхүү өгүүлэх үед ноёны зарц гүйн орж ирээд:

- Алдарт нэгэн улсын хааны элч ирлээ! гэв.

- Оруул гэж ноён тушаагаад домч эмгэнийг мартан, самгардан ийш тийш гүйв. Харь нутгийн

элч орж ирэн ноёнд мэхийж ёслоод:

- Уйтгарт мэдээ авчирлаа. Манай их хаан шархдан нас барлаа. Талийгаач их хааны дүү шинэ хаан намайг таны манай их зууч нарт сүй тавьж өгсөн шигтгээт бөгжийг эргүүлэн аваачиж өг гэж илгээсэн билээ.

Ноёны царай хувхай цайж үг хэлж чадахгүй байснаа асуусан нь:

- Яаж, юунаас болов?

- Саяхан манай их хаан цөөн цэргийг аван өвдөг сөгдөн бууж өгдөггүй нэгэн тайжийг номхотгохоор мордсон билээ. Гэтэл тэр догшин тайж хааны цэргийг зальдан урхинд оруулан бүгж байгаад гэнэдүүлэн цохив. Ийм хүч тэнцвэргүй тулалдаанд их хаан хүндээр шархдаж гэрт нь ухаангүй шахам авчирсанаас хойш хоёр хоногийн дараа нас барлаа.

Ингэж яриад элч ноёнд бөгжийг буцааж өгөв. Ноён бөгжийг авч элчийг явуулав. Дараа нь толгой гудайлган, бодол болон удаан суув. Сүүлд нь гэнэт:

- Энэ чинь одоо юу болоод байна? Гай зовлон дайрлаа. Нэгийг амсаж дуусаагүй байтал дахиад гай зовлон. Одоо тийм хаан хүргэн хаанаас олох вэ? Ингээд охиныхоо жаргалыг харсаар байгаад алдлаа! гэв.

- Гунигт мэдээ сайн ч болж магад гэж домч эмгэн дуугаран,

- Хэрвээ торгон цэрэг сайн хүн бол авхай хайртай хүнтэйгээ ханилан сууж жаргалтай болно. Ноёнтон минь, таны эд хөрөнгө хүргэн охин хоёртоо төдийгүй ач гучдаа хүрэлцэнэ! гэвээс ноён:

- Хөгшин зөнөг, чи зайл! Битгий саад болоод бай! гэж хашгирав.

Ноён хэнтэй юу ч ярилгүй удаан суув. Дараа нь буржгар залууг дуудуулж түүнд үнэтэй алчуур өгч найртайгаар үдэн гаргав.

- Чиний үг чинь дэмий боловч үнэний хувьтай бололтой гэж хэлжээ.

Тэгээд дараа нь охинтойгоо ярьж торгон цэргийг дуудуулжээ. Торгон цэрэг ноёны сэтгэлд нийцэж түүнээс хойш тун ч удалгүй охиныхоо өргөн их хурим хийжээ. Хурим найр хийж охин хүргэн хоёртоо маш их өв хөрөнгө таслан өгчээ.

Ингээд залуу хос сайн сайхан амьдарч, хөгжилтэй жаргалтай эрийн цамцыг нандигнан хадгалсаар байжээ. Хөгшин ноён жаргалтай гэр бүлийг харж нэг баярлаж хайрлаж нэг жаргасан гэдээг.

Ингээд сонин үлгэр төгслөө, сонссон хүнд гялайлаа.

## ЗАДГАЙ АМТАЙ ЭХНЭР

Эхнэр нөхөр хоёр амьдран суудаг байжээ. Эхнэр нь тун ч задгай амтай, юугаа ч хэнээс ч нуухгүй ярьдаг хүн байжээ, Юу л сонсоно, тэр дорхноо тосгоныхон нь мэдэж авдаг байв.

Нөхөр нь ойд явжээ. Чонын нүх ухаж байгаад бөөн алт мөнгө олжээ. «За одоо яах вэ? Эхнэр энэ баялгийн тухай мэдмэгц хол ойрынхон бүгд сонсох болно. Ноёны сонорт хүрвэл ч мөнгийг минь булаагаад авчихна. Тэгээд өнгөрнө дөө! За байз, яая даа?» гэж ядуу эр бодож бодож нэг арга олжээ.

Тэгээд олсон алт мөнгөө эргүүлж булаад тэр газраа сайн тэмдэглэж аваад гэр лүүгээ явжээ. Гол руу очиж тороо үзвэл цурхай баригдчихсан байна гэнэ.

Цурхайгаа аваад явжээ. Замдаа хавхаа үзсэн чинь туулай орчихсон байна гэнэ.

Тэгэхээр нь туулайг гаргаж аваад цурхайгаа хавханд хавчуулчихжээ. Харин туулайгаа загасны торонд хийчихжээ.

Тэгээд гэртээ иржээ.

- За эхнээр, пийшингээ галла, ихээхэн хуймаг хайр.

- Яах нь вэ? Харанхуй шөнө хэн галлаж, хуймаг хайрч байлаа? Бас юу болоов!

- Маргаад яахав, хий гэснийг хий... Татьяна, би бөөн мөнгө оллоо. Өнөө шөнө очиж мөнгөө гэртээ авчрах хэрэгтэй.

Эхнэр бөөн баяр болж, пийшингээ галлан хуймаг хайрав.

- Өвгөн минь, ид халуун дээр нь ид! гэнэ.

Мань эр нэгийг идээд хоёр гурвыг эхнэрээсээ нуун үүргэвч рүүгээ хийгээд байж.

- Өнөөдөр яасан их идэх нь энэ вэ? Хуймаг хайрч гүйцэхгүй нь шив.

- Тэгэлгүй яах вэ, эндээс нэлээд хол шүү, бас их мөнгө байгаа. Сайн идэж авах хэрэгтэй. Ингээд нөхөр нь үүргэвчээ хуймгаар дүүргэж аваад эхнэртээ:

- За, би цадлаа. Чи өөрөө ид, одоо тэгээд түргэлэлгүй болохгүй.

Эхнэр ч хурдхан хооллочихоод тэд явжээ.

Шөнө дүл байлаа. Нөхөр нь урд нь орчихоод үүргэвчнээсээ хуймгаа гарган нэг нэгээр нь модны мөчирт өлгөөд явжээ.

Эхнэр нь модны мөчир дэх хуймагуудыг гэнэт хараад:

- Хөөе хараач, мөчир дүүрэн хуймаг өлгөөстэй байна! гэжээ.

- Юунд нь гайхаад байгаа юм бэ? Бидний өмнүүр хуймгийн үүл нүүгээд өнгөрөхийг чи хараагүй юу?

- Үгүй, хараагүй. Би уначих вий гээд газар ширтээд л явж байна.

- Алив хоёулаа хавхаа үзээдхье, туулай орж уу, үгүй юу? Хавхан дээрээ очоод нөхөр нь цурхай гаргахыг харсан эхнэр:

- Хүүе, энэ чинь юу вэ? Загас туулайн хавханд орчихсон байх чинь!

- Хуурай газраар явдаг цурхай байдгийг чи мэдэхгүй юу?

- Мэдэхгүй шүү! Өөрийнхөө нүдээр үзээгүй бол хэнд ч итгэхгүй юм байна.

Голын эрэг дээр очоод эхнэр:

- Чиний тавьсан тор чинь хаа байна? Алив хоёулаа харъя. Тороо гаргаад иртэл туулай байв.

Эхнэр уулга алдан:

- Эцэг минь! Өнөөдөр чинь юу болоод байна даа? Торонд чинь туулай байх чинь!

- За за, юу гээд гуугачаад байгаа юм. Усны туулай үзээгүй юм шиг! гэж нөхөр нь зандрахад эхнэр:

- Үзээгүй юм чинь, үзээгүй гэв.

Ингээд хоёул тэмдэгт газраа хүрч, нөхөр нь булсан алт мөнгөө ухаж даахынхаа хирээр аваад гэр лүүгээ явжээ.

Буцах замдаа ноёны эдлэн газрын хажуугаар өнгөрч явтал хонь майлах сонсогдов.

- Ай, яасан аймаар юм бэ! Юу дуугараад байнаа? гэж эхнэр нь шивгэнэв. Нөхөр нь:

- Хурдал хурдал, гүйгээч! Энэ чинь манай ноёныг чөтгөр барьж байна. Биднийг харчих вий! гэв.

Ингээд гэр хүртлээ гүйцгээж, арай гэж амьсгаагаа дарцгаажээ. Нөхөр нь алт мөнгөө нуугаад унтахаар хэвтэцгээв

- Татьяна, мөнгө олсон гэж хэнд ч битгий хэлээрэй, муу юм болно шүү!

- Үгүй чиш, би юу гэж хэлдэг юм бэ! гэж эхнэр хариулжээ. Маргааш нь оройхон босоцгоожээ.

Эхнэр пийшингээ галлачихаад хувингаа шүүрч аваад усанд явжээ. Худгийн дэргэд айлынхан нь

- Татьяна, яагаад өнөөдөр ийм орой галлаж байгаа юм бэ?

- Тиймээ, бүр үд болчихож! Өчигдөр шөнөжин яваад ингээд үүрээр таг унтчихаж.

- Шөнө хаашаа яваав?

Нөхөр минь бөөн алт мөнгө олоод оо. Бид хоёр шөнө явж мөнгөө авчирлаа гэжээ.

Тэр өдөр тосгон даяар «Татьяна нөхөртэйгөө хоёул дарсан мөнгө олж гэнэ. Хоёр үүргэвч дүүрэн мөнгө авчирчээ» гэдэг яриа түгэв.

Оройдоо ноёны сонорт хүрчээ. Ноён ядуу эрийг дуудуулжээ.

- Чи алт мөнгө олоод яагаад надаас нуудаг билээ?

Би юу ч олоогүй, юу ч үзээгүй, юуны алт мөнгө вэ? гэж ядуу эр хариулжээ.

- Битгий булзааруулаад бай! Би бүгдийг сонссон. Чиний эхнэр чинь ярьсан гэнэ лээ.

- Миний эхнэр үү, аан тэр чинь юу ч гэж бурж мэднэ!

- За тэгвэл, чи өөрөө сонс л доо!

Тэгээд ноён Татьянаг авчруулав.

- Танай нөхөр чинь алт мөнгө олсон уу? Олсоон, ноёнтон минь, олсон.

- Шөнө явж мөнгөө зөөсөн үү?

- Явсаан, явсан.

- За ярь, яаж хаагуур явсан.

Эхлээд бид ой руу орлоо, тэгсэн чинь тэнд мөчир бүр дээр хуймаг өлгөөстэй байсан.

- Ямар юмны чинь хуймаг ойд байдаг билээ?

- Хуймгийн үүлнээс бууж л дээ!.. Дараа нь туулайн хавхаа үзсэн чинь цурхай орчихож. Цурхайгаа аваад цаашаа явлаа. Гол дээр очоод тороо гаргаад иртэл тэнд туулай баригдчихсан байлаа. Голоос нэлээд холгүйхэн нөхөр маань газар ухаж алт мөнгөө авсан. Нэг нэг үүргэвч алт мөнгөөр дүүргэж аваад буцлаа. Буцахдаа танай эдлэн газрын хажуугаар өнгөрч явтал чөтгөрүүд таныг барьж идэж байлаа.

Ноён тэсвэр алдан, хөлөө дэвсэлж:

- Тэнэг эм, зайл! гэж хашгирахад ядуу эр:

- За харав уу! Миний эхнэрт итгэх гэдэг байж болохгүй зүйл! гэжээ. За за, ойлголоо, чи харь!  
гэж ноён гараараа дохив.

Ядуу эр тэр цагаас хойш одоо болтол сэтгэл тайвуун, амар сайхан амьдрах болжээ. Хааяа нэг ноёноо бодон инээдэг гэнэ лээ.

# АХ ДҮҮ ХОЁР

Эртээ урьд цагт өндөр уулыг дов байхад өргөн мөрнийг горхи байхад гэнэ. Ах дүү хоёр амьдран суудаг байжээ. Ах нь Семён нэртэй, хар амиа боддог, атаач шунахай юм гэнэ. Дүү Иван нь цагаан сэтгэлтэй найрсаг, зөөлөн зантай хүнд тусархуу, юу байгаагаа өгөхөөс буцахгүй тийм нэг эр гэнэ.

Ах дүү хоёр галд хийх цуцалгүй, гаднаа босгох шонгүй, сольж өмсөх хувцасгүй, сүүжиндээ дэвсэх гудасгүй, ядуу зүдүү амьдарч байжээ. Арайхийж өл залгадаг байжээ.

Семён нэг удаа:

- За, бид хоёр гэртээ суугаад гэрээ идэх биш, амьтан хүнтэй уулзаж ажил төрөл эрж амь зуулга хөөцөлдье! гэжээ.

Иван ахынхаа үгнээс гажсангүй.

Жаахан талхаа хувааж аваад алсын замд гарцгаажээ.

Тэр хор зуны урт өдөр ургахын улаан нарнаас унахын шар нар хүртэл борви бохисхийлгүй явж эцэж ядарч гэнэ. Тэгээд горхины дэргэд нэг сайхан газар амрахаар суужээ.

- Усанд ойр хуурай аятайхан газар байна. Эндээ хоноё. Өнөөдөр маргаашдаа чиний юмыг идье, дараа нь минийхийг идье! гэж ах нь хэлжээ

- Тэгье, яасан сайн юм бэ! Миний үүргэвч хөнгөрөх нь! гэж Иван инээв.

Тэндээ хоноод маргааш нь цааш явцгаав. Орой нь Иваны хүнсийг идэж юу ч үгүй дуусгав.

Гурав дахь оройгоо Семён үүргэвчнээсээ талхаа гаргаж өөртөө тааруулж зүсэж аваад үлдсэнийг нь далд хийчихэв. Тэгээд хэнэг ч үгүй талхаа идэж байна гэнэ.

- Ахаа, та яагаад өөрөө идээд надад өгөхгүй байгаа юм бэ? Миний хүнсийг хоёулаа идсэн шүү дээ гэж Иван гомдон хэлээд,

- Би ч яахав, тэсээд л хоосон хонож чадна Харин энд их аймаар газар гэж би өвгөдөөс сонссон юм. Олон чоно байдаг гэсэн. Явуулын нэг хүн энд хонохдоо бүтэн шахам талх зүсэж өөрийгөө тойруулж цацчихаад унтсан гэдэг. Шөнө чоно ирээд талхыг нь түүж идчихээд унтсан хүнд халдаагүй явчихсан байсан гэнэ билээ гэв.

- Чи үүнийг хэлсэн чинь тун сайн боллоо, хоёулаа бас тэгье гээд Семён үүргэвчнээсээ талхаа гарган хэрчээд өөрийгөө тойруулан цацав. Тэгээд ах нь унтаад өгчээ. Унтахыг нь хүлээж байсан Иван цацсан талхнаас нь цадталаа идээд үлдсэнийг нуучихжээ.

Гэгээ ороход ах нь сэрэв.

- Хараач хөөш, аюул аминд ойрхон ирж шүү! Талхыг цөмийг идээд бидэнд халдсангүй.

Өчигдөр Иван ямар азаар ийм арга санав аа, талх яах вэ, хаанаас ч олдоно.

Ингэж бодоод сууж байтал Иван сэрэв.

- Иван, чи үнэн хэлж шүү, чононууд ирээд талхыг цөмийг идчихэж! гэж Семён хэлэхэд,

- Хоёр чоно ирээд талх үмхэлж байхыг би нойрон дундаа сонссон гэж Иван хариулжээ.

- За тэр, харав уу! Би чамайг аюулаас аварлаа, чи өчигдөр талх өгсөнгүй гэж гомдоод байсан. Чононууд талхыг идчихээд бидэнд халдсангүй шүү дээ гэж Семён хаахалзав.

Тэгээд ах дүү хоёр цааш явж байгаад салаа замын уулзвар дээр очжээ. Семён:

- Иван, чи баруун талын замаар яв, би зүүн талынхаар нь явъя. Мөр мөрөө хөөе гэжээ. Ах дүү хоёр салах ёс гүйцэтгээд Иван баруун тийш эргэж, Семён зүүн замаар орон явжээ.

Иван явсаар байтал бүрэнхий болов. Хонох газар эрсээр холгүйхэн газар хөвдөнд дарагдсан, хуучин муу тээрэм байхыг харав.

«Энд хоноё байз. Эвдэрч, эзэнгүй хаягдсан боловч өвсөн дотор унтсанаас дээр. Бороо ч орж магадгүй» гэж боджээ.

Тээрэмчний байшин нурж унасан байх тул тээрэм рүү оров. Гал гаргаж харвал хэн ч алга. Нэг буланд нь хуучирсан чингэлэг байх агаад түүний араар хоргодвол болох юм гэж харж аваад тийш орж хэрчим талхаа идчихээд унтаад өгчээ.

Хэдий хир унтсаныг бүү мэд, хүний дуу дуулдах шиг болоод сэрчихжээ. Ид шөнө дунд болж байв. Иван чимээгүйхэн чагнав.

- За хүрээд ирцгээв үү?

- Тэглээ, зөнч мэргэн хэрээ минь.

- Баавгайг бас авчраа юу?

- Авчирсаан, Хэрээчийн Хэрээ гуай!

- Гуаг гуаг! Цэрэг эр та хоёр хорин таван жил хааны алба хаалаа. Аян дайнд явж амь өрсөн тулалдаж ч явлаа. Гэтэл та хоёрт гурван зүсэм хатсан талх өгөөд албанаас халжээ. Харин та нар замдаа ядуу бадарчинтай дайралдаад сүүлчийнхээ зүсэм талхнаас харамгүй өгсөн байна. Ингээд би халагдсан цэрэг та хоёрын харамгүй сайхан сэтгэл, үнэнчээр алба хаасны төлөө шагнах гэж энд дуудсан билээ. Эндээс холгүйхэн өргөн нугад үй түмэн хонин сүрэг оторлож байгаа. Тэр оторт магнай халзан зурвастай хар хонь бий. Тэр хонийг өөрийн болгож авсан хүн баяжна.

- Зөнч мэргэн шувуу минь, яагаад тэр билээ?



- Гуаг гуаг! Эндхийн хааны охины нүд гурван жил өвдөж байгаа юмаа. Удахгүй сохрох байх. Олон эмч домч залсан боловч гүнжийг эдгээж чадаагүй байна. Гүнж хоног хоногоор доройтсоор байна. Хааны охиныг эмчлэх ганцхан арга байгаа юм. Магнай халзан зурвастай тэр хар хонийг олж аваад элгийг нь гүнжийн өвчтэй нүдэнд наавал долоо хоног дотор өвчин нь аваад хаячихсан юм шиг алга болно. Хаан баярлаж эмчилсэн хүнд охиноо гэргий болгон өгнө. Хаан амьддаа хаант улсынхаа хагасыг хүргэндээ өгнө, хөгшин хааныг нас барсны дараа хаант улс бүхлээрээ хүргэний мэдлийнх болно. За ингэхлээр хэн хар хонийг авахыг шодьё!

Иван хэн юу байгааг харахгүй боловч хамаг яриаг сонсож байлаа. Шодож байгаа бололтой... Гэнэт нэг нь баярлан:

- Би, би хар хонийг авах боллоо гэж хашгирав.

- Хэрвээ чинийх таарсан бол одоо сааталгүй яв! Гол гарахад цаад эрэг дээр нь нэг том чулуу харагдана. Тэр чулуун дор малчны гар дээр тавих гурван алтан зоос бий. Гуаг гуаг, харин чи яг дөрвөн жилийн дараа шөнө дунд энд баавгайтай цуг ирээрэй! Хаанаас баялаг олохыг чамд зааж өгнө. За, одоо ингээд азарган тахиа дуугарахаас өмнө явцгаая. Энд байж болохгүй!

Баавгай хүрхрэх, хаалга хяхтнах, хүний хөлийн чимээ, далавчны дэвэлт цөмийг Иван сонсов. Дараа нь чив чимээгүй боллоо.

Иван яаран босож хэрээний заасан зүг рүү хурдан явав. Голыг сэлж гатлаад чулууг олов.

«Хэрээний хэлснээр алтан зоос хэвтэж байна. Би тэр хүнээс түрүүлчихжээ. Нөгөө хүн гүүр эрж яваа байх» гэж Иван баярлаад зоосыг аваад ногоон нуга руу гүйв. Үй түмэн хонин сүрэг бэлчиж явна гэнэ. Хамгийн түрүүнд дайралдсан хоньчинд:

- Танайд магнай халзан зурвастай хар хонь бий юу? гэв.

- Сүрэг дотор ганцхан тийм хонь бий.

- Түүнийгээ надад зарчих!

- Яаж болох вэ? Энэ чинь эзний сүрэг, би хоньчин.

- Би чамд гурван алтан зоос өгье. Энэ мөнгөөр чи арван хонь аваарай.

- Худлаа хэлээгүй бол яах вэ! Би одоохон бариадхья. Алив мөнгөө!

- Май май гэж Иван гурван алтан зоосоо өгөв.

Хоньчин тэр даруй магнай халзан зурвастай хар хонийг барьж өгөв.

Иван хонийг холхон аваачиж төхөөрөөд, элгийг нь авч хот руу явлаа. Хааны ордны хажуугаар явж чанга дуугаар:

- Эмнүүлж сувилуулах хүн байна уу? Эрүүл бол жаргал шүү! Гайхамшигт сайн эм тан надад

байна!

Ийнхүү хашгирмагц л ордноос аягач бүсгүй гарч ирэн:

- Сайн эр минь, намайг дагаад яв! гэжээ. Тэгээд Иваныг хаанд авчрав. Хаан:

- Охиноос минь нүдний өвчин салахгүй байна. Жилээс жилд дордож байна. Хэрвээ чи гүнжийг эмчилж чадвал би юугаа ч хайрлахгүй. Хүргэн минь болно. Амьд сэрүүндээ улсынхаа хагасыг өгнө. Намайг өнгөрснөөс хойш улсын эзэн хаан болно. Харин эмчилж чадахгүй бол өөртөө гомд. Бусад эмч нартай адил толгойгүй л болно шүү. Ингэж тохирох уу? Өөртөө итгэж байгаа бол ажлаа эхэл! гэв.

Иван айж сандарсангүй, тэр даруй хааны охиныг эмчилж эхлэв. Хар хонины элгийг гүнжийн нүдэнд наасанд гүнжийн нүд даруйхнаа дээрджээ. Долоо хоногийн дараа хааны охин ерөөсөө өвдөөгүй байсан юм шиг эдгэрчээ. Гүнж дэгдэн дэрвэн хөөрнө. Хаан хатан хоёр охиноо хараад баярлаж ханахгүй сууна.

Хаан Иваныг дуудан:

- Хааны үг хууль. Охиныг минь чи эмнэж эдгээлээ. Хэрвээ чи охины минь санаанд таарвал хурим найраа хийцгээе.

Хаан ийнхүү хэлэхдээ «Охины санаанд таарахгүй бол улам сайн» гэж бодож суужээ. Хаан энгийн нэгэн эмчтэй охиноо суулгаж улсынхаа хагасыг өгөх дургүй байв.

Охиноо дуудан:

- Охин минь, энэ эмч хүргэн минь болох хүсэлтэй юм байна. Санаанд чинь таарч байна уу? Энэ хүний эхнэр болох уу? гэлээ.

Гүнжийн царай улайж харцаа буруулсхийн хариулсан нь:

- Энэ эмч намайг өвчин зовлонгоос салгаж гэрэлт хорвоог харах нүдтэй болголоо. Санаа сэтгэлд минь таарах сайн хүн юм. Эцэг эх та нар минь ивээвэл эр нөхрөө болгоход баяртай байна.

Хаан ийм хариу сонсоход таатай биш байвч яах ч аргагүй болов.

Хааны ордонд дутуу юм байх биш, сархад сав саваараа, шар айраг сөн сөнгөөрөө гэнэ. Хурим найраа хийв. Иван хаанд хандан:

- Хадам эцэг минь, улсынхаа хагасыг надад өгөх хэрэггүй. Харин хотын хаяанд, голын хөвөөнд сэлүүхэн газар зааж өг, тэгээд байшин барихад минь тус нэмэр болоорой. Тэнд цэцэрлэг мод суулгаж бид өөрсдийн хүчээр амьдарна гэжээ.

Хаан нас өндөргүй тул улсын хагасыг хүргэндээ өгөх дургүй байв. Тэгээд энэ үгийг сонсмогц ихэд баярлан:

- Иван, чи сайн эр байна! Бэлэн юмаар туйлаад юу хийнэ. Чиний төлөө, төрсөн охиныхоо төлөө би юугаа ч хайрлахгүй. Газар нутаг хэчнээн л бол ав, бас мужаан ч гаргаж өгье. Хэрвээ чи дуртай юм бол байшин бариад суу, цэцэрлэг модоо суулга. Үхэр мал тасалж өгье. Харин охиныг минь л битгий хатуу ажилд зараарай. Ганцаараа, эрх дураараа өссөн юм. Олон жил өвдөж зовсныг чи өөрөө мэдэж байгаа шүү дээ гэв.

Удалгүй Иван хоёр өрөөтэй том байшин голын эрэг дээр босгожээ. Хоосон газрыг хагалж зах нь харагдахгүй их алимын мод суулгав.

Хавар болоход алимын мод цэцэглэж урьдын хоосон газар нэлдээ цайран туяарч анхилам үнэр

сэнгэнээд амьтан хүн Иваныг магтан баярлана. Намрын цагт алимын модод жимсээ даахгүй бөхийж алтан шар алим нь мөчир дүүрэн багсайж байдаг гэнэ.

Цэцэрлэгт нь зөгий үүрлэж бал бурам бялхаад эзэндээ төдийгүй ээлтэй олонд ч хүрэлцдэг байв. Ингэж Иван эхнэртэйгээ энх түвшин элбэг сайхан амьдарч байжээ.

Нэгэн удаа тэднийд нэг бадарчин ирж хоножээ. Тэр нь Иваны ах Семён байв. Турж ядарсан, хувцас хунар муутай явна гэнэ. Ах дүү хоёр бие биеэ таниад баярлацгаав.

Тэгээд Семён өгүүлрүүн:

- Иван, чи аз заяа сайтай яваа нь илхэн байна. Гачигдал дутагдалгүй элбэг дэлбэг амьдарч байгаа аж. Харин би урьдын адил улаан нүцгэн явна, аз жаргал алга. Яаж чи ийм аз жаргалтай болсноо яриач! гэв.

Цагаан санаатай Иван юу ч нуусангүй. Түүнээс салж явсан тэр шөнө тээрэмд орж хоносон, юу сонссон, яаж хааны охиныг эдгээсэн, тэгээд гүнжтэй гэрлэсэн, яаж одоо эхнэртэйгээ хоёул өөрсдийн хүчээр сайн сайхан амьдарч байгаагаа цөмийг ярьжээ.

Дараа нь:

- Хэрээ яг дөрвөн жилийн дараа тэнд шөнө дахин ирж халагдсан хоёр дахь цэрэгт хаанаас яаж баялаг олохыг зааж өгнө гэж амласан. Энэ өдөр маргааш болно гэж нэмж хэлэв.

- Иван, чи багынхаа гэнэн цайлган байсан тэр хэвээрээ л байна. Улсын хагасыг захирахаас татгалзаж, хаан хадам эцгээсээ их инж нэхэж авдаггүй хүн байх уу? Гэхдээ яах вэ, алдсаныг засаж болно. Хоёулаа тэр хуучин тээрэм дээр очиж хөгшин хэрээ юу хэлэхийг сонсьё. Тэгээд алгуурлаж алмайрахгүй бол их баялгийг олоод хувааж авья. Ингээд чи ч баян, би ч баян болно. Естой сайхан арга шүү! гэж Семён өгүүлэхэд Иван:

-Надад баялаг хэрэггүй. Ийм их юм байхад илүүгээр яах вэ? Сайн сайхан амьдарч байна. Өөр юу хэрэгтэй билээ?

- За өөрөө мэд гэж ах нь хариулаад дотроо «Энэ тэнэг татгалзаж байна. Надад л сайн биз» гэж бодоод:

- Тээрэм рүү яаж очихыг заагаад өгөөч. Би нэг азаа үзээдхье. Хэрээ юу гэж залахыг сонсьё. Ингэж хэлээд Семён шунахай зандаа болж тогтож ядан чичэрч байв. Маргааш нь Семён хар үүрээр босож хуучин тээрмийн зүг гүйв. Тээрмийн тэнд ирэхэд гэгээ орж байв. Тээрмийн байшин руу орж Иваны хоргодож байсан чингэлгийн араар орж суув. Хүлээгээд л сууж, хүлээгээд л сууж. Хэвтэж чадахгүй, унтаж ч чадахгүй тэсэж ядан хүлээнэ. Аль хэдийнээ харанхуй болжээ. Шөнө дүл ч болов. Гэнэт хөлийн чимээ гарав. Үүд онгойх, дараа нь далавчны дэвэлт сонсогдов. Хэрээ:

- Гуаг гуаг! Энэ удаа яагаад хоёулаа ирэв?

- Зөнч мэргэн шувуу минь! Би түрүүчийн удаа шодож магнай халзан зурвастай хар хонь авч гүнжийг эмнэхээр болсон юм. Гэтэл би чулуун дороос зоос олоогүй, хонийг надаас өмнө өөр хүн гурван алтан зоосоор худалдаад авчихсан байлаа. Дараа нь сонсохноо гүнж эдгэрч эмнэсэн эмчтэйгээ суусан гэнэ лээ. Хар хонины анагаагч элэгний тухай урьд нь хэн нэгэнд хэлсэн байсан биш үү.

- Гуаг гуаг! гэж хэрээ гуагалаад,- Энэ тухай урьд нь хэн ч мэдээгүй, мэдэж ч чадахгүй байсан! Тэр үед энд хүн байгаад сонсож чамаас түрүүлсэн байх! Өнөөдөр ч гэсэн бидний яриаг чагнаж байж мэднэ шүү? Алив, баавгайг тавиадах, булан бүрийг нэгжээд ирэг гэв.

Үүнийг сонссон шунахай Семён айхын ихээр айвч зугтах арга байсангүй.

Энэ хоромд баавгай түүнийг үст савраараа шүүрэн авч чингэлгийн араас чирч гаргав.

- Энэ хүн түрүүчийн удаа хар хонины тухай нууцыг сонсоод хааны охинтой гэрлэсэн байх нь! Бас тэгээд ханахгүй дахин сонсохоор иржээ! Үүнийг тонилгох хэрэгтэй гэж хоёр хүн зэрэг хашгирав.

- Зөнч мэргэн шувуу минь, би биш. Тэр шөнө миний дүү тээрэмд хоносон! Түүнээс л хариугаа ав. Тэр хар хонийг авч гүнжийг эдгээж гэрлэсэн! Тэр надад ийшээ очихыг зааж өгсөн юм гэж Семён үглэв.

- Дүүг нь алах хэрэгтэй! Баавгайгаар тас татуулья! гэж хоёр цэрэг дахин хашгирав

- Гуаг гуаг! гэж хэрээ гуагалаад,- Шууд л сүр сар шийдээд яахав, юмыг ухаантай бодож байж хийх хэрэгтэй. Түрүүчийн удаа энэ хүн биш дүү нь байж. Хонох газар эрж яваад энд орж бидний яриаг санаандгүй сонсжээ. Тэгээд хааны охиныг эмнэжээ. Тэр хүн бидний өнөөдрийн болзооны тухай мэдэж байсан атлаа чагнахаар ирсэнгүй. Иймд тэр хүн шунахай биш байх нь. Ахдаа цөмийг ярьж өгчээ. Харин шунахай аймхай ах нь баян болохыг хүсэж бидний яриаг сонсохоор иржээ. Тэгсэн мөртлөө бүх бурууг дүүдээ тохож байна. Хүйтэн шунахай сэтгэл, хар санаа гаргасан үүнийг хашраан шийтгэе. Хэрвээ хашрахгүй бол алж хэзээ ч амжина.

Чулуун уулын дотор асар их алт мөнгө бий. Энэ хүнд царил, зээтүү, хүрз өгье. Чулуун уулыг ухааж алт мөнгө гаргаг. Алт мөнгийг та хоёр хувааж аваарай. Тэгээд энэ хүн өөрийнхөө хөдөлмөрөөр амьдарч сурвал дуртай зүг рүү нь суллан тавина. Хэрэв ажиллахыг хүсэхгүй бол

өөртөө гомдог, баавгайгаар тас татуулна! За тэгэхлээр энэ хүнд хувцас, хоол хүнс өг. Уул ухаг! гээд Семёнд хандан,- За явж уул ух! гэв.

Чулуун уулыг хармагцаа Семёны зүрх нь үхэв. «Энэ уулыг ч энэ насандаа ухаж барахгүй юм байна, аймшигт үхлээр үхэхээс зайлшгүй боллоо» гэж боджээ. Тэгээд их л дургүйхэн ухаж эхлэв. Яваандаа ажилдаа дадан ухаж гарлаа. «Айдас нүдэнд төрнө, ажил гарт оногдоно» гэдэг нь аргагүй үнэн ажээ. Ажил урагштай боллоо.

Хичнээн хэцүү ч Семён улам улам ухсаар урагшилсаар байв.

Удсан ч юмуу, удаагүй ч юмуу бүү мэд, ухаж ухаж уулын голд ортол зээтүү нь ямар нэг төмөрт хүрч дэлсэн хангинав. Төмрийг тойруулан ухтал маш том төмөр тогоо гарч ирэв. Гэтэл хаанаас ч юм гэнэт хоёр цэрэг гарч ирэв. Далавчны дэвэлт сонсдон хэрээ ч нисэн ирж:

- Гуаг гуаг! Сайн байна, Семён! Алт мөнгийг гартал уулыг ухаж чадлаа. Тогоог чирч гарга! гэв.

Халагдсан хоёр цэрэг Семёнтэй гурвуул тогоог түлхэж чирж өнхрүүлсээр гэрэлд гаргаж ирэв. Ухсан нүхээр хэрээ нисэн гарч ирээд:

- Тагийг нь онгойлго. Алт мөнгийг хоёр цэрэг адилхан хувааж ав. Тэгээд Семёнд тавь тавин рубль өг. Түүгээр хөлжиг. Семён, чи дуртай зүг рүүгээ яв. Энэ чулуун уулыг ухсан шигээ өөрийн хүчээр ажиллаж амьдарвал талхаар тасрахгүй. Хүний юманд бүү шуна! гэв.

Семён зөнч мэргэн хэрээ, халагдсан хоёр цэрэгт талархаад «Алтан дэлхийгээр хичнээн ч их явав даа, амар хялбар аргаар амьдрах гэж хичнээн ч зүтгэв дээ. Амь наснаасаа ч хагацах шахлаа. Зөнч мэргэн хэрээ намайг аварч ухаан суулгалаа. Хөлжих мөнгөөр шагналаа Ажлыг үнэн сэтгэлээсээ сайн хийвэл өөрийн хөдөлмөрөөр сайхан амьдарч болох юм байна. Дүүгээсээ дутахгүй аж төрж болох юм» гэж боджээ.

Ингэж ухаараад Семён төрсөн нутгийнхаа зүг явжээ. Тэгээд төрсөн тосгондоо очиж аж ахуйтай болж удсан ч үгүй гэрлэжээ. Үнэн сэтгэлээсээ хичээн ажиллаж аж төрөлдөө арчтай эзэн болж, амар хялбар аргаар амьдрах тухай бодохоо ч больжээ.

# МЭРГЭН УХААНТАЙ ӨВГӨН

Ийм явдал болсон юмуу, үгүй юу мэдэхгүй. Сонссоноо л ярья.

Нэгэн тариачин байжээ. Ганц хүүтэй юмсанжээ. Хүү нь өсөж гэрт гадаагүй ажилд нь тусалдаг болоход эцэг нь:

- Ажаад байхад ажилд дөртэй болох нь байна. Цаг цагаараа байдаггүй. Залуу нь өсөж хөгшин нь өтөлнө. Удахгүй чи эр болж эхнэр авч гэр толгойлох болно. Тэгэхлээр би чамд захих зүйл байна. Тосгон бүрд гэртэй бай, өдөр бүр шинэ гуталтай яв, хүмүүс чамд дандаа мэхийн ёсолж байхаар яв.

Тэгвэл чи өрхийн сайн тэргүүлэгч болж чадна гэжээ : Хүү нь энэ үгийг сонсоод гайхан:

- Аав минь, энэ чинь юу гэсэн үг вэ? Би тосгон бүрд өөрийн байшин барьж чадна гэж үү? Яаж өдөр бүр шинэ гутал худалдан авах вэ Бас яаж амьдарвал хүмүүс надад мэхийж ёслох вэ?

Эцэг нь инээмсэглэн:

- Зовох юмгүй ээ, хүү минь. Миний захиасыг биелүүлэхэд амархан. Тосгон бүрд гэртээ байгаа юм шиг байя гэрэл тосгон бүрд үнэн итгэлт нөхөртэй болох хэрэгтэй. Тэгвэл тосгон бүрд гэртэй боллоо гэсэн үг. Өдөр бүр шинэ гуталтай байхын тулд орой болгон гутлаа арчиж цэвэрлэж тосло. Өглөө хамгийн эрт бос, бүгдээс урьтаж ажилдаа гар, тэгвэл чамаас орой боссон хүмүүс чамайг хүндэтгэн мэндэлж байх болно. Ийм л амархан захиас шүү дээ гэжээ.

Ингээд хүү том болж айл гэр толгойлон, аавынхаа захисныг үргэлж санаж явж сайн сайхан амьдрах болов гэнээ.

«Эцэг минь тун үнэн юм хэлжээ. Ингэж амьдрах нь дээр юм» гэж бодно.

Тэр улсад тэр цагт ажил хийж чадахаа байсан хөгшин хүнийг хааны цагдаа нарт өгөх хуультай байжээ. Харин тэд хөгшдийг зандалчинд тушааж тэгээд хөнөөдөг байв.

Хүүгийн эцэг ч хөгшрөв. Хүү нь эцгээ өрөвдөн хайрлаж хааны цагдаа нарт өгөхийг хүссэнгүй. Тэгээд аль эртнээс байшингийнхаа дээвэр доор нэг дулаахан өрөө хийж бэлтгэжээ. Энэ өрөөг хэн ч олж мэдэхгүй айхтар аргаар хийжээ Тэгээд хүмүүст мэдэгдэлгүйгээр эцгээ тэндээ нуужээ. Эцэг нь ингээд нууцгай амьдарч байв.

Удсан ч юмуу, үгүй ч юмуу нэгэн удаа хааны цагдаа нар давхин ирж:

- Эцэг чинь хаа байна? Бид түүнийг авахаар ирлээ гэхэд хүү:

- Мэдэхгүй. Гурван өдрийн өмнө л хаашаа ч юм бэ яваад одоо болтол эргэж ирээгүй байна.

Цагдаа нар байшинд нь орж эрээд, булан бүрийг нь нэгжиж амбаар савыг нь үзсэн боловч эцгийн нь байгаа нууц өрөөг анзаарсангүй. Айлынхнаас нь асуув. Тэд:

- Өнгөрсөн долоо хоногт гэртээ байсан, харин сүүлийн гурав дөрвөн өдөр огт харагдахгүй байна гэжээ.

- Эргэж ирэхээр нь бидэнд мэдэгдээрэй! гэж цагдаа нар тушаагаад хоосон буцацгаажээ. Хэдэн өдрийн дараа цагдаа нар дахин ирэв. Хүү нь ч, айл хөршийнхөн нь ч цөм:

- Түүрүүн явснаасаа хойш одоо болтол эргэж ирээгүй байна... гэж хариулав.

Өвгөн нууц өрөөндөө суугаад хэнд ч үзэгдэхгүй байв. Жижиг сажиг юм хийж гэрийнхэндээ туслан, бас юуг яаж хийхийг хүүдээ зөвлөнө.

Хавар болов. Өвгөн:

- Энэ зун их ган болох шинжтэй. Зуны тариагаа чи нам дор, чийгтэй хотгор газар тарь гэжээ.

Хүү эцгийнхээ хэлснээр чийгтэй хотгор газар тариагаа тарьжээ. Хүмүүс шоолон:

- Энэ чинь одоо яаж өвчигнөж байгаа нь энэ вэ? Хотгор газар суулгаад юу ч ургахгүй, тариагүй хоцрох нь! гэцгээв.

Тун хуурай, халуун зун болов. Бороо огт орсонгүй, өдөр бүр нар шарж байв. Тариа хураах цаг болж, хотгор газрын тариа сайн ургаж хүү их ургац авчээ. Өндөр хуурай газрын тариа наранд шарагдаж айл хөршийнхөн нь тариа будаагүй хоцров.

Хойтон хавар нь хүмүүс нам дор, чийгтэй хотгор газар тариагаа тарьж эхлэв. Харин өвгөн хүүдээ:

- Энэ зун бороо ихтэй, хуртай зун болох шинжтэй. Чи хэнийг ч бүү дуурай. Дэнж дэв газарт тарь. Ургац их авна гэжээ.

Яг л өвгөний хэлснээр болжээ. Зунжингаа бороо орж, нэг ч өдөр өнжсөнгүй. Нам дор, хотгор газарт тарьсан тариа ус чийгт ялзрав. Харин өвгөний хүү ахиад их ургац авав. Хүмүүс гайхан шагширч:

- Тариагаа хаана тарихыг урьдаас мэдээд байдаг. Энэ ер нь чөтгөр шулмастай нөхөрлөснөөс зайлахгүй, буруу номтон! гэцгээх боллоо.

Ургац тариа их авдаг урагштай залуугийн тухай яриа улс даяар түгж хааны сонорт хүрчээ. Хаан:

- Хэрэв тэр тийм урагштай, ухаантай эр юм бол миний ордонд хувцастай ч биш, нүцгэн ч биш хүрч ир гэж зарлиг буулгав.

Энэ зарлигийг сонсоод хүү уйтгарлан гуниглаж толгойгоо ганзагалан суухыг харсан эцэг нь:

- Хүү минь, юунд царай барайлгана вэ? Ямар гуниг сэтгэлийг чинь шаналгана? гэхэд хүү хааны зарлигийг хэлжээ. Эцэг нь:

- Уйтгарлаж гуниглаад хэрэггүй. Энэ хэцүү биш ажил. Хуучин тор олж аваад биеэ ороон хааны ордонд оч. Чамайг хувцастай ч гэхгүй, нүцгэн ч гэхгүй гэжээ.

Хүү эцгийнхээ хэлснээр хийжээ.

Хаан түүнийг хараад:

- Сайн байна! Миний зарлигийг яаж биелүүлэхээ мэдэж байна!

Тэгээд залууг гал зууханд очиж хоол унд идээд ир гэжээ. Дараа нь хэлсэн нь:

- За май, энэ чанасан арван өндөг. Чиний тахиа энэ өндөгнүүдийг дараад гурван долоо хоногийн дотор дэгдээхэй болгог! За яв!

Хүү гэртээ их гунигтай буцаж ирэв. Эцэг нь:

- За, хаан юу гэж байна?

- Эхлээд магтлаа. Зарлиг сайн биелүүлж гэлээ. Гэхдээ бүр хэцүү даалгавар өгсөн болохоор ямар хэрэг байх вэ дээ!

- За ярь, би тус болж ч магад? Бүгдээрээ хэлцвэл буруугүй... гэдэг бус уу гэж эцэг шалгаав.

- Юугаар ч тус болохгүй байхаа. Чанасан өндгийг дарж дэгдээхэй болгоно гэж байх уу?!

- Хүү минь, бүү гунигла, хэрэв ухаантай хандвал тус болж болох л юм байна. Алив, чанасан өндгөө аваад ир. Хоёулаа хооллочихъё. Харин чи хаанд нэг сав чанасан шар будаа аваачиж өгөөд «Энэ будааг тарьж ургуулна уу? Нөгөө чанасан өндөгнөөс гарсан дэгдээхэйн үүд зөвхөн ийм л амуу идэх болно» гэж хэлээрэй гэжээ.

Хүү ч эцгийнхээ хэлснээр хийжээ. Хүү хаанд сав чанасан шар будаа авчраад:

- Хаан эзэнтэн минь, энэ чанасан шар будааг тарьж амуу тариа ургуулж өгнө үү? Таны өгсөн өндөгнөөс гарсан дэгдээхэйнүүд зөвхөн ийм л амуу идэх болно гэв.

Хаан гайхаж «Аа аан, чи тийм зоригтой сэргэлэн толгой юм бол би бүүр ч ухаантай хандана даа хөө» гэж бодоод:

- Энэ зарлигийг минь зөв хариуллаа, сайн байна! Гурван өдрийн дараа явган ч биш, морьтой ч биш, бэлэгтэй ч биш, бэлэггүй ч биш миний ордонд ир. Хэрэв энэ зарлигийг минь биелүүлбэл их шан өгнө, биелүүлж чадахгүй бол өөртөө гомд. Миний сэлэм гялс, чиний толгой бөндгөс! Ойлгов уу! гэв.

Хүү гэртээ бүүр царай алдчихсан ирэв. Эцэг нь санаа зовон:

- Юу болов, хүү минь? Ямар гай зовлон учрав! гэхэд хүү:



- Яагаад хаан намайг ингэж өшин хорсоно вэ? Энэ хорвоогоос тонилгох гээд байх шиг байна. Энэ удаа ч үхлээс аврагдаж чадахгүй байх. Эхлээд намайг сайн гэж магтлаа. Тэгээд дахиад шинэ даалгавар өглөө. Гурван өдрийн дараа морьтой ч биш, явган ч биш, бэлэгтэй ч биш, бэлэггүй ч биш хүрч ир гэнээ. Хэрэв биелүүлэхгүй бол цаазлах гэнэ. Энэ чинь шууд л үхэл рүү аваачна гэсэн үг биз дээ? гэж ярьжээ.

- Зүгээрээ хүү минь, зүгээр. Гайгүй, болж бүтэх байх. Өглөө үдшээс мэргэн гэдэг. Одоо хоолоо идээд унт гэж эцэг хэлэв.

Маргааш нь эцэг хүүгээ өглөө эрт сэрээж:

- Ойд яв. Туулай бөднө хоёр амьдаар нь бариад ир. Хааныг яаж аргалахыг би чамд зааж өгье гэжээ.

Хүү өдөр дунд эцгийн хэлснээр туулай бөднө хоёр амьдаар нь бариад иржээ.

- За сайн байна. Ангийн хийморьтой хүү байна гэж эцэг нь магтаад,- Нөгөөдөр хааны ордон руу очихдоо туулайгаа унаж яваа юм шиг хөлөөсөө уячих бөднөө өвөртөө нуучих. Тэгээд ингээд... Яаж юу хийхийг хүүдээ зааж өгчээ.

Нөгөөдөр нь хүү хааны ордон руу явжээ. Хаан залуу хүүг хармагцаа нохойгоо тавь гэж тушаажээ.

«Хашаанд ороод ирмэгц нь л ноход дайран хэдэн хэсэг тасдаж хаяг!» гэж боджээ.

Залуу хүү нохдыг хармагцаа туулайнхаа уяаг тайлж, туулай ч зугтан ноход ч туулайн хойноос элдэн одож түүнд хүрсэнгүй. Тэгээд хаан довжоон дээрээ зогсож байхыг хараад зоригтой өгсөн очиж:

- Хаан таны зарлигаар би явган ч биш, морьтой ч биш, туулай унаад ирлээ. Аа, энэ миний бэлэг гээд өврөөсөө бөднө шувуугаа атган гаргаж ирэв. Хаан авах гээд гараа сунгахад залуу хүү алгаа тэнийлгэв... Бөднө шувуу нисэн одов.

- Таны зарлигаар бэлэгтэй ч биш, бэлэггүй ч биш ирлээ.

- Энэ зарлигийг бас биелүүллээ, сайн байна! гэж хаан магтаад, - За одоо үнэнээ хэл! Чиний хөгшин эцэг хаачсан бэ? Хаана нуугдаж байгаа вэ? Хаана байгааг нь зааж үнэнээ хэлбэл шагнал хайрлахгүй, хэлэхгүй бол цаазална! гэв.

- Эцэг минь намайг өсгөж, хөлийг минь дөрөөнд гарыг минь ганзаганд хүргэсэн билээ. Гэтэл би ачтай буурал эцгээ яаж чиний цагдаа нарт амь насыг нь хороолгохоор өгөх билээ? Тэгээд байшингийнхаа дээвэр доор нэг нууц өрөө хийгээд тэндээ эцгийгээ суулгаж байгаа билээ... Эцэг минь надад дарамт болохгүй. Харин ч гэр зуурын ажил элбэлцэн, амьдралын мэргэн зөвлөлгөө сургамж өгч сайн сайхан амьдрахад минь тусалдаг билээ.

Бусад хүмүүс тариа будаагүй хоцорсон ган гачигтай, ус чийгтэй хоёр жил эцгийнхээ зөвлөлгөөг дагаж ямар их ургац авснаа ярив.

- Эцэг минь наддаа юунаас ч илүү үнэтэй билээ. Түүнгүйгээр амьдрал амьдрал биш гэжээ.

- Миний зарлигийг биелүүлэхэд эцэг чинь тусалсан уу?

- Эцэг минь хэлж зөвлөөгүй бол би яаж таны зарлигийг биелүүлж чадах билээ? гэж хариулжээ.

Энэ ярианы дараа хаан тунгаан бодоод хөгшин хүмүүсийг хороож байх хуулиа өөрчилжээ.

- Энэ чинь л надад болон бүх хүнд хамгийн том шагнал боллоо! гэж залуу хүү хэлэв. Сонин үлгэр үүгээр төгслөө, сонссон хүнд гялайлаа.

# ЭРЭЛХЭГ ХҮЧИТ БААТАР ЕРУСЛАН ЛАЗАРЕВИЧИЙН ҮЛГЭР

Эрт урьд цагт нэгэн улсад Картаус гэдэг хаан байжээ. Картаус хаан арван хоёр баатартай бөгөөд хамгийн хүчтэй, хамгийн эрэлхэг баатар нь тайж Лазарь Лазаревич гэнээ. Залуу баатар Лазарь Лазаревичийг бусад баатрын хэн ч дийлдэггүй байжээ.

Ингээд залуу баатар Лазарь Лазаревич хорь хүрчээ. Эцэг эх нь:

- Хүү гэрлэх цаг болжээ! гэв. Лазарь Лазаревич ч гэсэн гэрлэхдээ дургүй биш байжээ. Гагцхүү гэргий болгомоор хүүхэн олдохгүй байж гэнэ. Эцэг эхийн сэтгэлд нийцэхгүй, эсвэл өөрийнх нь санаанд таарахгүй байжээ.

Ингэж байтал Лазарь Лазаревич эцэг эхдээ хандан:

- Алсын замд явья, өнгөт орчлонг үзье, өөрийн хүчийг сорьё гэж гуйв.

Эцэг эх нь ч саад болж хориглосонгүй. Тэгээд сайн эр эцэг эхтэйгээ салах ёс хийгээд Картаусын хаант улсаасаа гаран явжээ. Өндөр уулыг өвөрлөн намхан газрыг нарлан явсаар Лазарь Лазаревич харийн нэгэн улсад иржээ. Тэгтэл тэр улсын ард олон ихээсээ багаа хүртлээ цөм уйлан хайлан, уйтгар гунигт дарагдан байна гэнэ. Лазарь Лазаревич:

- Ард олон гуниглан зовохын учир юу вэ? Ямар гай зовлон учрав? гэхэд,

- Ээ сайн эр минь, бидний зовлон их. Манай улсад далайн могой нисэн ирж өдөр бүр нэг хүн авч иддэг болоод байна. Хэрвээ дэг хүн өгөхгүй бол манай бүх хот тосгоныг түймэрдэн шатаана гэж зандаг. Өнөөдөр бид нэг бүсгүйгээ могойд идүүлэхээр далайн хөвөөнд хүргэж өглөө гэжээ.

Эрэлхэг баатар өөр юу ч асуусангүй морио ташуурдан далайн хөвөөнд давхин очлоо. Далайн хөвөөн дээр нэгэн бүсгүй гашуунаар уйлан сууж байна гэнэ.

Лазарь Лазаревич тэр бүсгүйд ойртон очиж:

- Амар сайн уу, үзэсгэлэнт бүсгүй минь! гэв. Бүсгүй толгойгоо дээш болгож түүнийг хараад:

- Сайн санаат хүн гуай, эндээс хурдан холд! Одоохон далайн могой гарч ирээд намайг иднэ. Таныг ч амьд үлдээхгүй гэв.

- Үзэсгэлэнт бүсгүй минь, би могойгоос зугтаж нэрээ бузарлахгүй. Аян замд ядарлаа, жаахан амраадхья. Могой гарч ирмэгц намайг сэрээгээрэй.

Ингэж хэлээд мориноосоо бууж ногоон дээр хэвтээд баатрын нойроор бөх унтжээ.

Удсан ч юмуу, удаагүй ч юмуу гэнэт далай цалгилж, өргөн давлагаа хаялан шуугив. Могой ирж яваа нь энэ ажээ. Бүсгүй харийн баатрыг сэрээх гэж дуудав. Лазарь Лазаревич унтсаар байв.

Энэ үед могой эрэг дээр гарч ирэв. Бүсгүй айн уйлахад нэг дусал нулимс баатрын нүүрэн дээр унав. Эрэлхэг баатар сэрлээ.

Могой:

- Өнөөдөр яасан элбэг дэлбэг байх нь энэ вэ? Нэг хүний оронд хоёрыг явуулж бас нэмээд морь өгчээ!

- Үхээрийн хар мангас чи ганц намайг ч залгиж чадахгүй хахах биш үү! гэж Лазарь

Лазаревич чанга хэлэв.

- Би чам шиг гурвыг нэг зэрэг идэж байсан. Одоо чамаас эхэлнэ! гэж могой орилоод баатар луу үсрэв.

Ингээд могой баатар хоёр амь дүйн барилцаж авав. Ноцолдож ноцолдоод могойн хүч буурч эхлэхийг Лазарь Лазаревич мэдмэгцээ самбаачлан болд сэлмээрээ могойн толгойг тас цавчиж хаяв.

Тэгээд ухаангүй айн зогсож байгаа бүсгүй рүү очиж дуудахад бүсгүй баярлан:

- Би амьдарна гэж бодоогүй, таныг мэнд үлдэнэ гэж ч санасангүй. Аймшигт үхлээс аварсан танд гялайлаа. Таны алдар нэр хэн бэ? Эх эцэг дээр минь очъё. Эцэг минь таныг шагнана!

- Надад шагнал хэрэггүй, харин эцэг эхэд чинь хүргэж өгье гэж баатар хэлээд бүсгүйг мориндоо мордуулж өөрөө араар нь сундлаад хотод иржээ. Эцэг эх хоёр нь охиноо ирж явахыг цонхоороо хараад итгэхгүй байв. Тэгээд угтан гүйж ирцгээн баярласандаа нэг уйлж нэг инээжээ.

- Аймшигт могой охиныг минь өршөөх нь энэ үү? Эсвэл зөвхөн нэг өдөр эцэг эхтэйгээ дахин уулз гэж явуулав уу?

Бүсгүй Лазарь Лазаревичийг заан:

- Аймшигт үхлээс намайг аварсан хүн энэ байна. Энэ баатар эр могойг алсан гэв. Эцэг эх нь эрэлхэг баатарт баярлахдаа яах учраа олохгүй тэвдэв.

Тохойг нь түшин цагаан гантиг өрөөнд оруулан хамгийн хүндтэй суудалдаа урьж суулгав. Ширээ засан амттан бүхэн, архи дарсыг өрөв. Дуртай бүхнээ зооглогтун! гэж хүндэлнэ.

Ундалж хооллож зочилсныхоо дараа бүсгүйн эцэг эх:

- Эрэлхэг хүчит баатар минь, чиний ачийг чинь яаж хариулах билээ? Биднээс хүсэл зүйл байна уу? гэхэд баатар эр толгойгоо мэхийн хүндэтгээд үзэсгэлэнт бүсгүйг харснаа эцэг эхэд хандан:

- Хэлэх үгэнд минь бүү уурлаарай. Алдарт Картаусын хаант улсын тайж Лазарь Лазаревич

гэгч билээ би. Үзэсгэлэнт охин чинь сэтгэлийг минь татна. Хэрвээ охин чинь намайг таалан үзвээс хувь заяагаа холбохыг минь зөвшөөрнө үү? Энэ л надад хамгийн том шагнал болно. Энэ үгийг сонссон бүсгүйн царай нь улайн тонгойв.

Эцэг нь:

- Эрэлхэг баатар Лазарь Лазаревич, чи сэтгэлд минь нийцэх боловч охиноо би албадахгүй, хүсэл зоригт нь зөрчихгүй. Өөрөө юу гэж шийднэ, түүгээрээ болог. Эрсхэн хариулсанд бүү гомдоорой. Охин минь өөрөө мэдэг! гэв.

Үзэсгэлэнт бүсгүйн царай улам улайж:

- Өссөн гэрээсээ нисэн одож өөрийн үүрээ засах цаг минь болсон бизээ. Амийг минь аварсан Лазарь Лазаревич сэтгэлд минь таарах хүн мөн гэж зөөлөн хариулахад,

- Охины минь санал ийм хойно эцэг эх бид хоёр нь саад болохгүй. Хэлсэн үгнээс минь хэрэг үйлс зөрөхгүй гэв.

Тэр даруй хөл ихтэй хурим найр хийж Лазарь Лазаревич залуу эхнэрээ нутагтаа аваачжээ. Жилийн дараа хүү төрөхөд Еруслан нэрийг өгөв.

Еруслан өдрөөр биш цагаар өсөж, эр бие нь сунаж эрч чадал суужээ. Гурван настайдаа арван настайтай дүйхүйц болов гэнэ.

Ноёдын хүүхдүүдтэй наадан ордны хашаагаар гүйхдээ багын томоогүй зангаар хэн нэгний гараас нь татвал булгалж, хөлөөс нь чангаавал гэмтээгээд байжээ. Ийм л харьцуулашгүй их хүчтэй гэнээ.

Тайж ноёд Картаус хаанд бараалхаж:

- Лазарь Лазаревичийн хүү бидний хүүхдүүдийг эрэмдэг зэрэмдэг болгож байна. Тоглохдоо тоо ноос хэтэрч эрхлэхдээ эрхээсээ даварч хүүхдийн гар хөл хугалж байна. Хаантан минь, нулимсыг минь хатааж сэтгэлийг минь амрааж аль! Еруслан Лазаревичийг хар гэрт хорь, эсвэл эндээс холдуулж аль! гэж гомдол мэдүүлжээ.

Хаан Картаус Лазарь Лазаревичийг дуудуулан:

- Тайж ноёд ирж Ерусланы тухай надад гомдол мэдүүллээ. Еруслан ноёдын хүүхдүүдийг эрэмдэг зэрэмдэг болгодог гэнэ. Иймд чи хүүгээ хар гэрт суулга, эсвэл хаант улсаас минь зайлуул! гэж зарлиг болов.

Лазарь Лазаревич хааны зарлиг сонсоод омголон тэргүүнээ гудайлган, уйтгарлан гунигласаар харив.

- Лазарь Лазаревич, юундаа царай барайлгана вэ? Ямар нэгэн гай зовлон бидэнд тохиолдов уу? гэж эхнэр нь асуув.

Лазарь Лазаревич хааны хатуу зарлигийн тухай яриад:

- Энэ зовлон зовлон биш үү? гэв.

Эхнэр нь шаналан уйлав. Харин Еруслан Лазаревич энэ яриаг сонсоод эцэг эхдээ мэхийж ёслоод хэлсэн нь:

- Аав ээж минь, надад бүү уурла, ноёдын хүүхдүүдтэй тоглохдоо би хар муу санаа агуулаагүй билээ. Та хоёр ч буруугүй. Хэрэв хаан Картаус намайг нутгаасаа хөөж байгаа бол би явъя. Харин надад тохирсон болд сэлэм, баатрын хуяг дуулга, хурдан морь олдвол сайнсан гэжээ.

- Агтны хашаан дахь морьд цөөднө гэж үү? Аль нэгийг нь шилээд ав. Зэвсгийн сангаас хуяг дуулга, жад сэлэм ямрыг л бол ямрыг шилж ав! гэж эцэг Лазарь Лазаревич хэлэв.

- Баатрын өмсгөл, жад сэлэм шилж авч болноо. Харин надад таарах морь алга. Би нэгд нэггүй үзсэн. Хашаанаас гаргаад сэрвээн дээр нь гараа тавимагц өвдөглөж унаад байх юм. Ийм морьдыг чинь яаж унах вэ!

- Тэгвэл онгон нуга руу оч. Тэнд адуучин Фрол миний морьдыг хариулж яваа. Тэндэх эмнэг морьдын дотроос өөртөө тохирохыг шилж ав гэж Лазарь Лазаревич өгүүлэв.

Ингээд Еруслан Лазаревич аян замд явахаар төхөөрөв. Баатар эрийн хуяг дуулга, хүчирхэг гартаа тэнцэх болд сэлэм, хурц жад олов. Эмээл хазаар, давхар тохом, гөрмөл ташуур бэлдэж аваад ээж аав хоёртойгоо салах ёс хийж замд гарчээ.

Өндөр уулыг өвөрлөн намхан газрыг нарлан явсаар онгон нугад ирвэл морь харайж чадамгүй өргөн зам дурайж байна гэнэ. «Энэ өргөн замаар хэн явдаг байх нь вэ?» гэж Еруслан Лазаревич бодоод замын хажууд суугаад хүлээжээ.

Нэгэн хэсэг суутал адуун сүрэг тэр замаар давхин ирэв. Нэг сүрэг хуйлран өнгөрсний дараа урьдынхаасаа бүр их сүрэг давхин өнгөрөв. Сүргийн араас адуучин үзэгдэж Еруслан Лазаревичид дөхөж ирээд:

- Сайн байна уу, Еруслан Лазаревичаа! Энд яахин сууна? Хэнийг хүлээгээ вэ?

- Та хэн гээч вэ? Алдар нэрийг минь яагаад мэдэж байна вэ?

- Яаж мэдэхгүй байх вэ дээ! Би чиний эцэг Лазарь Лазаревичийн адуучин. Еруслан Лазаревич баярлан:

- Эцэг минь намайг онгон нугад очиж морь шилж ав гэсэн билээ. Манай хашаан дахь морьд цөм дорой. Сэрвээн дээр нь нэг гар хүрмэгц шургачиж унах юм. Тийм морьд намайг даахгүй. Фрол, та сайн морь барьж өгнө үү? Ачийг чинь мартажгүй гэвэл,

- Еруслан Лазаревич, санаа зоволтгүй. Надад ажиглаж тэмдэглэсэн тийм сайн морь бий. Морь гэж ёстой баатрын хөлөг. Ус уухад нь нуур долгион, ширүүн давлагаа босож, модны навчис унадаг юм. Харин чи барьж авч чадах болов уу? Хэрвээ бариад авч чадах юм бол ч

морь чамд номхроод өгнө. За хараач, уснаас буцаж яваа сүргийн хамгийн түрүүнд давхиж явна!

Сүрэг тэдний хажуугаар давхин өнгөрөхөд адуучин дахин:

- Морьд усалдаг нуурыг би чамд зааж өгье. Чи маргааш өглөөнөөс тэнд отоод хүлээж бай гэжээ.

Өглөө нь Еруслан Лазаревич нуурын захад нуугдан хүлээв. Газар доргиж морьдын туурайн чимээ ойртсоор ирэв. Хамгийн эхний хэсэг адуу хажуугаар нь давхин нуур луу очив. Бүх адууны түрүүнд гал мэт хөлөг морь явна гэнэ. Нүднээс нь гал бадарч, хамраас нь дөл дүрэлзэж, чихнээс нь утаа савсана. Өвдөгцөө уснаа орж залгилж эхлэв.

Нуурын ус долгион оволзож модны навчис эрэг рүү нэвсийлдэн унав гэнэ.

Тэр морь ус ууж дуусаад эрэг дээр гарч ирмэгц зүүн гартаа хазаар барьсан Еруслан Лазаревич баруун гараараа морины дэлээс нь шүүрч авав. Морь цойлон цоройж туурайгаа газар цавчихад нь дорх газар чичрэвч баатрын гараас мултарч чадсангүй, жинхэнэ эзнээ мэдээд номхорч гэнэ.

- Зөнч Хурдан хөлөг байна! гээд хазаарлаж цулбуураас нь хөтлөн эмээл, дуулга байгаа газраа авчрав.

Еруслан Зөнч Хурданаа эмээллэж, өөрөө хуяг дуулгаа өмсөөд байтал адуучин Фрол ирэв.

- Морь чамд номхорчээ! Чи ч эзэн болж чаджээ.

- Гялайлаа, Фрол! Ач тусыг чинь мартаггүй!

Ингээд тэд салцгаажээ. Сайн эр ухасхийн мордоод тасхийтэл ташуурдаад алсын замыг зорин давхихад адуучны нүдэнд улаан тоос босох нь л харагдав гэнэ.

Еруслан Лазаревич хэдэн өдөр яваад нэгэн өргөн талд гарч ирвэл талаар дүүрэн хиар цохигдсон цэрэг байна гэнэ.

Еруслан Лазаревич:

- Амьд хүн байна уу? гэж чангаар асуувал нэгэн хүн:

- Би л ганцаар амьд үлджээ! гэв. Еруслан ойртон очиж:

- Хэн танай цэргийг ингэж хиар цохин устгаа вэ?

- Оросын баатар Иван.

- Оросын баатар Иван одоо хаана байгаа вэ?

- Өмнө зүгийг барин яв, гүйцэж магадгүй. Оросын баатар манай бусад цэргийг цохихоор явсан гэжээ.

Ерусдан Лазаревич өмнө зүгийг чиглэн давхив. Яв явсаар нэг өргөн талд гарч ирвэл бас л хиар цохигдсон их цэрэг харлан хэвтэж байна гэнэ.

Еруслан баатар чангаар:

- Амьд хүн байвал, хариулаач! гэж хашгирав. Нэгэн хүн өндийж:

- Баатар эр минь, чамд юу хэрэгтэй вэ? Их цэргээсээ би ганцаар амьд үлдлээ.

- Энэ хэний цэрэг цохигдоо вэ? Хэн гэгч баатар танай цэргийг цохио вэ?

- Энэ бол Феодул Змеулановичийн цэрэг билээ. Биднийг оросын баатар Иван хиар цохилоо.

- Оросын баатар Иван одоо хаашаа одсон бэ?

- За тэр харж байна уу? Баатар эрийн морины туурайн мөрийг. Гишгэсэн газраасаа толгодын чинээ шороо онгилдог тийм л морь доо. Морь чинь омголон бол энэ мөрийг даган давхи, гүйцэж ч магадгүй.

Еруслан Лазаревич цэрэгт талархаад морины мөрийг даган давхив. Үүрийн туяанаас үдшийн бүрий болтол хоёр өдөр давхиад гурав дахь өдөр нь ногоон нугад цагаан цацар байхыг харав. Цацрын хажууд нэгэн том морь улаан буудай идэж байв. Еруслан Лазаревич мориныхоо эмээл хазаарыг нь авч тавив. Зөнч Хурдан ч улаан буудай руу очиж идэж эхлэв.

Еруслан Лазаревич цацарт орвол оросын баатар Иван бөх гэгч унтаж байв. Еруслан сэлмээ шүүрэн авснаа «Унтаа хүн рүү дайрах нь гутамшиг билээ.

Аян замд би ч ядарлаа, амрая» гэж бодоод хажуугаар нь хэвтээд унтаад өгчээ. Оросын баатар Иван эхэлж сэрэн урилгагүй зочноо хараад:

- Сайн эр минь, босооч, сэрээч! гэв.

Еруслан Лазаревич босоход оросын баатар Иван:

- Урилга, заллагагүй ирж цацарт минь унтахын учир юу вэ? Сайн санаат зочинд суудал тавьж хүндэлдэг нь манай оросын заншил. Чи хар муу санаа агуулаагүй чинь ил байна. Наашаа сууж цай идээ амс, аль газрын хэн гэгчийн үр вэ?

- Би алдарт Картаусын хаант улсын Еруслан Лазаревич гэгч хүн. Оросын баатар Иван чиний тухай би олонтаа сонсож, эртнээс нүүр учран уулзахыг хүсэж явсан билээ. Мөрөөр чинь олон өдөр явж, чиний хиар цохьсон Феодул Змеулановичийн их цэргийг харлаа. Өөрийгөө би хамгийн хүчтэй гэж бодож явлаа. Гэтэл одоо, чи надаас хүчтэй гэдгийг би хүч үзэлтгүй мэдлээ. Хуурай ах минь болооч! гэж хариулав.



Оросын баатар Иван Еруслан Лазаревич хоёр ах дүү бололцож, цом архи ууж замын хүнсээрээ даруулцгаав. Еруслан Лазаревич:

- Хаан Феодул Змеулановичтой чи юундаа ингэж нүдэлцэн байлдана вэ? Үнэн учрыг сонсоно уу? Их цэргийг нь ямар учраас хиар цохио вэ?

- Яаж ч нүдэлдэн байлдахгүй байх билээ дээ, Еруслан Лазаревич минь? Феодул Змеулановичийн охин бид хоёр бие биедээ хайртай болсон билээ. Тэгээд би Феодул Змеулановичийн улс руу сайн сэтгэлийг барин худ ураг бололцохоор очтол нэр хүндийг гутаан

«Зальт этгээдийг би мэдэх ч үгүй таних ч үгүй, нүднээс далдар! Танай улсыг дайран орж бүх

Оросыг эзлэн, оросын баатруудыг олзлон авна» гэж хашгиран хараалаа. Ингээд миний өөдөөс цэргээ дайруулав. Гэм хэнд зэм түүнд гэдэг үнэн шүү. Змеулановичийн цэргийг би хиар цохин устгав. Дахин бүр их цэрэг илгээсэн боловч юу болсныг чи өөрийн нүдээр харсан шүү дээ. Ингээд би Феодул Змеулановичид «Хаан, та хар хүчиндээ дэмий итгэжээ! Оросыг дайран эзэлж оросын баатруудыг олзолно гэж гайхуулсан биш билүү, чинийхээр болсонгүй дээ. Иймд бид сайнаар эвлэрвэл дээр биш үү? Охиноо өг, эс өгвөөс хүчээр авна» гэж очиж хэлэхээр шийдээд сууж байна. Эрхэм хуурай дүү Еруслан Лазаревич минь, Феодул Змеулановичийн нийслэл хот руу надтай цуг яваач. Хаан надтай эвлэрч, охинтой нь хурим найр хийх болбол чи манай хуримд оролц гэжээ.

Хоёр баатар хуяг дуулгаа өмсөж аян замд гарлаа. Хотод арваад мод газар ойртож очоод оросын баатар Иван байлдааны дунгаа үлээв.

Хотын харуулын элч хаанд давхин очиж:

- Оросын баатар Иван хотоос арваадхан мод газар ирээд байна. Түүнтэй хамт харийн нэгэн баатар явна! гэж мэдэгдэв.

Феодул Змеуланович айн сандарч:

- Ээ, ямар их гай зовлон бэ! Ганцаараа хоёр их цэргийг хиар цохьсон, одоо хоёул бол улс орныг минь сүйтгэнэ! гэв.

Дараа нь жаахан сэхээ орж, халуун хэвтрээсээ бууж титмээ өмсөөд:

- Зарц нар аа! Хатанг дууд! Оросын баатар Иваныг талх давс барин угтацгаая. Эвлэрэх магадгүй гэжээ.

Тэгээд шадар ноёд, тайж нартаа:

- Оросын баатар Иваныг угтан авч хотод авчирцгаа. Хатан бид хоёр ордныхоо үүдэнд угтъя гэжээ.

Ах дүү хоёр баатрыг талх давс барин хүндэтгэн угтав.

- Урьдын явдлыг мартъя, хуучны хэргийг хумхия. Харин өнөөдөр хатан бид хоёр зочдоо хүндэтгэн угтахдаа баяртай байна гэж хаан хэлэв.

Ордонд ширээ засан зочлол хүндэтгэл болж, удсан ч үгүй хурим болон өргөжив. Хурим найрын үеэр Еруслан Лазаревич оросын баатар Иваны эхнэрээс асуусан нь:

- Үзэсгэлэнт гүнж минь, чамаас сайхан хүүхэн энэ хорвоо дээр бий юу?

Гүнж энэ үгийг дуулаад жаахан ичингүйрснээ:

- Үзэсгэлэнтэй гэж миний тухай ярьдаг ч зуун уулын цаанатаа зургаан улсын тэртээх эгч дүү гурвын хамгийн бага дүү нь надаас үзэсгэлэнтэй гэж сонссон гэв.

- Оросын баатар Иван чиний нөхрөөс өөр надаас хүчтэй хүний тухай сонссон уу?

- Еруслан Лазаревич, чиний эрэлхэг зориг, их хүч чадлын тухай хотол даяар шагшицгаадаг. Харин Энэтхэг улсын хилийг гучин жил хамгаалан зогсож буй Цагаан нөмрөгт Ивашка гэгч эрэлхэг баатар, ах дүү та хоёроос ч хүчирхэг гэж ярилцах юм. Гэхдээ хүчээ үзэлцээгүй баатруудын хэн нь хүчирхэгийг хэлж мэдэхгүй байна.

Еруслан Лазаревич үзэсгэлэнт гүнжид талархаад яриагаа дуусгажээ. Хурим найр төгсөхөд Еруслан Лазаревич хуурай ах оросын баатар Иван түүний үзэсгэлэнт залуу эхнэртэй салах ёс хийв.

- Хэдэн өдөр ч болтугай зочлохгүй юу? гэж гуйхад Еруслан Лазаревич:

- Хайрт ах минь, гялайлаа! Харин ч удаан зочиллоо. Зөнч Хурдан ч амарлаа. Аяны замаа үргэлжлүүлэх цаг болжээ гээд морио эмээллэн баатрын хуяг дуулгаа өмсөөд зуун уулын цаанатаа зургаан улсын тэртээг зорин явжээ.

Еруслан ургахын улаан нарнаас унахын шар наран хүртэл, өглөөнөөс орой болтол давхина. Ингээд олон өдөр явж урт замыг туулжээ. Явсаар эгч дүү гурвын байдаг тэр улсад иржээ. Нарийн шонгийнх нь дэргэд бууж алтан гогцооноос нь морио уяад хээлж сийлсэн довжоог өгсөн үүдийг тогшив.

Хаалгач бүсгүй:

- Хэт нутаг хаана вэ, хэрэг зориг юунд вэ? Хэний хэн, юу гэж хэлэх вэ?

- Алдарт Картаусын хаант улсын баатар Еруслан Лазаревич ирлээ гэж хэлнэ үү. Эгч дүү гуравтай нүүр учран уулзмаар байна.

Хаалгач бүсгүй гүйн одоход удсан ч үгүй нэг нь нэгнээсээ илүү үзэсгэлэнтэй эгч дүү гурав гарч ирэв.

- Сайн эр минь, тавтай морилон орно уу! гэв. Эгч дүү гурав зочноо амтат идээ өрөн дайлав. Еруслан Лазаревич эгч дүү гуравт мэхийн ёслоод:

- Дайлж зочилсонд баярлалаа! Эгч дүү та гурваас үзэсгэлэнтэй, эелдэг бүсгүй байхгүй гэдэг үнэн юмаа! гэв.

Эгч дүү гурав энэ үгийг сонсоод харцаа буулган хацраа улайлган ичингүйрснээ:

- Эрэлхэг баатар Еруслан Лазаревич, эелдэг үгэнд чинь баярлалаа! Гэхдээ биднийг хамгийн үзэсгэлэнтэй гэж боддог нь буруу. Вахрамей хааны охин хамгийн үзэсгэлэнтэй билээ. Марфа Вахрамеевна хэнтэй ч зүйрлэшгүй, нүүр царай сайхан төдийгүй нуруу туруу, хүч чадал сайтай. Урсгал дөлгөөн харцтай уран хар хөмсөгтэй, хун шувуу шиг явдалтай, хурмастын нар шиг гэрэлтэй билээ! гэж өгүүлэв.

- Эгч дүү та гурвыг ухаантай цэцэн гэж ярилцдаг. Үзэсгэлэнт бүсгүйчүүл минь, энэ дэлхий дээрх хамгийн хүчит баатар хэн бэ? Хэлж өгнө үү?

- Сайн үг салхин хөлөгтэй гэдэг. Хамгийн хүчтэй, хамгийн эрэлхэг баатар бол оросын баатар Иван гэж бид сонссон.

- Оросын баатар Иван миний хуурай ах билээ.

- Зочин таны их хүч, эрэлхэг зоригийн тухай өөрөө хүрэлцэн ирэхээс чинь өмнө бид

сонсож байсан. Бас Цагаан нөмрөгт Ивашка гэгч хүчит баатрын тухай сонссон. Энэ баатар Энэтхэг улсын хилийг гучин жил хамгаалж буй гэнэ лээ. Түүний тухай дуулснаас уулзаж хараагүй билээ.

Еруслан Лазаревич эгч дүү гуравтай ийнхүү ярилцаад дайлж зочилсонд талархаад цааш явжээ.

Хотоос гарч явахдаа «Олон хоног ийнхүү явах зуур орон гэрт минь юу болж байгаа бол. Ээж аавгайгаа уулзъя. Эхнэр авах ерөөл хүртье. Тэгээд Вахрамейн хаант улс руу явж Марфа Вахрамеевнаг гуйж эхнэр болгоё» гэж боджээ.

Тэгэд Зөнч Хурданыхаа амыг эргүүлж Картаусын хаант улс руугаа явав.

...Зөнч Хурдан эцвэл хазаарыг нь авч амруулж тэнхрүүлж өөрөө амарч аваад цааш явдаг байв. Яв явсаар нутгийнхаа захад хүрэв. Яаран догдолж морио шавдан давхисаар Картаусын хаант улсынхаа нийслэл хотын барааг харав.

Гэтэл хотыг тойрон тоо томшгүй их цэрэг хүрээлэн байхыг хараад нүдэндээ итгэсэнгүй. Хотыг бүхэлд нь хүрээлжээ. Агсам морьтой цэргүүд давхилдан, явган цэрэг хотын хаалга руу дөхөж явлаа. «Энд юу болж байна?» гэж бодоод толгой дээрээс бууж явтал адуучин Фрол дайралдав. Нийслэл хотоос зугтан давхиж явна гэнэ.

- Амар сайн уу, Фрол!

Адуучин Еруслан Лазаревичийг танин зогсоод мэндлэв.

- Энэ хэний их цэрэг манай хот руу дайран орж байна вэ? гэж баатрыг асуухад,

- Еруслан Лазаревич минь! Чиний эцэг Лазарь Лазаревичтай уулзахаар би онгон нугаас хот руу давхисан чинь арай л баривчлагдсангүй. Хурдан морины ачаар л зугтаж гарлаа. Цагаан Данила тайж морьт болон явган их цэргээ хөдөлгөн манай хот руу

дайран орлоо. Картаусын баатрууд ийш тийш яваад Лазарь Лазаревич тайжаас өөр баатар хотод байгаагүй билээ. Хаан, тайж, ноёд, хотынхон цөм хотын хэрэм дотор нуугдан байна. Хот руу орох гарах ямар ч арга алга. Цагаан Данила манай улсыг эзлэн авч устгана гэж сүрдүүлж байна.

.Хаант улсыг хамгаалах хүнгүй, Цагаан Данилагийн цэрэг үй олныг үзээд залуу баатар Ерусланы уур нь хүрч уушиг нь сагсайж хав хийтэл мордон дав хийтэл ташуурдан хотын зүг давхижээ.

Эрэлхэг баатар давхин айсуйг хараад «Картауст туслахаар баатар ирлээ!» гэж өстөн дайснууд шуугилдав.

Цагаан Данила тайж морьт цэргээ угтуулан:

- Амьдаар нь бариарай! гэж хашгирав.

Еруслан Лазаревич улам хурдлан Данилагийн морьтонгууд руу хуй салхи шиг хуйлран оров. Баруунтшаа цавчиж баахныг цохиж зүүнтшээ ширвэж зөндөөнийг ханаруулж хатгасан бүгдийгээ ханаруулан унагав. Зөнч Хурдан ч дайсны морийг цээжээрээ түлхэн унагаж үсэрч ойчсон өстөнг өшиглөн дэвсэж байлаа. Өстөн дайсны үхдэл талаар нэг харлахад үлдсэн хэдэн морьтон амь тэмцэн зугтав.

Еруслан Лазаревич Цагаан Данилаг хөөн гүйцэж урт жадныхаа бөгсөөр цохин унагав. Зөнч Хурдан цээжин дээр нь гишгэн зогсоход Данила

- Эрэлхэг хүчит баатар минь, амь өршөө, амьд үлдээ! Картаусын хаант улсыг миний нэг ч цэрэг дахин хэзээ ч дайран довтлон орохгүйг андгайлан тангараглая! Танай улстай дайсагнахгүй байхыг үр удамдаа захиана гэж гуйв.

- За гуйснаар болог. Хэрэв хэзээ нэг цагт хэлсэн үгээ няцвал амьд үлдэхгүй шүү! гэж Еруслан Лазаревич хэлэв.

- Энэрэн өршөөснийг чинь энэ насандаа мартахгүй, андгай тангаргаа эвдэхгүй! гэж Цагаан Данила хэлээд босов. Тэгээд тэр даруйхнаа хотыг бүсэлсэн их цэргээ аван Картаусын хаант улсаас холдож явав.

Дайсны цэрэг холдон явахыг харсан хотынхон гэнэт:

- Энэ чинь тайж Лазарь Лазаревичийн хүү Еруслан Лазаревич байна шүү дээ! Биднийг Еруслан Лазаревич аварлаа! гэж хашгиралдав.

Энэ мэдээ тэр дорхноо Еруслан Лазаревичийн эцэг эхэд төдийгүй эзэн хаанд хүрэв. Хайрт ээж аав нь, хаан Картаус шадар ноёдынхоо хамт гол хаалганы өмнө гарч Еруслан Лазаревичийг ихэд хүндэтгэн баярлан угтацгаав. Эх нь баярлан хүүгээ тэврэн үнсэв.

Хаан Картаус хүртэл нулимс цийлэгнүүлэн:

- Нийслэл хотоо, төрөлх нутгаа, төрөл биднээ аварсан чамайг юугаар яаж баярлуулахаа мэдэхгүй байна. Эртний явдлыг март, элгэн дэх гомдлоо хая гээд зарц олондоо хандан,

- Хүндэт зочноо дайлцгаая! Архи дарс, амтат балтай торхоо авчир! Өнөөдөр цөм найрлаж эрэлхэг хүчит баатар Еруслан Лазаревичийн эр зориг эрэмгий чадлыг магтан алдаршуулъя! гэв.

Өргөн их найр гурван өдөр үргэлжлэв. Дөрөв дэх өдрөө Еруслан Лазаревич хаан Картауст талархаад эцэг эхдээ мэхийн ёслоод:

- Хайрт эцэг эх та хоёроосоо удаан холдож олон хотыг үзэж, түмэн газрыг туулсан боловч гэртээтухлан сууж чадахгүй нь. Өргөн хорвоог үзэж өөрийн хүчийг соримоор байна. Хувь заяаныхаа ханьтай дайралдвал эцэг эх та хоёрын энэрэл өршөөлийг хүснэ! гэв.

Эцэг эх хоёр нь эсрэгцэж хорьсонгүй, ивээлт үгээр ерөөгөөд аян замд нь бэлтгэв.

- Хатан зоригт эрийг хашиж хорьж дийлэхгүй. Залуу байсан болохоор би өөрийн биеэр мэднэ! Явж үзэж сэтгэлээ баярлуул! гэж Лазарь Лазаревич хэлэв.

Еруслан Лазаревич Зөнч Хурдан морио эмээллэн баатрын хуяг дуулгаа өмсөөд аав ээжээсээ ерөөлийг нь хүртээд алсын замд дахин гарав.

Хотоосоо гараад «Энэтхэг улс руу явж Цагаан нөмрөгт Ивашка баатартай танилцъя. Тэндээсээ Вахрамейн хаант улсад очиж Марфа Вахрамеевнаг харъя» гэж бодов.

Өндөр уулыг өвөрлөн намхан газрыг нарлан явсаар алдарт Энэтхэг улсын захад ойртон ирэв. Хилийн хотын хажууд нэгэн том баатар унтаж байна гэнэ. «Энэ нөгөө Цагаан нөмрөгт Ивашка гэгч баатар мөн бизээ» гэж Еруслан Лазаревич бодоод дэргэд нь очвол баатар эр ажиг ч үгүй унтсаар байв.

Еруслан морин дээрээсээ бөхийн тэр баатрыг суран ташуураар нэг шавхрав.

- Ингэж хилийг харж улсыг хамгаалдаг юм уу? Чамайг унтаж байх хооронд чинь дуртай нэг нь орж гарч болох байна!

Цагаан нөмрөгт Ивашка үсрэн босож ууртайгаар:

- Чи хэн гэгч вэ? Гучин жилийн турш миний хажуугаар хүн амьтан байтугай жигүүртэн шувуу нисэж өнгөрөөгүй! Харин чи ташуураар шавхарч үзнэ гэнэ! Тоглоом тоотой нь дээр байх! Алган завсраа чамайг хавчихад атга шороо ч үлдэхгүй! Алив тийшээ тал руу очье, чамайг хашраагаад өгье! гэж хашгирав.

Ингээд Цагаан нөмрөгт Ивашка баатар морио эмээллэн, хуяг дуулгаа өмсөөд эрэлхэг хүчит баатар Еруслан Лазаревичтай амь наана там цаана ач тач үзэлцэхээр явлаа.

Еруслан Лазаревич эхний дайралтаар Цагаан нөмрөгт Ивашкаг жадныхаа бөгсөөр цохьтол эмээлээсээ ховх үсрэн ойчив. Зөнч Хурдан морь цээжин дээр нь гишгэн зогсоход Цагаан нөмрөгт Ивашкагийн үг хэл нь зөөлөрч:

- Эрэлхэг хүчит баатар эр минь, амь өршөө, амьд үлдээ! Чиний хүчний дэргэд минний чимхийн төдий гэдгийг мэдлээ. Уулыг цас эрийг нас даржээ. Харин чи ургаж байгаа ногоо дэлгэрч байгаа дэлбээ байна. Ах дүүс болж амгалан энхийг сахья! гэв.

- Амийг чинь халиах хүсэл надад байхгүй. Алдар сүр чинь хоосон гэдгийг л мэдлээ. Хүчит баатар биш байна чи, за бос бос!

Ингэж хэлээд Еруслан Лазаревич Зөнч Хурданаа холдуулав. Цагаан нөмрөгт Ивашка босон хуу рай ахдаа мэхийж:

- Алдар цуут Энэтхэг орныг үз! Орох зам нээлттэй. Манай хотод хэдэн өдөр тухтай зочилно уу! гэв.

Еруслан Лазаревич шууд нийслэл хотыг нь чиглэн явсаар төдхнөө хааны ордныг үзэв. Зөнч Хурданахаа эмээл хазаарыг нь аван нарийн шонгийн алтан гогцооноос уяв.

Хаан цонхны цаана сууж байснаа харийн баатар ирэхийг хараад хээлж сийлсэн өндөр довжоон дээрээ гарч ирэн эелдэгхэн угтав.

- Эрхийдээ чадалтай эрэлхэг баатар минь, хэт нутаг хаана вэ? Хэний хэн гэгч вэ? Баатар эр хааныг хүндэтгэн мэндлээд:

- Алдарт Картаусын улсын тайж Лазарь Лазаревичийн хүү Еруслан Лазаревич билээ би.

Ингээд шатаар өгсөн очиход хаан түүнийг ордондоо урьж дайлж цайлаад аяны замын сониныг асууж лавлаад:

- Зочилж ирсэн чинь сайн байна. Сайн санаат зочин бүрд бид баяртай, чам шиг баатар эрийг хүндтэй суудалдаа суулгана, амттай идээгээр дайлна! Одоо аян замынхаа алжаалыг тайлж амарч нойрс! гээд зарцаа дуудан,- Зочныг унтах өрөөнд аваачиж хэрэгтэй бүгдийг өг! гэв.

Ийнхүү Еруслан Лазаревич энэтхэгийн хааныд хэд хоног амраад дайлж зочилсонд талархаад аяны замаа цааш үргэлжлүүлжээ. «Цагаан нөмрөгт Ивашка баатрыг үзлээ. Цайлж дайлсан элэгсэг хааныд зочиллоо. Одоо Вахрамейн улсад очъё. Марфа Вахрамеевна гүнжийг нүдээр харахаас нааш сэтгэл амрахгүй» гэж Еруслан Лазаревич шийдэн давхиж явав.

Ийнхүү аяны зам сунган явсаар Вахрамейн хаант улсын захад ирээд байтал нэгэн өвгөн бадарчин дайралдав. Өвгөн бадарчин малгайгаа аван мэхийж баатрын амрыг эрэв.

- Амар сайн уу, Еруслан Лазаревич!

Эрэлхэг баатар гайхан:

- Та хэн гэгч хаанахын хүн бэ? Нэр алдрыг минь дуудахыг бодоход намайг таньж мэдэх юм уу?

- Би нэг муу бадарчин хүн. Орчлон дэлхийг тойрч, олон хотыг үзсэн. Картаусын хаант улсад очиж эцэг эхтэй чинь уулзаж байсан. Чамайг олон удаа харсан. Гэтэл саяхан би Картаусын улсын дэргэдүүр өнгөрөхдөө юу үзсэн, юу харсан гэх вэ? Уйггар гунигт мэдээ чамд дуулгая.

Баатар мориноосоо үсрэн бууж бадарчин өвгөний мөрнөөс барин сэгсэрч:

- Нутаг улсад минь юу болоов? Түргэн хэлээч! Эцэг эхтэй минь уулзав уу? Эрүүл энх эсэн мэнд үү?

- Еруслан Лазаревич байз, намайг бүү сэгсэр! Гар таслах нь! Нутаг улсад чинь гай зовлон учиржээ! Цагаан Данила гайж эзгүй цагийг чинь далимдуулан үй олон цэрэг хөдөлгөн танай улсыг дайран орж эзлэн авчээ. Нийслэл хотыг үнсэн товрог болгон шатаажээ. Хаан Картаус, эцэг эх хоёрыг чинь, бас бусад шадар ноёдын хамт олзлон авч нүдийг нь сохолжээ. Харах хараагүй болсон тэднийг өөрийн улсдаа аваачин гянданд хорьсон байна. Хөөрхий тэд одоо тэнд зовж шаналж байгаа.

Еруслан Лазаревич бадарчны яриаг сонсоод толгой гудайн:

- Цагаан Данилаг амьд үлдээдэг буруу болжээ! Нутаг ус руу минь дайрахгүй гэж шороо үмхлэн гуйхад нь би итгэсэн билээ! Гэтэл зэрлэг чоно юу хийв! Өрөвдсөн биш өр өшиглөжээ! Одоо чиний өрвөлзөх хорыг дарж өрөвдөх сэтгэлгүй цохино доо! гэв.

Ингээд өвгөн бадарчинтай салах ёс хийгээд Цагаан Данилагийн хаант улс руу хурдлан давхив. Эцэг эх, хаан Картаус, шадар ноёдын хоригдон буй гянданг олж харуул манаагий нь хаман авч шидлэн, хаалга үүд, цоож цуургыг нь хэмх цохин онгойлгов. Үүдийг нь нээн:

- Гэрэл гэгээ болсон эцэг эх хоёр минь амар сайн уу? Эзэн Хаан Картаус минь, шадар ноёд минь амар сайн уу? гэж хашгирав.

- Дуугий чинь сонсож байвч харах нүдгүй бид хэн гэдгийг мэдэхгүй байна! гэж нэг нь хариулав.

Тэгтэл ч баатрын эх:

- Харахгүй авч хайрт хүүгээ би дуугаар нь танилаа, сэтгэлээрээ мэдэрлээ. Еруслан Лазаревич хүү минь! гэхэд Лазарь Лазаревич:

- Тийм байна, хүү минь мөн байна. Хайрт хүү минь, биднийг хар аюул гашуун зовлон нөмрөөд байна. Олзлон баривчлагдаад орчлонг харах нүдгүй болж туйлдаад байна. Гэхдээ одоо энэ тухай ярихгүй. Харин хүү минь, чи өндөр уулсын тэртээ өргөн мөрний цаана Гал бамбай Дөл жад хааных руу яв. Тэр улсад мөнхийн устай худаг байдаг гэж хуудуугүй нөхдөөс сонссон. Чи Гал бамбай Дөл жаднаас мөнхийн ус авчирч бидний шархыг шүршвэл бид

цөмөөр хараа орон эдгэнэ гэж хэлэв.

- Гал бамбай Дөл жад руу би заавал явна. Харин одоохон Цагаан Данилаг олоодхье гээд баатар эр эргэв.

Еруслан Лазаревичийг олзлогдсон эцэг эх, эзэн хаантайгаа ярилцах зуур гяндангийн харуул Цагаан Данила дээр гүйн ирж.

- Тайж минь, гай дайрлаа! Харийн нэгэн баатар ирээд гяндангийн харуул манааг цохиж алаад хаалга үүдийг нээлээ! Би ганцаар амь мэнд зугтаж ирлээ гэж мэдээлжээ.

- Тайж Лазарь Лазаревичийн хүү биз гэж Цагаан Данила хэлээд,- Түгшүүр зарла, хотод байгаа бүх цэргийг цуглуул гэв.

«Гянданд байхад нь дараад авья» гэж бодоод хуяг дуулга өмсөөд их цэргээ аван давхив. Еруслан Лазаревич гяндангаас гарангуутаа тайжийн их цэргийг харлаа. Эрэлхэг баатар Еруслан

Лазаревич Цагаан Данилагийн цэрэг рүү элээ мэт шунган оров. Цавчихыг нь цавчиж, жадлахыг нь жадална. Зөнч Хурдан морь нь ч дайсны морийг түлхэж өнхөрч унасан өстөнийг хурц туурайгаараа бяц гишгэж байв. Еруслан Лазаревич цэргийг даруйхнаа хиар цохиж дуусгзв. Хэдэн дайсан амь зугтан одов.

Тэдний дотор Цагаан Данила зугтаж явахыг Еруслан хараад:

- Чи л надад хэрэгтэй! гэж хашгираад морио давиран эзлэн түрэмгийлэгчийн хойноос элдэн хөөв.

Цагаан Данила морио хичнээн шавхуурдавч Зөнч Хурдан дорхноо гүйцэв.

Еруслан Лазаревич Цагаан Данилаг эмээл дээрзэс нь хийсч унатал цохин толгойг нь цавчив.

- Амийг хорлох хорт өвсийг шатаах мэт устгая! гэж Еруслан Лазаревич хэлээд гянданд буцан ирж,

- Гарцгаагаарай, та нар одоо чөлөөтэй. Цагаан Данилагийн ордонд орцгоо! гээд хаан

Картауст хандан:

- Эднийхэн манай улсын хавсрага харьяат болцгоог. Та Цагаан Данилагийн оронд хаан ширээнд суун улс орныг залж бай, би мөнхийн усанд явья. Манай нийслэл хот үнсэн товрог болсон тул дахин барьж босготсл бид энд байх болох нь гээд ал бамбай Дөл жадны улс руу явлаа.

Явж бэйтэл нэгэн их өргөн тал нүднийх нь өмнө цэлийн харагдав. Тэр талаар нэг хиар цохигдсон их цэрэг харлан хэвтэнэ гэнэ. Баатар эр өндөр дуугаар:



Энэ талд амьд хүн байна уу?

Аан, юу гэв? гэж нэг цэрэг хариулав.

- Энэ их цэргийг хэн ингэж хиар цохио вэ?

- Манай их цэргийг Росланей баатар цохин устгалаа.

- Росланей баатар өөрөө хаана байна?

- Эндээс холгүйхэн өөр нэгэн талд бас л их цэргийг хиар цохин устгасан байгаа. Тэнд алагдсан Росланей баатар хэвтэж буй.

Еруслан баатар цаашлан явж өөр нэгэн талд хүрвэл тэнд урьдынхаас их олон цэрэг алагдсан байх ажээ. Өмнө нь нэгэн том толгод байхад дөхөж очвоос тэр нь уул толгод биш баатар эрийн толгой байсанд гайхахын ихээр гайхав.

- Амьд хүн байна уу? гэж Еруслан хашгирав.

Хэн ч хариулсангүй. Дахин хашгирваас хариу алга. Гурав дахь удаагаа хашгирваас том толгойн нүд нээгдэн, эвшээснээ:

- Чи хэн гээч вэ? Юу хэрэгтэй вэ? гэв.

- Би алдарт Картаусын улсын Еруслан Лазаревич гэгч билээ. Энэ хэний цэрэг хиар цохигдон хэвтэнэ вэ? Росланей баатар гэгч хаана байна вэ?

- Росланей баатар гэгч би байна. Түрүүчийн болон энэ талд харлан байгаа алагдсан цэргүүд Гал бамбай Дөл жад хааных билээ. Гал бамбай Дөл жад хааны цэргийг би хиар цохин эцэст нь өөрөө ингээд алагдаад байна.

- Яагаад энэ билээ? Чи хоёр их цэргийг нь хиар цохьсон мөртлөө өөрөө яагаад ингэж хэвтэнэ вэ?

- Олон жилийн өмнө намайг бага байхад Гал бамбай Дөл жад хаан манай улс руу гэнэт дайрсан юм. Тэр үед эцэг минь хаан байв. Хаан эцэг минь бага цэргээ хөдөлгөн өөдөөс нь очив. Уулыг тал болтол усыг цус болтол тулалдаад олон цэрэгтэй Гал бамбай Дөл жад хаан дийлсэн билээ. Манай олон цэрэг амь үрэгдсэн билээ. Гал бамбай Дөл жад хаан эцгийг минь олзлон авч алсан юм.

Ингээд би өсөж баатар эр болоод Гал бамбай Дөл жад хаанаас эцгийнхээ өшөөг авахаар шийдсэн билээ. Үүнийг минь манай хотын шидэт эм мэдээд надад хэлсэн нь «Гал бамбай Дөл жад хаан маш их чадалтай бөгөөд ид шидийн хүчтэй. Нэгэн газар далдлан булсан сэлмийг олж авч чадвал л түүнийг дийлж болно. Тэнгис далайн тэртээх Буянт арлын дээр өндөр уулын хярд хөгшин царсны доор нэгэн агуй бий. Тэр агуйд эрт цагт далдлан нуусан шидэт сэлэм бий. Зөвхөн тэр сэлмээр Гал бамбай Дөл жадыг дийлнэ» гэсэн билээ.

Би их хүчийг гаргаж олон газрыг туулсаар шидэт сэлмийг олж аваад Гал бамбай Дөл жадны улс руу явлаа. Гал бамбай Дөл жад миний өөдөөс их цэргээ илгээв. Би тэр цэргийг цохин устгавал дахин урьдынхаас их цэргийг авч өөрөө миний өөдөөс ирлээ. Энэ талд халз тулалдан тэдний цэргийг цавчин хаяж, заримыг нь морь минь өвс мэт гишгэж цөөхөн үлдээд байтал Гал бамбай Дөл жад давхин ирж «Одоо чамайг ална!» гэж хашгирав. Би түүнийг шидэт сэлмээрээ цохин мориноос нь унагав. Гэтэл түүний зарц нар «Росланей баатар сэлэмнийхээ ид шидийг мөн ч гайхамшигтай үзүүллээ. Дахиад, дахиад нэг цохиод өгөөч!» гэж орилолдов. Би ч дахин нэг далайн цохьтол түүнд хүрсэн миний сэлэм хүчтэй ойж миний толгойг тас цавчив. Харин Гал бамбай Дөл жад юу ч болоогүй юм шиг дахин амь оров. Яг энэ үед миний хуурай дүү шидэт сэлмийг шүүрэн авч миний толгой дор тавьжээ. Дараа нь Гал бамбай Дөл жад баатруудынхаа хамт олон удаа ирж энэ сэлмийг авах гэж оролдсон боловч чадаагүй юм. Одоо ч миний толгой дор байна гэж Росланей баатрын толгой яриад,

- Ямар хэргээр явна? Аль газрыг зорино вэ? гэж асуув.

Еруслан Лазаревич Гал бамбай Дөл жад хаант улс руу ямар хэргээр явж байгаагаа ярив.

- Аав ээж, ах дүүгээ гай зовлонгоос авраад мөнхийн усанд явж байгаа чинь магталтай байна. Гэхдээ тийшээ дэмий явж байна даа. Энэ Гал бамбай Дөл жад ямар хорт муу амьтан гэдгийг чи мэдэхгүй байна. Сайнаар гуйлаа гээд өвлийн цагт өөдсөн чинээ мөс ч өгөхгүй тийм амьтан. Мөнхийн ус чамд өгнө гэж үү? Жад, сум, сэлэм алинд нь ч өртдөггүй болохоор хүчээр чи дийлэхгүй. Чамайг нэг далайх хооронд арав алж амжина. Иймд түүнийг яаж дийлэхийг би чамд зааж өгье. Чи сайн тогтоож ав. Хэлснийг минь биелүүлбэл хэрэг чинь бүтэж, хорт Гал бамбай Дөл жадыг дийлнэ гэж Росланей баатрын толгой хэлэв.

Еруслан Лазаревич Росланей баатрын толгойн хэлсэн бүгдийг сайн тогтоож аваад талархан цааш явахдаа:

- Мөнхийн ус олоод чам дээр ирж чамайг биетэй чинь залгаж өгнө... гэв. Ингэж хэлээд Зөнч Хурдан мориндоо мордон

Гал бамбай Дөл жадны хаант улс руу довголгов. Гал бамбай Дөл жад ирж яваа баатрыг алсаас хараад гал сумаар харваж:

- Одоохон буц, түлж ална шүү! гэж хашгирчээ. Еруслан Лазаревич дуулгаа авч:

- Сайн санааг өвөрлөн ирлээ! гэв.

- Хаанахын хэн гэгч вэ? Ямар хэргээр явна вэ? Алив хэл!

- Би алдарт Картаусын хаант улсын Еруслан Лазаревич гэгч байна. Чиний их хүч чадал, нэр алдар орчлонг бүрхэн цуурайтна. Би чиний шадар болохоор ирлээ!

- Арван хоёр баатартай минь хамжаад Росланейн толгой дорх сэлмийг авч өгвөл л чамайг шадар болгон авна. Хэрэв чадахгүй бол амьд үлдэхгүй гэж мэдээрэй!

- Би ганцаар тэр сэлмийг авчирна! Чиний арван хоёр баатар хэрэггүй! гэвэл Гал бамбай

Дөл жад ойртон ирээд:

- Хурдан яваад сэлэм авчир! Тэгвэл чамайг арван хоёр баатрын даамал болгоно! гэв. Еруслан Лазаревич мориныхоо амыг эргүүлэв. Росланейн толгой түүнийг алсаас хараад:

- За яав, Гал бамбай Дөл жадыг харав уу?

- Бүгдийг чиний зааснаар хийлээ. Шидэт сэлэм авахаар ирлээ. Росланейн толгой хажуу тийш өнхөрч:

- За ав, харин ганцхан удаа цохино шүү! Бүү мартаарай! гэв. Еруслан Лазаревич сэлмийг аваад Зөнч Хурдандаа мордон эргэв. Гал бамбай Дөл жад барааг нь хармагцаа угтан ирж:

- Шидэт сэлэм авчрав уу?

- Энэ байна гэж Еруслан Лазаревич хэлээд давхин очиж Гал бамбай Дөл жадыг хар хүчээрээ цавчив.

Гал бамбай Дөл жад хадсан өвс шиг ханаран унав.

- Дахиад цохь, дахиад! гэж Гал бамбай Дөл жадны зарц нар орилолдоход,

- Сайн эр сэлмээ хоёр дахин далайдаггүй юм. Нэг удаа л болоо! гэж Еруслан Лазаревич хариулав.

Тэгэхэд Гал бамбай Дөл жадны зарц нар «Дайраад! Хэдэн хэсэг болгож хаяад шидэт сэлмийг авч

Гал бамбай Дөл жад хаанаа аварья!» гэж хашгиралдан давшив.

Гэвч эрэлхэг хүчит Еруслан Лазаревич тэднийг хиар цохин устгав. Дараа нь худгийг олж мөнхийн ус савлаж аваад өөрөө ууж Зөнч Хурдан мориндоо уулгав. Ингэхэд тэдний алжаал ядаргаа нь даруйхнаа арилав.

Росланейн толгой түүнийг алсаас хараад:

- Амь мэнд эргэж ирэхийг чинь харваас миний дайсан Гал бамбай Дөл жадыг ялан дийлжээ чи! Мөнхийн ус олов уу?

- Олоод авчирлаа. Одоохон чи эдгэнэ гэж Еруслан Лазаревич хариулав.

Толгой бие рүүгээ өнхрөн очиход Еруслан Лазаревич мөнхийн усаар шүршив. Толгой биедээ залгагдан ургаж эдгэв. Росланей баатар өндийн босов. Маш том, харахад сүрдмээр ажээ.

- Еруслан Лазаревич, чи надад их ач тусыг хүргэлээ. Энэ насандаа мартаггүй! Хэрэв хэрэгтэй

бол амь насаа ч чиний төлөө хайрлахгүй! гэж Росланей баатар хэлэхэд,

- Энэ тухай ингэж ярьж яахин болно вэ? Чиний шидэт сэлэм, мэргэн заавар үгүйгээр би Гал бамбай Дөл жадыг дийлэхгүй байх байсан шүү дээ. Мөнхийн усыг ч олж авч чадахгүй байсан. За май, шидэт сэлмээ ав! гээд Еруслан Лазаревич сэлмийг нь өгөв.

Харин Росланей баатар гараараа түлхэн:

- Хуурай дүү Еруслан минь, энэ сэлэм чамд дахин хэрэг болно гэв.

- Гарт минь яг таарсан сэлэм байна. Хайрт ах Росланей чамд гялайлаа. Одоо би эцэг эх рүүгээ яаралгүй болохгүй.

- Би морио олох хэрэгтэй. Эндээс холгүйхэн байгаа бизээ. Үнэнч тэр морь минь л намайг даана.

Ингээд хоёр баатар салжээ. Росланей морио олохоор, Еруслан Лазаревич Цагаан Данилагийн улс руу явав.

Еруслан Лазаревич Цагаан Данилагийн ордонд гүйн орж ээж, аав, хаан Картаус, шадар ноёдын нүдийг мөнхийн усаар шүршвээс хараа оров. Тэд баярлалдан нулимс унагацгаав.

Хаан Картаус Еруслан Лазаревич ийг хүндэтгэн их найр хийв.

Тэр өргөн найран дээр цөм амттаныг идэж ууцгаан баатар эр Еруслан Лазаревичийг алдаршуулан магтацгаав.

Өргөн найр өндөрлөхөд баатар эр эцэг эхдээ хандан:

- Вахрамейн хаант улсад явмаар байна. Аян замыг минь мялааж адис ерөөлөө өгнө үү! гэв.

- Дахин хагацахад харуусам боловч одоо яая гэх вэ дээ! Ээж бид хоёр чинь эрүүл саруул байхад явах газраа явж үзэх юмаа үз! гэж Лазарь Лазаревич өгүүлэв.

Ингээд аян замд бэлдэн хуяг дуулгаа өмсөн Вахрамейн хаант улс руу гарав. Нийслэл хотод хүрч очтол хаалга нь цоожтой байсанд тогшвоос харуул нар:

- Хэн бэ? Хэрэг зориг юунд вэ? гэв.

- Би Еруслан Лазаревич, сайн хэргээр хаан Вахрамейд ирлээ.

Хаалгыг онгойлгож баатрыг оруулаад дахин хааж түгжив. «Яагаад хаалга үүдээ түгжинэ вэ?» гэж Еруслан бодов.

Хаан Вахрамей баатар эрийг элэгсэг угтав.

- Тавтай морилно уу! Хэний хүү хэн гэгч вэ?

- Би Картаусын хаант улсын тайж Лазарь Лазаревичийн хүү Еруслан Лазаревич байна. Олон газраар явж олон нутгийг үзсэн боловч танай улсад зочлохоор ирлээ.

- Аан ийм эр байсан юм уу! Чиний баатар гавьяаны тухай хотол дэлхийн хот улс бүхэн шагшин бахархаж байна. Бид ч гэсэн сонссон. Хүндэтгэл ихт зочин ирсэнд баяртай байвч улс орныг минь гай зовлон дайраад байгааг нууж чадахгүй нь. Далайн гурван толгойтой могой нисэн ирж хүн идээд байх боллоо. Ингээд үүд хаалга түгжин сууна. Гэсэн ч нисдэг махчинд хотын хана юу ч биш л дээ! гэж Вахрамей өгүүлэв.

- Далайн могой олон удаа нисэн ирж байна уу? гэж Еруслан Лазаревич асуухад,

- Гурав хоногт нэг удаа. Өнөөдөр яг ирдэг өдөр нь, дахин хэн нэгийг минь үмхэж аваад арилна даа гээд хаан Вахрамей,- Хүндэтгэл ихт зочин минь, ордонд минь орооч! Аян замынхаа алжаалыг тайлж амарч тухал! гэж урив.

- Баярлалаа, гэвч би эхлээд далайн зах дээр очоод ирье. Дараа нь амаръя гэж Еруслан Лазаревич хэлээд Зөнч Хурданаа унан далай руу давхив. Далайн хөвөөнд дайчин дунгаа гурав дахин үлээтэл далай ихээр давлагаалан шуугиснаа уснаас гурван толгойтой могой цухуйв. Гурван том ам нь ангайж, шүд нь ярзайн, хорт зургаан нүд нь хомхойрон гялалзаж байв.

Могой эрэг рүү хараад:

- Энэ удаа хаан Вахрамей намайг хүлээлгэсэнгүй, нэг хүн бас нэмээд морьтой нь өөрөө явуулжээ!

- Хар муу махчин чи баярлах чинь болоогүй байна. Харин хахаж үхэх биш үү! гэж баатар эр хашгирав.

Тэгээд могой далайн эрэг дээр гарч ирмэгц Еруслан шидэт сэлмээрээ нэг удаа цавчин хоёр' толгойг нь унагав.

Могой айн чичирч:

- Эрэлхэг баатар эр минь, утсан чинээ улаан голыг минь бүү тасал, үлдсэн ганц толгойг минь бүү цавчаач! Вахрамейн хаант улс руу дахин хэзээ ч нисэж очихгүй, чамд их баялаг өгнө. Энэ дэлхийд өөр хаанаас ч олохгүй, маш сайхан эрдэнийн чулуу надад бий гэж гуйв.

- Чиний эрдэнийн чулуу чинь хаа байна?

- Одоохон аваад ирье!

Ингэж хэлээд могой далай руу үсрэн ороод тэр доржноо хаана ч, хэзээ ч үзээгүй сайхан эрдэнийн чулуу авчирч өгөв.

Еруслан Лазаревич эрдэнийн чулууг аваад мориноосоо үсрэн могой дээр мордоод:

- Вахрамейн хаант улс руу намайг аваачиж өг! Тэгээд дахин хүмүүст халдахгүй гэдгээ өөрөө

хэл! гэв.

Далайн могой үгийг нь дагахаас өөр аргагүй болжээ.

Баатар эр могойг унан нисэхэд Зөнч Хурдан араас нь даган давхив.

Харийн баатар далайн могойг унан нисэж ирэхэд Вахрамейн хаант улсын ард олон их бага цөмөөр үймэн шуугилдаж сандарцгаав.

- Еруслан Лазаревич минь, энэ муу махчнаа алаад өгөөч. Хичнээн ч хүн үрэгдэж, хичнээн ч нулимс асгарав даа. Одоо чиний дэргэд номхон боловч чамайг явмагц урьдын адил биднийг айлган идэх болно. Бид энэ хорт могойг сайн мэднэ! гэж хотын ард олон төдийгүй хаан Вахрамей гуйв.

Эрэлхэг баатар Еруслан эсрэгцэх үг хэлэлгүй шууд могойгоос үсрэн бууж үлдсэн ганц точгойг нь тас цавчив

Хотынхон үхсэн хорт могойг арван хоёр тэргээр чирэн хотын зах рүү аваачиж гүнзгий жалганд булжээ.

Гай зовлонгоо илчлэн өлгөсөн хар тугаа авч ард олон баяр хөөр болов.

Вахрамей хаан хотол даяар их найр хийв. Хошуу бүрээс зочид уоив. Еруслан Лазаревичийг хамгинн хүндэт суудагдаа суулган амгтаны дээжээрээ зочлон дайлав.

Хүндэт зочин минь, зооглогтун! Ач тусыг чинь яаж хариулахаа мэдэхгүй сууна гэж хаан Вахрамей хэлнэ.

Энэ үед гүнж гарч ирж зочидтой мэндлэв. Баатар эр үзэсгэлэнт Марфа Вахрамеевнаг хармагцаа хөдөлж чадахгүй хөшив. «Ийм сайхан бүсгүйг урьд өмнө нь үзээгүй юм бгйна. Насыг дуустал харсан ч ханашгүй аж» гэж бодов.

Марфа Вахрамеевнагийн зүрх ч хүчтэй цохилон Зочин олонтой эрхэмсгээр мэхийн мэндлэхдээ ямар сайхан эр вэ? гэж Еруслан Лазаревичийг дахин нэг харав.

Өргөн найр ч өндөрлөж ирсэн олон зочин талархан баярлаад тарцгаав. Тэгэхэд нь Еруслан Лазаревич:

- Хаантан минь, сайн санааг өвөрлөн сайхан охиныг чинь гуйхаар танай улсыг зорин ирсэн бнлээ. Эцэг хаантан та адис ерөөлөө өгч Марфа Вахрамеевна надтай суувал миний хамгийн дээд хувь болно! гэвэл,

- Хүндэт Еруслан Лазаревич, хэрэв охин өөрөө зөвшөөрвөл би чамтай худ ураг болох дуртай байна. Охин минь, чи л хариул цаа гэж Марфа Вахрамеевна руу хандан,

- Нөхөр болох хүн сэтгэлд чинь нийцэв үү? гэж асуув. Үзэсгэлэнт бүсгүй хацраа улайлган харцаа буулган:

Хаан эцэг минь, таны үг надад хууль! Хэрвээ та адис ерөөлөө өгвөл би хуримын ширээнээ суухдаа дуртайяа байна гэж аяархан хэлэв.

- Тун сайн байна! Хэн хэний сэтгэлд тохирсон хүргэнтэй болов! гэж хаан Вахрамей баярлан өгүүлэв.

Хааны ордонд дутуу юм байх биш, сархад сав саваараа, шар айраг сөн сөнгөөрөө гэнэ. Ингээд удалгүй өргөн их хурим найр хиив

Еруслан Лазаревич залуу сайхан эхнэр Марфа Вахрамеевнатай хамт хадам эцэг хаан Вахрамейн ордонд жаргалтай сайхан амьдарсаар өдөр хоногиг үл тоолон нэг жилийг өнгөрөөжээ.

Нэг удаа Еруслан Лазаревич Марфа Вахрамеевнад:

- Эцэг эхээ эргэж очихсон, эхнэр чамайгаа тэдэнтэйгээ танилцуулахсан гэв.

- Чамтайгаа явж эцэг эхийг чинь эргэх би хичнээн их дуртай, баяртай байна эхдээ одоо би алсын замд явж чадахгүйг чи өөрөө харж буй бизээ. Тийшээ явах зам хол басхүү амаргүй билээ. Иймд чи энэ удаа ганцаар явж уулзаад хурдан эргээд ирээрэй. Харин дараа жил цөмөөрөө явна. Гэхдээ Хүүхэн хаант улсын хажуугаар өнгөрөхдөө урьж залсан ч битгий очоорой. Очих л юм бол чамайг Хүүхэн хаан илбэдээд авна.

- Чи юу ярина вэ? Хүүхэн хаант улс руу очих хэрэг надад байхгүй!

Ингэж Еруслан Лазаревич хэлээд далайн могойгоос авсан эрдэнийн чулууг шигтгэн хийсэн алтан бөгжөө хуруунаасаа авч эхнэртээ өгөн:

- Хүү төрөөд том болоход үүнийг өгөөрэй. Өдөр ч, шөнө ч энэ бөгжийг хуруунаасаа салгахгүй зүүж яваг гэж хэлэв.

Ингээд Еруслан Лазаревич аян замдаа гаран явсаар гурав дахь өдрөө зах нь үл харагдах их цэцэрлэгийг үзэв. Тэр цэцэрлэгт алтан дээвэр нь наранд гялалзсан гоёмсог ордон байх аж. Ордны цонх болор, цонхны хүрээ модыг урнаар хээлэн сийлэн хийжээ.

Цэцэрлэгийн хажуугаар явгал гэнэт нэгэн морьтой хүн хаалгаар давхин гарч ирэх нь цэх шулуун биетэй цэвэр цагаан царайтай хүүхэн ажээ. Өтгөн хар хөмсөгтэй өнгөлөг цагаан царайтай тэр хүүхний урт үс дуулган дороос нь урсах ус мэт долгино.

- Сайн эр, чамайг би цонхоор харлаа. Унасан морио ундаалж алжаасан биеэ амраахгүй юунд яаран явна вэ? гэж дуулах мэт өгүүлэв.

- Хүүхэн хаан минь, баярлалаа, гэхдээ одоо би амжихгүй. Эцэг эхээ эргэхээр яарч явна гэж

Еруслан Лазаревич хариулавч Хүүхэн хааныг нүд салгалгүй ширтэнэ.

- Завгүй гэж юу гэсэн үг вэ! Урт замд явахдаа унасан морио хайрла гэдэг шүү гээд Хүүхэн

хаан зуны нар төөнөх мэт инээмсэглэв.

Баатар эр эхнэрийнхээ захисныг умартан Хүүхэн хаантай цуг дөрөө харшуулан гайхамшигт цэцэрлэг рүү оров.

Хүүхэн хаант улсад үзэсгэлэнт хүүхнүүд нэг нь нөгөөгөөсөө сайхан агаад Хүүхэн хаан өөрөө бүгдээс илүү үзэсгэлэн гоо ажээ.

Хүүхэн хаан Еруслан Лазаревичийг далайн чанадах архи дарс, амттан бүхнээр хүндэтгэн зочлов. Дайлж зочлоод дараа нь пийпаа хөгжим цохиж уянгат яруу хоолойгоор дуулав.

Сайн эр Хүүхэн хааныг харж ханахгүй сонсож барахгүй бүхнийг умартан сууна. Дараа нь ордны олон хүүхэн цуглан ирж дуу дуулж наадан цэнгэв.

Ийнхүү наадан цэнгэж бүжиглэсээр нэг жил, хоёр жил өнгөрчээ. Еруслан Лазаревич «Нэлээн удчихлаа. Цаг хиртэй болно гээд хоёр өдөр өнжчихлөө» гэж бодно.

Хүүхэн хаанд талархан:

- Одоо явах цаг минь боллоо! гэвээс Хүүхэн хаан аргадан энхрийлж:

- Наран болсон Еруслан Лазаревич минь, намайгаа битгий орхиоч, надтайгаа цуг үлдээч!

- Үгүй ээ, чадахгүй нь. Эцэг эхтэйгээ уулзах хэрэгтэй!

- Эцэг эхтэйгээ уулзаж амжинаа! Ядахдаа долоо хоног байж сэтгэлийг минь тайтгаруулаач! гэж Хүүхэн хаан гуйв.

Энхрий үг эелдэгхэн аалинд сайн эр өөрийн эрхгүй татагдан хөл нь хөшиж гар нь гацах мэт болов. Ингээд Хүүхэн хааныд үлдэж долоо хонолоо гэсэн чинь долоон жил өнгөрөөд найм дахь жил гараад байв.

Еруслан Лазаревич явсны дараа Марфа Вахрамеевна хүү төрүүлжээ. Хүүд Еруслан Ерусланович нэр өгөв.

Еруслан Ерусланович хүч чадал ихтэй том биетэй төржээ. Төрсөн цагаас эхлэн өдрөөр биш цагаар өсөж хоёр настайдаа арван хоёртой юм шиг болж, долоотойдоо хүчирхэг баатар болов гэнэ.

Мэргэн ухаан хүч чадлаараа улс орондоо хэнтэй ч эгнэшгүй болов гэнэ. Баатар бүрийг дийлдэг гэнэ. Нэгэн удаа Еруслан Ерусланович эхдээ хандан:

- Ээж минь, миний эцэг Еруслан Лазаревич хаачсан юм бэ? Картаусын хаант улс руу эмээ өвөө хоёрыг эргэхээр явсан гэх атал одоо болтол эргэж ирээгүй байдаг. Аян замдаа аюул осолд өртөөгүй байгаа даа? Эцгийнхээ эрэлд явмаар байна, ээж минь, та элбэрэл ерөөлөө өгөөч! гэж хэлэв.



Марфа Вахрамеевна уйлан:

- Улсаасаа өөр газар үзээгүй уулнаасаа өндөр даваа даваагүй нас бага цус шингэн хүү минь, чи хаашаага ч явах юм билээ дээ! Эцэг чинь Хүүхэн хаант улсад саатсанаас зайлахгүй. Илбэдэн татаж эрхэндээ оруулсан Хүүхэн хаант улсынхаас гарах зам байхгүй. Чи тэнд амь насаа алдана! гэжээ.

Еруслан Ерусланович эхийнхээ үгэнд орсонгүй, өөрийнхөөрөө зүтгэв.

- Заавал явж Еруслан Лазаревич эцгээ эрж олоод эргүүлж авчирна! гэнэ. Марфа Вахрамеевна хүүгээ ятгаж чадахгүйгээ мэдээд:

- За яах вэ? Өөрөө мэд, яв даа. Энэ шигтгээт бөгжийг өдөр шөнийн алинд ч хуруунаасаа битгий салгаарай гэв.

Еруслан Ерусланович эрдэнийн чулуун шигтгээтэй алтан бөгжийг хуруундаа хийв. Хаан Вахрамей ч зээ хүүгээ аргадан ятгасан боловч үгэнд орохгүйд сүүлд нь:

- Яв даа! гэжээ.

Еруслан Ерусланович ингээд аян замын хувцсаа өмсөн, салах ёс хийв. Хаан Вахрамей, Марфа Вахрамеевна болон асрагч аягагч хүүхнүүд цөмөөр Еруслан Еруслановичийг үдэн гаргав. Залуу баатар мориндоо мордон давхин одоход улаан тоос ард нь босон үлдэв.

Залуу баатар Еруслан Ерусланович яван явсаар гурав дахь өдрийнхөө өглөө асар их гайхамшигт цэцэрлэгийг үзэв. Тэр цэцэрлэгт алтан дээвэртэй болор цонхтой ордон байх аж. «Хүүхэн хаант улс энэ бизээ» гэж Еруслан Ерусланович бодоод хаалганых нь ойр очин чанга дуугаар:

- Халз тулалдах эр байна уу, гараад ир! Хаалга үүдийг чинь эвдэлнэ шүү! гэж хашгирав. Хүүхэн хаан сонсоод:

- Хаалга нүдэн халз тулалдахыг хүсэгч хэн бэ?

- Харийн нэгэн залуу баатар байна гэж үүдний харуулын баатар хэлэхэд,

- Бүдүүлэг зангий нь хариуд хашраагаад өг! гэж Хүүхэн хаан тушаав. Харуулын баатар хаалгаар гарч ирэн:

- Хаалга үүд нүдэж халз тулалдах баатар шаарддаг бүдүүлэг залуу чи юун хүн бэ?

- Хүчээ үзэлцсэний дараа хэр бүдүүлгийг минь мэдэж аваарай! гэж залуу хариу хашгирав. Ингээд Еруслан Ерусланович эхнийхээ цохилтоор харуулын баатрыг эмээл дээрээс нь унагаад:

- Амийг чинь хороохгүй! Хүүхэн хаандаа очин халз тулалдах баатар явуул гэж хэл. Чам шиг эртэй үзэлцэх нь надад тохирохгүй! гэв.

Цохиулсан баатар Хүүхэн хаанд хүчирхэг залуу баатрын тухай ярив. Хүүхэн хаан Еруслан Лазаревичийг сэрээн:

- Сэтгэлийн гэрэл минь, босооч, сэрээч! Харийн залуу баатар ирээд халз тулалдах хүн шаардаж байна. Чамайг сэрээх харамсалтай ч өөр арга алга. Зөвхөн чамд л найдаж байна!

Еруслан Лазаревич босож хуяг дуулгаа өмсөөд Зөнч Хурданаа эмээллээд цэнхэртэх хөндий цэлгэр талд гарав. Ингээд хоёр баатар арван бээрийн газраас ухарч ухарч дайралцахад аянгат үүлс мөргөлдөх мэт, асгат уулс харшилдах шиг болжээ.

«Тун залуу авч арга хүчээр хэнээс ч дутахгүй баатар байна» гэж Еруслан Лазаревич бодов.

Хоёр дахь удаагаа сэлмээ далайн мөргөлдөхдөө Еруслан Лазаревич хүчтэй цохиход залуу баатар эмээл дээрээ тогтож үл чадан газар өнхрөн унав. Зөнч Хурдан ч унасан баатрын цээжин дээр нь гишгэв. Залуу баатрын гарт нэг юм гялсхийхийг Еруслан Лазаревич харав. Дахин лавлан ажиглаад шигтгээт бөгжөө танимагцаа «Хүү минь байна?» гэдэг бодол харван оров.

- Аль нутгийн хэний хүү хэн гэгч вэ? гэвэл залуу баатар:

- Хэрэв миний морь чиний цээжин дээр гишгэсэн бол чамаас би овог төрөл, эцэг эхийн чинь тухай асуух ч үгүй толгойгий чинь тас цавчих байсан даа!

- Залуу амьдралыг чинь таслахыг би үл хүснэ. Гагцхүү хэний хүү хэн гэдгээ хэлээч?

- Ээж минь Марфа Вахрамеевна, эцэг минь эрэлхэг хүчит баатар Еруслан Лазаревич. Намайг Еруслан Ерусланович гэдэг.

Еруслан Лазаревич мориноосоо үсрэн бууж залуу баатрыг чанга тэврэн:

- Хайрт хүү минь, ингэж уулзах гэж! Одоо чи хэдтэй вэ? гэв.

- Долоо өнгөрөөд найм хүрэх гэж явна. Таны эрэлд гарсан минь энэ. Ингэж уулздаг байжээ.

«Яахаараа энэ билээ? Би Хүүхэн хаант улсад долоо хоног илүүхэн зочилсон бус уу? Гэтэл хүү минь найм хүрэх гэж байдаг?» гэж Еруслан Лазаревич бодов.

- Хайрт хүү минь, харья! Вахрамейн хаант улс руугаа түргэн явья гэж хэлээд мордон явцгаав.

Хаан Вахрамей, Марфа Вахрамеевна, ордны олон хоёр баатрыг угтан авч баяр хөөр болцгоов. Хаан Вахрамей хотол их найр хийв. Найрын дараа Вахрамей:

- Хүндэтгэл ихт хүргэн Еруслан Лазаревич минь, сонсож бай. Насанд дарагдаж өтөл боллоо би. Хаан ширээг чи залгамжилж ав. Өтөл би насныхаа эцэст бие амарья! гэжээ.

- Шидэт сэлэм хурц жадыг эзэмшин Зөнч Хурданыг унан олон хотыг үзэж түмэн газрыг туулж туйллаа. Одоо хаан ширээг дуртайяа залгамжилж авья. Харин эцэг эхийнхээ сургийг ч

дуулаагүй суудаг сэтгэлийн нэгэн зовиур байна. Хаант төрийн их ажилд дарагдаж, тэдэнтэйгээ дахин уулзахгүй болов уу?

- Үүнд зовох хэрэггүй. Залгамжлан авах хүү чинь байна. Еруслан Ерусланович Картаусын хаант улс руу явж бидний мэндийг хүргээд тэднийг авч ирэг! гэж хаан Вахрамей хэлэв.

Ингээд Еруслан Лазаревич хаан ширээнээ сууж, Еруслан Ерусланович Картаусын хаант улс руу явжээ.

Удсан ч үгүй Еруслан Ерусланович эмээ өвөө хоёроо Картаусын хаант улсаас авч ирэв. Еруслан Лазаревич эцэг эхтэйгээ уулзаж учирсандаа баярлан хотол их найр хийв. Тэр найран дээр би байж хундага тавилгүй дарс ууж суухдаа сонссон түүх энэ билээ, сонирхуулж ярьсан минь ингээд төгслөө.

# НИСДЭГ ХӨЛӨГ

Эмгэн өвгөн хоёр байжээ. Гурван хүүтэй юмсанжээ. Ахмад хоёр хүү нь залхуу, хувцасны сайныг өмсөж, амттаны дээдийг идэж, их унтаж ажилгүй хэвтэж байх дуртай гэнэ. Бага хүү Иван номхон даруу зантай, ажилсаг шаламгай гэнэ. Иван бүхнээс түүрүүнд босож бүгдээс сүүлд унтдаг. Эцэгтэйгээ тариалан дээр ажиллаж, ээждээ тус болж тоглоом наадам хөөцөлдөхгүй, олдсоныг идэж, өгснийг ууж, ах нарынхаа хуучин хувцсыг өмсдөг байжээ. Иван пийшин дээр унтана.

Ах нар нь түүнийг тэнэг гэж шоолон, Пийшин

Иван гэж хочилжээ. Ах нарыг нь айл хөршийнхөө аав ээж нь ч хүртэл дуурайж Иваныг шоолон инээлдэнэ.

Үүнд нь Иван огтхон ч гомдсонгүй үүрийн гэгээнээс үдшийн бүрий болтол ажиллан бусад цагт пийшин дээрээ хэвтэж амардаг байв.

Энэ үед хаан охиноо гэрлүүлэхээр шийдэж хот хошуу бүрд элч илгээжээ.

- Нисдэг хөлөг хийгээд тэр хөлгөөрөө хааны ордонд нисэн ирэх уран гартан байна уу? Тэр хааны хүргэн болно. Зургаан долоо хоногийн дараа хааны ордонд хүргэнг шалгаруулна гэж элч нар зарлан давхина.

- Нисдэг хөлөг хийж чадсан ч чадаагүй ч хааны ордонд орж найрлаж үзье. Өргөн олныг харъя, өөрийн биеийг танилцуулья гээд хоёр ах нь энэ зарыг сонсонгуутаа замд төхөөрч эхэлжээ.

Эмгэн өвгөн хоёр ахмад хөвгүүдээ ухаантай гэж бодож үнэн голоосоо хайрлан, хэлсэн хүссэн бүгдийг нь дураар нь болгодог байжээ. Энэ удаа ч гэсэн эмгэн өвгөн ер хориглож саатуулсангүй аян замд төхөөрөв. Эх нь хоёр хүүдээ замын хүнс зэхэж, амтат ундаа савлав. Эцэг нь урлах дархлахад хэрэгтэй бүгдийг олж өгчээ. Ингээд хоёр ах нь эцэг эхдээ үнсүүлээд аян замд гарчээ.

Арван мод газар яваад ах нь:

- Эндээс өөр сайн модтой газар олдохгүй байх энд мод унагаж нисдэг хөлөг хийе гэвэл дүү нь:

- Эхлээд ууж идэж аваад дараа нь ажлаа эхэлье гэв.

Ах дүү хоёр үүргэвчээ мултлан дөнгөж суумагц тэдний өмнө эрүү өвдөг нь тулсан хөгшин өвгөн гарч ирэв гэнэ.

- Сайн санаат ах дүү нар минь, идэх уух юмнаасаа илүүчлээч. Би та нарт тус болж магадгүй гэв.

Ах дүү хоёр инээлдэн нэгэн зэрэг:

- Ирсэн замаараа буц! Бялуугаа бид хоёр дөнгөөд идчихнэ гэж хариулжээ.

Өвгөн тэр хоромд огт байгаагүй мэт алга болов. Ах дүү хоёр ч амтат ундаа ууж, бялуугаа идээд амрахаар хэвтэцгээв.

Унтаж унтаж босоод мод унагаж нисдэг хөлөг хийж эхэлжээ.

Хичээгээд хичээгээд, оролдоод оролдоод, олон мод сүйтгэснээс ондоо юу ч бүтсэнгүй.

- Энд ингэж зууралдаж байх гэж төвөг. Цаг маш бага үлдлээ. Хааны найрнаас хоцрох нь гэж ах нь хэлэхэд дүү нь:

Дэмий хүчээ барлаа. Нисдэг хөлөг гэж ер дуулдаж сонсдоогүй зүйл! Амжих байх явган явья гэж гэнэ.

Ингэж ярилцаад ахмад хоёр хүү үүргэвчээ үүрээд нийслэл хотыг чиглэн алхжээ. Энэ үед хамгийн бага хүү Пийшин Иван эцэг эх хоёроосоо:

- Ээж аав минь, намайг хааны найранд явуулаач! гэж гуйв. Эцэг эх хоёр нь:

- Иван, чи пийшин дээрээ л хэвтэж бай! Өлгөх хувцасгүй өмсөх гуталгүй чи хааны найранд яаж явах вэ? Үнс шороо болсон өөрийгөө хар! гэж аргадав.

Иван:

- Явуулсан ч явна, явуулаагүй ч явна гэж зөрөв. Эцэг эх хоёр нь уурлаж:

- За за, яв, баячуудын инээд доог бол! Гүнж ийм сайхан эрийг хараад ухаан алдах байлгүй! гэж загнажээ.

Эх нь хатсан талхны зах үүргэвчинд нь хийгээд үйсэн саванд булгийн ус дүүргэж өглөө гэнэ. Иван пийшин дээрээсээ бууж өмсөж байсан хуучин өмд цамцтайгаа тэр чигээрээ яваад өгчээ. Айлынхан нь шоолон инээлдэж:

- Хараач, хөөе хараач! Пийшин Иван хааны охинтой суухаар явлаа! гэлцэв.

Харин залуу эр Иван яван явсаар хоёр ахынхаа хөлөг хийж байсан газар хүрчээ. Хожуул дээр сууж амрав, Гэтэл хаанаас ч юм бэ, эрүү өвдөг нь тулсан хөгшин өвгөн гарч ирээд:

- Сайн санаатан минь, надад идэх юмнаасаа илүүчлээч, би чамд тус болж магадгүй гэв.

- Өвөө минь, би танд өгмөөр л байна. Харин та идэх болов уу даа. Надад жаахан хатсан талх ус хоёр л байна гэж Иван хэлээд үүргэвчээ мөрнөөсөө буулгав.

- Найрсаг үгэнд чинь баярлалаа! Юу байгаагаа гарга даа гэж өвгөн хэлэв.

Иван үүргэвчнийхээ амыг онгойлгоод нүдэндээ итгэсэнгүй гайхахын ихээр гайхав. Хатсан захны оронд дугуй зөөлөн талх, үйсэн саванд нь үнэр нь анхилсан зөгийн шинэ бал дүүрэн байх юм гэнэ. Талхаа нэг, балаа нэг, өвгөнийг нэг харан гайхлаа.

Өвгөн инээж:

- За залуу эр минь, зочноо дайл, өөрийгөө ч бүү гомдоо гэв. Талхаа идэж балаа ууцгаав.

Өвгөн:

- Хаашаа явж байгааг чинь би мэдэж байна. Ажлаас шантрахгүй, унтах идэхийг урдаа барихгүй бол нисдэг хөлөг яаж хийхийг би чамд зааж өгье гэв.

Өвгөн Иванд нэг богц өгөөд:

- Энд хэрэгтэй юм бүхэн байгаа. За явъя, цаг тун бага байна. Ингээд цааш явж өвгөн гурван мод сонгож аваад:

- Энэ гурвыг унага! Хэлж зааж л чадна би, хийхийг нь харин чи ганцаараа хийх болно шүү.

Эр чадал минь харьж энэ бие минь суларчээ гэлээ.

Иван гурван өдөр гурван шөнө гар хумхилгүй, нүд анилгүй ажиллав. Гурав дахь өдрийн орой өвгөн:

- За одоо амар, би нарийн ширийн ажлыг нь хийе гэжээ. Иван унтаж байтал өвгөн сэрээж:

- Эрхэм нөхөр сайн эр минь, бос. Явах цаг чинь боллоо гэж хэлэв.

Иван нүдээ нээвэл өмнө нь нисдэг хөлөг бэлэн болчихсон дайвалзаж байлаа. Торгон далбаатай, мөнгөн шурагтай хөлөг гэнэ.

Өвгөн Иваныг үдэхдээ:

- Замдаа дайралдсан хүн бүхнийг хамт явъя гэж дуудаарай гэж захижээ.

Ингэж сайн эр Иван үүлтэй тэнгэрийн доогуур, үзүүртэй модны дээгүүр хааны найрыг зорин нислээ.

Иван уулсын дээгүүр үүлсийн доогуур нисэж яваад тэртээ доор нэг өвгөн явж байхыг харав. Өвгөн газар наалдан хэвтээд юм чагнаж байна гэнэ.

- Өвөө, та юу чагнаа вэ? гэж Иван хашгиран асуув.

- Би Сонорч хүн. Хааны найранд зочид цуглаж уу, үгүй юу? гэж чагнаж байна.

- Сонорч, та нааш гараад ир. Хоёулаа цуг нисье!

- Гялайлаа, хүү минь. Би бүр эцчихсэн явна. Ингээд тэр хоёр нисэж яваад дахин нэг өвгөнийг харав. Өвгөн өрөөсөн хөл дээрээ маш хурдан гүйж явав. Нөгөө хөлөө юмаар уяжээ.

- Өвөө, та яагаад өрөөсөн хөлөөрөө яваа юм бэ? гэж Иван асуув.

- Би хааны найранд очиж явна. Хэрвээ энэ хөлийнхөө уяаг тайлж хоёр хөлөөрөө гүйвэл хотыг өнгөрөөд давхичих байх гэж айж байна. Би бол дэлхийд хамгийн хурдан гүйдэг газар товчлогч Хурдан гэдэг шүү дээ.

- Бидэнтэй хамт нис!

Хурдан хөлөгт сууж тэд гурвуул болон нисэв.

Гурвуул нисэж яваад тэртээ доор нэг өвгөн буугаа шагайн зогсож байхыг үзэв. Ойр хавьд ан амьтан жигүүртэн шувуу үл харагдана.

- Өвөө, та юу буудах гэж шагайж байгаа юм бэ?

- Би зуун уулын цаанатаа зургаан улсын тэртээх модны мөчир дээрх сойр шувууг буудаж хаанд бэлэг болгох гэсэн юмаа. Би хамгийн мэргэн бууддаг, намайг Мэргэн гэдэг гэж өвгөн хариулав.

Иван:

- Нисдэг хөлөгт минь суу. Хааны найранд хамт очицгооё.

- Гялайлаа, хүү минь! Би ч гэсэн хааны найранд очих гэж яваа юм. Ингээд өвгөн гарч ирж тэд дөрвүүл болон нисэв.

Үүлтэй тэнгэрийн доогуур үзүүртэй модны дээгүүр цааш нисэж яваад дахин нэг өвгөнийг харцгаав.

- Өвөө, та хаанаас хаана хүрч явна вэ? Нэр алдар хэн бэ? гэж Иван асуув.

- Би Жавар Жавардай гэдэг байна. Хаанаас хаашаа явж байгааг минь бүү асуу, харин намайг хөлөгтөө суулгаач, би чамд хэрэг болно гэж өвгөн хэлэв.

- Өвөө минь, суу суу! Хааны найранд хамтдаа очицгооё. Жавар өвгөн хөлөгт сууж тэд удсан ч үгүй нийслэл хотод нисэн очив. Хааны гүнжид нөхөр шилж авах найранд түм буман хүн цуглажээ.

Торгон далбаатай мөнгөн шурагтай сайхан хөлөг нисэн ирэхийг хүмүүс хараад хашгиралдав.

- Энэ л гүнжийн нөхөр ирж явна! Энэ хөлгийн эзэн л хааны хүргэн болох ёстой! гэлцэнэ. Малгайгаа дээш шидлэн угтав.

Нисдэг хөлөг хааны ордны хашаанд буув.

Ордныхон, шадар ноёд, хаан, хатан, гүнж, аягачин шивэгчин хүүхнүүд цөм хүргэнийг угтах гэж гүйн гарч ирцгээв.

Иван зангуугаа хаяхад нисдэг хөлөг дайвалзан зогсов. Хөлгөөс Сонорч, Мэргэн, Хурдан, Жавар өвгөд эхлэн гарч ирж, тэдний хойноос Пийшин Иван буув. Далан нөхөөс болсон өмдтэй даавуун цамц нь уранхай, үртэс зоргодос, будаг шунх наалдсан Иван бууж ирэхэд шадар ноёд:

- Хүргэн хаана байна? Хэн нисдэг хөлөг хийсэн бэ? гэхэд өвгөд ухран Иваныг зааж:

- Энэ Пийшин Иван ийм сайхан нисдэг хөлөг хийсэн гэж хариулав.

Хатан Иваныг хараад гараараа элгээ даран харуусаж нулимсаа унагаж гүнжийг тэврэн авч:

- Ээ, яасан муухай, нүдний булай вэ! Хун цагаан охиноо юуны төлөө нүдний цэцгийгээс илүү хайрлан өсгөсөн билээ? Энхрий охиноо энэ муу хөдөөний эр Пийшин Иванд өгөх гэж үү! гэж орилов.

Хатныг даган гүнж, аягачин шивэгчин хүүхнүүд цөмөөр уйлалдлаа. Хатныхаа үгийг сонссон хаан ч уурлаж зүхэн шогширч, дэвслэн:

- Надаар та нар тоглох гээ юу? Жинхэнэ хүргэн хаана байна! Нисдэг хөлөг хийсэн сайн эрийг аваад ирцгээ! гэж хашгирч гарав.

Энэ үед зах нь харагдахгүй олон хүн цуглав. Хааны найранд ирсэн хол ойр, хот хөдөөний олон хүн нисдэг хөлөг Иван хоёроос нүд салгалгүй ширтэнэ.

Хаан уурлаж:

- Энэ муу хөдөөний эр нисдэг хөлөг хийлээ гэж насандаа ч итгэхгүй! гэж хашгирав. Өвгөд хаан хатан хоёрт, цугласан олонд мэхийн ёслоод:

- Хөлгийг Пийшин Иван хийсэн. Иван гүнжийн нөхөр болох ёстой гэв. Ард олон:

- Хаан хүн үгээ буцдаггүй! Нисдэг хөлөг хийсэн хүн хааны хүргэн болох ёстой! гэцгээв. Тэгтэл гүнж уйлагнан:

- Ийм хүнтэй суухгүй! гэв.

Хатан охиныхоо энэ үгийг сонсоод улам их уйлав. Аягачин шивэгчин хүүхнүүд хатныг сугадан авч өргөөнд нь орууллаа.

Хаан дув дуугүй ууртай зогссоноо шулуудсан дур үзүүлэн:

- Эрхэм зочид минь, ёсоор болж таарах нь шив дээ. Хурим найр хийж гүнжийг нөхөрт гаргая гэв.



Ингээд зочид царсан ширээнээ сууцгаан амттан бүхнийг идэж ууж их найр өрнөв. Хаан шадар ноёдынхоо хамт тусдаа ширээнд сууцгаан ууж идэх ч үгүй бодол болцгоов.

- Энэ муу хөдөөний эр Пийшин Иваныг яаж тонилгох вэ? Тонилгочихвол ч нисдэг хөлөг минийх болно. Хаан надаас гарз гарахгүй Иваны оронд баян угсаат хүргэнтэй болоод авна даа гэж хаан ярихад хамгийн ахмад ноён гүнээ мэхийн ёслоод:

- Хаантан минь, хэлэх үгийг минь сонсоно уу, хэрэв таалахгүй бол өвгөн миний толгойг бүү аваарай! гэвэл хаан:

- За, ярь ярь, бид сонсьё гэв.

- Төрийн эзэн хаантан минь, энэ хүргэнд зуун уулын цаанатаа зургаан улсын тэртээх шувууг нэг цагийн дотор авчирч өг гэж зарлиг буулгаад тогтсон цагт авчрахгүй бол толгойгий нь авцгаая.

Иванд хааны зарлигийг хэлэв.

- Сайн эр минь, битгий санаа зов! Би тэр шувууг буудъя. Хурдан маань хагас цагийн дотор гүйгээд аваад ирэг гэж Мэргэн хэлээд шагайж шагайж буудав. Хурдан нэг хөлийнхөө уяаг тайлаад тэрхэн хоромд салхи мэт далдрав.

Сонорч чихээ газар наалдуулаад:

- Замынхаа тэг дунд ороод байна. Нэг минутын дараа:

- Шувууг аваад буцаж явна гэв.

Найр улам өрнөж зочин олон ууж идэн, гэрлэж буй хосыг магтан, дуу хөгжим эхэлжээ. Иван нөхдийн хамт хүлээгээд байв.

Тогтоосон цаг дөхөж байдаг Хурдан алга байлаа.

Тэгтэл Сонорч дахин газар чагнаад:

- Замынхаа хагаст ороод унтаж байна! Хурхирах нь сонсогдоно гэв.

Мэргэн буюгаа авч буудвал Хурдан нэгэн минутын дараа гүйж ирэв. Шувууг хаанд өргөв. Хурдан амьсгаагаа даран:

- Нэг хоромд гүйж очоод шувууг авлаа. Буцах замдаа нойр хүрээд байхаар нь хэзээд л хугацаанаасаа өмнө очихоос хойш хагас цаг дугхийгээд авъя гээд хэвтсэн чинь унтчихаж. Модны мөчир унаж намайг сэрээгээгүй бол ч орой болтол унтах байлаа гэжээ.

Иван шувуу авчирсныг сонсоод хаан уурлан хилэгнэж титмээ авч шидэн, шадар ноёдоо загнан:

- Энэ муу хөдөөний эрийг дийлэхгүй бол та нар гахай хариулцгаа! гэж хашгичив.

- Төрийн эзэн хаан минь, уур хилэнгээ дар! Пийшин Иваныг бид заавал үгүй хийнэ, газар гишгэх хугацаа түүнд бага үлдсэн! Хаантан минь, халуун усны байшингаа галлуул! Иваныг нөхөдтэй нь тэнд угаал үйлд гээд оруулья. Тэд тэндээс эргэж гарахгүй түлэгдэх болно гэж шадар ноёд аргадав.

Арван хоёр тэрэг түлээ түлж халуун усны байшинг галласан нь ойртох аргагүй халуун болжээ! Хаан Иваныг нөхөдтэй нь дуудан:

- За заяаны хүргэн худ ургууд минь, өнөөдөр угаал үйлдэж бэлтгэ. Маргааш гэрлэх ёслол болно гэв.

Тэгээд тэднийг халуун усны байшинд оруулаад түгжжээ. Тэнд бүтэж үхмээр халуун байв. Жавар өвгөн хоёр булан руу нь үлээж нулимахад халуун намдав. Нөгөө хоёр булан руу үлээж нулимахад бүр хүйтэн болов.

Хэсэг хугацаа өнгөрсний дараа хаан зарц нартаа:

- Тэдний ясыг нь цуглуулж булчхаад ир гээд явуулжээ.

Хааны зарц нар халуун усны байшинг онгойлгоод нүдэндээ итгэхгүй гайхацгаав. Иван өвгөдтэй цуг эв эрүүл:

- Дөрвөн хана нь цантсан ийм хүйтэн байшинд яаж халуун усанд орох юм бэ! гэж хараацгааж байна гэнэ. Хааны зарц нар айж халуун усны байшингаас гарч зугтав. Пийшин Иван вандан дээрээс бууж:

- Бидэнд өөрийн цэрэг байдагсан бол надаар тоглох ямар байдгийг хаанд үзүүлээд өгөхсөн! гэхэд Мэргэн:

- Энэ ч хэцүү биш шүү. Задгай газар гарцгаая гэв.

Өргөн задгай талбайд гараад Мэргэн буугаараа нэг, хоёр, гурван удаа даллахад хаанаас гарч ирснийг бүү мэд морьтой явган их цэрэг цугларав. Хороо хороогоороо жагсан бөмбөр дэлдэн

«Урай» цуурайтуулан, буугаар буудна.

Иван их цэргээ аван хааны ордон руу очив.

Их цэрэг дагуулсан Иван өвгөдтэй цуг ирж явахыг харсан хаан довжоон дээрээ гүйн гарч ирээд шагшран гасалж:

- Гай зовлонгоос тойрч гарахгүй нь! Охиноо энэ хөдөөний эртэй гэрлүүлэхээс яая гэх вэ! Ингэж нэрээ гутааснаа ч би ёстой санаандаа санаж шанаандаа зууна даа хө! Зай ч байна, лай ч байна, учрыг нь олоод хужрыг нь тунгаах цаг ч ирнээ хөө! гэж занав.

Хааны энэ хорон үгийг Сонорч сонсоод Пийшин Иванд хэлэв.

- Зусар зөөлөн үгэнд бүү хууртаарай. Хаан чамайг учрыг нь олно гэж байна.

- Хааны санаанд юу байгааг би мэдлээ. Эхнэр эрж энд ирдэг буруу болжээ! Хаантай яаж ярихаа ч одоо мэдэж авлаа.

Энэ үед их цэрэг хааны ордны үүдэнд тулж очив. Хаан гүйж гарч ирээд зусардан найрсгаар:

- Бид бүх юмаа зэхсэн, хүргэнээ л хүлээж байна. Гэрлэх ёслолоо үйлдэх цаг боллоо гэв.  
Пийшин Иван инээж:

- Та надаар тоглосон, тоглох ч гэж бодож байгаа. Эсэн мэнд дээрээ улс орноос минь зайл.

Хаан таны сүүдэр ч бүү үзэгдэг! гэв.

Ингэж Пийшин Иван хааныг шадар ноёдынх нь хамт хөөгөөд өөрөө хаан ширээнээ сууж улс орноо захирах болжээ.

# ИВАН БААТРЫН ТУХАЙ ҮЛГЭР

Эртээ урьд цагт энхжин тогтсон нэгэн улсад өвгөн эмгэн хоёр амьдран суудаг байжээ. Хүүхэдгүй юмсанжээ. Өвгөн эмгэн хоёр хүүхдийн хүсэл болж уйтгарлан хичнээн зовсон ч хүүхэд гараагүй байжээ.

Эмгэн нэг удаа гүн ойн дундах дөлгөөн нууранд байдаг алтан хайрст загасыг идвэл хүүтэй болно гэж зүүдэлжээ.

Эмгэн сэрээд өвгөнөө яаруулан: - Тийм нэгэн газар орших тэр нуурыг олж очоод алтан хайрст загасыг бариад ирээч! Загасны шинэ шөл уумаар байна! гэжээ.

Өвгөн юмаа төхөөрч тороо аваад замд хөдөлжээ. Харанхуй их ойд эрсээр яваад нуурыг олж гэнэ

Тороо анх удаа шидтэл хоосон гарч иржээ Хоёр дахь удаагаа хаяхад нь бас хоосон гэнэ. Гурав даль удаагаа хаятал алтан хайрст загас баригджээ.

Өвгөн тороо эвхэж, олзоо аваад харьжээ. За сайхан шөл хий!

Эмгэн өвгөн хоёр амттай сайхан шөл хийж ууцгаав

- Ёстой дээд уруулд хүргэшгүй дэргэдэх хүнд өгөшгүй амттай шөл байна! гэлцжээ. Удалгүй Иван гэдэг хүүтэй болжээ.

Өвгөн өглөөнөөс үдэш болтол тариан талбайдаа ажиллаж, эмгэн гэрээ сахиж хүүгээ бүүвэйлнэ. Хүү нь өдрөөр биш цагаар өсөж, эр бие нь сунаж эрч чадал суужээ.

Гурван настайдаа айл хөршийн хүүхдүүдтэй тоглодог болов. Харин айл хөршийнхөн нь:

- Хүүгээ гадаа бүү тоглуулаач! Тоглохдоо тооноос хэтэрч эрхлэхдээ эрхээсээ даварч хүүхдийн гараас нь барихлаараа гарыг нь, хөлөөс нь барихлаараа хөлийг нь хугалаад байх юм. Хүүхдүүд гэмтэж эрэмдэг зэрэмдэг болох нь байна! гэж гомдол хэлцгээх боллоо.

Эмгэн өвгөн хоёр санаа нь зовж «Энэ хүүхдийг яах вэ?» гэж бодол болцгоов. Өвгөн:

- Би тариан талбай руу дагуулаад явж байя. Тэнд тоглож байг.

Ингэхээр болжээ.

Дараа өдөр нь өвгөн газар хагалахдаа хүүгээ дагуулаад явжээ. Өвгөн анжсаа автал хүү нь:

- Би газар хагалья! гэж гуйв.

- Юу гэсэн үг вэ, хүү минь. Чи бага балчир байна! Том болоод ханатлаа хагалаарай! Одоо зүгээр л тогло, гүйж харай, харин хол битгий яваарай гэхэд хүү нь салахгүй гуйгаад байв

- Би газар хагалж үзье!

- За за, үз.

Хүү анжсаа газар гүнзгий шигтгэхэд морь татаж дийлэхгүй байв.

- Хүү минь, чи их гүнзгий шигтгээд байна! Морь татаж дийлэхгүй анжсаа эвдэнэ гэж эцэг нь сургамжлав.

Иван анжсаа өргөж моринд хөнгөлөн түлхэж өгөхөд анжис сайн хагалж эхлэв. Өвгөний нэг өдөр барахгүй их газрыг Иван үдийн зуур хагалжээ.

- Хүү минь, зогс, морио амраая! Морь хөөсөртлөө хөлөрч усан хулгана боллоо гэж байж өвгөн хүүгээ болиулжээ.

Морио нугад бэлчээж өөрсдөө цай ундаа уув. Цай ундаа уучихаад өвгөн:

- Хүү минь. морио бариад ир. Хоёулаа ажилдаа гарья гэв.

Хүү нуга руу очтол морь нь алга. Ийш тийш харваас бутны цаана нэг чоно суугаад ам хамраа долоож байв. Мориноос арьс яс хоёр үлджээ. Чоно Иваныг хараад түүн рүү дайрав.

- Морийг чинь идсэн одоо чамайг иднэ дээ'

- Бардах цаг болоогүй байна!

Ингэж хэлээд Иван чонын хөлөөс шүүрч аван хүчтэйгээр газар савахад чимхийн чинээ чийг үлдэв. Газар доргиж аянга буусан мэт их дуу чимээ гарав.

Эргэж ирээд эцэгтээ:

- Морийг минь чоно идчихжээ.

- Ээ, ямар гай вэ! Чонын нүдэнд өртөөгүй чинь сайн байна. Бид хоёрыг идчихнэ шүү, бушуухан явья! гэж эцэг хэлэв.

Тэр цагаас хойш олон жил өнгөрч Иван насанд хүрэв. Иван үлгэрт хэлшгүй үзгээр бичишгүй ханхар сайхан эр болжээ.

Тэр үед хааны гурван охин алга болжээ. Хорт Ясан хэдрэгийн Тохойн чинээ сахалт хумсын чинээ биет гэдэг хочтой зээ хүү нь тэр гурвыг хулгайлсан юм гэнээ. Уулыг урвуулж усыг зогсоох нь холгүй эрсэн боловч олдсонгүй гэнэ. Тайж ноёд эрэлд яваад хэн нь ч эргэж ирдэггүй алга болдог байжээ. Хаан хот тосгон, хошуу бүрд зар тараав.

- Охидыг олж чадсан азтай эрд амьд ахуйдаа хаант улсынхаа хагасыг өгч гурван гүнжийн аль нэгтэй нь суулгана! гэж зарлажээ.

Иван аав ээж хоёроосоо:

- Хааны охидын эрэлд явах ивээл ерөөлөө хайрлаач! гэж гуйж гэнэ. Эцэг эх хоёр нь:

- Мэдэхгүй газар хаашаага ч явах нь вэ? Алс замд амь насаа ч алдаж мэднэ! Хүний газар тэнэж явахаар нутаг уснаасаа гэрлэж орон гэрээ толгойлбол дээр биш үү! гэж аргадав. Харин хүү нь санаснаараа зүтгэж:

- Өнгөт орчлонг үзье, өөрийн чадлыг сорьё. Хүний газар гээд миний ухаан хорогдохгүй гэж гуйна.

Ингээд алс замд төхөөрөв. Эхлээд дарханд очиж:

- Гурван зуун пүү төмөр шийдэм давтаж өгөөч. Хугарч нугарахгүй, хотойж хавгайхгүй болтол нь давгаад өгөөч гэжээ.

- Давгах ч яахав, давгах л биз. Харин гурван зуун пүүгийн төмрийг бид яаж өргөх вэ?

- За, та нар төмрийг нь ширээчих өргөхийг нь би өргөж эргүүлж тойруулж өгье! Ингээд шийдэм хийж эхэлжээ.

Хоёр өдөр өдөржин давтав. Иван төмрийг эргүүлж тойруулж, зуух руу зөөж өгнө. Гурав дахь өдрөө шийдэм бэлэн болов.

- За туршаад үз. Болох нь үү, үгүй юу?

Иван шийдмийг өвдөглөн татгал нахийгаад ирэв.

- Энэ шийдэм биш байна! Өөрийг давтаж өгөөч!

Гурван өдрийн дараа сайн ширээсэн өөр шийдэм давтан хийв. Тахийлгах гэтэл тахийсангүй, харин чулуун дээр цохивол хуга үсрэв.

.- Энэ ч бас тохирохгүй!

Гурав дахь шийдэм хийв. Тахийсан ч үгүй, чулуун дээр цохиход хугарсан ч үгүй. Иван шийдмээ дээш шидвэл нүдэнд харагдахгүй алга болоод гурван цагийн дараа исгэрэн шуугин эргэж унав.

Чулуун дээр унаж тэр чулуу нь хоёр алд гүнзгий газарт шигдэв гэнэ.

- Надад яг тохирсон шийдэм давтаж өглөө, гялайлаа! гэж Иван талархав. Маргааш нь Иван өглөө эртлэн босож аав ээж хоёртоо үнсүүлээд алсын замд гарчээ.

- Санаа сэтгэлээ зовоогоод хэрэггүй, аав ээж хоёр минь! Гүнж нарыг олоод та нартайгаа уулзана.

Ингэж хэлээд гурван бялуу өвөртлөн шийдмээ бариад явжээ. Ээж аав хоёр нь хүүгээ тосгоныхоо зах хүртэл даган үдэв.

Өглөөнөөс орой болтол ургахын улаан нарнаас унахын шар нартай уралдан явав. Ан амьтан үзэгдэхгүй, жигүүртэн шувуу ч жиргэхгүй, хэнтэй ч юутай ч дайралдсангүй.

Дараа өдөр нь нэг хүнтэй дайралдав. Тэр эр хоёр гартаа нэг нэг царс бариад нэгийг нь нөгөөгөөр нь цохиж байх юм гэнэ.

- Амар сайн уу, Царс баатар минь!

- Би ямар баатар байх вэ! Энэ хорвоод Иван гэдэг нэг баатар байдаг гэнэ лээ. Иван гуравтайдаа хөх чоныг алсан юм гэдэг. Газар дэлхий доргиж байсан гэнэ билээ. Тэр эр ёстой баатар!.. Үгүй энэ чинь, чи Иван баатар биш биз?

- Миний нэр Иван. Хөх чоныг би алсан нь үнэн. Хар ин одоо болтол хэнтэй ч хүч чадлаа үзэлцээгүй билээ.

Царс баатар:

- Намайг аваад яваач! гэж гуйжээ. Иван ч:

- Тэгье, хамт явья гэв.

Өндөр уулыг өвөрлөн намхан газрыг нарлан явсаар Иван баатар Царс хоёул хоёр том ууланд тулаад иржээ.

Хоёр уулын хооронд нэг эр зогсчихсон хоёр уулыг харшилдуулж байна гэнэ. Их цуурай гарч байх юм гэнэ.

- Уул баатар минь, амар сайн уу?

- Би баатар гэж үү! Оросод Иван гэдэг баатар байдаг гэж сонссон. Хүүхэд байхдаа хөх чоныг нүцгэн гараараа алсан гэдэг. Газар доргиж уулс нурсан гэдэг. Тэр л ёстой баатар!

Царс Иваныг заан:

- Хөх чоныг алсан баатар энэ байна! Тэгэхэд Уул баатар ёслоод:

- Иван баатар, намайг аваад яваач! гэж гуйв.

- Тэгье, хамт явья.

Ингээд гурвуул болов. Өглөөнөөс орой болтол ургахын улаан нарнаас унахын шар нартай уралдан явцгаав. Ан амьтан, жигүүртэн шувуу юу ч дайралдсангүй.

Дараа өдөр нь гурвуул нэгэн өргөн гол дээр ирцгээв. Эрэг дээр нэг эр хэвтээд сахал

дээгүүрээ хүмүүсийг гол гатлуулж байх юм гэнэ.

- Сахал баатар, амар байна үү?

- Амар байна аа, амар байна уу? Эрчүүд минь! Та нар намайг баатар гэнэ. Оросод Иван гэдэг жинхэнэ баатар байдаг гэнэ билээ. Тэр баатар балчир хүүхэд байхдаа хөх чоныг алсан гэдэг. Газар дэлхий доргиж, ус эргээсээ халин хичнээн газраар үер болов доо! Тэр Иван л ёстой баатар!

Царс баатар Уул баатар хоёр Иваныг заан:

- Иван баатар энэ байна! Тэгэхэд Сахал баатар:

- Ах дүү нар минь, намайг аваад яваач дээ! гэжээ.

- Тэгье, хамт явья. Ингээд дөрвүүлээ цааш явжээ.

Үлгэрт хэлэхэд амархан ч үйлс бүтэх нь хэцүү, эрэлхэг сайн эрчүүд эцэж цуцахгүй явсан гэдэг.

Явж байтал нэг байшин дайралдаж гэнэ. Хашаагаар нь дүүрэн олон шар бэлчих боловч байшинд хүн алга байна гэнэ.

- Эзэнгүй энэ байшинд сууж эргэн тойрных нь газрыг самнаж үзье. Эхлээд зүүн талыг, дараа нь урд, баруун талыг, сүүлд нь хойд талыг самнан явж үзье. Хааны охидыг хулгайлагчийн мөр хаа нэг газар дайралдах биз! гэж Иван баатар хэлэв.

Ингээд бүгдийн санаа нийлэв.

- Царс, чи өнөөдөр үлдээд үдийн ундаа хий. Бид нар зүүн талыг явж үзээд ирье гэж Иван баатар хэлэв.

Царс баатар үлдээд таван том шар алж чанажээ. Тэгээд цонхоор харан «Тэд нар яагаад удаад байна. Хоол нь хөрөх нь» гэж бодоод сууж байтал гэнэт Тохойн чинээ сахалт хумсын чинээ биет дөчин тэрэг өвс чирчихсэн хүрээд ирлээ гэнэ шүү. Өвсөө чирсээр авчирчихаад худгаас ус татаж шарнуудаа усалж ундаалаад тоолж гэнэ. Тоолж тоолж таван толгой дутахад:

- Шарнуудыг тэжээж услахгүй мөртлөө гар хүрсэн хүн энд байна уу? гээд ийш тийш харснаа Царсыг үзээд барьж аван нүдэв! Нүдэж нүдэж байшингийнхаа нэг буланг өргөж байгаад тийш нь чихчихэв.

- Энэ булан өмхрөхгүй байг! гэж хэлээд дахин алга болов.

Царс тийчигнэж тийчигнэж арайхийн мултарч гараад байшинд орж пийшин дээр хэвтэв. Нөгөө гурав нь ч эргэж ирэв.

- Унд бэлэн үү?



- Бэлээн бэлэн.

- Чи яагаад тэнд хэвтгээд байгаа юм бэ? Босож ундаа уу!

- Үгүй, уумаргүй байна. Би утаанд бүтэж үхлээ. Тэд хоолоо идээд бага юм шиг санагдав.

Ингээд маргааш нь Уул баатрыг унд хий гээд үлдээв.

Уул баатар долоон шар алж чанаад нөгөө гурваа хүлээн цонхоор харж суув. Гэтэл Тохойн чинээ сахалт хумсын чинээ биет дөчин тэрэг өвс чирээд ирж явна гэнэ. Гүйж ирээд шарнуудыг ундалж усалчихаад тоолж гарав гэнэ. Долоо дутаад байж.

- Ямар хулгайч энд байна? Шарнуудыг ундалж услахгүй мөртлөө гар хүрдэг хэн бэ?

Ингэж хашгираад Уул баатрыг хармагцаа барьж аван балбав! Балбаж балбаж байшингийнхаа нэг буланг өргөж байгаад доогуур нь Уул баатрыг чихчихэв.

- Ингээд хэвтэж бай! гэж хэлээд дахин гүйж одов. Уул тийчигнэж тийчигнэж арайхийн мултарч гарав.

Царс, Сахал, Иван баатар гурвуул буцаж ирэхэд Уул пийшин дээр ёолон хэвтэж байв.

- Уул, чи яагаад хэвтгээд байгаа юм бэ? Босож ундаа уу!

- Уумааргүй байна. Утаанд хордсон байх, толгой өвдөөд байна.

- Энд юуных нь утаа байх билээ? гэж Иван баатар хэлэв. Уул баатар, Царс баатар хоёул дув дуугүй байв.

Гурав дахь өдрөө Сахлыг унд хий гэж үлдээв. Сахал баатар есөн шар алж чанаад амсаад үзвэл сайхан тослог шөл болжээ. Ингээд цонхоор харан сууж байтал Тохойн чинээ сахалт хумсын чинээ биет дөчин тэрэг өвс чирчихсэн гүйж ирэв. Шарнуудаа ундалж усалчихаад тоолж байснаа харааж хэлэв.

- Энэ чинь юу болоод байна даа? Өнөөдөр есөн толгой дутаад байна!

Ингээд Сахлыг шүүрч аваад балбаж балбаж чирсээр байшингийнхаа нэг буланг өргөж байгаад тийш нь чихчихэв.

- Ингээд чи хашир! гэж хэлээд гүйн одов.

Сахал байшин дороос арайхийн мултарч гараад пийшин дээр ёолон хэвтжээ. Нөгөө гурав ч эргэж ирэв.

- Унд бэлэн үү?

- Бэлээн.

- За буугаад ир, ундаа уу!

- Үгүй ээ, чадахгүй нь. Толгой өвдөж байна. Утаанд л хордчихож. Өглөө нь Иван баатар:

- Өнөөдөр хойд зүгийг нэгжиж тойроод ир. Хэрэв эндээс ямар нэг мөр олдохгүй бол цааш явцгаая. Гүнж нарыг эндээс дахиад эрсний хэрэггүй. Өнөөдөр би унд хийе. Миний хордох ээлж гэв.

Нөгөөдүүл нь ч яваад өгөв. Иван баатар арван хоёр шар чаначихаад цонхоор харан дуулж суув. Гэнэт Тохойн чинээ сахалт хумсын чинээ биет дөчин тэрэг өвс чирчихсэн гүйж ирэв. Шарнуудаа ундалж усалчихаад тоолж гарав. Арван хоёр дутуу байв. Ийш тийш харж дуу дуулахыг сонсоод Иван баатрыг үзэнгүүт дайрав.

- Чамтай нэгийгээ үзэж, нэхий дээлээ уралцана гэлээ!

Тэр хоёр нүдэлцэж нүдэлцэж Иван баатар Тохойн чинээ сахалт хумсын чинээ биетийг даран авч сахлыг нь таслаад вандан сандал доогуур шидчихэв.

- Ингээд чи энд хэвтэж бай! Нөгөө гурав нь ч эргэж ирэв.

- Унд зэхчихээд хүлээгээд байлаа! Ямар нэг мөр олов уу?

- Үгүй ээ, өнөөдөр ямар ч мөр олсонгүй!

Дөрвүүл ундаа ууж суухдаа Царс вандан доогуур шагайгаад:

- Хөөе хараач, бидний хорддог утаа тэнд хэвтэж байх чинь!

- Ямар юмны чинь утаа вандан доор байдаг билээ? гэж Иван баатар асуухад,

- Энэ, энэ Тохойн чинээ сахалт хумсын чинээ биет. Энэ чинь л биднийг хордуулдаг утаа байхгүй юу!

Иван баатар инээмсэглэн:

- Урьд нь надад хэлэхгүй яасан юм бэ?

- Биднээс хэн нь илүү хүчтэйг үзэх гэсэн юм. Ингээд биднээс хамгийн хүчтэй нь Иван гэдгийг мэдлээ.

Тохойн чинээ сахалт хумсын чинээ биет тэр үед ухаан орж сэргээд сэмхэн босож зугтав.

Дөрвөн эр түүний хойноос элдэв. Тохойн чинээ сахалт хумсын чинээ биет гүнзгий хавцал хүрээд газар доогуур орон алга боллоо.

Иван баатар:

- Бид хичнээн явж, эргэн тойрныг самнан нэгжсэн боловч энэ хавцлыг үзээгүй. Энэ хавцал руу орж үзэх хэрэгтэй. Энэ муу шидтэний атганд хааны охид зовж байгаа юм биш биз?

Ингээд тэд шарын арьсаар сур хийв.

- За, хэн ийшээ орох вэ? Хэн ч дуугарсангүй. Иван баатар:

- Би орьё. Та нар эндээс холдолгүй хүлээж бай. Сурны нөгөө үзүүрээс татахтай зэрэг намайг татаж аваарай.

Ингээд Иван баатар шийдмээ бариад хавцал РУУ буув. Доош буусан хойноо сурныхаа үзүүрийг биеэсээ тайлж орхиод замаар орон цааш явав. Явсаар байтал нэг их гэгээ татав. Удалгүй Иваны өмнө зэс ордон харагдаж гэнэ. Асар том зэс ордон дүнхийх агаад хаалганд нь зэс гинжээр аварга могой уяжээ. Могой час час дуугаран ордны үүц хаалгыг хамгаална. Ордны ойролцоо худаг, худагт зэс шанага зэс гинжээр дүүжлээстэй харагдана. Иван баатар худгаас ус утгаж өөрөө уугаад могойд ч уугав. Могой чимээгүй болон номхров. Зэс ордонд орвол тэнд зэс вандан дээр үзэсгэлэнт бүсгүй суугаад юм оёж байв. Учиг татах болгонд нь л нэг цэрэг гарч ирээд байх юм гэнэ.

- Амар байна уу, үзэсгэлэнт бүсгүй минь! Юугаа оёж хатаж, хэнийг дарах гэж эр цэрэг гаргана вэ

- Сайн эр минь, амар байна уу? Би Иван баатрыг дарах эр цэрэг бэлдэж сууна.

- Хэн энэ цэргийг авч явах юм бэ?

- Тохойн чинээ сахалт хумсын чинээ биет.

- Үзэсгэлэнт бүсгүй минь, тэр Тохойн чинээ сахалт хумсын чинээ биет чинь чиний юу юм бэ?

- Би Анна гүнж. Миний хогёр дүү Марфа, Татьяна гүнж гэж бий. Бид тэр нэгэн улсын хааны гурван охин билээ. Тохойн чинээ сахалт хумсын чинээ биет бид гурвыг хулгайлан энд авчраад гурван жил хорьж шаналган зовоож байна. Тэр өөрөө Хорт Ясан хэдрэгийн зээ билээ.

Ингэж ярихад нь Иван баатар

- Би та гурвыг эрж яваа билээ. Үзэсгэлэнт бүсгүй минь, оёж шидэхээ орхиж эр цэрэг бэлдэхээ боль! Эргэж явах замдаа чамайг авч газар дээр гаргаж аав ээжид чинь хүргэж өгнө гэв,

Гүнж баярлан оёж байсан юмаа гал руу шидэхэд эр цэргүүд байгаагүй юм шиг алга болов. Гүнж Иван баатрыг дайлав. Иван зэс ордонд амраад цааш явжээ.

Явж байтал мөнгөн ордон дайралдав. Асар том мөнгөн ордон цайран дүнхийнэ. Хаалганд нь мөнгөн инжээр аварга могой уяжээ. Могой час час дуугаран амаа ангалзуулна... Ордны ойролцоо худаг, худагт мөнгөн гинжээр мөнгөн шанага дүүжлээстэй байна гэнэ.

Иван баатар худгаас ус утгаж өөрөө уугаад могойд уулгав. Могой номхрон хэвтээд өглөө

Мөнгөн ордонд орвол мөнгөн вандан дээр түрүүчийнхээс илүү үзэсгэлэнтэй бүсгүй суугаад юм оёж байв. Дунд гүнж Марфа учиг татах болгонд нь л хоёр цэрэг бий болоод байх юм гэнэ.

Үзэсгэлэнт бүсгүй минь, юугаа оёж хатгаж хэнийг дарах гэж цэрэг бэлдэнэ вэ

- Иван баатрыг дарах цэрэг бэлд гэж надад тушаасан юм.

- Хэн энэ цэргийг ав явах юм бэ?

- Тохойн чинээ сахалт хумсын чинээ биет.

- Одоо тэр хаана байна?

- Одоо гурав дахь ордонд байгаа.

- Үзэсгэлэнт бүсгүй минь, оёж шидэхээ орхиж намайг дарах эр цэрэг бэлдэхээ боль! Эргэж явах замдаа чамайг авч газар дээр гаргаж аав ээжид чинь хүргэж өгнө.

Гүнж баярлан оёж байсан юмаа гал руу шидвэл эр цэргүүд байгаагүй юм шиг алга болов. Иван баатар мөнгөн ордонд амарч дайлуулаад ааш явжээ.

Явсаар байтал улам л гэгээтэй болоод байв. Дараа нь эргэн тойронд юм бүхэн гялалзан харахад нүд өвдөм болов гэнэ. Удалгүй өмнө нь алтан ордон харагдав. Шижир алтан ордон гал мэт гялалзан дүнхийнэ. Энэ ордны цонх нь болор, цонхных нь хүрээ очир шигтгээтэй ажээ. Алтан хайрст аварга могой алтан гинжээр уяатай байх агаад час час дуугаран ордныг манаж байлаа. Хашаан дотор нь худаг, худагт алтан шанага алтан гинжээр дүүжлээстэй байв.

Иван баатар алтан худгаас ус утган өөрөө уугаад могойд уулгав. Могой чимээгүй хэвтээд өглөө.

Сайн эр алтан довжоо өөд өгсөн алтан хаалгыг онгойлгов. Ордонд алтан вандан дээр үлгэрт хэлшгүй үзгээр бичишгүй үзэсгэлэнтэй гурав дахь гүнж Татьяна юм оёод сууж байна гэнэ. Учиг татах болгонд нь л гурван цэрэг бий болоод байх юм гэнэ.

- Татьяна гүнж минь, амар сайн уу? Юугаа оёж хатгаж хэнийг дарах эр цэргийг бэлдэнэ вэ?

- Сайн эр минь, амар сайн уу? Иван баатрыг дарах цэрэг бэлд гэж даалгасан. Оёж шидэж цэрэг бэлдэх дургүй байвч оёхгүй байж болохгүй. Хорт Ясан хэдрэгийн зээ Тохойн чинээ сахалт хумсын чинээ биет амийг минь өршөөхгүй.

- Үзэсгэлэнт гүнж минь, оёж шидэхээ боль. Би чамайг газар дээр гаргаж аав ээжид чинь хүргэж өгье.

- Аз хийморьт эр минь, эцгийн минь явуулсан олон баатар энүүгээр ирсэн. Гэхдээ хэн нь ч эсэн мэнд эргэж хариагүй. Тохойн чинээ сахалт хумсын чинээ биет цөмийг алсан. Тэр их

хүчтэй бас гурван толгойтой могой туслагчтай. Энэ хоёрыг дийлсэн хүн байхгүй. Харин Оросод Иван баатар гэж байдаг гэж сонссон. Тохойн чинээ сахалт хумсын чинээ биет гурван толгойтой могой хоёулаа зөвхөн энэ л баатраас айдаг юм. Биднийг их цэрэг бэлд гэж тушаасан. Иван баатартай байлдахаар бэлдэж байгаа юм.

- Намайг дарах дайнд явахаас өнгөрчээ. Ясан хэдрэгийн зээтэй хүч үзэлцэн дийлж, хулгайлагдсан эгч дүү та нарыг чөлөөлөхөөр би өөрөө хүрээд ирлээ.

- Иван баатар гэдэг ийм баатар ажээ! гэж Татьяна гүнж баярлав.

Тэгээд оёж байсан юмаа гал руу шидвэл цэргүүд байгаагүй мэт алга болжээ. Татьяна гүнж ширээ бүтээн идээ будаа, архи дарс өрөн зочноо хүндлэн дайлав.

- Сайн эр минь, зооглогтун! Ингэж Иван баатрыг дайлаад:

- Ясан хэдрэгийн зээ Атгаалжин хар могой хоёртой тэмцэлдэх тун хэцүү дээ. Эдний цэцэрлэгт нь алимын алтан модон дор хоёр домбо бий. Нэгэнд нь мөнхийн, нөгөөд нь билгийн устай. Тэр хоёр тулалдахын өмнө мөнхийн ус уудаг тул тэднийг ямар ч хүч дийлэхгүй, ямар ч хурц сэлэм цавчиж даахгүй болдог юм.

- Үзэсгэлэнт гүнж минь, зочлон дайлсанд баярлалаа. Ясан хэдрэгийн зээ Тохойн чинээ сахалт хумсын чинээ биетийг би хаанаас олох вэ? Хэлж өгнө үү?

- Одоо тэр хамаг бие нь шархдаж, хэмх нүдүүлсэн амьтан халуун усны байшинд хэвтэж байгаа. Ууранд, усанд орж биеэ тэнхрүүлж, биднийг олон цэрэг гаргахыг хүлээж байгаа гэж Татьяна гүнж хэлэв.

Татьяна гүнж Иван баатрын хайр сэтгэлийг булаав. Татьяна гүнж царай тун ч үзэсгэлэнтэй төдийгүй нуруу туруу, хүч чадал сайтай, алтан өнгөт урт үс нь ар нуруугаа чимсэн, урсгал дөлгөөн харцтай, уран хар хөмсөгтэй, хун шувуу шиг явдалтай, хурмастын нар шиг гэрэлтэй ажээ.

Татьяна гүнж Иван баатрыг хараад нүүр нь улайж:

- Ясан хэдрэгийн зээтэй хүч үзэлцэн тэмцэлдэхдээ биеэ сайн хамгаал. Хоёр дахь удаагаа бүү цохиорой. Эргээд амь орно гэж захив.

Сайн эр Иван баатар шийдмээ аван сайхан гүнжтэй салах ёс хийгээд гарч явлаа.

Дархан цэцэрлэгт нь орж алимын алтан модыг нь эрж олоод мөнхийн ус билгийн ус хоёрынх нь байрыг сольж тавив. Дараа нь халуун усны байшинд нь орвол Тохойн чинээ сахалт хумсын чинээ биет вандан дээр хэвтчихсэн:

- Халаа, бүүр халаа! гэж хашгирч байв гэнэ. Иван баатар босгыг нь алхан ормогц Тохойн чинээ сахалт хумсын чинээ биет биеэ балбаж байсан мөчрөө шидэн:

- Энэ чинь юун хүний үнэр гараад байна вэ? гээд огло үсрэн босож Иван баатрыг харав.

- Аа, Иван баатар үхэхийг хүсээд өөрөө хүрээд ирлээ! Миний гараас ч амьд гарахгүй дээ! гээд чангаар исгэрэхэд байшингийн дээврээс нь долоон банз бүлт үсрэн унаж, зарц барлагууд нь үхэтхийн ойчив гэнэ. Ингээд Тохойн чинээ сахалт хумсын чинээ биет гадагш гүйн гарлаа. Тэр хоромд эргэн тойрон шуугин дүнгэнэж, хав харанхуй болсноо гурван толгойтой могой нисэн ирсэн нь сарвуундаа домбо барьжээ.

Гурван толгойтой могой:

- Орос баатар Иван хаана байна вэ? гээд Иваныг хараад хөхрөн,- Яасан жижигхэн юм бэ? Би түүнийг алган дээрээ тавиад нөгөө алгаараа дарчихна. Нойтон чийгээс өөр юу ч үлдэхгүй гэв.

- Ёрын муу чөтгөр, чи юу юуны туханд хүрэлгүй бүү гайхуул! Эхлээд чамайг оршуулах ч юм билүү?

Гэтэл Тохойн чинээ сахалт хумсын чинээ биет яаруулан:

- Юугаа яриад байгаа юм бэ? Наад домботойгоосоо бушуу уу, тэгээд Иван баатрыг цохь! гэж орилов.

Могой домбоноос нэг балгаад хүч нь сулран хөл дээрээ тогтож ядан салганав. Иван баатар аяархан цавчиж могойг алав.

Тохойн чинээ сахалт хумсын чинээ биет дэвслэн:

- Ай халаг, могой мөнхийн усны оронд билгийн ус уучихлаа! гээд хоёр дахь удаагаа модны навчийг унатал өвс ногоог налтал чанга исгэрэв. Жаахан хүлээснээ:

- Энэ муу гүнж нар ч намайг бас хуурчээ! Цэрэг алга! За яахав, ганцаараа чамайг дөнгөчихнөө!

Ингэж хэлээд Иван баатар луу үсрэн хар хүчээрээ цохиход Иван баатар өвдгөө хүртэл газар шигдэв. Иван баатар ч хариу цохиход Тохойн чинээ сахалт хумсын чинээ биет өнхрөн унав.

Гэтэл түүний зарц барлагууд нь:

- Дахин цохь! гэж хашгиралдав.

Дахин цохивол Тохойн чинээ сахалт хумсын чинээ биет амь орно гэж Иван баатар урьд нь мэдсэн тул:

- Оросын баатар хоёр удаа цохино гэдэг танай эзэнд хүнддэнэ! Нэг удаа л боллоо гэж хариулав.

Гэтэл Тохойн чинээ сахалт хумсын чинээ биетийн зарц нар Иван баатар луу дайрцгаав. Иван баатар тэднийг зүг зүгт шидэхийг нь шидэн, цохихыг нь цохиж унагажээ. Амжиж зугтсан нь амьд үлдэж, үлдсэн бүгд нь үхжээ. Тэгээд Иван баатар алтан ордон руу алхав.

Татьяна гүнж сайн эрийн ирж явахыг цонхоороо хармагцаа үүдэндээ гүйн гарч ирж, баярлан угтав.

- Эрэлхэг зоригтны энгүй алдар бадартугай!

Тэгээд Татьяна гүнж өөрийн нэртэй бөгжөө сугалан авч Иван баатрын хуруунд хийгээд:

- Сэтгэлд чинь би таалагдаж байвал эргэж хариад, сайн эр минь, намайг эхнэрээ болгон аваарай! Сайн эр чи миний сэтгэлийг татлаа. Чиний үнэнч сайн эхнэр чинь болно гэв.

Иван баатар баярлан Татьяна гүнжийн зөөлөн цагаан гарыг барин болзоот хүүхэн минь гэж нэрлэв.

Тэгээд тэд буцах боллоо. Алтан ордноос гарсныхаа дараа Татьяна гүнж нэг алтан өндөг Иван баатарт өгөөд:

- Нэг гараасаа нөгөө гар дээрээ шид, тэгээд юу болохыг үз гэв.

Сайн эр алтан өндгийг нэг алганаасаа нөгөө алган дээрээ шидвэл алтан ордон алга болов. Татьяна гүнж:

- Хэрэгтэй үедээ алтан ордон хаана л бол хаана босгож болно. Зөвхөн энэ өндгийг нэг алганаасаа нөгөө алган дээрээ шид. Одоо дунд эгч дээр очё гэв. Ингээд мөнгөн ордонд ирцгээгээд:

- Марфа гүнж минь! Бушуулаарай, гэр лүүгээ явцгаая! гэхэд дунд эгч нь баярлан дүүгээ, Иван баатрыг дайлав.

Тэгээд мөнгөн ордноос гармагцаа Марфа гүнж мөнгөн өндөг нэг алганаасаа нөгөө рүүгээ шидэхэд ордон алга болов. Марфа гүнж Иван баатарт өндгөө өгөөд:

- Хэрэгтэй үедээ мөнгөн ордон хаана л бол хаана босгоорой гэв.

Ингээд том эгч дээрээ ирцгээв. Анна гүнж зэс өндөг нэг алганаасаа нөгөө алган дээрээ шидэхэд зэс ордон алга болов. Зэс өндгийг Иван баатарт өгчээ.

Иван баатар эгч дүү гурван гүнжийг сурны үзүүр унжиж байгаа нөгөө газартаа авчрав.

Сурны үзүүрт банз бэхлээд Анна гүнжийг суулгаж сурнаасаа татаарай гэж дохио өгөхөд гурван баатар гүнжийг дээш татаж гаргав. Гурван баатар Анна гүнжийг «Яасан сайхан бүсгүй вэ!» гэж харан харан шагшина.

Сурыг дахин буулгаж эхнийхээсээ бүүр ч илүү үзэсгэлэнтэй дунд гүнжийг татаж гаргав. Гурав дахь удаагаа сурыг буулгахад Иван баатар:

- Татьяна гүнж минь, за суугаарай гэтэл,

- Үгүй ээ, чи суу. Юу ч гэсэн эхлээд чамайг татаад гаргаадхаг. Чиний эсрэг элдэв муу санаа гарах вий гэхээс би айж байна.

Иван баатар Татьяна гүнжийн үгэнд орсонгүй.

- Чамайг яаж энд ганцааранг чинь орхих билээ! Миний нөхөд намайг хорлохгүй. Чиний араас татаад гаргачихна гээд сурныхаа үзүүрээс татлав.

Царс, Уул, Сахал баатар Татьяна гүнжийг татаж гаргаад:

- Ийм үзэсгэлэн урьд хожид үзээгүй билээ! гэж хөдөлж чадахгүй хөшин гайхаж, хэлэх үгээ олж ядацгаан, хийж байснаа мартацгаав.

Сахал баатар гэнэт:

- Гурав дахь гүнжийг би эхнэрээ болгоно! гэж хашгирахад Уул баатар Марфа гүнжийн гараас барьж аван:

- Энэ бүсгүй эхнэр минь болно! гэв. Царс баатар ч хоцролгүй:

- Ах дүү нар минь, би нэг дэх бүсгүйг авна! гэвээс Татьяна гүнж:

- Сайн эрчүүд минь, байз байз. Иван баатрыг та нар мартав уу? Гурван толгойтой могойг устгаж, Тохойн чинээ сахалт хумсын чинээ биетийг алж эгч дүү бид гурвыг чөлөөлсөн Иван баатраа юуны түрүүнд татаж гаргая, дараа нь тавтай ярилцъя гэлээ.

Уул Сахал хоёр баатар чимээгүй болон сураа хавцал руу буулгатал Царс:

- Богино ухаант эмийн үгийг бүү сонс! Иван баатрыг татаж гаргавал бидний хэн нэг нь эхнэргүй болно! гэж хашгираад үсрэн очиж сурыг тас огтлов.

- Ай халаг гэж! Татьяна гүнжийн үгэнд ордоггүй буруудлаа! Яг л үнэн хэлж дээ. Гээд яахав дээ, газар дээр гарах арга олох хэрэгтэй.

Ингэж бодоод Иван баатар дархан цэцэрлэгт очиж алтан өндгөө нэг алганаасаа нөгөө алган дээрээ шидэхэд алтан ордон бий болов. Алтан ордонд орж хоол унд идэж аваад, оройноос өглөө сэргэлэн гээд амрахаар хэвтжээ.

Маргааш нь цэцэрлэг дэх алтан алимын модон дороос мөнхийн устай домбыг хэрэг болно гэж авав.

Энэ үед эргэн тойронд их дуу чимээ гаран хар үүл харанхуйлж Тохойн чинээ сахалт хумсын чинээ биетийн ээж, Ясан хэдрэгийн эгч Шулмас эмгэн нисдэг хивсэн дээр суун нисэн ирэв. Төмөр шүдтэй, тугалган нүдтэй, дэгээ урт хамартай, ам нь чихээ хүртэл ангайсан, үс гээг нь сэгсийсэн ажээ.

Газар мөргөн өнхөрч:



- Хайрт хүү минь үгүй болов. Хавирган сар мэт энхэр үр минь алга болов! гэж уйлж уйлж ядарч унтаад өгөв.

Иван баатар алтан өндгөө нэг алганаасаа нөгөө алган дээрээ шидэхэд ордон ч алга болов.

- Ясан хэдрэгийн эгч эргээд нисэхэд нь намайг авч яв гэе гэж шийдээд үснээс нь чирэн нисдэг хивсэн дээр нь гаргаад хажууд нь суужээ.

- Намайг гэрэлт газар дээр гаргаад аль, үгүй бол чамайг ална шүү! гэв.

Ясан хэдрэгийн эгч сэрж шүдээ хавиран могой шиг дуугаран босож ирээд Иван баатартай ноцолдож ноцолдож дийлсэнгүй нисдэг хивснээсээ түлхэн унагаах гээд чадсангүй, дээш нисэн газар дээр гарч үүлнээс дээгүүр нисэв.

- Одоо чамайг тэнгист унагаж ална даа! гэж загнана.

Иван баатар нэг гараа үсээр нь ороон зуурч, нөгөө гартаа шийдмээ өргөөд:

- Унавал хамт унана, чамайг тавихгүй! гэв. Ясан хэдрэгийн эгч чадлаа шавхан ноцолдоод

Иван баатрыг нисдэг хивсэн дээрээс түлхэн унагаж хүчирсэнгүйдээ уурлан ихэд өндөрт нисэхэд газар жижиг толбо мэт харагдана.

- Хар ой руу бяц унахад чамаас юу ч үлдэхгүй дээ! гэж Ясан хэдрэгийн эгч орилон газар луу усанд хаясан чулуу мэт шунган нисэхэд Иван баатар:

- Би бяцрахад чи бас бяцарна! гэж зулгаалдсаар явав. Нисдэг хивс ойд дэлэм хирийн дөхөж ирснээ эргэж нисэв.

Ясан хэдрэгийн эгч Иван баатрыг үсрэн дайрч савраараа урж, шүдээрээ зулгаан, хивсэн дээрээсээ унагах гэж хар хүчээрээ нүдээд эцэн сульдаж ногоон талд буув. Газардмагц Иван баатар ногоон дээр үсэрч буугаад эргэж харвал Шулмас эмгэн жижигхэн хорхой болон хувирснаа дараа нь газар цөмрөөд орчихсон мэт алга болов. Нисдэг хивс ч алга болов.

- За ингээд газар дээр гараад ирсэн хойно ч боллоо! гэж Иван баатар тайвшраад шарх шалбархайгаа мөнхийн усаар шүршвэл бие нь дорхноо хөнгөрчээ.

Жаахан амарч аваад ойгоос гарахаар алхлаа.

Зүүрмэглэх өтгөн ой, зүйрлэшгүй өргөн талын дундуур ус голыг гатлан туулсаар улс орондоо эргэн ирвэл юу үзсэн гэж санана! Улс орныхон бүгд чулуу болчихжээ. Газар хагалж байсан хүмүүс морьтойгоо, өвс хадаж байсан нь хадууртайгаа, малчид сүрэгтэйгээ, модчин сүхээ барьсан хэвээрээ, загасчид усны захад дэгээ юугаа татсан чигээрээ, цөм л яаж байсан тэр чигээрээ чулуужжээ.

Нийслэл хотод хүрч ордонд орвоос амьд амьтан алга байлаа. Хаан, хатан, аягачин, шивэгчин, манаач, харуул цөм хөшин чулуужжээ. Гурван гүнж, Царс, Уул, Сахал нарын хэн нь ч алга

байв.

Иван баатар ордноос гаран хандсан зүг рүүгээ алхав. Явж байтал өмнө нь нэг их цэрэг хиар цохигдсон хэвтэнэ гэнэ.

- Амьд хүн байна уу? гэж хашгирав.

Хэн ч хариулсангүй. Ийш тийш хартал Царс баатар хоёр хэсэгт тас цавчигдсан хэвтэнэ гэнэ.

- Царсны үхэл энд байжээ!

Ингээд цааш явж байгаад дахин урьдахаасаа их цэрэг хиар цохигдсон байхыг үзэв.

- Нэг ч болтугай амьд хүн байна уу? гэж хашгирчээ.

Жаахан хүлээн зогсоход ямар ч хариу алга. Ийш тийш хартал унжгар удын бутан дор Уул баатар алагдсан хэвтэнэ гэнэ.

Нэг мод хиртэй яваад урьд хоёроосоо бүүр их олон цэрэг хиар цохигдсон байхыг үзэв.

- Амьд хүн байна уу? Хэн ингэж танай их цэргийг хиар цохио вэ? гэж хашгиртал нэг цэрэг өндийж:

- Би ганцаар амьд үлджээ гэж дөнгөж хэлээд өвсөн дээр өнхрөн унаж нүдээ анив. Иван баатар тэр эрийн шархыг мөнхийн усаар шүршвэл сэргэн босож:

- Яасан сайхан болов оо! Өвдөх хатгах юмгүй боллоо! Сайн эр минь, чамд гялайлаа! гэв.

- Манай улс яагаад юунаас болоод чулуу болсон бэ? Энэ гурван их цэргийг хэн ингэж устган дарав? Татьяна, Анна, Марфа гүнж хаачсан бэ? Би эрээд эрээд олсонгүй гэж Иван баатар асуухад тэр Анд эр:

- Манай хотын гурван гүнж алдагдсанаас хойш гурван жил болсон билээ. Дэвэн дэлхийгээр эрээд олоогүй юм. Гэтэл саяхан харийн баатар Царс, Уул, Сахал нар Хорт Ясан хэдрэгийн зээг дийлж газар доорх улсаас гурван гүнжийг авчирсан билээ. Хаан хатан хоёр баярлахын ихээр баярлаж найр наадам эхлэв. Хаан гурван баатартай охидоо гэрлүүлэх гэсэн боловч гүнж нар уйлан татгалзсан гэж сонссон. Яг энэ үед Хорт Ясан хэдрэг их цэргээ дагуулан манай улс руу дайрлаа. Манай хааны явуулсан Царс, Уул, Сахал баатар жанжинтай гурван их цэргийг Хорт Ясан хэдрэг хиар цохин устгаж галдан шатаав. Улс орон, хүн ард цөмөөрөө чулуу болон хувирахад Хорт Ясан хэдрэг гурван гүнжийг олзлон авч оджээ. Ингээд байтал сайн хүн та намайг сэхээн эдгээлээ. Одоо би хаашаага ч явах билээ дээ? гэж өгүүлэв. Иван баатар хэлэв.

- Хорт Ясан хэдрэгтэй байлдя!

- Ясан хэдрэгийн амь нь хаана байдгийг олохгүй бол түүнтэй хүчээр тэмцэлдээд дийлэхгүй гэж Анд зөвлөхөд Иван баатар:

- Ясан хэдрэгийн амийг олтлоо энэ дэлхийг самнан нэгжье' гэж хэлээд хоёул тохиролцон эрлийн замд гарчээ.

Олон газар, олон улсаар явж сурагласан авч Ясан хэдрэгийн амь хаана байдгийг хэлэх хүн олдсонгүй.

Сайн эрчүүд явсаар нэгэн шөнө нэгэн эмгэнийд хонохоор болжээ. Эмгэн тэднийг гэртээ оруулж, хоол унд өгөөд:

- Аль газрын хэний үрс вэ? Хүслийн зоргоор явна уу, хүний эрхээр явна уу? Иван баатар:

- Бид тэр газрын тийм улсаас явна. Ясан хэдрэгийн амийг олохоор хүслийн зоргоор явж байнаа. Хорт Ясан хэдрэг их цэргээ хөөлгөн улс гүрнийг минь дайрч манай их цэргийг цохин устгаж галдан шатаахад ард олон, улс орон маань чулуу болон хувирлаа. Ингээд бид Ясан хэдрэгийг устгаж улс орон, ард олноо хорт хүчнээс салгаж, хааны гурван гүнжийг авран чөлөөлөхөөр явж байна.

- Үрс минь, Ясан хэдрэгийн амь хаана байгааг би мэднэ. Гэхдээ түүнд хүрч авна гэдэг тун хэцүү! гэж эмгэн хэлэв.

- Амь насаа үл хайрлан, хүнд хэцүүг үл хайхран улс гүрнээ аварна. Гагцхүү Ясан хэдрэгийн амь хаана байгааг хэлж өгөөч гэж сайн эрчүүд гуйв.

- Зуун уулын цаанатаа зургаан улсын тэртээ үүлнээс өндөр чулуун уул байгаа. Уулын дунд төмөр авдар, тэр төмөр авдарт өндөг, өндгөн дотор Ясан хэдрэгийн амь бий. Хүрэх зам бэрх хол ч хэрэг зоригийн эрхээр даван туулж болно. Харин чулуун уулыг бут цохин ухаж хэн ч чадаагүй билээ гэж эмгэн өгүүлэв.

Маргааш өглөө нь Иван баатар Андынхаа хамт үүрээр босон эмгэнтэй салах ёс хийгээд цааш явжээ.

Яваад л байж, яваад л байж гэтэл гэнэт өмнө нь замын хажуудах чулуун дээр нэг хүн сууж байна гэнэ. Тэр хүн:

- Залуу эрс минь, хаанаас хаана хүрч явна вэ? гэжээ.

- Ясан хэдрэгийн амийг эрж явна.

- Хаана байгаа юм бэ?

- Зуун уулын цаанатаа зургаан улсын тэртээ чулуун ууланд булаастай байгаа.

- Намайг аваад яваач! Би бага наснаасаа уулын ажил хийсэн хүн тэр уулыг бутлахад тусалъя.

- Тэгье, хамт явцгаая!

Ингээд тэд гурвуул болон цааш явжээ. Өндөр чулуун уул харагдав. Тэр уулын орой үүлнээс

дээш цухуйна. Уулыг нүдэж эхлэв. Уулын ажилчин чулууг өрөмдөн цоолон унагав. Иван баатар шийдмээрээ хага хага цохин бул булаар нь авч шидлэв. Анд эр жижиг чулууг зайлуулан зөөв.

Чулууг бутлан, хагалан зөөсөөр долоо хоноход нэг дэлэм хирийн газар ухав. Тэд эцэж хөл дээрээ тогтож ядан байв.

Анд эр:

- Бүтэн жил ухсан ч төмөр авдарт хүрч чадахгүй байх, эндээс явцгаая! гэхэд Иван баатар:

- Энэ насаараа ухсан ч цуцаж ухрахгүй! Хорт Ясан хэдрэгийг дийлэхээс нааш буцахгүй гэж хариулж Уулын ажилчин ч дэмжин:

- Ажлын их айдас төрүүлэвч арга ухаан хөдөлмөрөөр дийлж болдог гэнэ.

Ингээд долоон сар уулыг ухаж тэг дунд хүрвэл алтан бүслүүртэй төмөр авдар харагдав. Уулын ажилчин:

- Үхэл нь ойртсоныг Хорт Ясан хэдрэг мэдэрч байгаа. Удахгүй наашаа нисээд ирнэ. Энэ авдраас амийг хурдхан авахгүй бол гай гамшиг болно! Хурдалъя! гэв.

Иван баатар төмөр авдрыг шийдмээрээ цохино. Цохиж цохиж налчийлгасан боловч зад цохиж чадсангүй.

Гэнэт их дуу чимээ гаран салхи шуурга дэгдэв.

- Иван баатар, хурдлаарай! Авдрыг зад цохихгүй бол бидний хөдөлмөр үргүй болон үрэгдэнэ. Хорт Ясан хэдрэг авдрыг булааж авбал бид энэ насаараа ч эрээд олохгүй. Хорт Ясан хэдрэг амьд байгаа цагт хүн ард амар заяа үзэхгүй гэж Уулын ажилчин яаруулав.

Хорт Ясан хэдрэг ч тэднийг галаар тургиж эхлэв.

Энэ хоромд Иван баатар хамаг хүчээрээ цохин авдрыг хэмхлэв. Авдраас өндөг өнхрөн гарч ирэхэд өндгийг хүчтэй цохиход аянга мэт дуугарч чулуун уул элс болон бутрав. Хорт Ясан хэдрэг ч газарт үхэтхийн унав. Гурван эр түүний ясыг шатаан үнс болгон хийсгээд ордон руу нь явжээ.

Гурван гүнж ч Иван баатрыг харж, бага гүнж Татьяна өөдөөс нь гүйн ирж уйлан:

- Иван минь, чи минь, энэ чинь мөн үү! гэнэ. Гурван гүнж зэрэг зэрэг:

- Сайн эрчүүд минь наашаа юунд ирэв дээ? Хорт Ясан хэдрэг одоо нисэж ирээд та нарыг алчихна, яанаа? гэцгээв.

- Үзэсгэлэнт хүүхнүүд минь, бүү зов! Хорт Ясан хэдрэг сөнөсөн тул хүмүүсийг түйвээж чадахгүй.

Эгч дүүс баярлан:

- Хэрвээ Ясан хэдрэг үхсэн бол манай улс гүрэн, ард олон түүний хорт шидээс ангижран дахин амь орсон бизээ.

Ингээд тэд улс руугаа буцахаар бэлдэв. Гурван шуудайд алт, үнэт чулуу дүүргэж нисдэг хивсийг нь олж авав. Тэгээд өөрийн улсдаа нисэн ирж нийслэл хотынхоо хааны ордны өмнөх өргөн талбай дээр буужээ. Гурван гүнж аав ээж рүүгээ гүйн очиж тэврэн авцгаав. Иван баатар алтан өндгөө нэг гараасаа нөгөө гар дээрээ шидэж алтан ордон, дараа нь мөнгөн өндөг шидэж мөнгөн ордон, зэс өндөг шидэж зэс ордон босгов.

Хаан хатан хоёр охидоо харан баярлан уйлж, гурван ордныг бахархан харна.

Иван баатар, Уулын ажилчин, Анд эр гурвыг магтан зочлон дайджээ. Ард олон ч гурван эрийн алдар гавьяаг шагшжээ. Иван баатар аав ээж хоёроо авчрав.

Удалгүй ордонд их хурим найр боллоо. Иван баатар Татьяна гүнжтэй, Уулын ажилчин Марфа гүнжтэй, Анд эр Анна гүнжтэй гэрлэжээ.

Өргөн их хурим гурван долоо хоног үргэлжлээд өндөрлөхөд Иван баатар залуу эхнэр, эх эцгийнхээ хамт алтан ордонд, Уулын ажилчин Марфа гүнжтэй мөнгөн ордонд, Анд эр Анна гүнжтэй зэс ордонд сууж амар сайхан жаргаж, амгалан энх амьдрах болжээ. Хөгшин хаан насан эцэслэсний дараа тариачны хүү Иван баатар хаан төрийг залах болсон гэдэг.

# ЯДУУ ЭР НОЁНТОЙ ЦУГ ХООЛЛОСОН ТУХАЙ

Баярын нэг өдөр эрчүүд байшингийн хаяавч дээр сууцгаан элдвийг хүүрнэлдэж байв. Тэдэн дээр хөдөөний нэг мухлагийн эзэн ирж:

- Би, би гэж баахан өөрийнхөө тухай ярьснаа,- Би ноёны өрөөнд нь орж үзсэн гэж хөөрөхөд хамгийн ядуу эр хөхрөн:

- Ноёны өрөөнд орж үзэх юу байсан юм бэ? Тэгье гэвэл би ноёнтой зэрэгцэн хооллоно гэв.

- Чи, чи, чам шиг муу амьтан ноёныд орж хооллоно гэнээ! Ёстой энэ насандаа итгэхгүй! гэж баян хашгирахад,

- Ноёнтой цуг хооллоно доо!

- Үгүй, үгүй, чи чадахгүй!

Ийнхүү баян ядуу хоёр маргалдаж, ядуу эр:

- Ноёнтой цуг хооллоно гэж мөрийцөх үү? Хар хүрэн хоёр морио чи тавь. Хэрвээ би ноёнтой хооллож чадахгүй бол гурван жил чамд үнэ хөлсгүй ажиллаж өгье гэжээ.

Мухлагийн эзэн баярлан:

- Тэгье, тэгье. Хар хүрэн хоёр морин дээрээ нэг бяруу нэмье. Сонссон бүгд гэрчлэг! гэж амлав.

Ингээд харсан сонссон цөм гэрчлэн мөрий тавив. Ядуу эр ноёныдоо очин:

- Эзэн минь, миний малгайн чинээ цул алт хэдий хир үнэтэй болох бол? гэжээ.

Ноён юу ч хэлсэнгүй алгаа ташин:

- Энэ эр бид хоёрт уух юм даруулах хоол өгөөдөх! Бушуул, бушуул! За, суу суу! Бүү нэрэлх, юу дуртайгаа ид, уу? гэж хөл алджээ.

Ингэж ноён ядуу эрийг хүндэт зочин мэт хооллон дайлж, цул алт өвөрлөнө гэхээс тэсэж ядан чичирнэ.

Тэгээд эцэст нь:

- За, чи яваад алтаа аваад ир! Би чамд нэг пүү гурил, тавин мөнгө өгье гэж өгүүлэв.

- Үгүй ээ, надад ямар ч алт байхгүй! Би зүгээр л миний малгайн чинээ цул алт ямар үнэтэй байдгийг мэдэх гэсэн юм.

Ноён уурлан хашгирав.

- Тэнэг чи, зайл!

- Ноёнтон та намайг хүндэт зочин шигээ хүлээн авч дайлсан, үүгээр ч зогсохгүй ингэж дайлүүлсныхаа төлөө би мухлагийн эзэнгээс хоёр морь, нэг бяруу авна. Ингэхлээр би ямар тэнэг байх билээ дээ!

Ингэж хэлээд ядуу эр их л баяртай яваад өгчээ.

# ЦЭЦЭН ЭХНЭР

Хааны хүү анд морджээ. Ховор амьтан хөөн давхисаар танихгүй газар ороод ирснээ өөрөө мэдсэнгүй. Мориныхоо амыг татан хаашаа явах, хаагуур явж замдаа орохоо мэдэхгүй эргэлдэв.

Баруунтшаа хөдөлвөөс хөндөлдсөн их ой, зүүнтшээ эргэвэл бас л ой байх бөгөөд харгуй зам, харах мөр юу ч дайралдсангүй.

Ийнхүү үдшийн гэгээнээс үүрийн гэгээ хүртэл эргэлдээд унасан морь нь ч эцэж, өөрөө ч ядарчээ. Ой зах хязгааргүй үргэлжлээд байж гэнэ.

Өглөөгүүр гэгээ ороход нэгэн нарийхан жим тахиралдан зурайхыг олж харжээ. Тэгээд баярлан морио давиран жим даган явсаар цэлгэр тал, цэнхэртэх хөндийд гараад иржээ.

Эргэн тойрноо харвал нэг тосгон үзэгдэв. Ингээд хааны хүү тэр тосгонд хүрч, яндангаас нь бөөн утаа олгойдон байгаа байшингийн гадаа очив.

«Гал хөсөө түлээд хүнтэй л байгаа юм байна» гэж боджээ.

Мориноосоо буун байшингийн гадаах шатаар өгсөн дөнгөж үүднийх нь өрөөнд ортол нэхэх суурийн араас нэг бүсгүй огло үсрэн пийшингийн цаагуур орчихов. Тэгээд тэндээсээ:

- Хашаа хаалгандаа чихгүй, ханат байшиндаа нүдгүй байна гэдэг муухай юм! Залуу минь, жаахан хүлээж бай гэв.

Хаан хүү «Энэ чинь юу яриад байна даа? Эрүүл юм болов уу?» гэж боджээ. Тэгээд:

- Чи ганцаараа суудаг юм уу? Эсвэл аав ээж, ах дүүтэйгээ юү?

- Ганцаараа гэж юү гэсэн үг вэ! Аав, ээж, дүү гурав минь өнөөдөр байхгүй байна.

- Тэд чинь хаачсан юм бэ?

- Ээж аав хоёр минь зээл уйлахаар, дүү маань зуун янчаанаа таван мөнгөнөөс солихоор явсан гэв.

Хааны хүү дахиад юу ч ойлгосонгүй.

Бүсгүй ч пийшингийнхээ цаанаас гараад ирлээ.

Хааны хүү бүсгүйг хармагцаа зогтусан гөлрөв. Ямар үзэсгэлэнтэй бүсгүй вэ! Энэ дэлхийг тойрсон ч ийм бүсгүй олдохгүй бизээ. Алтан өнгөт урт үс нь ар нуруугаа чимсэн, огторгуйн цэнхэр нүд нь од мэт гялалзсан, алимын улаан хацартай, үүрийн туяа шиг сайхан бүсгүй ажээ. Зочноо хүндэтгэн:

- За, та дээшээ суу. Аль газрын хэний хүү вэ? Хэрэг зориг юунд билээ? гэж намуухан дуугаар



асуув.

Хааны хүү сэхээ авч вандан дээр суугаад хэрхэн яаж ойд төөрсөн, энэ тосгонд яаж хүрч ирснээ ярьж бүсгүйг нүд салгалгүй ширтэнэ.

- Хашаа хаалгандаа чихгүй, ханат байшиндаа нүдгүй гэж чи юу ярив аа? Би ойлгосонгүй гэхэд бүсгүй инээж:

- Ойлгож ядах юмгүй ээ! Хашаандаа нохойтой байсан бол таныг хараад хуцаж, би энэ чимээгээр гаднын хүн ирлээ гэж мэдэх байсан юм. Гэтэл манайх нохойгүй, ингэхлээр хашаандаа чихгүй айл даа. Гэрт маань бага хүүхэд байсан бол тэд танихгүй хүн ирэхийг цонхоор хараад надад хэлэх байсан. Ингээд та орон гэрээ янзлаагүй байхад минь орж ирэхгүй байхсан! гэж өгүүлэв.

- Аав ээж, дүүгийнхээ тухай юу гээд ярьчих ваа? гэж зочин дахин асуухад, «Өө, яасан ч анхиагүй, авхаалж сэхээгүй юм бэ дээ! Харахад эелдэг сайхан залуу мөртлөө» гэж бүсгүй боджээ. Тэгээд:

- Ээж аав хоёр минь оршуулгад явсан. Өнгөрсөн хүнийг өрөвдөн гашуудан уйлна. Өөрсдийнх нь цаг ирэхэд сайн хүмүүс ирж уйлан тэднийг минь оршуулна. Дүү минь зуун янчааны морь унаж туулай хөөхөөр явсан. Туулай агнавал таван мөнгөний ашигтай, морио эцээвэл зуун янчааны гарзтай.

Ийнхүү ярьсаар ширээ засан идээ будаа өрөв.

- Зооглогтун, байгаагаараа баян гэдэг гэж зочноо дайлж цайлаад гарч зам зааж өгөв.

- За ингээд шулуухан яваад бай, оройдоо гэртээ хүрнэ гэжээ.

Хааны хүү харьж тэр өдрөөсөө эхлэн уйтгар гунигт дарагдан уух идэхийг мартан үзэсгэлэнт бүсгүйг өдөр шөнөгүй санах болжээ.

Хүүгээ өрөвдөн эцэг эх нь ч зовно. Янз бүрийн баяр найр хийвч хүүгийн сэтгэлийг сэргээн хөгжөөж үл чадав.

- Хүүг гэрлүүлье. Ханьтай бүлтэй болохоор уйтгар гуниг нь дорхноо арилна гэж хөгшин хаан хэлэв.

Тэгээд хүүгээ дуудан:

- Хайрт хүү минь, хань бүлээ сонго, гэр толгойлох нас чинь боллоо. Хатан ээж бид хоёр чинь ач гучаа харж баясмаар байна. Эхнэр хаанаас ч олдоно. Ямар ч гүнж чамтай дуртайяа сууна.

- Манай улсад нэгэн үзэсгэлэнтэй сайхан бүсгүй бий гэж хаан хүү хариулахад,

- Тун сайн байна! Хаашаа, ямар ноёных руу элч явуулах вэ? Хэлээтэх! гэж хаан эцэг нь асуув.

Хаан хүү анд явж байхдаа яаж төөрч тэр нэгэн тосгонд очсон, тэнд ямар үзэсгэлэнтэй сайхан бүсгүйтэй дайралдсанаа яриад:

- Гүнж ч биш, авхай ч биш, эгэл жирийн тариачны охин сэтгэл зүрхийг минь булаалаа. Өөр ямар ч эхнэр надад хэрэггүй гэв.

Хаан шагшран гасалж уурлан хашгирав.

- Хар ардтай хамаатан садан болж би яасан ч чадахгүй!

- Таны дураар болог. Харин надад хайргүй дургүй бүсгүйтэй гэрлэснээс энэ насаараа ганцаар явсан дээр гэж хаан хүү хэлээд өргөөндөө орчихов.

Хаан бодож бодож «Одоо ч үгнээс минь гарахгүй ингээд больж гэж бодъё, гэхдээ үгүй болсноос минь хойш тэртэй тэргүй тэр муутайгаа гэрлэнэ дээ» гэж санан хатандаа цөмийг ярьжээ. Хатан ч уйлна:

- Ямар гай билээ! Одоо яах вэ? гэхэд хаан:

- Би арга оллоо. Хөөе, зарц нараа, хаан хүүг дуудаад ир! гэв. Тэгээд хүүдээ:

- Хатан ээж бид хоёр чинь хэлцэн зөвлөлдөж, шүүн бодсоор ийнхүү шийдлээ. Хэрвээ тэр бүсгүй миний гурван даалгаврыг биелүүлж чадвал чиний эхнэр болог. Биелүүлж чадахгүй бол өөртөө гомдог, хорвоод гишгэх өдрийнх нь тоо гүйцнэ гэж хэлээд маалингын нэг шилбэ өгөөд:

- Энэ маалингаар утас ээрч, ээрсэн утсаараа даавуу нэхэж надад цамц оёж авчраг. Хэр зэргийн уран гэдгийг нь үзье! гэжээ.

Хаан хүү эцгийнхээ зарлигийг аван давхив. Үзэсгэлэнт бүсгүй хаан хүүг цонхоороо харж, угтан гарч ирлээ. Зочноо үүдэн дээрээ угтан эелдэгхэн харцаа тусган:

- Хүслийн зоргоор явна уу? Хүний эрхээр явна уу? гэв.

Хаан хүүгийн зүрх догдлон цохилж хоёр хөлөө солбин дуугүй зогсоно. Тэгснээ зориглон:

- Үзэсгэлэнт бүсгүй минь, чи миний сэтгэлээс гарахаа болилоо. Чамайг эхнэрээ болооч гэж гуйхаар ирлээ гэж дуугарав.

Бүсгүй улайж улам ч үзэсгэлэнтэй болсноо тун аяархнаар:

- Үйл заяаг үргээж болдоггүй гэдэг. Миний сэтгэл ч чамайг таална. Эцэг эх минь ч эсрэг үг хэлэхгүй, харин чи өөрийн эцэг эхээс асуух хэрэгтэй гэжээ.

Хаан хүү гэртээ болсон бүгдийг нууж хаалгүй яриад маалингын шилбээ өгөв.

Бүсгүй хааны зарлигийг сонсоод инээмсэглэв. Дараа нь шүүрээс хусны мөчир хугалж аваад:

- Энэ мөчрөөр ээрүүл, шорноок, хамгийн нимгэн даавуу нэхэж болох суурь хийж өгвөл би хааны зарлигийг биелүүлнэ гэжээ.

Хааны хүү гэртээ буцан ирж мөчрөө өгөн бүсгүйн гуйлтыг хэлэв.

Хаан гайхан, өөрийгөө зэмлэн «Чи ийм аргатай хүүхэн үү, би бүр ч илүү арга мэх олно доо!» гэж шүд зуугаад чанасан зуун өндөг авчруулав.

- Энэ өндөгнүүдийг бэрд аваачиж өг. Энэ өндөгнүүдийг дэгдээхэй болгож хуримын ширээнээ бэлтгэг гэв..

Хаан хүү шинэ зарлигийг сонсоод гунигласан авч юу ч хэлсэнгүй бүсгүй рүү явжээ. Бүсгүй өндгийг аваад нэг хувин агшаасан шар будаа авчран:

- Энэ будааг хаанд хүргэж өг! Үүнийг суулгаж, тарьж ургуулаг. Энэ өндөгнөөс гарсан дэгдээхэйнүүд тэр ургасан будааг л иднэ, өөр юм тонших ч үгүй!

Хаан хүү харьж агшаасан будааг эцэгтээ өгөв.

Хаан бүсгүйн үгийг сонсоод хүүгээ гурван өдрийн дараа ир гэжээ.

Хаан хоёр өдөр шөнө бодоод гурав дахь өдрийн өглөө их хөгжилтэй босон ирж «Хаантай хадралцвал яадгийг чи муу одоо үзнэ дээ хө!» гэж хөхрөв.

Тэгээд хүүгээ дуудан:

- Чи хань болох бүсгүйгээ яваад уриад ир. Хуримын өмнө бэрээ нэг харъя. Харин хувцастай ч биш, хувцасгүй ч биш, бэлэгтэй ч биш, бэлэггүй ч биш, явган ч биш, мориор ч биш гэхдээ унаатай ирэг! гэлээ.

Хаан хүү бүсгүй дээр ирж эцгийн зарлигийг сонсгов. Эцэг, эх, дүү гурвынх нь санаа зовон:

- Энэ ч нэг зүгээргүй дээ! гэж шанална. Хаан хүү ч царай барайлгав.

Харин үзэсгэлэнт бүсгүй хөгжилтэйхэн:

- Маргааш үдээс хойш хүлээж бай гэж эцэг эхдээ дамжуул даа! гэхэд хаан хүү ч гэр лүүгээ явав.

- Миний дүү, өглөө гэхэд эгчдээ нэг туулай, нэг бөднө хоёрыг амьдаар нь бариад ирээч гэж бүсгүй хэлж дүү нь ч тэр даруйхнаа ой руу явжээ.

Бүсгүй эцэг эхээ ч бүү зов, бүү гунигла, бүх юм сайн сайхнаар бүтнэ гэж тайвшруулна.

Маргааш нь үдээс хойш хаан ордныхоо дээд давхарт цонхоор алсыг ширтэн сууна.

Бүсгүйг хармагцаа зарцаа «Хашааны хаалга онгоймогц хамгийн зэрлэг эр нохдыг өөдөөс нь тавь» гэж тушаав.

Тэгээд дотроо:

- Амьд байсан гэхээс өөр юм үлдээхгүй хэдэн хэсэг болгоно доо, чамайг! гэж инээнэ.

Хаан цонхоороо харсаар суув. Бүсгүй ч ойртоод ирлээ... Бошинзын оронд том том нүхтэй тор нөмөрчээ. Хувцастай ч биш, хувцасгүй ч биш нь энэ ажээ. Туулайг хазаарлан, мөчрөөр гуядан урдаа хөөж явна гэнэ. Морьтой ч биш, явган ч биш, унаатай ирж буй нь энэ ажээ.

Ингээд бүсгүй хаалга онгойлгомгогц аймшигт ноход түүн рүү улаан галзуу дайрав!

Хаан ч үсрэн босож шатаар уруудан үүдэндээ гарч ирвэл хашааны хаалганаас нэлээд хол туулай хөөсөн хоёр нохой давхиж харагдав гэнэ. Гэтэл шатаар өөдөөс нь олон нүхтэй тор нөмөрсөн үлгэрт хэлшгүй үзгээр бичишгүй үзэсгэлэнт сайхан бүсгүй өгсөн гарч ирлээ гэнэ.

Бүсгүй мэхийн ёслоод инээмсэглэн:

- Хаан үүдэндээ гарч ирэн угтсан нь надад их хувь билээ. За энэ миний бэлэг! гээд гараа сунгав.

Хаан бэлгийг авах гэтэл бүсгүй атгасан гараа тэнийлгэж тэр хоромд бөднө шувуу хааны хамрын хажуугаар дэрхийн нисэн одов.

Хаан толгойгоо гэдийлгэн тэнгэр ширтэнэ.

- Таны зарлиг ёсоор бэлэгтэй ч биш, бэлэггүй ч биш ирлээ гээд бүсгүй инээмсэглэв. Хаан бөднө шувуу харж байгаад хий гишгэж шат руу өнхрөн унаж бөмбөрөв.

Бүсгүй түшихээр ухасхийв. Зарц нар нь гүйн ирж хаанаа босгоход хаан ёолон, бөөр нуруугаа барилан дуу тавина.

Энэ дуу чимээгээр хаан хүү гарч ирэн бүсгүйгээ харж баярлав. Энэ үед хаан жаал уужирч:

- За, хүндэт зочин бүсгүй хэлсэн бүгдийг минь биелүүллээ. Ийшээ ордонд морилогтун, хатан хүлээж байгаа гэж хэлэв.

Гэхдээ хаан «Яах ч аргагүй боллоо. Хаан хүн үгээ буцалтай биш. За яахав, дараа учир нь олдonoо» гэж дотроо бодож л дээ.

Бүсгүй бутны ард очиж нөмөрсөн тороо авч шидвээс гоёлын бошинзтой үлдэв. Цөм харж ханахгүй, нүд салгаж чадахгүй зогсон:

- Ийм үзэсгэлэн гоо эмэгтэйг урьд хожид үзээгүй билээ! гэж шагшицгаана. Бүсгүйн үзэсгэлэнтэй сайхныг үзмэгцээ хатан ч нулимсаа арчин хөгжин хөөрч баясав. Хаан:

- Гурван даалгаврыг бэр минь биелүүллээ! Одоо өргөн их хурим найраа хийж болно гэв.

Удалгүй хурим хийж хоёр залуу жаргалтай сайхан амьдарчээ.

Тэгээд нэгэн хэсэг болсны хойно хөгшин хаан хатантайгаа өөр улс руу хатныхаа эгчийнд зочлохоор болжээ.

Хаан явахынхаа өмнө хүү бэр хоёртоо:

- Хүү минь, чи намайг эргэж иртэл хаан төрөө удирдан зал. Журам дэгийг сахиулж хэрэг ажлыг захир. Аа харин бэр чи, хөрөнгө зоорийг харж хамгаалж, эд баялгийг хямгадан хайрлаж бай. Харин хаан төрийн хэрэгт хошуу бүү дүр. Эзэн хааны ажилд эм хүний ухаан хүрэхгүй! Үгнээс минь зөрвөл өөртөө гомдоорой гэжээ.

Ингээд хаан хатан хоёр явчихжээ. Хаан хүү нэг удаа анд яваад эргэхдээ хотын хаалганы дэргэд нэгэн ядуу эртэй дайралджээ.

Ядуу эр түүнийг зогсоон:

- Сайн санаатан минь, хаантай яаж уулзах вэ? Хэлж өгөөч гэж гэнэ.

- Хаантай уулзах ямар хэрэгтэй билээ? гэж хаан хүү асуув.

- Энэ хорвоо дээр үнэн гэдэг байхгүй юм уу? гэж асуух гэсэн юм.

- Яагаад чи үнэн байхгүй гэж бодоо вэ? гэж хаан хүү асуухад ядуу эр:

- Яагаад гэвэл ядуу хүн юм бүхэнд л буруутай, баян хүн дандаа, юм бүхэнд зөв болох юм гэж хариулав.

- Яагаад тэр билээ? гэж хаан хүү гайхжээ.

- Яах юу байх вэ! Өчигдөр би баян хөршгэйгөө шүүхэд очоод үнэн гэж байхгүй, баян хүн буруутай атлаа зөвдөхийг нүдээрээ харж, чихээрээ сонслоо гэжээ.

Хаан хүү ядуу эрээс хэнтэй, ямар шүүгчид очсоныг асуугаад:

- Маргааш үдэд хааны ордонд ир гэв.

Ингээд хаан хүү ордондоо ирээд тэр шүүгчийг баяны хамт дуудуулжээ. Маргааш нь хааны ордны хашаанд баян эр, шүүгч, ядуу эр гурав иржээ. Үд дунд хаан үүдэндээ гарч ирэн ядуу эрээс:

- Хаанаас юу хүсэж байгаагаа хэл! гэв.

- Бидний хэргийг зөвөөр шүүн шийдэж өгөөч! Баян хөрш бид хоёр зах руу явах болж түүний тэргэнд миний гүүг хөллөөд явсан билээ. Замд шөнө болж бид хээр хоносон юм. Өглөө босоод хартал тэргэн доор нэг унага хэвтэж байна. Миний гүү унагалжээ.

- Үгүй, худлаа! гэж баян эр үгийг нь таслан хашгираад,

- Миний тэрэг унагалсан. Хаан хүү шүүгчээс:

- Шүүгч, чи юу гэж бодож байна? Хэний унага гэж шүүсэн бэ?

- Би зөв шүүсэн. Унагыг эзэнд нь өгсөн гээд баяныг зааж,- Баяны унага гэв.

- Яаж чи мэдсэн бэ? гэж хаан хүү асуухад,

- Унага тэргэн доор хэвтэж байсан юм чинь гүү биш тэрэг унагалжээ.

Хаан хүү «Нээрээ, гүү унагалсан бол унага юу гэж тэргэн доор хэвтэх билээ? Шүүгч зөв шүүсэн бололтой» гэж бодов.

Энэ үед хаан хүүгийн залуу эхнэр үүдэн дээрээ гүйн гарч ирээд:

- Хэний унага вэ? гэдгийг мэдэхэд тун амархан. Шийдэж ядах юм алга! гэв.

- Яаж амархан? гэж хаан хүү асуув.

- Унага эхийгээ дагадаг... Чи тэргээ аваад зүүн тийшээ яв гэж баянд, чи гүүгээ хөтлөөд нөгөө тийшээ яв гэж ядууд хэлжээ.

Баян ядуу хоёр хоёр тийш явахад унага гүүг даган гүйв.

- За харж байна уу! Шүүгч буруу шүүжээ гэж залуу эхнэр хаан хүүд хэлэв.

Хаан хүү унагыг ядуу эрд өгөх, шударга биш шүүгчийг ажлаас нь халах зарлиг гаргажээ. Удсан ч үгүй хөгшин хаан хатантайгаа буцаж иржээ. Шадар ноёд хаандаа:

- Хаан эзэнтэн минь, таныг үгүйд бэр хүүхэн юм юмыг гартаа авч оролцохгүй хэрэггүй, хэлэхгүй, шийдэхгүй ажил гэж байхгүй болсон. Үнэнч олон шадар ноёдыг тушаал зиндаанаас халж, зохих хүний үгийг үг гэж тоохгүй дураар аашиллаа гэж ховложээ.

Хаан бэрээ дуудан:

- Чи миний үгийг сонссонгүй. Чамайг шийтгэнэ. Чи ордноос зайл! гэхэд бэр нь:

- Хамгийн үнэт зүйл минь энд байхад би хаашаа явж, яаж амьдрах билээ? гэж гэнэ. Хөгшин хаан «Гоёл чимэглэл, сувд эрдэнэсдээ хоргодож байна!» гэж бодоод:

- Юу дуртайгаа ав, гагцхүү бушуухан далд орж үз! Өглөө гэхэд нүдэнд бүү үзэгд! гэжээ.

Тэгээд зарц нартаа энэ муу хүүхэнд морь тэрэг хөллөж өг гэж тушаажээ. Маргааш нь хаан:

- Нөгөө муу хүүхэн явсан уу? гэхэд,

- Явсаан, явахдаа хаан хүүг аваад явсан гэж шадар цэрэг нь хариулав.

- Юу, юу гэнээ! Хаан хүүг аваад явсан гэнээ? гэж хаан хашгирав.

- Хамгийн үнэтэй юмаа авч явж болно гэж хаан таныг болгоосон гэж хэлсэн шүү. Нөхрөөс өөр үнэтэй юм байхгүй гэнэ.

Хаан уурлан:

- Би гоёл, эрдэнэ сувд гэж бодсон юм! Одоохон элч явуулж эргүүлж авчир! гэжээ.

Хаан хүү эхнэртэйгээ буцаж ирсэн аж. Тэгээд хөгшин хаан насан хутаг болсны дараа хүү нь хаан ширээнээ сууж ажил хэрэг бүхнийг цэцэн эхнэртэйгээ зөвлөх болсон юм гэнэ лээ.

# ОЮУН УХААН ТӨГӨЛДӨР ОТГОН ХҮҮ ИВАН

Эмгэн өвгөн хоёр амьдран суудаг байжээ. Өвгөн ан амьтан жигүүртэн шувуу агнаж түүгээрээ хоёул амьдарна. Он жилийг элээн олон насыг насалсан авч эд хөрөнгө гэх юм байсангүй.

Эмгэн харамсан зовж:

- Амттанг идэж уусангүй, аятай хувцсыг өмсөж зүүсэнгүй энэ насыг галын хажууд эргэлдсээр өнгөрөөлөө! Өглөх насанд харж баясах үр хүүхэд ч алга! гэхэд өвгөн нь:

- Эмгээн, бүү зов! Гар минь нугарч, хөл минь хөдөлж байгаа цагт өлсөхгүй байх. Юу юуны туханд хүрэлгүй гонсойгоод яах вэ!

Ингэж хэлээд өвгөн анд явжээ.

Өглөөнөөс орой болтол яваад нэг ч шувуу, нэг ч амьтан намнасангүй. Ганзага хоосон буцмааргүй байж, тэгээд яах билээ? Нар гудайчихаж харилгүй болохгүй.

Ингээд аргагүйн эрхэнд харихаар явж байтал хажууханд нь далавчны дэвэх сонсдон бутны цаанаас тун үзэсгэлэнт гоё нэг том шувуу нисэн хөөрөв гэнээ.

Өвгөн буугаа шагайх хооронд шувуу нисэн одов.

«Миний хувь биш байжээ!» гэж өвгөн бодоод шувуу нисэн гарсан бутыг шагайж үзвэл тэнд гучин гурван өндөг байна гэнэ.

«Ядахдаа энэ олзыг чинь аваад харья!» гэж сэтгээд бүсээ чангалан гучин гурван өндгийг өвөртлөв.

Явсаар байтал замдаа бүс нь суларч өндөг нь цувран унасаар байжээ. Өндөг газар унамагцаа сайхан залуу эр болж хувираад байж гэнэ. Гучин хоёр өндөг унаж гучин хоёр сайн эр болон босжээ!

Яг энэ үед өвгөн бүсээ чангалсанд гучин гурав дахь өндөг өвөрт нь үлдчихжээ. Өвгөн нэг эргээд хартал гучин хоёр сайхан залуу дагаж явахыг үзээд нүдэндээ итгэсэнгүй гайхав. Үс зүс, өндөр намаараа ив ижилхэн гучин хоёр залуу нэгэн дуугаар:

- Та биднийг олж чадсан, одоо та бидний эцэг, бид таны хүүхдүүд. Гэртээ харьцгаая! гэв.

«Эмгэн бид хоёрт нэг ч хүүхэд байгаагүй гэтэл одоо гэнэт гучин хоёр хүүтэй болдог юм байжээ!» гэж өвгөн баярлажээ.

Гэртээ ирээд өвгөн:

- Эмгээн, чи хүүхэд шуухад байхгүй гэж зовж шаналаад байсан. За май, одоо чи энэ гучин хоёр хүү, гучин хоёр сайн эрийн эх боллоо. Ширээгээ засаж идээ будаагаа гарга, хүүхдүүдээ хоолло!



Ингэж хэлээд өвгөн яаж гучин хоёр хүүтэй болсноо ярьжээ.

Эмгэн гайхах баярлах зэрэгцэн юу хэлэх, юу хийхээ мэдэхгүй самгардан зогсож байснаа ширээгээ засаж эхлэв. Өвгөн эхлээд бүсээ дараа нь тэрлэгээ тайлж эхэлтэл өврөөс нь гучин гурав дахь өндөг өнхрөн унаж тэндээс гучин гурав дахь залуу босож ирэв.

- Чи хаанаас гараад ирэв?

- Би бас л чиний хүү. Отгон хүү Иван. Өвгөн:

- Аа нээрээн, үүрэнд гучин гурван өндөг байсан шүү дээ гэж санаад,- За суу, Отгон хүү Иван, хоол ид! гэжээ.

Гучин гурван залуу эр ширээнд суугаад эмгэнд байсан бүхий л идэх юмыг дуусгаад гэдэс цадаагүй ч сэтгэл дүүрэн босоцгоожээ.

Нэг шөнө өнгөрөв. Өглөө нь Отгон Иван:

- Эцэг та биднийг олж авч чадсан юм чинь одоо ажил олж өг! гэв.

- Та нарт би ямар ажил өгөх вэ? Эмгэн бид хоёр үр тариа суулгадаггүй, хагалах газар ч байхгүй, анжис хадуур, морь тэрэг ч байхгүй шүү дээ!

- Байхгүй бол байхгүй, гомдох юм алга! Хүмүүст ажил хийж өгөөд амьдарч болно. Эцэг та дархнаар гучин гурван хадуур хийлгээч гэж Отгон Иван өгүүлэв.

Өвгөн дарханд очиж хадуур ширээж ирэх хооронд Отгон Иван ах нарынхаа хамт гучин гурван тармуур, гучин гурван хадуурын иш хийж бэлдээд байжээ. Эцэг нь ч дархныхаас эргэж ирэв. Отгон Иван ах нартаа хадуур, тармуур тараан өгч:

- За явж ажил эрцгээе. Олсон мөнгөөрөө өөрийн гэсэн аж төрөлтэй болж эцэг эхийгээ амраая гэв.

Ингээд ах дүү гучин гурвуулаа аав ээждээ үнсүүлээд алсыг зорин явжээ. Явсаар байтал өмнө нь нэгэн том хот харагдав. Тэр хотоос хааны бойдоо гарч яваад тэдэнтэй тулгарч ирмэгцээ:

- Залуу эрчүүд минь, ажлаас зугтаж явна уу, ажил эрж явна уу? Хэрвээ ажил эрж яваа бол намайг дагаад яв, би ажил олгоё гэв.

- Ямар ажил вэ? гэж Отгон Иван асуув.

- Хэцүү ажил бишээ. Хааны дархан нугын өвсийг хадаж, хатааж, бухалдах, нуруулдах хэрэгтэй байна. Хамгийн ахмад чинь хэн бэ? гэхэд цөм дуугүй байцгаав.

Отгон Иван:

- За тэр нугаа заагаад аль.

Бойдоо тэднийг хааны дархан нугад авчрав.

- Гурван долоо хоногт амжих уу?

- Тэнгэр сайхан байвал гурван өдөрт амжина гэж Отгон Иван хариулав. Бойдоо баярлаж:

- Залуу эрчүүд минь, ажилдаа орцгоо! Шан хөлс гомдоохгүй төлнө... Хоол унд юу гэснийг чинь авчруулна.

- Бидэнд гучин гурван шарын бүхэл мах шарж, гучин гурван хувин дарс, хүн бүрд нэг нэг дугуй талх өгөөрэй. Өөр юм хэрэггүй гэж Отгон Иван өгүүлжээ.

Бойдоо ч явав. Ах дүү гучин гурвуулаа хадуураа ирлээд хадаж гарахад зөвхөн шир шир хийх л дуулдаж, өвс ханарна. Орой гэхэд нугыг нэлд нь хадаж дуусав. Тэгтэл ч хааны ордны гал тогооноос гучин гурван шарын шарсан мах, гучин гурван дугуй талх, гучин гурван хувин дарс авчирч өгөв. Ах дүү нар хагас хагас хувин дарс, өрөөл өрөөл шар, тал тал талх идээд унтацгаажээ.

Дараа өдөр нь нар гармагц өвсөө хатааж. бухалдаж орой нь нуруулдаж дуусгалаа. Тэгээд үлдсэн хагас хагас хувин дарс, өрөөл өрөөл шар, тал тал талхаа идээд амарцгаав. Отгон Иван нэг ахыгаа хааны ордон руу явуулав.

Ажлаа хүлээж ав гэж хэл.

Ах нь буцаж ирэв. Араас нь хааны бойдоо, хаан өөрөө хүрч ирлээ Хаан өвсөн нурууг тоолж нугаар явж шалгаад босоо өвс нэг ч олдсонгүйд:

- Залуу эрс минь, та нар мнний дархан нугыг маш хурдан тун сайн хадаж өвсийг хатааж нуруулдаж өглөө! Ажил сайн хийсэнд шан хөлс дээр нь зуун рубль, дөчин литрийн торх дарс нэмж өгнө. Харин одоо нуруулдсан өвсөө манаж хамгаал! Энэ нугад жил бүр нэг амьтан өвс идээд байх болсон юм. Тэр хулгайчийг барьж чадахгүй байгаа билээ гэв.

- Хаан эзэнтэн минь, миний ах нарыг гэр лүүгээ буцахыг болгооно уу. Өвсөө би ганцаараа маная гэж Отгон Иван гуйжээ.

Хаан ч зөвшөөрч гэнэ. Ах нар нь хааны ордон руу очиж шан хөлсөө аваад дарс ууж, хоол идэцгээгээд эцэг эхээ баярлуулахаар харьжээ.

Харин Отгон Иван хааны дархан нугад эргэж ирэв. Шөнө унталгүй өвсөө манаж хоноод өдөртөө хааны гал тогоонд хоол унд идэж амарна.

Ингэж байтал намар болжээ. Шөнө уртсаж харанхуй байх болов. Отгон Иван нэг орой нуруулдсан өвсөн дээрээ гарч тухлан унталгүй хэвтэж байжээ. Гэтэл гэнэт шөнө дунд эргэн тойрон гэрэлтэн нар гарсан мэт болов гэнэ. Отгон Иван нүдээ бүлтийлгэн харваас алтан дэлт гүү далайгаас гарч ирээд шууд нуруулдсан өвс рүү давхиж гэнэ. Гүү давхихад газар доргиж, алтан дэл нь салхинд дэрвэн хийсэж хамраас нь дөл бадарч чихнээс нь утаа суунаглана.

Нуруулдсан өвсөнд хүрмэгцээ идэж гарав. Отгон Иван гэнэт үсрэн мордоод авав. Алтан дэлт гүү мултран зугтах гэж хааны дархан нугаар өөд уруугүй давхив. Отгон Иван зүүн гараараа дэлээс нь зууран, баруун гартаа барьсан суран ташуураар гуядан гуядан намаг хөвдөт газар луу залсаар байлаа.

Давхиж давхиж булгиж байснаа алтан дэлт гүү намагт гэдсээ хүртэл шигдэн аргагүйн эрхэнд зогсов.

- Ай Отгон Иван, чи намайг барьж авч чадлаа, номхотгон захирч чадлаа! Одоо намайг бүү нүд, бүү зовоо, үнэнч хүлэг чинь больё гэжээ.

Отгон Иван алтан дэлт гүүг хааны ордонд авчирч агтны хашаанд хашаад өөрөө гал тогооны өрөөнд орон унтжээ.

Маргааш нь хаанд:

- Хаан эзэнтэн минь, таны дархан, нугын өвсийг ямар амьтан идээд байгааг би мэдлээ. Тэр хулгайчийг бариад авлаа. Та үзнэ үү? гэж айлтгав.

Хаан алтан дэлт гүүг хараад баярлаж:

- Иван, чи айлын отгон хүү ч гэсэн оюун ухаан төгөлдөр юмаа! Албаа үнэнчээр биелүүлсэн чамайг агтны даамал болгоё гэжээ.

Тэр цагаас хойш Иваныг оюун ухаан төгөлдөр Отгон Иван гэдэг болжээ.

Ингээд Отгон Иван агтны даамал болов. Шөнө үл унтан агт морьдоо тордон хамгаална. Хааны морьд удалгүй тэвхийсэн сайхан биетэй, мяндас зөөлөн үстэй, дэл сүүл нь намирсан, харахад нүд сэргэм сайхан болоод ирэв.

Хаан магтан сайшааж:

- Оюун ухаан төгөлдөр Отгон Иван чи тун сайн байна. Ийм даамал надад хэзээ ч байгаагүй! гэнэ.

Хуучин агтчид атаархан:

- Энэ муу хөдөөний хархүүг бидний даамлаар тавилаа! Хааны агтчидыг энэ муу захирах гэж үү! гэлцэв.

Ингээд муу санаа агуулан хорлох арга бодоцгоов. Оюун ухаан төгөлдөр Отгон Иван оногдсон ажлыг хийж гай тоггор нүүрлэн ирж буйг мэдэх ч үгүй явна.

Нэг өдөр хааны ордны хашаанд архичин хөгшин цагдаа орж ирэн агтчидыг дуудан:

- За нөхөд минь, шар тайлах аяга юм өгөөтөх! Би та нарт агтны даамлыг хорлох арга заагаад өгье гэжээ.

Агтчид ч баярлаж аяга дарс барьжээ. Хөгшин цагдаа шараа тайлаад:

- Манай хаан өөрөө дуугарагч ятга, дэгдэн бүжиглэгч галуу, дэвхрэн тоглогч мууртай болох гэж ухаангүй хүсэж байгаа билээ. Олон ч сайн эр хүслээрээ явж, бүүр ч олон хүн албан шахалтаар явсан боловч амь мэнд буцаж ирсэн хүн нэг ч үгүй билээ. Та нар хаанд «Оюун ухаан төгөлдөр Отгон Иван энэ бүгдийг олоход юу ч биш гээд байна» гэж очиж хэл. Хаан Отгон Иваныг явуулна, тэгээд тэр муу эргэж ирэхгүй болно гэжээ.

Агтчид цагдаад баярлаж талархсанаа илэрхийлж дахин нэг аяга дарс өгөөд хааны ордны цонхон тушаа ярилцах дүрийг үзүүлэн зогсоцгоов. Хаан тэднийг хараад гарч ирэн:

- Эрчүүд минь, юугаа шүүн ярилцана вэ? Юу гэж явна вэ?

- Хаан эзэнтэн минь, агтны даамал оюун ухаан төгөлдөр Отгон Иван «Өөрөө дуугарагч ятга, дэгдэн бүжиглэгч галуу, дэвхрэн тоглогч муур хаанаас яаж олохыг би мэднэ» гээд байна. Тэгээд бид энэ үнэхээр олж чадах юмуу, хоосон гайхуулж байгаа юмуу яаж мэдэх вэ гэж маргалдаж байна гэцгээжээ.

Үүнийг сонссон хаан ч царай нь хувиран хөл гар нь чичрэн «Энэ ховор сонин юмыг олоод авбал бусад хаад надад атаархана! Хичнээн хүн явууллаа, хэн ч эргэж ирээгүй!» гэж дотроо бодоод даруй агтны даамлыг дуудуулав гэнэ.

Отгон Иваныг ирмэгц:

Өөрөө дуугарагч ятга, дэгдэн бүжиглэгч галуу, дэвхрэн тоглогч муур бушуухан олж ир! гэж хашгирчээ.

Оюун ухаан төгөлдөр Отгон Иван:

- Хаан эзэнтэн минь! Та юу ярина вэ? Би тийм юм байдаг гэж дуулаа ч үгүй юм байна! Хаашаага би явах вэ?

Хаан уурлан титмээ хажуулдуулж дороо дэвслэн:

- Олон үг хэлж эзэн хааны зарлигийг эсрэгцэх эрх чамд хаана байна? Олоод ирвэл шагнана, олохгүй бол миний сэлэм гялс чиний толгой бөндгөс. Ойлгов у? гэх нь тэр.

Отгон Иван хааны ордноос толгойгоо гудайлган гунигтай буцав. Алтан дэлт гүүгээ эмээллэтэл гүү нь:

- Эзэн минь юундаа гуниглаа вэ? Гай зовлон тохиолдов уу? гэхэд,

- Яаж ч хөгжин баясах билээ дээ? Хаан өөрөө дуугарагч ятга, дэгдэн бүжиглэгч галуу, дэвхрэн тоглогч муур олж ир гэж зарлиг буулгалаа гэж Иван хариулжээ.

- Энэ гай, гай биш. За намайг уна Шулмас эмгэнийд очъё. Энэ сонин зүйлсийг хаанаас олохыг асууя гэж алтан дэлт гүү нь өгүүлэв.

Ингээд оюун ухаан төгөлдөр Отгон Иван алс замд гарчээ. Алтан дэлт гүүндээ мордохыг нь харцгааж, харин хаашаа хаагуур гараад явсныг нь хэн ч амжиж үзсэнгүй.

Отгон Иван явсаар явсаар битүү харанхуй ойд оров. Алтан дэлт гүү нь эцэн өөрөө ч ядарчээ. Тэгтэл ч ойн цоорхойд тахиан хөлт байшин нар зөв эргэлдэн байх нь харагдав гэнэ.

Тэр байшинд ойртон очиж:

- Байшинхан, байшинхан, ар ханаа ой руу онгойх хаалгаа над руу харуулаач! Зууныг энд хороохгүй зуур хоноод явъя гэжээ.

Байшинхан түүний зүг эргэв. Отгон Иван алтан дэлт гүүгээ уяд довжоон дээр нь гүйн гарч үүдийг нь дэлгэв. Тааз хүрсэн хамартай, тахир ясан хөлтэй Шулмас эмгэн уур нүдүүрээ хажуудаа тавьчихсан сууж байлаа.

Шулмас эмгэн зочныг хараад:

- Хүний бараа хараагүй олон жил болсон юмсан. Одоо чинь орос сайн эр өөрөө ороод ирдэг болоо шив! За сайн эр, юу гэж явна? гэв.

- Эмгэн, та өлсөж даарсан замын хүнийг яасан царайгүй угтаж байх юм бэ! Орос ёсоор аяны хүнийг эхлээд цайлж ундал, халуун усанд оруулж замын алжаалыг нь салгадаг! Дараа нь асуух хэлэх юмаа ярилцдаг билээ гэхэд Шулмас эмгэн бүдчин:

- Ай залуу эр минь, хүний өөрийн ёсон өөр, хөгшин зөнөг намайг уучил! Одоохон хэлснээр чинь бүгдийг хийнэ.

Ингэж хэлээд Шулмас эмгэн ширээ засаж зочноо дайлаад халуун усны байшингаа галлав. Оюун ухаан төгөлдөр Отгон Иван халуун усанд орж хар хирнээсээ саллаа. Шулмас эмгэн Отгон Иванд ор дэр засаж өгч хэвтүүлээд, өөрөө хажууд нь суун асуув.

- За сайн эр минь, хүслийн зоргоор явна уу, хүний эрхээр явна уу? Аль газрыг зорин аяны замд гараа вэ?

- Хаан эзэнтэн өөрөө дуугарагч ятга, дэгдэн бүжиглэгч галуу, дэвхрэн тоглогч муур олж ир гэлээ. Энэ зүйлсийг хаанаас олохыг та надад хэлж өгвөл ачийг чинь мартахгүй!

- Ай хүний тэнэг үр минь, энэ сонин зүйлс хаана байгааг би мэднэ. Гэхдээ олж авах гэдэг тун хэцүү! Олон сайн эрчүүд тийшээ явсан ч нэг нь ч эргэж ирээгүй шүү.

- Нэг үхэхээс хоёр үхэх биш дээ. Одоо яая гэх вэ! Зовлонг минь ойлгож, хаашаа явж эрэхийг заагаад өгөөч.

- Ай хүний тэнэг үр минь, чи хөөрхий л байна, гээд яахав дээ. Зовлонгий чинь би ойлгож байна. Чи алтан дэлт гүүгээ манайд орхи. Эсэн мэнд бүрэн бүтэн байх болно. За май, энэ бөөрөнхийлсөн утсыг ав. Маргааш өглөө гарч явахдаа утсаа өмнөө шид. Утас хаашаа өнхрөнө, тийшээ яваад бай. Тэгээд миний дунд эгч дээр очно. Чи бөөрөнхий утсаа үзүүл. Дунд эгч

чамд бүгдийг зааж хэлж өгөөд том эгч рүү явуулна.

Ингээд маргааш нь Шулмас эмгэн зочноо үүрээр сэрээж цай хоол өгөөд гаргаж өгөв. Оюун ухаан төгөлдөр Отгон Иван түүнд талархаад цааш явжээ.

Үлгэрт хэлэхэд амархан ч үйлс бүтэх нь хэцүү. Бөөрөнхий утас өнхөрсөөр сайн эр дагасаар.

Гурав дахь өдрөө утас бор шувуун хөлтэй, ээрүүл шиг эргэлдсэн байшинханд тулж очив.

- Байшинхан, ар ханаа ой руу онгойх хаалгаа над руу харуулаач! гэж сайн эр хэлэв. Байшинхан эргэв. Сайн эр тэнд орвоос эзэгтэй эмгэн их л дургүй угтав.

- Хүний үнэр үнэрлээгүй, хүний мах идээгүй удсан юмсан. Гэтэл хүн өөрөө хүрээд ирдэг байжээ! За, юу гэж явна, хэл!

Оюун ухаан төгөлдөр Отгон Иван бөөрөнхий утсаа эмгэнд өгөв. Шулмас эмгэн утсыг хараад шогширч:

- Өө чи чинь, хүний хүн биш хүндэт зочин байх нь! Чамайг дүү минь над руу явуулжээ! Чи шууд хэлэхгүй яав!

Ингээд хоол унд болж ширээ засан архи дарс амтат идээг өрөв.

- Ууж идээд унтаж амар. Ажил хэргийг аажуудаа ярилцъя гэв.

Оюун ухаан төгөлдөр Отгон Иван ууж идэж аваад унтаж амрахаар хэвтгэл Шулмас эмгэн хажууд нь суун хэрэг зоригийг асуув. Хааныхын хэн болох, хааныхаа зарлигаар хаа хүрэх гэж яваагаа Отгон Иван ярьжээ.

Шулмас эмгэн:

- Эрлийн зам чинь эрлэгтэй, холын зам чинь хорлолтой юм байна. Эсэн мэнд гарна гэдэгт чинь эргэлзэж байна. Өөрөө дуугарагч ятга, дэгдэн бүжиглэгч галуу, дэвхрэн тоглогч муур миний зээ Атгаалжин хар могойд бий. Олон сайн эр тийшээ явсан ч олж буцсан нь үгүй билээ. Миний эгчийн хүү Атгаалжин хар могой бүгдийн толгойг залгисан юм. Эгчийгээ чамд тусал гэж гуйя даа. Тэгэхгүй бол чи амьд үлдэхгүй. Өнөөдөр зөнч мэргэн хэрээг тэднийх рүү явуулъя. Урьдчилаад хэлэг. Харин одоо чи унтаж амар, маргааш эрт сэрээнэ гэв.

Сайн эр өглөө эртлэн босож, нүүр гараа угаахад Шулмас эмгэн хоол цай уулгаад бөөрөнхийлсөн улаан ноосон утас өгч зам дээр гаргаж өгөв. Ингээд Отгон Иван салах ёс хийгээд бөмбөрөн өнхрөх утсыг даган явжээ.

Үүрийн гэгээнээс үдшийн бүрэнхий болтол явсаар Отгон Иван ядарвал утсаа барьж байгаад амарч, жаал ус уугаад цааш явна.

Гурав дахь өдрийнхөө орой утас нэгэн том байшингийн гадаа өнхрөн ирж зогсов. Тэр байшин арван хоёр багана, арван хоёр бул чулуун дээр тогтож байна гэнэ. Байшинг тойроод өндөр

өндөр хатгууран хашаатай ажээ.

Нохой хуцахад хамгийн том эгч Шулмас эмгэн гарч нохойгоо хорин:

- За сайн эр минь, чиний тухай би мэдэж байна. Цөмийг мэдэж байна. Дунд дүүгээс зөнч хэрээ нисэн ирж хэлсэн. Яаж ийгээд тусалж зовлонг чинь нимгэлье. Ор, ор, аян замын алжаалаа тайлагтун гэв.

Ингээд зочноо ундлаад:

- Одоо чи нуугд. Миний хүү Атгаалжин хар могой өлсөж, уурлачихсан амьтан удахгүй нисээд ирнэ. Чамайг аманд нь өртөөчихгүй юмсан гээд зоорио онгойлгон,- За ийшээ ороод суу. Дуудахаас нааш гарч ирж болохгүй шүү гэлээ.

Шулмас эмгэн зоориныхоо хаалгыг дөнгөж хаатал эргэн тойронд их чимээ гарч үүд дэлгэгдэн

.Атгаалжин хар могой нисэн орж ирэв.

- Хүний үнэр үнэртээд байна!

- Хүү минь, чи юу ярина вэ? Манай энд хөх чоно давхисангүй, хөвчийн шонхор ниссэнгүй хичнээн жил болж байна, юуны чинь хүний үнэр! Чи л дэвэн дэлхийг тойрон нисэхдээ хүний үнэрийг шингээгээ биз.

Ингэж хэлээд Шулмас эмгэн ширээ засаж, зуухнаасаа шарсан шарын мах гаргаж, хувин дарс тавьж хүүдээ өгөв. Атгаалжин хар могой дарсыг ууж, шарсан махаар даруулаад сэтгэл нь сэргэжээ.

- Ээж минь, хэнтэй ч юм нэг сайхан тоглохсон, хөзөр ч болохноо тоглохсон!

- Чамтай тоглох хүн олж чадах байна. Харин чи түүнийг хорлох вий гэхээс айж байна.

- Ээжээ, тэр хүнээ дууд дууд, бүү ай! Би хэнийг ч хорлохгүй. Тоглож зугаацахсан гэхээс тэсэж ядаж байна!

- За хүү минь, хэлсэн үгээ мартав аа! гэж Шулмас эмгэн хэлээд зоориныхоо хаалгыг онгойлгон,

- Оюун ухаан төгөлдөр Отгон Иван гараад ир. Эзнийг хүндлэн хэдэн удаа хөзөр тоглоотох гэв. Тэгээд тоглохоор суужээ. Атгаалжин хар могой:

- Хэн хожсон нь хожигдсоныгоо идье, тэгэх үү? Аан? гэлээ.

Шөнөжингөө тоглов. Шулмас эмгэн зочиндоо тус болж, өглөө болоход оюун ухаан төгөлдөр

Отгон Иван Атгаалжин хар могойг хожжээ. Гэтэл Атгаалжин хар могой:

- Манайд дахин хэд хоно! Би орой ирээд дахин тоглоё. Би хариугаа авмаар байна гэж гуйж гэнэ.

Гуйсан ёсоор ч болж. Атгаалжин хар могой нисэн одоход оюун ухаан төгөлдөр Отгон Иван ханатлаа унтаж авчээ. Шулмас эмгэн ч түүнд хоол унд өгөв.

Орой нь Атгаалжин хар могой ирж бүхэл гунын шарсан мах идэж хагас хувин дарс уугаад:

- За тоглоё, хариугаа авна гэжээ.

Тоглож эхэлтэл Атгаалжин хар могой урьд шөнө нь унтаагүй, өдөржингөө нисээд амраагүй тул эцэж ядран, нойр нь хүрч үүрэглэж эхлэв. Оюун ухаан төгөлдөр Отгон Иван Шулмас эмгэн хоёр түүнийг дахин хожжээ.

Атгаалжин хар могой:

- Би одоо яваад орой ирнэ. Тэгээд гурав дахь удаагаа тоглоё гэв.

Оюун ухаан төгөлдөр Отгон Иван ханатлаа унтаж амрав. Харин хоёр шөнө унтаагүй Атгаалжин хар могой дахин дэвэн дэлхийгээр нисэн эцэж ядарчихсан буцаж иржээ. Шарын шарсан мах идэж хоёр хувин дарс уугаад зочноо дуудан:

- За залуу эр, суу! Одоо ч хариугаа авна! гэв.

Тэгээд тоглож суухдаа үүрэглээд байж гэнэ. Отгон Иван гурав дахь удаагаа хожив.

Атгаалжин хар могой өвдөг сөхрөн:

- Сайн эр минь, намайг бүү хөнөө, бүү ид! Юу гэснийг чинь хийе гээд бас ээжийнхээ хөлд сөгдөн,- Ээжээ, намайг амьд мэнд үлдээ гэж зочноос гуйгаач! гэж гэнэ.

Энэ үгийг хүлээж байсан оюун ухаан төгөлдөр Отгон Иван:

- За яахав, Атгаалжин хар могой, чамайг би гурав хожлоо. Хэрвээ чи надад өөрөө дуугарагч ятга, дэгдэн бүжиглэгч галуу, дэвхрэн тоглогч муураа өгвөл бид тохиролцлоо гэж бод гэхэд атгаалжин хар могой инээн зочноо, ээж эмгэнээ тэврэн авч:

- Өгье, өгье! Би өөртөө илүү сайхныг олж авна гэв.

Ингээд Атгаалжин хар могой ширээ засуулан найрлав. Найран дээрээ Отгон Иваныг хүндлэн зочилж дүүгээ гэж нэрлэж гэнэ. Дараа нь:

- Зочин минь, чи өөрөө дуугарагч ятга, дэгдэн бүжиглэгч галуу, дэвхрэн тоглогч муур аваад яаж явган явах вэ! Би чамайг нэг цагийн дотор хүргэж өгье! гэж гэнэ.

- За хүү минь, сайн байна! Зочноо миний бага дүү дээр хүргээд өг. Буцах замдаа дунд дүүгийнхээр орж эргээд ир. Чи тэд нарынхаар ойрдоо очоогүй шүү дээ гэж Шулмас эмгэн



хүүдээ хэллээ.

Найр цэнгэл дуусахад Отгон Иван нөгөө зүйлсээ аваад Шулмас эмгэнтэй салах ёс гүйцэтгэв. Атгаалжин хар могой түүнийг шүүрч аван үүлэнд тултал өндөрт нисэв. Цаг ч өнгөрөөгүй байтал Атгаалжин хар могой бага Шулмас эмгэний гадаа буужээ. Эзэгтэй Шулмас эмгэн үүдэн дээрээ гүйн гарч ирж зочдоо баяртай угтав.

Оюун ухаан төгөлдөр Отгон Иван тэнд саатсангүй, алтан дэлт гүүгээ эмээллэн бага Шулмас эмгэн, Атгаалжин хар могойтой салах ёс хийгээд өөрийн улс руу яаран явжээ.

Энэ үед хааныд гурван хаан нэг нэг хүүтэйгээ, бас гурван ван нэг нэг ван агьтайгаа, өөр олон сайд ноёд, шадар түшмэд зочлон ирээд байжээ.

Сайн эр хааны өргөөнд орж хаандаа өөрөө дуугарагч ятга, дэгдэн бүжиглэгч галуу, дэвхрэн тоглогч муураа өгөв. Хаан баярлан:

- Оюун ухаан төгөлдөр Отгон Иван, чи надад энэ албыг гүйцэтгэж их тусыг үзүүллээ! Би агтны даамал байсан чамайг сайшаан, хаан миний зөвлөх болгоё гэж гэнэ.

Сайд ноёд ярвайлдан, өөр хоорондоо:

- Энэ агтчинтай суудал нэгтгэнэ гэдэг бидний нэр алдрыг гутааж байна! Хаан юу бодох нь энэ вэ! гэлцэв.

Тэгтэл ч өөрөө дуугарагч ятга эгшиглэж, дэвхрэн тоглогч муур нарийнхан дуугаар даган дуулж, дэгдэн бүжиглэгч галуу дэргэн эргэлдэн бүжиглэв. Ингээд сууж байхын аргагүй бүжиг наадам өрнөв гэнэ. Сурвалжит зочид ч цөм босон бүжиглэж эхэлжээ.

Бүжиглээд л байж. бүжиглээд л байж хаадын титэм нь хазайчихсан, хаан хүү, ван, агиуд эргэлдэн тойрон бүжиглэсээр. Сайд, шадар ноёд дуу шуу болж хашгиралдан хөлс нь цутган эргэлдэвч хэн ч зогсож чадахгүй ажээ.

Хаан гараараа даллан:

- Оюун ухаан төгөлдөр Отгон Иван, зогсоогооч, энэ наргианаа зогсоо, бүтэж үхэх нь! гэж ориллоо.

Сайн эр сонин гурван зүйлээ шуудайд хийхэд тэр дороо дуугарахгүй, бүжиглэхгүй болов. Зочид хандсан зүгтээ унан, хөлсөө сэвэн:

- Энэ ч ёстой зугаа, ёстой цэнгэл байна даа. Ийм юмыг энэ насандаа үзээгүй юм байна! гэцгээв.

Харийн зочид атаархана. «Одоо ч цөм атаархана. Надаас өөр хэнд ч ийм сонин зүйлс байхгүй» гэж хаан ихэд баярлана. Харин сайд ноёд:

- Энэ муу хөдөөний эрийг одоо л холдуулж салахгүй бол ордонд хамгийн гол хүн болж

хамаатан саднаа тушаалд дэвшүүлж, сурвалжит биднийг орчлонгоос зайлуулах болно гэж ярилцав.

Маргааш нь сайд, шадар ноёд цуглан яаж хааны шинэ зөвлөхийг хорлохыг бодоцгоов. Нэг хөгшин тайж:

- Архичин цагдааг дууд. Тэр ийм юманд адтай гэлээ. Архичин цагдаа ирж ёслон:

- Сайд, шадар ноёдоо, та нар намайг дуудсаны учрыг би мэдэж байна! Хагас хувин дарс өгвөл хааны шинэ зөвлөхийг хорлох арга зааж өгнө гэхэд,

- За хэл хэл. Шан хөлсөөр чамайг гомдоохгүй гэж гуйжээ

Эхлээд нэг цом дарс авчирч өгсөнд цагдаа уугаад:

- Хаан бэлэвсрээд дөчин жил боллоо. Энэ хугацаанд сайхан гүнж Алёнаг эхнэр болгон авах гэж хэчнээн удаа гуйгаад бүтээгүй билээ. Алёнагийн улс руу гурван удаа дайран орж хэчнээн цэрэг амь үрэгдлээ. Тэгээд хүчээр авч чадаагүй шүү дээ. Тэгэхлээр Алёна руу оюун ухаан төгөлдөр Отгон Иваныг явуулаг. Тэндээс амьд буцаж ирэхгүй.

Сайд, шадар ноёд баярлан сэргэж маргааш өглөө нь хаандаа:

- Хаан та ухаант зөвлөхтэй болсон билээ. Дуртай юмыг чинь олж ирсэн Отгон Иван одоо хайртай хүүхэн Алёнаг чинь гуйж бэр буулгаж ирж чадна гэж бардагнаж байна гэжээ.

Сайхан гүнж Алёнагийн тухай сонсмогцоо хаан суудлаасаа босон харайв.

- Нээрээн, би бүр мартчихаж! Сайхан гүнж Алёна руу явуулах хүн чинь Отгон Иван яг мөн! Тэгээд шинэ зөвлөхөө дуудан:

- Зуун уулын цаанатаа зургаан улсын тэртээ явж сайхан гүнж Алёнаг надад авчирч өг! гэв.

Оюун ухаан төгөлдөр Отгон Иван:

- Хаан эзэнтэн минь, сайхан гүнж Алёна чинь өөрөө дуугарагч ятга, дэгдэн бүжиглэгч галуу, дэвхрэн тоглогч муур биш шүү дээ. Шуудайд хийгээд үүрээд ирнэ гэхийн аргагүй билээ. Ирэхийг хүсэхгүй бол яах вэ!

Хаан зүхэн шогширч, дэвслэн:

- Олон юм битгий ярь! Ямар нэг аргаар заавал олоод ир! Сайхан гүнж Алёнаг авчирвал хот тосгон таслан өгч сайд болгоно. Авчрахгүй бол толгойг чинь авна! гэж хашгирав.

Оюун ухаан төгөлдөр Отгон Иван хааныхаас гүн бодолд дарагдан гунихран гарчээ. Алтан дэлт гүүгээ эмээллэтэл гүү нь асуув.

- Эзэн минь, юундаа бодлогошроо вэ? Гай зовлон тохиолдов уу?

- Уйлах ч хэцүү, инээх ч хэцүү болоод байна. Хаан сайхан гүнж Алёнаг бэр буулгаж ир гэж зарлиг буулгалаа. Өөрөө гурван жил гуйгаад, гурван удаа дайрч ороод чадаагүй атлаа одоо намайг ганцааранг минь явуулж байна.

- Өө, энэ ч гайгүй. Гэвч би чамд тусалъя. Энэ хэрэг эрхиш бүтнэ.

Оюун ухаан төгөлдөр Отгон Иван хурдан төхөөрч холын замд гарав. Отгон Иваныг алтан дэлт гүүндээ мордохыг нь харцгааж, харин хаашаа хаагуур гараад явсныг нь хэн ч амжиж үзсэнгүй.

Явсаар явсаар зуун уулын цаанатаа нэгэн гүрэнд ирэв гэнэ. Зам хөндөлсөн нэг их өндөр хашаа харагджээ. Алтан дэлт гүү нь хашаан дээгүүр сэвхийтэл харайж, ингээд сайн эр Отгон Иван тэндхийн хааны дархан цэцэрлэгт орчихож гэнэ. Алтан дэлт гүү нь:

- Би алтан алимтай сайхан мод болж хувиръя. Чи миний ойрхон нуугд. Маргааш сайхан гүнж Алёна цэцэрлэгт зугаалахаар гарч ирээд алтан алим харангуугаа таслан авах гэж над руу ойртоно. Ойртоод ирэх үед нь чи Алёнаг самбаачлан шүүрч аваад над дээр морд. Би бэлэн байна. Жаахан саатаж удвал бид хоёр амьд үлдэхгүй! гэж гэнэ.

Маргааш нь сайхан гүнж Алёна дархан цэцэрлэгт зугаалахаар гарч ирээд алтан алим хармагцаа аягачин шивэгчин хүүхнүүддээ:

- Ямар сайхан алим бэ! Алтан алим байна!.. Би нэгийг аваадхья, та нар эндээ хүлээж бай! гэв.

Тэгээд сайхан гүнж Алёна алтан алимтай мод руу гүйж ирэхэд нь Отгон Иван гэнэт гарч ирэн гараас нь шүүрч авав. Тэр хоромд алимын мод алтан дэлт гүү болон хувирч Отгон Иваныг яаруулан туурайгаараа газар цавчилна. Сайн эр эмээл дээрээ үсрэн мордоод Алёнаг өргөн авч өмнөө суулгав. Энэ үед аягачин шивэгчин хүүхнүүд тэднийг харж хашгирч харуул манаанууд гүйлдэн ирэв. Гэвч сайхан гүнж Алёна бараагүй алга болсон байлаа. Хаан эцэг нь мэдэж дөрвөн зүг найман зовхист морьтон элчийг илгээсэн боловч эрлийн элч нар маргааш нь хоосон эргэж ирцгээжээ. Хамаг морьдоо хөлөртөл давхисан ч үзэсгэлэнт гүнжээ олж чадсангүй.

Оюун ухаан төгөлдөр Отгон Иван энэ зуур олон голыг гаталж олон уулыг давжээ.

Сайхан гүнж Алёна эхлээд эсэргүүцэн мултрахыг оролдон тийчигнэж байснаа сүүлдээ уйлав. Уйлж байснаа сайхан залууг харж, дахин уйлж дахин харж арга хүчээ баран явна.

Маргааш нь сайхан гүнж Алёна асуув.

- Чи аль газрын, аль улсын, хэний хэн гэгч вэ?

- Намайг Отгон Иван гэдэг, оюун ухаан төгөлдөр гэж хочилдог. Би тийм улсын албат, тариачны хүү билээ.

- Оюун ухаан төгөлдөр Отгон Иван, чи намайг өөртөө авах гэж хулгайлав уу, эсвэл хүний зарлигаар уу?

- Манай хаан чамайг авчир гэсэн билээ.

Сайхан гүнж Алёна гараа базлан хашгирч:

- Тийм хөгшин хүнтэй энэ насандаа суухгүй! Гурван жил гуйгаад намайг авч чадаагүй, гурван удаа дайлаар ирээд их цэргээ алдсанаас өөр юмгүй буцсан юм. Одоо ч гэсэн хүн алганыхаа хонхорхойг хазаж чаддаггүйтэй адил намайг эхнэрээ болгоно гэж горьдолтгүй! гэж уйлан хашгирав.

Сайн эрд энэ үг таашаагдсан авч юм хэлсэнгүй, харин «Би ийм эхнэртэй болохсон!» гэж дотроо хүсжээ.

Ингээд удсан ч үгүй улсдаа эргэж ирэв. Хөгшин хаан энэ өдрүүдэд цонхноосоо холдолгүй алсын зам ширтэн оюун ухаан төгөлдөр Отгон Иваныг хүлээжээ.

Сайн эр хот руу орж ирэхэд хаан үүдэндээ гаран хүлээж байлаа. Хаан сайхан гүнж Алёнаг дун цагаан гараас нь барин тосон буулгав.

- Хичнээн жил элч илгээж, өөрөө ч хүртэл гуйж очоод дандаа хоосон буцсан билээ. Одоо ч гарцаагүй минийх боллоо доо! гэхэд сайхан гүнж Алёна жуумалзан:

- Би замынхаа тоосыг гүвье дээ, хурим найрын тухай дараа нь ярина уу гэхэд хаан сандчин аягачин шивэгчин хүүхнүүдийг дуудав.

- Хүндэт зочинд өргөө бэлэн үү?

- Бэлээн, аль эрт бэлэн болгосон.

- За хатан болох Алёнаг угтан авцгаа. Юу л гэнэ, бүгдийг биелүүлэгтүн гэж хаан тушаав. Аягачин шивэгчин хүүхнүүд сайхан гүнж Алёнаг өргөө рүү авч оров. Хаан оюун ухаан төгөлдөр

Отгон Иванд:

- Иван, чамайг сайшаая! Өнөөдрөөс эхлэн чи миний ерөнхий сайд бол! Гурван хот тосгонтой нь ав гэжээ.

Хаан сайхан гүнж Алёнагтай хуримаа хийнэ гэхээс тэсэж ядан нэг хоёр өдрийн дараа:

- Ямар өдөр зочдоо урьж хуримынхаа ширээнд зэрэгцэн суух вэ? гэж асуухад Алёна:

- Хуримын сүйх, шигтгээт бөгж минь байхгүй байхад би яаж тантай гэрлэх вэ? гэж гэнэ. Хаан:

- Ай, үүнд санаа зоволтгүй. Сүйх тэрэг, алтан бөгж манай улсад өвс ногоо шиг элбэг. Эндээс шилж сонгоод санаанд чинь таалагдахгүй бол далайн чанадаас ч авчруулж болно.

- Хаан эзэнтэн минь, би зөвхөн өөрийн сүйхэнд сууж, өөрийнхөө бөгжийг зүүж хуримлана гэж сайхан гүнж Алёна хэлжээ.

- Хуримын чинь сүйх, шигтгээт бөгж чинь хаана байгаа юм бэ? гэж хаан асуухад Алёна:

- Шигтгээт бөгж минь хайрцагт, хайрцаг сүйхэнд, сүйх тэнгис далайн ёроолд Буянт арлын ойрхон бий. Сүйх бөгж хоёрыг минь олж ирэхээс нааш хуримын тухай бүү яриарай! гэж хариулж гэнэ.

Хаан титмээ аван шилээ маажин:

- Сүйхийг чинь тэнгис далайн ёроолоос яаж олж авах вэ? гэхэд Алёна:

- Энэ таны үүрэг, яаж л олж авдагсан өөрөө мэд гээд өргөө рүүгээ орчихжээ.

Хаан ганцаар үлдээд бодож бодож гэнэт оюун ухаан төгөлдөр Отгон Иваны тухай санажээ. «Аан, сүйх, бөгж олж чадах хүн чинь Отгон Иван шүү дээ!» гэж баярлаад Отгон Иваныг дуудан:

- Үнэнч зарц, оюун ухаан төгөлдөр Отгон Иван минь, зөвхөн чи л өөрөө дуугарагч ятга, дэгдэн бүжиглэгч галуу, дэвхрэн тоглогч муур олж ирсэн билээ. Сайхан гүнж Алёнаг ч гэсэн чи л авчирч өгч чадсан. Одоо гурав дахь удаа миний хүслийг биелүүлж Алёнагийн хуримын сүйх, шигтгээт бөгжийг олж ир. Шигтгээт бөгж хайрцагт, хайрцаг сүйхэнд, сүйх тэнгис далайн ёроолд Буянт арлын ойрхон бий гэнэ. Хэрвээ сүйх бөгж хоёрыг авчирвал хаант улсынхаа гуравны нэгийг өгнө гэлээ.

Оюун ухаан төгөлдөр Отгон Иван:

- Хаан эзэнтэн минь, би ямар илбэ шидэт алтан загас биш дээ! Яаж тэнгисийн ёроолд байгаа сүйх олох юм бэ?

Хаан уурлан, дэвслэн:

- Би мэдэхгүй, чи хариуцна! Хэлж зарлигдах нь хаан миний хэрэг, хийж гүйцэтгэх нь албат чиний үүрэг! Сүйх бөгж хоёрыг авчирвал хааны ёсоор шагнана, авчрахгүй бол толгойгий чинь авна! гэж хашгирчээ.

Отгон Иван хашаа руу орж алтан дэлт гүүгээ эмээллэхэд гүү нь:

- Эзэн минь, хаашаа явах нь вэ?

- Хаашаа явахаа өөрөө мэдэхгүй байна. Хаан хатанд зориулж сүйх тэрэг, шигтгээт бөгж олж ир гэж зарлигдлаа. Шигтгээт бөгж хайрцагт, хайрцаг сүйхэнд, сүйх тэнгис далайн ёроолд Буянт арлын ойрхон байдаг гэнээ. Ингээд л ийм ажил бид хоёрт оногдлоо доо!

Алтан дэлт гүү нь:

Бэрх ажил байна даа. Зам хол биш ч гай тотгор тохиолдож магад. Сүйх хаана байгааг би мэднэ, харин авах тун хэцүү. Хэрвээ намайг далайн морьд харчихгүй бол ч би далайн ёроолд орон сүйхэнд хөллөгдөн аваад л ирнэ. далайн морьд намайг харвал хэдэн хэсэг тасдан хаяна. Чи намайг ч, сүйхийг ч хэзээ ч үзэхгүй болно! гэж гэнэ.

Оюун ухаан төгөлдөр Отгон Иван бодож бодож нэг арга олжээ. Хаанд очиж:

- Хаан эзэнтэн минь, надад арван хоёр шарын арьс, арван хоёр пүү давирхайдсан сур, арван хоёр пүү давирхай, нэг том тогоо өгнө үү? гэхэд хаан:

- Юу хэрэгтэйгээ бүгдийг ав, тэгээд сүйхэндээ хурдан яв гэв.

Сайн эр арьс, сур, давирхай, том тогоо тэргэнд ачаад алтан дэлт гүүгээ хөллөөд алсын замд гарчээ.

Хааны дархан нуга, далайн эрэгт ирээд алтан дэлт гүүндээ арьс нөмөргөн давирхайдсан сураар хүлжээ.

- Далайн морьд дайрсан ч чиний биед хүртэл нэлээд удна гээд арван хоёр шарын арьс нөмөргөн, арван хоёр пүү давирхайдсан сураар дарж боогоод дээрээс нь арван хоёр пүү давирхай асгажээ.

- Одоо ч би далайн морьдоос айхгүй! Энэ нугад гурван өдөр нүд анилгүй намайг хүлээ гэж алтан дэлт гүү нь хэлэв.

Тэгээд далай руу үсрэн орлоо.

Оюун ухаан төгөлдөр Отгон Иван далайн эрэг дээр ганцаар үлдэв. Сайн эр үл унтан ятга тоглон алтан дэлт гүүгээ хүлээсээр далайг ширтэж хоёр өдөр өнгөрөөв. Гурав дахь өдөр нойр нь хүрч, ятга хөгжимдөө ч үл сатааран нүд нь анилдаад эхлэв. Тэссээр тэссээр сүүлдээ бүүр тэнхэл нь алдран зүүрмэглэжээ.

Хэдий хир унтсаныг бүү мэд, гэнэт нойрон дунд нь морин төвөргөөн сонсдоход нүдээ нээн сэрвэл сүйх хөллөсөн алтан дэлт гүү нь эрэг дээр гараад ирлээ гэнэ. Алтан дэлт гүүнийх нь бөөрөнд далайн зургаан морь наалдан дүүжлэгджээ.

Оюун ухаан төгөлдөр Отгон Иван угтан очиход алтан дэлт гүү нь:

- Чи намайг шарын арьсаар ороож, сураар боож давирхайдаагүй бол ч би эргэж ирэхгүй байсан! Далайн морьд над руу сүргээрээ дайрч есөн шарын арьсыг хуулан урж хаяад хоёр шарын арьсыг цоолж тасдлаа. Энэ зургаан морины шүд нь сурны давирхайд наалдаад салсангүй би ч тэр чигээр нь аваад ирлээ. Чамд хэрэг болох бизээ гэж өгүүлэв.

Сайн эр далайн морьдыг тушчихаад суран ташуураар тас тас ороолгон номхотгов.

- Үгийг минь дуулж, үнэнчээр надад зүтгэх үү? Хэлсэн бүгдийг минь биелүүлэхгүй бол хэдэн хэсэг болтол нүдэж чоно нохойн хоол болгоно!

Далайн морьд сөгдөн:

- Сайн эр минь, бүү зовоо, бүү нүд! Үгийг чинь биелүүлж үнэнчээр зүтгэнэ. Аюул гай тохиолдсон ч алтан амийг чинь аварна! гэцгээв.

Отгон Иван ташуураа хаян бүх морьдоо хөллөөд улс гүрэн рүүгээ явжээ.

Ингээд хааны ордон руу долоон морио хөллөн давхиж ирээд алтан дэлт гүү, далайн морьдоо агтны хашаанд тавиад хаандаа:

- Хаан эзэнтэн минь, сүй бэлэгт сүйх тэрэг үүдэнд зогсож байна, та хүлээн авна уу? гэв. Хаан түүнд гялайлаа ч гэсэнгүй гүйн гарч сүйхнээс хайрцгийг авч сайхан гүнж Алёнад аваачиж өгөв.

- Сайхан гүнж Алёна, хүслийг чинь биелүүлж хайрцаг, шигтгээт бөгж, хуримын сүйх авчирлаа! Үүдэнд зогсож байгааг харна уу? За ямар өдөр хуримаа хийж зочдоо урих вэ?

- Хурим найраа хийж ханилан суухад ч би дуртай байна. Гэхдээ ийм хөгшин, буурал үстэй өвгөнтэй бөгж солилцох нэг л эвгүй юм. Хүмүүс «Энэ буурал хөгшин залуу хүүхэн авлаа!» гэж шоолон инээлдэх бизээ. Амьтны ам хэлийг алчуураар таглалтай биш дээ. Чи хуримынхаа өмнө залуужвал бидний бүх юм сайн сайхан байхсан гэж сайхан гүнж Алёна хариулж гэнэ.

Хаан:

- Хөгшин хүн яаж залуу болдгийг заагаад өгөөч. Залуу болбол хэлэлт юу байх вэ, тун сайн. Бид ийм ид шидийг мэдэхгүй, сонсоогүй юм байна.

- Гурван том зэс тогоо бэлд. Нэгэнд нь дүүрэн сүү, нөгөө хоёрт нь булгийн хүйтэн ус дүүргэх хэрэгтэй. Сүү, нэг тогоотой ус хоёроо халаах хэрэгтэй... Сүү ус хоёр буцлахаар нь эхлээд сүүнд, дараа нь буцалсан ус руу ор. Сүүлд нь хүйтэн устай тогоондоо ор. Ингэж гурван тогоонд ороод гарахад үзэсгэлэнтэй сайхан, хорин настай залуу шиг болно.

- Би шалзарч үхэхгүй биз? гэж хаан асуухад,

- Манай улсад хөгшин хүн байхгүй. Цөм ингэж залууждаг, хэн ч шалзарч үхээгүй гэж сайхан гүнж хариулжээ.

Хаан сайхан гүнж Алёнагийн хэлснээр бүх юмыг бэлтгүүлэв.

Сүү ус хоёр буцлахад айдас нь хүрч тогоог тойрон явж явж гэнэт санав.

- Юундаа ингэж шаналах вэ? Оюун ухаан төгөлдөр Отгон Иван эхлээд ороод үзэг. Хэрвээ сайхан болбол өөрөө орёе. Отгон Иван шалзарч үхэхэд ямар уйлах хүн байх биш. Надад л сайн, улсынхаа гуравны нэгийг таслан өгөх ч хэрэггүй бас сайн морьдтой ч болно. Харин ч ашигтай гэж бодоод Отгон Иваныг дуудуулжээ. Отгон Иван:

- Хаан эзэнтэн минь, намайг юунд дуудав? Би аян замаас ирээд амарч амжаагүй байна гэхэд

хаан:

- Одоохон одоохон. Чи энэ гурван тогоонд ороод очиж амар гэлээ.

Оюун ухаан төгөлдөр Отгон Иван тогоонуудыг өнгийн харвал эхний хоёрт нь сүү ус буцалж гурав дахид нь хүйтэн ус мэлтийнэ.

- Хаан эзэнтэн минь, амьдаар минь шалзлахаар шийдээ юү? Үнэнч зүтгэлийн минь шан энэ үү?

- Үгүй, үгүй Иван! Гурван тогоонд шунгаад шунгаад гарахад хөгшин хүн залууждаг юм.

- Хаан эзэнтэн минь, би тэртэй тэргүй залуу, надад залуужих хэрэггүй.

- Чи үргэлж эсэргүүцэж олон үг ярих юм! Хүслээрээ орохгүй юм бол хүчээр оруулна шүү. Хааны хүслийг тэрсэлсэн гэж дүүжлэх болно гэж хаан хашгирав.

Энэ үед сайхан гүнж Алёна гүйн ирж хааны нүд хариулж байгаад завчлан Отгон Иванд:

- Тогоонд орохынхоо өмнө алтан дэлт гүү, далайн морьддоо хэлж мэдүүл. Дараа нь айх юмгүй шумбан ор гэж шивгэнээд хаанд хандан:

- Хэлснээр минь цөмийг бэлдэж үү, үгүй юу гэдгийг үзэхээр ирлээ гэв. Тэгээд тогоонуудыг тойрч хараад:

- Бүх юмыг ёсоор бэлджээ. Хаан эзэнтэн, та шунгаж ор, би хуримд бэлтгэн хувцас хунараа өмсөе гээд яваад өглөө гэнэ.

Оюун ухаан төгөлдөр Отгон Иван хаанд:

- За яахав, сүүлчийн удаа хүслийг чинь биелүүлье! Тэртэй тэргүй нэг үхэхээс хоёр үхэх биш. Харин алтан дэлт гүүгээ нэг хараад ирэхийг болгооно уу? Олон ч газрыг, олон ч улсыг бид хоёр хамт туулсан юмсан даа. Эргээд уулзалдахгүй байж магадгүй гэжээ.

Хаан зөвшөөрөв.

- За хурдан очоод ир. Битгий уд!

Оюун ухаан төгөлдөр Отгон Иван алтан дэлт гүү, далайн морьдод цөмийг ярив. Тэд түүнд:

- Бид бүгд нэгэн зэрэг гурван удаа унгалдахыг сонсонгуутаа айлтгүй ор гэжээ.

Отгон Иван эргэж ирээд хаанд:

- За хаан эзэнтэн минь, би бүгдтэй салах ёс хийлээ. Одоо тогоонд шумбан орно доо. Ингэж хэлээд чагнаваас морьд гурван удаа унгалдах нь сонсдов. Тэгээд Отгон Иван сүүтэй тогоо руу пүлхийтэл үсэрч ороод тэндээсээ шууд хоёр дахь тогоотой буцалсан ус руу шумбаж, дараа



нь гурав дахь тогоотой хүйтэн ус руу дэвхэрч ороод гарч ирэхдээ үлгэрт хэлшгүй үзгээр бичишгүй сайхан эр болоод гараад ирлээ гэнээ.

Хаан түүнийг хармагцаа удаан ч бодсонгүй тавцан өөд мацаж гараад тогоотой сүү рүү пүлхийн унаж чанагдав.

Тэгтэл сайхан гүнж Алёна өндөр довжоон дээрээсээ гүйн ирж оюун ухаан төгөлдөр Отгон Иваны цагаан гараас барин авч гэрлэлтийн шигтгээт бөгжөө хуруунд нь зүүв. Алёна инээж:

- Хааны зарлигаар чи намайг хулгайлж авчирсан. Одоо хаан дахин босож ирэхгүй. Аав ээжид минь буцаан хүргэж өгнө үү, аль эсвэл эндээ байлгана уу чиний дур гэж өгүүлжээ.

Оюун ухаан төгөлдөр Отгон Иван сайхан гүнжийн гарыг атган хувь заяа минь чи билээ гэж өөрийн бөгжөө зүүж өглөө.

Дараа нь эцэг эх, ах дүү нараа хуримдаа урьж тосгон руу элч явуулав.

Удалгүй эцэг эх хоёр нь, гучин хоёр сайхан эр, гучин хоёр сайн ах нь хааны ордонд иржээ. Ингээд өргөн их хурим найр хийсэн гэнэ.

Тэр цагаас хойш оюун ухаан төгөлдөр Отгон Иван сайхан гүнж Алёна эхнэртэйгээ эвтэй найртай амьдарч эцэг эхээ жаргаажээ.